

Шинэ Гэрээний

Сайн Мэдээний Номлолын Багшийн Гарын Авлага



Шинэ Гэрээ

Сайн Мэдээний Номлолын Багшийн Гарын Авлага

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав.
Солт Лэйк Сити, Юта

Хавтас: Карл Блокийн *Уулан дээрх Номлол*. Фредериксбургын Үндэсний Түүхийн Музейн зөвшөөрөлтэйгээр ашиглав.

© 2002 Intellectual Reserve, Inc.

Бүх эрхийг эдэлнэ.

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 98/1

Орчуулгын зөвшөөрөл: 98/1

New Testament Gospel Teacher's Manual -ийн орчуулга

Агуулга

Хичээлийн Дугаар ба Гарчиг	Хуудас
Багшид Зориулсан Тусламж	v
1 “Есүс Бол Христ Гэдэгт Та Итгэх Болно” (Исаиа 61:1–3; Иосеф Смитийн Орчуулга, Лук 3:4–11; Иохан 1:1–14; 20:31)	1
2 “Сэтгэл Минь Их Эзэнийг Дээдэлнэ” (Лук 1; Матай 1)	5
3 “Аврагч . . . Та Нарын Төлөө Мэндэллээ” (Лук 2; Матай 2)	9
4 “Та Их Эзэний Замыг Бэлтгэ” (Матай 3–4; Иохан 1:35–51)	14
5 “Дахин Төрнө” (Иохан 3–4)	19
6 “Тэд Даруй Тороо Орхив” (Лук 4:14–32; 5; 6:12–16; Матай 10)	23
7 “Бидний Сул Дорой Байдлыг [Тэр]Өөртөө Авч, Бидний Өвчнийг Үүрсэн” (Марк 1–2; 4:35–41; 5; Лук 7: 11–17)	28
8 Уулан Дээрх Номлол: “Илүү Сайн Зам” (Матай 5)	32
9 “Эхлээд Бурханы Хаант Улсыг Хайгтун” (Матай 6–7)	38
10 “Буулгыг Минь Өөр Дээрээ Авч Надаас Сурагц” (Матай 11:28–30; 12:1–13; Лук 7:36–50; 13:10–17)	44
11 “Тэрээр Тэдэнд Олон Зүйлийг Сургаалт Зүйрлэлээр Хэлсэн” (Матай 13)	48
12 “Би Бол Амьдралын Талх” (Иохан 5–6; Марк 6:30–44; Матай 14:22–33)	52
13 “Би Та Нарт Хаант Улсын Түлхүүрийг Өгнө” (Матай 15:21–17:9)	57
14 “Миний Хөрш Гэж Хэн Бэ?” (Матай 18; Лук 10)	62
15 “Би Бол Ертөнцийн Гэрэл Мөн” (Иохан 7–8)	67
16 “Би Сохор Байсан, Одоо Харж Байна” (Иохан 9–10)	71
17 “Би Мөнхийн Амьдралыг Өвлөн Авахын Тулд Юу Хийх Вэ?” (Марк 10:17–30; 12:41–44; Лук 12:13–21; 14; 16)	76
18 “Тэр Алдагдсан ч Олдлоо” (Лук 15; 17)	81
19 “Итгэл Тань Таныг Эдгээв” (Лук 18:1–8, 35–43; 19:1–10; Иохан 11)	85
20 “Хоёр нүүрт Хүмүүс. . . Та Нар Золгүй еэ” (Матай 21–23; Иохан 12:1–8)	89
21 “Таны Заларч Ирэх Үеийн Тэмдэг Юу Байх Вэ?” (Иосеф Смитийн Орчуулга—Матай [Матай 24])	94
22 “Та Нарт Бэлтгэгдсэн Хаант Улсыг Өвлөн Авсугай” (Матай 25)	99
23 “Би Та Нарыг Хайрласан Шиг Бие Биеэ Хайрлагтун” (Лук 22: 1–38; Иохан 13–15)	104

24	“Энэ Бол Мөнх Амьдрал” (Иохан 16–17)	109
25	“Миний Хүсэл Бус, Харин Таны Хүсэл Биелэгдэг” (Матай 26:36–46; Марк 14:32–42; Лук 22:39–46)	114
26	“Үүний Тулд Би Төрсөн” (Матай 26:47–27:66; Марк 14:43–15:39; Лук 22:47–23:56; Иохан 18–19)	119
27	“Тэр Энд Байхгүй, Учир нь Тэр Амилсан” (Матай 28; Лук 24; Иохан 20–21)	125
28	“Бид Нар Гэрчүүд” (Үйлс 1–5)	130
29	“Шавь Нарын Тоо Өсөн Нэмэгдсэн” (Үйлс 6–9)	136
30	“Бурхан Нүүр Тал Хардаггүй” (Үйлс 10–14; 15:1–35)	141
31	“Тийнхүү Сүм Итгэл Дээр Байгуулагдсан” (Үйлс 15:36–18:22; 1 ба 2 Тесалоник)	146
32	“Сүнс Дотор Амьд Байгаа” (Үйлс 18:23–20:38; Галат)	151
33	“Та Нар Бурханы Ариун Сүм Мөн” (1 Коринт 1–6)	156
34	“Та Нарт Дамжуулж Өгсөнчлөн Ёслолуудыг Сахь” (1 Коринт 11–16)	161
35	“Бурхантай Эвлэрэгтүн” (2 Коринт)	166
36	“Гэгээнтнүүд Байхаар Дуудагдсан Бурханы Хайртай Хүмүүс” (Ром)	170
37	Есүс Христ “Бидний Итгэлийн Зохиогч Бөгөөд Төгсгөгч” (Еврей)	175
38	“Чи Намайг Гэрчилсэн” (Үйлс 21–28)	180
39	“Гэгээнтнүүдийг Төгс Төгөлдөр Болгохын Тулд” (Ефес)	185
40	“Би Христээр Дамжуулан Бүгдийг Хийж Чадна” (Филиппой; Колоссай; Филемон)	190
41	“Би Замаа Дуусгасан” (1 ба 2 Тимот; Тит)	195
42	“Цэвэр Ариун Шүтлэг” (Иаков)	199
43	“Сонгогдсон Үе Удам” (1 ба 2 Петр; Иуда)	203
44	“Бурхан Бол Хайр” (1, 2 ба 3 Иохан)	208
45	“Ялагч нь Бүх Зүйлийг Өвлөнө” (Илчлэлт 1–3; 12)	212
46	“Тэр Тэдний Дунд Нутаглаж, Тэд Түүний Ард Түмэн Болно” (Илчлэлт 5–6; 9–22)	219

Багшид Зориулсан Тусламж

Дахин амилсан Их Эзэн өөрийгөө Төлөөлөгчиддөө харуулсны дараа тэрээр Галил Нуурын дэргэд тэдэнд дахин үзэгдсэн. Тэр тэдэнтэй байхдаа Петрээс, “Чи намайг хайрладаг уу?” гэсэн асуултыг гурван удаа асуув. Асуух бүрт нь Петр “Би таныг хайрладгийг та мэднэ” гэж хариулсан. Их Эзэн Петрийг ийн мэдэгдсэний хариуд “Миний хургануудыг тэжээ. . . . Миний хонийг тэжээ. . . . Миний хонийг тэжээ” гэжээ (Иохан 21:15–17).

Сайн Мэдээний Номлолын багшийн хувьд түүний хонинуудыг тэжээж, ангийнхаа гишүүн бүрийг “Бурханы сайн үгээр тэжээгдэж, тэтгүүлж” байгаад нь санаа тавьснаараа та Их Эзэнд хайраа харуулж чадна. (Моронай 6:4-ийг үз.) Бурханы үгийн нэг чухал зорилго нь бидэнд “Есүс бол Христ, Бурханы Хүү гэдэгт бид нарыг итгүүлж, ингэснээр итгэлээр дамжуулан [бид] нар түүний нэрээр амьтай болоход” туслах явдал юм (Иохан 20 :31). Сүнсээр удирдуулан та ангийнхаа гишүүдийн Аврагчийн талаарх гэрчлэл, түүнд итгэх итгэл ба түүний сайн мэдээгээр амьдрах тэдний амлалтыг бэхжүүлэхэд туслах боломжтой болно. Мөн та Ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэнчлэн, Шинэ Гэрээг чин сэтгэлээсээ судалснаас ирдэг бусад адислалуудыг хүлээн авахад тэдэнд туслах боломжтой. Тэрээр:

“Шинэ Гэрээн дэх бүх мэдээ нь хүн төрөлхтний зүрх сэтгэлийг сэргээх сүнсийг агуулдаг. Итгэлийн туяа цөхрөлийн сүүдрийг сарниулж, уй гашуу баяр баясгалангаар солигддог бөгөөд Тэнгэрлэг Эцэг маань бид бүгдийн, хүн нэг бүрийн төлөө анхаардаг гэсэн тэр л мэдлэг олны амьдралын дунд төөрөлдсөн мэт санагдах сэтгэгдлийг маань үгүй болгодог” гэжээ (“The Spirit Giveth Life,” *Ensign*, June 1997, 2).

Сүнсээр Заах

Сайн Мэдээний Номлолын хичээлийг бэлтгэхдээ та Ариун Сүнснээс илчлэлт болон удирдамжийг эрэлхийлэх нь чухал. Их Эзэн, итгэлтэйгээр залбирснаар Сүнс танд өгөгдөх бөгөөд хэрэв та Сүнсийг хүлээн аваагүй бол зааж эс чадна гэж хэлсэн. (С ба Г 42: 14-ийг үз.) Ариун Сүнс бол танай ангийн багш гэдгийг сана.

Та залбирч, мацаг барьж, судраас өдөр болгон суралцаж, зарлигуудыг дуулгавартай дагаснаар Сүнсийг эрэлхийлж чадна. Хичээлд бэлтгэж байхдаа судрууд болон ангийн гишүүдийн хэрэгцээг ойлгохын тулд Сүнснээс тусламж авахаар залбир. Мөн Сүнс танд судруудын талаар ярилцаж, тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой арга замуудыг төлөвлөхөд тусалж чадна. (1 Нифай 19:23-г үз). Сүнсний удирдамжаар та түүний үгийг хүүхдүүдэд нь заах Их Эзэний гар дахь сайн багаж болно.

Ангидаа Сүнсийг хэрхэн урих зарим зөвлөгөөг дор өгөв:

1. Хичээлийн эхэнд болон төгсгөлд залбируулахаар ангийн гишүүдийг урь. Хичээлийн туршид Сүнс таныг удирдаж, ангийн гишүүдийн зүрх сэтгэлийг нээж, гэрчилж, сүнслэг урам хайрлахын төлөө зүрх сэтгэлдээ залбир.

2. Судруудыг ашигла. (“Судрууд дээр Төвлөрөх нь” хуудас vi-г үз)
3. Зөвхөн хичээлийн төгсгөлд биш, Сүнс танд урам өгөх бүрт гэрчлэлээ хуваалц. Есүс Христийг гэрчил. Ангийн гишүүд гэрчлэлээ хуваалцахыг байнга урь.
4. Ангийн гишүүдийн зүрх сэтгэлийг Сүнсийг мэдрэхэд бэлтгэхийн тулд дуулал, Хүүхдийн Хэсгийн дуу болон бусад нандин хөгжмүүдийг хэрэглэ.
5. Ангийн гишүүд болон бусдад, мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд хайртайгаа илэрхийл.
6. Хичээлтэй холбоотой бодол, сэтгэгдэл болон туршлагаасаа хуваалц. Ангийн гишүүдийг мөн адил урь. Ангийн гишүүд бас өнгөрсөн хичээл дээр ярилцсан зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлснээ ярьж болно.

Судрууд дээр Төвлөрөх нь

Ахлагч Бойд К.Пакэр заахдаа, “Үнэн номлолыг ойлгосноор аливаад хандах хандлага, зан чанар өөрчлөгддөг” гэсэн (Conference Report, Oct. 1986, 20; or *Ensign*, Nov. 1986, 17). Та бэлтгэж байхдаа, мөн хичээлийн явцад сударт болон хожмын үеийн бошиглогчдын номлолд заасны дагуу сайн мэдээний авралын номлолд анхаарлаа голлон хандуул. Энэ нь таныг судруудаас хичээнгүйлэн залбирч суралцахыг шаарддаг. Их Эзэн бидэнд түүний үгийг тунхаглахыг эрэлхийлэх бус, эхлээд түүний үгийг өөртөө олж авахаар эрэлхийл гэж тушаасан. Судраас суралцан түүний үгийг олж авах үед таны хэл суллагдана; тэгээд, хэрэв та хүсвэл түүний Сүнс, түүний үг, хүн төрөлхтнийг ятган үнэмшүүлэх Бурханы хүч чадлыг авах болно гэж Их Эзэн амласан. (С ба Г 11:21-ийг үз.)

Ангийн гишүүдийг долоо хоног бүр судраа авчрахад нь урамшуул. Сонгосон судрын хэсгүүдээс ярилцахдаа хамтарч унш.

Энэ гарын авлагыг ашиглах нь

Энэ гарын авлага нь танд судраас сайн мэдээний номлолыг заахад туслах хэрэгсэл юм. Энэ нь өсвөр насныхан болон насанд хүрэгсдийн Сайн Мэдээний Номлолын хичээлд зориулан бичигдсэн бөгөөд үүнийг дөрвөн жил тутамд хэрэглэнэ. Хичээлүүдийг заахад өөр нэмэлт лавлагаа болон тайлбаруудыг хэрэглэх шаардлагагүй.

Энэхүү гарын авлагын хичээлүүдэд бараг нэг хичээлийн цагт заахаас илүү мэдээлэл агуулагдсан. Ангийн гишүүдийн хэрэгцээг сайн хангах сударт өгүүлсэн зүйл, асуулт болон хичээлийн бусад материалуудыг сонгохдоо Их Эзэний Сүнсийг эрэлхийл.

Хичээл бүр дараах хэсгүүдээс бүрдсэн:

1. *Гарчиг*. Гарчиг нь хоёр хэсгээс: тайлбар бүхий товч хэллэг буюу ишлэл болон хичээлд бэлтгэхээс өмнө таны унших ёстой судраас бүрддэг.
2. *Зорилго*. Зорилгын хэсэгт хичээлийг бэлтгэж, заахдаа таны анхаарлаа төвлөрүүлэх гол үзэл санааг санал болгодог.

3. *Бэлтгэл.* Энэ хэсэг хичээлд гарах сударт өгүүлсэн зүйлийг агуулах бөгөөд таныг илүү үр дүнтэй заахад туслах зөвлөгөө өгдөг. Мөн энэ нь нэмэлт зүйл унших ба хичээлдээ авчрахыг хүссэн материал гэх мэт бэлтгэлийг хангахад зориулсан бусад санааг багтаасан.
4. *Анхаарал Татах Ажиллагаа.* Энэ хэсэг нь энгийн үйл ажиллагаа, бодит хичээл эсвэл ангийн гишүүдийг сурч мэдэж, оролцож, мөн Сүнсний нөлөөг мэдрэх зэрэгт бэлтгэхэд туслах асуултуудаас бүрддэг. Та гарын авлагын анхаарал татах ажиллагаанаас эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас ашиглах нь хамаагүй, харин хичээлийн эхэнд ангийн гишүүдийн анхаарлыг татахад голлон анхаарах нь чухал. Үйл ажиллагаа нь товч байх хэрэгтэй.
5. *Судрын ярилцлага ба Ашиглалт.* Энэ бол хичээлийн гол хэсэг юм. Сударт өгүүлсэн зүйлийг залбирч судалснаар та тэдгээрийг үр дүнтэй зааж, ярилцаж чадна. “Ангид Ярилцлага Өрнүүлэх” ба “Судруудыг Заахад Төрөл Бүрийн Арга Ашиглах нь” (хуудас viii–ix)-д өгөгдсөн зөвлөгөөг та заах арга барилаа өөрчлөхөд болон ангийн гишүүдийн сонирхлыг татахдаа хэрэглэ.
6. *Дүгнэлт.* Энэ хэсэг хичээлийг дүгнэж, таны ярилцсан зарчмуудын дагуу амьдрахад ангийн гишүүдийг урамшуулахад танд тусалдаг. Бас гэрчлэлээ хуваалцахыг танд сануулдаг. Хичээл тус бүрийг дүгнэж ярилцахад хангалттай цаг үлдээж бай.
7. *Заах нэмэлт санаанууд.* Энэ хэсэг гарын авлагын ихэнх хичээлд бий. Энэ нь сударт өгүүлсэн зүйлийн үнэнүүд, янз бүрийн заах аргууд, үйл ажиллагаанууд эсвэл хичээлийн гол санаанд нэмэлт болох бусад зөвлөгөөг багтаана. Та эдгээр санаануудын заримыг хичээлийн хэсэг болгон ашиглаж болох юм.

Хичээл тус бүрийг дор хаяж долоо хоногийн өмнөөс тоймлон үз. Та унших даалгавар болон хичээлийн материалыг урьдчилж судалбал долоо хоногийн туршид уг хичээлийг заахад туслах санаа, бодлуудыг хүлээн авах болно. Та долоо хоногийн туршид хичээлийг эргэцүүлэн бодохдоо Сүнсний удирдамжийг хайж залбир. Их Эзэн таныг адислана гэсэн итгэлтэй бай.

Ангид Ярилцлага Өрнүүлэх

Та ер нь лекц өгөх ёсгүй. Үүний оронд ангийн гишүүдийг судраас ярилцахад үнэн сэтгэлээсээ оролцоход нь тусал. Ангийн гишүүдийн оролцоо нь тэдэнд доорх байдлаар тусалдаг:

1. Судрын талаар илүү ихийг сурах.
2. Сайн мэдээний зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэхийг сурах.
3. Сайн мэдээний дагуу амьдрах илүү их эрмэлзэлтэй болох.
4. Ангид Сүнсийг урих.
5. Нэг нэгэндээ зааж, гэгээрүүл (С ба Г 88:122), ингэснээр тэд нэг нэгнийхээ авъяас билэг, мэдлэг, туршлага болон гэрчлэлээс ашиг тусыг олно.

Ангид өрнүүлэх ярилцлага нь гишүүдийг Христэд ирж, түүний шавь нарын адилаар амьдрахад туслах ёстой. Ярилцлагын сэдвийг өөрчлөх нь эдгээр зорилгод хүргэдэггүй.

Та тус гарын авлага дахь асуултуудыг судалж, алийг нь асуухаа шийдэхдээ Сүнсний удирдамжийг эрэлхийл. Гарын авлага эдгээр асуултуудын ихэнхэд нь хариулахад танд болон ангийн гишүүдэд туслах судрын ишлэлээр хангадаг. Ангийн гишүүдийн хувийн туршлага бусад асуултын хариултыг өгнө.

Ангийн гишүүдэд судрыг ойлгож, хэрэглэхэд туслах нь, бэлтгэсэн хичээлийнхээ бүх зүйлийг заахаас илүү чухал. Хэрэв гишүүд сайн ярилцсаны үр дүнд сурч авч байвал хичээлийнхээ бүх материалыг заахыг хичээснээс үүнийгээ үргэлжлүүлэх нь тустай байдаг.

Дараах зааврыг ангид ярилцлага өрнүүлэхдээ хэрэглэ:

1. “Тийм” эсвэл “Үгүй” гэж хариулахаас илүү бодол санаагаа хуваалцаж, ярилцах шаардлагатай асуулт тавь. *Яагаад, хэрхэн, хэн, юу, хэзээ* болон *хаана* гэж эхэлсэн асуултууд ер нь ярилцлага өрнүүлэхэд илүү үр дүнтэй байдаг.
2. Ангийн гишүүдийг судрын зарчмууд болон номлолуудыг хэрхэн амьдралд хэрэгжүүлж болохыг харуулсан туршлагаасаа хуваалцахад нь урамшуул. Мөн тэд судраас юу сурсан талаарх сэтгэгдлээ хуваалцахыг урамшуул. Тэдний хийснийг магтаж сайшаа.
3. Ангийн гишүүн бүрийн хэрэгцээг ойлгож ханд. Хэдийгээр ангийн бүх гишүүдийг ярилцлаганд оролцохыг урих ёстой ч зарим нь хариулт өгөхөөс зайлсхийж магад. Та тэднээс хичээл дээр чанга унших эсвэл оролцох нь ямар санагддагийг олж мэдэхийн тулд тэдэнтэй аминчлан ярилцаж болох юм. Хэрэв тэднийг ичээж болох бол ангийн гишүүдийг дуудахгүй байхад анхаар.
4. Ангийн гишүүдэд зарим асуултуудын хариултыг олоход туслах судрын ишлэлийг өг.

Судруудыг Заахад

Төрөл Бүрийн

Арга Ашиглах нь

Дараах зөвлөгөөг сударт өгүүлсэн зүйлсийг илүү үр дүнтэй, илүү олон замаар заахын тулд хэрэглэ:

1. Сударт Есүс Христийн талаар юу заадгийг ангийн гишүүдийг ойлгоход тусал. Аврагчид итгэх тэдний итгэлийг судрын тодорхой нэг хэсэг хэрхэн нэмэгдүүлж, түүний хайрыг мэдрэхэд тэдэнд хэрхэн тусалдгийг бодож үзэхийг тэднээс хүс.
2. Судрын хэсгээс амьдралдаа хэрэгжүүлж болох тусгай арга замын талаар бодож, түүнийгээ хуваалцахыг ангийн гишүүдээс хүс. Сонгосон судрын хэсэгт нь тэдний өөрсдийн нэрийг орлуулж бодуулан судруудыг өөрийн болгуул.
3. Сургаал номлолыг заахын зэрэгцээгээр ангийн гишүүдийг ойлгож байгааг бататган Шинэ Гэрээн дэх итгэл өдөөх түүхийг онцлон тэмдэглэж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замын талаар ярилц.

4. Судрын хэсэгт байн байн давтагдсан эсвэл онцгой утга учир бүхий үгс, өгүүлбэрүүд, санаануудыг олохыг ангийн гишүүдээс хүс.
5. Сударт өгүүлсэн зүйлтэй холбоотой өгүүлбэр, түлхүүр үгс эсвэл асуултуудыг самбарт бич. Тэгээд сударт өгүүлсэн зүйлийг унш эсвэл дүгнэ. Ангийн гишүүд тухайн өгүүлбэр, түлхүүр үгс болон асуултын хариуг сонсох үед зогсож, тэдгээрийн талаар ярилц.
6. Мормоны Номд заагдсан зарчмуудыг дүгнэж танилцуулахдаа “иймээс бид харвал” гэсэн хэллэгийг үргэлж хэрэглэдэг (жишээ нь Хиламан 3:28-ыг үз). Судрын хэсгийг ярилцсаны дараа “иймээс бид харвал” гэсэн хэллэгийг хэрэглэж хэсэг дэх зарчмыг тайлбарлахыг ангийн гишүүдээс хүс.
7. Шинэ Гэрээнд хэрэглэдэг бэлэг тэмдгийг олж, ярилц. Жишээ нь Шинэ Хүргэн болон шинэ бэр нь Аврагч, түүний хүмүүсийг төлөөлдөг.
8. Судар дахь хүмүүс болон үйл явдлуудыг өөр хооронд нь хэрхэн зүйрлүүлж болохыг тэмдэглэ.
9. Ангийн гишүүдээр түүхэнд гарч буй янз бүрийн хүмүүсийн үгийг чангаар уншуулан судрын түүхийг жүжигчлэн тоглуул. Жүжигчилсэн тоглолт нь судруудыг хүндэтгэж буйг бататгаж үз.
10. Ангийг хоёр буюу олон жижиг бүлэг болгон хуваа. Сударт өгүүлсэн зүйлийг тоймлон үзсэний дараа бүлэг тус бүрээр уг мэдээлэлд заасан номлол болон зарчмуудыг бичүүл. Дараа нь эдгээр сургаалуудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бүлгүүдээр ээлжлүүлэн яриул.
11. Эдгээрийг ярилцах үед чухал шүлгүүдийг тэмдэглэж авах харандаа авчрахыг ангийн гишүүдээс хүс.

Шинэ Гишүүдэд Туслах нь

Сайн Мэдээний Номлолын багшийн хувьд та Сүмийн шинэхэн гишүүдэд заах боломжтой байж болно. Таны заасан зүйл шинэ гишүүдийг бат итгэлтэй болоход нь тусалж чадна.

Тэргүүн Зөвлөлөөс хэлэхдээ, “Сүмийн гишүүн бүр, ялангуяа усан баталгааны дараах хэдэн сард хайрлуулж, тэтгэгдэх хэрэгтэй байдаг. Шинэ гишүүд чин сэтгэлийн нөхөрлөлийг олж авч, үйлчлэх боломжтой байж, Бурханы үгнээс суралцсанаар олж авах сүнслэг тэжээлийг хүртэхдээ тэд удаан үргэлжлэх өөрчлөлтийг мэдэрч, “гэгээнтнүүдийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх” (Ефес 2:19) болдог” гэсэн. (First Presidency letter, 15 May 1997).

Өсвөр Насныханд Сайн Мэдээг Заах нь

Хэрэв та өсвөр насныханд зааж байгаа бол тэднийг голдуу идэвхтэй оролцуулж, ярилцаж буй сургаал номлолын үзүүлэн таниулах зүйл хэрэглэж заах хэрэгтэй гэдгийг сана. Дүрс бичлэг, зураг болон гарын авлагад санал болгосон үйл ажиллагааг ашиглах нь өсвөр насныхныг хичээлдээ сонирхолтой байхад тусална. Өсвөр насныханд сайн мэдээг заахад туслах бусад санаануудыг *Заах Удирдамж* (34595)-аас авч болно.

“Есүс Бол Христ Гэдэгт Та Итгэх Болно”

Хичээл

1

Исаиа 61:1–3; Joseph Smith Translation, Luke 3:4–11; John 1:1–14, 20:31

Зорилго Ангийн гишүүдийг Шинэ Гэрээнээс суралцсанаар Есүс Христэд итгэх итгэлээ батжуулахад уриалах.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Исаиа 61:1–3; Joseph Smith Translation, Luke 3:4–11. Исаиа, Баптисм хүртээгч Иохан нар Аврагчийн номлолын талаар зөгнөдөг.
 - б. Иохан 1:1–14; 20:31 Төлөөлөгч Иохан Есүс Христ бол “жинхэнэ Гэрэл” хэмээн гэрчилсэн. Тэрээр гэрчлэлээ бичиж байгаагийн зорилго нь бусдыг “Есүс бол Христ гэдэгт итгэхэд” туслах явдал мөн гэж тунхагласан.
 2. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл ангийн хэдэн гишүүнээс Шинэ Гэрээн дэх хамгийн дуртай хэсгээ унших эсвэл дүгнэж хэлэхэд бэлтгэж, энэ хэсэг тэдэнд яагаад урам хайрладаг болон тустай байдгийг товч тайлбарлахыг хүс.
 3. Хэрэв дараах зургууд байгаа бол тэдгээрийг хичээлд ашигла: Исаиа Христийн Мэндлэх Тухай Бичсэн нь (62339; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 113) болон Иохан Цөлд Номлосон нь (62132; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 207). Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл Есүс Хараагүй Хүнийг Эдгээсэн нь (62142; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 213) болон Мариа ба Дахин Амилсан Их Эзэн (62186; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 233) зэрэг Шинэ Гэрээн дэх үйл явдлуудыг харуулсан хэдэн зурагнуудыг мөн авчир.
 4. Заахад зориулсан зөвлөмж: Ангийн гишүүдэд даалгаж өгсөн унших зүйлсийг долоо хоног бүр уншиж, уншсанаа ярилцахаар бэлтгэн ирэхийг уриал. Ингэж бэлтгэх нь номлож байгаа, номлолыг сонсож байгаа хүн хоёр үнэний Сүнсээр дамжуулан нэг нэгнийгээ ойлгож, хоёул гэгээрч, хамтдаа баярлан баясдаг гэсэн Их Эзэний амлалтыг биеллээ олоход тусална. (С ба Г 50:22-ыг үз.)

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Шинэ Гэрээн дэх үйл явдлуудыг харуулсан зургийг үзүүл.

Ангийн гишүүдээс дараах асуултын талаар бодохыг хүс:

- Шинэ Гэрээн дэх ямар үйл явдал эсвэл сургаал танд чухам урам хайрлаж, тусалсан бэ?

Ангийн гишүүдэд бодох хугацаа өгөөд, урьдчилан товлосон ангийн гишүүдийг Шинэ Гэрээний дуртай хэсгээ уншихыг эсвэл дүгнэж хэлэхийг хүс. Хэрэв ангийн бусад гишүүд дуртай хэсгээ хуваалцахыг хүсвэл хэдэн хүнийг хуваалцахыг зөвшөөр.

Энэ жил Шинэ Гэрээнээс зааж, суралцах боломжтой болсон талаарх өөрийн сэтгэгдлээ илэрхийл. Энэ жил Шинэ Гэрээнээс суралцах зорилго нь ангийн гишүүдийг Есүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлж, түүний амьдрал болон номлолтой илүү сайн танилцахад туслах явдал юм гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Исаиа, Баптисм хүртээгч Иохан нар Аврагчийн номлолын талаар зөгнөдөг.

Исаиа 61:1–3 ба Joseph Smith Translation, Luke 3:4–11-ийг уншаад ярилц.

Исаиа Аврагчийг мэндлэх тухай бичиж байгаа зургийг үзүүл. Бид Аврагчийн номлолын тухай зөгнөсөн Исаиа болон бусад хүмүүсийн үгсээс суралцсанаар Есүс Христийн тухай гэрчлэл, Шинэ Гэрээнд талархах талархлаа батжуулж чадна гэдгийг тайлбарла.

- Исаиа 61:1–2-г Аврагчийн номлолын ямар талуудыг нь дүрслэгдсэн бэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбарт жагсааж бич. Хариултанд дор дурьдсан зүйлс багтаж болно.)

- а. “Зовогсдод сайн мэдээг номлох” (шүлэг 1).
- б. “Шаналсан зүрх сэтгэлтэй хүмүүсийг эдгээх” (шүлэг 1).
- в. “Олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах” (шүлэг 1).
- г. “Бүх гашуудагсдыг тайвшруулах” (шүлэг 2).

- Эдгээр зөгнөлүүдийг Есүс хэрхэн биелүүлсэн бэ? (Ангийн гишүүдийг судраас жишээ татаж, хувийн туршлагаасаа хуваалцахыг уриал.)

Есүс өөрийн үйлчлэлийнхээ эхэнд тэрээр Мессиа мөн хэмээн тунхаглах гэж энэ хэсгийг иш татсан болохыг цохон тэмдэглэ. (Лук 4:16–21; 6-р хичээлийг үз.)

Баптисм хүртээгч Иохан цөлд номлосон нь зургийг үзүүл. Есүс өөрийн мөнх бус үйлчлэлээ эхлэхийн өмнөхөн Баптисм хүртээгч Иохан Аврагчийн номлолыг зөгнөсөн гэдгийг тайлбарла.

- Баптисм хүртээгч Иохан Аврагчийн номлолыг хэрхэн дүрсэлсэн бэ? (Joseph Smith Translation, Luke 3:4–9-г үз. Ангийн гишүүдийн хариултыг самбарт жагсааж бич. Иосеф Смитийн Орчуулгын эдгээр шүлгүүд байхгүй бол дор дурьдсан зөгнөлийг жагсааж бич.)
 - а. “Дэлхийн нүглийг зайлуулна” (шүлэг 5).
 - б. “Буруу номтон үндэстэнд авралыг авчирна” (шүлэг 5).
 - в. “Алдагдсан тэр хүмүүсийг цуглуулна” (шүлэг 5).
 - г. “Харийнханд сайн мэдээг номлох боломжтой болгоно” (шүлэг 6).
 - д. “Харанхуйд суутч бүгдэд гэрэл болно” (шүлэг 7).
 - е. “Үхлээс дахин амилалтыг авчирна” (шүлэг 7).

ж. “Бүгдийг үнэнч шударгаар удирдана” (шүлэг 9).

з. “Бурханлаг бус зүйл хийгсдэд бурханлаг бус үйлдлийг нь ухааруулна” (шүлэг 9)

- Эдгээр зөгнөлүүдийг Есүс хэрхэн биелүүлсэн бэ? (Ангийн гишүүдийг судраас жишээ татаж, хувийн туршлагаасаа хуваалцахыг уриал.)
- Есүсийн бидний төлөө хийсэн зүйлүүдийн талаар бодохдоо та нар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ? Хэрэв Есүс бидний төлөө эдгээр зүйлүүдийг хийгээгүй бол бидний амьдрал ямар байх байсан бэ?

2. Төлөөлөгч Иохан Есүс Христ Бол “Жинхэнэ Гэрэл” Хэмээн Гэрчилсэн

Иохан 1:1–14; 20:31-ийг уншаад ярилц.

- Иохан 1:1–3; 14-өөс Есүс Христийн талаар бид юу сурч болох вэ? (Дор дурьдсан жагсаалтыг үз. Иохан 1:1; 14 дэх “Үг” гэдэг нь Аврагчийг хэлж байгааг тайлбарла.)
 - а. Тэр “эхэнд нь” Бурхан Эцэгтэй хамт байсан (Иохан 1:1–2). Аврагчийн номлол түүнийг Бетлехемд төрөхөөс бүр өмнө мөнх бус амьдралын өмнөх дэлхийд эхэлсэн гэдгийг тайлбарла.
 - б. Тэр бол Бурхан (Иохан 1:1). Бид Бурханы тухай ярихдаа ихэвчлэн Тэнгэрлэг Эцэгийн тухай ярьдаг гэдгийг тайлбарла. Хэдий тийм ч, Хуучин Гэрээнд Жэхова хэмээгддэг хүн нь . . . Есүс Христ хэмээгддэг . . . Хүү нь . . . мөн Бурхан юм. Есүс Эцэгийн удирдлаган дор ажилладаг. . . . Сударт гардаг Бурханаар хийгдсэн гэсэн олон зүйлүүдийг үнэндээ Есүс хийсэн (Bible Dictionary, “God”, 681).
 - в. Мөнх бус амьдралын өмнөх дэлхийд тэрээр сайн мэдээг номлосон (Joseph Smith Translation, John 1:1).
 - г. Тэр бүх зүйлийг хийсэн. (Иохан 1:3).
 - д. Тэр бол Бурханы Заяасан Ганц махбодтой Хүү юм (Иохан 1:14; мөн 1 Нифай 11:14–21-ийг үз). Энэ номлолыг 2-р хичээлд ярилцана.
- Төлөөлөгч Иохан хэлэхдээ “[Есүст] амь байсан” гэсэн (Иохан 1:4). Мөн тэрээр Есүс бол “Ертөнцөд ирэх хүн бүрийг гэгээрүүлдэг жинхэнэ Гэрэл” гэж гэрчилсэн (Иохан 1:9). Аврагч танд хэрхэн амьдрал болон гэрлийг өгсөн бэ? (Ангийн гишүүдийг энэ асуултын тухай ярилцах хооронд та Иохан 8:12; 1 Коринт 15:20–22; Моронай 7:15–18; 41; С ба Г 88:6–14-ийг дурьдаж болно.)
- Иохан ямар зорилгоор гэрчлэлээ бичсэн бэ? (Иохан 20: 31-ийг үз). “Есүс бол Христ гэдэгт итгэх” нь юу гэсэн үг вэ? (*Христ* гэдэг нь тослуулсан хэмээх Грек үг гэдгийг тайлбарла. Бид Есүс бол Христ гэсэн гэрчлэлтэй болохдоо тэр бол Бурханы Хүү бөгөөд бидний Аврагч болохоор урьдчилан томилогдсон ба тослуулсан гэдгийг бид мэдэж авдаг.) Энэ жил Ням Гарагийн Хичээл дээр Шинэ Гэрээнээс суралцах нь Есүс бол Христ мөн гэсэн таны гэрчлэлийг бэхжүүлэхэд хэрхэн туслах вэ?
- Шинэ Гэрээнээс суралцахдаа Сүнсээр удирдуулахын тулд бид хувиараа болон ангиараа юу хийж болох вэ? (Иаков 1:5–6; С ба Г 50:17–22; 88:118).
- Хэдийгээр бид Аврагчийн мөнх бус үйлчлэлийн үед дэлхий дээр байгаагүй ч Иохан 1:10–14 дэх үгс бидэнд хэрхэн хамаарах вэ?

Ахлагч Томас С.Монсон заахдаа:

“Бид түүнтэй ойрхон байхыг мэдрэхийн тулд Ариун Газарт очих хэрэггүй. Бид Есүсийн алхсан Галилын эрэг эсвэл Иудейн толгод дээгүүр явах хэрэггүй.

“Үнэндээ бол бид мөнх бус амьдралд амьдрахдаа уруул дахь түүний үгс, зүрх сэтгэлдээ байгаа түүний сүнс, бидний амьдралд өгсөн түүний сургаалуудаар дамжуулж Есүсийн алхсан газраар бид бүгд алхаж чадна”, гэсэн (Conference Report, Apr. 1974, 10; or *Ensign*, May 1974, 48).

Дүгнэлт

Есүс Христийг гэрчилж, Шинэ Гэрээнээс суралцсанаар түүний тухай сурч байгаа талаарх сэтгэгдлээ илэрхийл.

Шинэ Гэрээнээс суралцахдаа Сүнсний удирдамжийг эрэлхийлж, мөн ангийн ярилцлаганд оролцсоноор Аврагчийн тухай тэдний гэрчлэл өснө гэдгийг ангийн гишүүдэд батлан хэл.

Заах Нэмэлт

Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Шинэ Гэрээний Ерөнхий Утга

Ангийн гишүүдийг Библийн Гарчгийн хуудсыг нээж, Шинэ Гэрээний 27 номны нэрийг тоймлон үзэхийг хүс. Шинэ Гэрээг дөрвөн хэсэг болгон хувааж болно гэдгийг тайлбарла. (Та эдгээрийг самбарт жагсааж бичиж болно.)

- а. Есүс Христийн амьдрал, номлол болон сургаалуудын гэрч ба бичээс болох сайн мэдээнүүд (Матай, Марк, Лук ба Иохан)
- б. Есүсийн үхэл, Дахин Амилалтын дараах Төлөөлөгчдийн үйлчлэлийн тухай мэдээлэл болох Үйлсийн Ном. Энэ номонд Еврейчүүдийн дунд хийсэн Петрийн ажил, Харийнхны дунд хийсэн Паулын ажлыг тусгасан байдаг.
- в. Паул болон Сүмийн бусад удирдагчдын илгээлт (захиа) нь тэр үеийн Гэгээнтнүүдийг удирдаж, гэгээрүүлэхийн тулд бичигдсэн.
- г. Патм хэмээх арал дээр Төлөөлөгч Иоханд Их Эзэний өгсөн илчлэлт.

2. Дүрс Бичлэг

New Testament Video Presentations (53914) байгаа бол та “The Message of the New Testament” гэсэн хоёр минутын бичлэгийн хэсгийг үзүүлж болно.

3. “Тэр . . . өнөөх Гэрлийн тухай гэрчлэхээр иржээ” (Иохан 1:8)

Ангийн гишүүдээр Иохан 1:6–8-ыг уншуул.

- Эдгээр шүлэгт хэний тухай дурьдсан бэ? (Баптисм хүртээгч Иохан.) Түүний номлол юу байсан бэ? (Иохан 1:8-ыг үз.) Бид хэрхэн Иохан шиг “өнөөх Гэрлийн тухай гэрчилж” чадах вэ?

“Сэтгэл Минь Их Эзэнийг Дээдэлнэ”

Хичээл
2

Лук 1; Матай 1

Зорилго Елизабет, Захариа, Баптисм хүртээгч Иохан, Мариа, Иосеф нарын амьдралыг судалснаар Есүс Христэд итгэх агуу итгэлийг хөгжүүлэхэд ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Лук 1:5–25, 57–80. Тэнгэр элч Габриел Захариа дээр ирээд залбирлын хариуд Захариагийн эхнэр Елизабет хүү төрүүлнэ гэжээ. Энэ хүүг Иохан гэж нэрлэх бөгөөд Их Эзэнийг хүлээн авахад хүмүүсийг бэлтгэнэ. Захариа Габриелын үгэнд эргэлзсэн бөгөөд хэлгүй болсон. Елизабет өндөр настайдаа жирэмсэлж Иоханыг төрүүлэв. Захариа Иоханы номлолын талаар зөгнөснөөрөө итгэлээ дахин сэргээснээ харуулсан.
 - б. Лук 1:26–56; Матай 1:18–25. Тэнгэр элч Габриел Мариад Бурханы Хүүгийн эх нь болно гэж хэлдэг. Мариа, түүний үеэл Елизабет хоёр Аврагчийг ирэх тухай мэдээнд бахдан баярладаг. Мариа Аврагчийг төрүүлнэ гэдгийг Иосеф мэддэг.
2. Хэрэв дараах зургууд байгаа бол тэдгээрийг хичээлд ашигла: Иохан Цөлд Номлосон нь (62132; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 207), Мэдээлэл: Сахиулсан Тэнгэр Габриел Мариа Дээр Ирсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 241).
3. Заахад зориулсан зөвлөмж: Хүн Ариун Сүнсний хүчээр заах үед Ариун Сүнсний хүч хүмүүсийн зүрх сэтгэлд мэдээг хүргэдэг. (2 Нифай 33:1-ийг үз.) Ариун Сүнсний нөлөөг мэдрэх нь ангийн гишүүдийн гэрчлэл, Их Эзэн болон нэг нэгнийгээ хайрлах хайрыг нь мөн зөв шударгаар амьдрах амлалтуудыг бэхжүүлдэг. Хичээл бүр дээр Сүнсийг урихын тулд та юу хийж болох талаар залбирч, бодож үз. (Энэ гарын авлагын v–vi-р хуудсыг үз.)

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүдэд дараах асуултуудыг тавь:

- Хэрэв та нар Шинэ Гэрээнд гардаг хүмүүсээс, Есүсээс гадна хэн нэгэнтэй нь уулзаж болбол хэнтэй уулзахыг хүсэж байна вэ? Та нар яагаад тэр хүнтэй уулзахыг хүсэж байна бэ?

Ангийн хэдэн гишүүнийг асуултанд хариулсны дараа, Аврагчийг дагаж, түүнийг гэрчилдэг учраас бид үргэлж зөв шударга хүмүүст татагддаг гэдгийг тайлбарла. Бид эдгээр хүмүүстэй илүү сайн танил болох тусмаа мөн Есүс Христтэй илүү сайн танилууд болдог. Энэ хичээлд зөв шударга үлгэр жишээ нь биднийг түүнд улам ойр болгодог зарим хүмүүсийн талаар ярилцана.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал. Хичээлийн асуулт бүрийг тавьж эсвэл санаа болгоныг ярилцах нь хэцүү тул ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх хэсгийг залбирч сонго.

1. Елизабет, Захариа хоёрт Баптисм хүртээгч Иохан Заяажээ.

Лук 1:5–25, 57–80-ыг ярилц. Сонгосон шүлгийг чангаар уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Сударт Елизабет, Захариа нарыг хэрхэн дүрсэлсэн байдаг вэ? (Лук 1:6–9-ийг үз.)
- Елизабет, Захариа хоёр ямар адислалын төлөө залбирсан бэ? (Лук 1:7, 13). Энэ залбирлын хариу хэрхэн ирсэн бэ? (Лук 1:11–13, 24–25. Елизабет, Захариа хоёр хүүхэдтэй болж адислуулаасай гэж магад олон жил залбирсан гэдгийг цохон тэмдэглэ. Хэдий тийм ч өөрийн зорилгоо бүтээх зөв цагийг иртэл Тэнгэрлэг Эцэг тэдэнд энэ адислалыг өгөөгүй.) Чин сэтгэлийн залбирлын маань хариу бидний хүссэнээр тэр дороо ирэхгүй үед бид хэрхэн итгэлтэй байж, шантрахгүй байж чадах вэ?
- Иоханы номлолын талаар Габриел юу гэж зөгнөсөн бэ? (Лук 1:14–17-г үз. Иохан цөлд номлож байгаа зургийг үзүүлж, Габриелын зөгнөлийг дүгнэж ярилцаад, самбарт бич. Зөгнөлүүд нь ямар утгатай, тэдгээрийг Иохан хэрхэн биелүүлсэн болон ийм зүйлд бид хэрхэн Иоханы жишээг дагаж болох талаар ярилц.)
 - а. Иохан “[олон хүмүүсийг] Бурхан Их Эзэнд нь эргүүлэн хандуулах” болно (Лук 1:16).
 - б. Тэрээр “эцгүүдийнх нь зүрхийг хүүхдүүд уруу нь хандуулах” болно (Лук 1:17).
 - в. Тэрээр “дуулгаваргүй нэгнийг зөвт хүмүүсийн мэргэн ухаанд . . . буцаах” болно. (Лук 1:17).
 - г. Тэрээр “Их Эзэний төлөө бэлтгэгдсэн хүмүүсийг бэлэн болгоно” (Лук 1:17).

Тайлбар: Баптисм хүртээгч Иохан бол “бүх л түүхэнд шилдэг Аароны Пристийн Зэрэгтэн” байсан (Bible Dictionary, “John the Baptist,” 714). Иоханы номлолын талаар дээр дурьдсан зүйлүүдийг Аароны Пристийн Зэрэгтний ангийн гишүүдэд хэрхэн хамаатай болохыг та ярилцаж болно.

- Тэнгэр элчийн хэлсэн үгэнд эргэлзсэнээр Захариад юу тохиолдсон бэ? (Лук 1:18–20-ийг үз.) Иоханыг мэдэлсний дараа Захариагийн итгэл дахин сэргэснийг түүний үйлдлүүд хэрхэн харуулсан бэ? (Лук 1: 59–63-г үз. Елизабет тэр хоёр хүүгээ Иохан гэж нэрлэснээр нутгийн уламжлалыг дагахаасаа илүүтэй Бурханы зарлигийг дагасан.)
- Захариа хүүгийнхээ номлолын талаар зөгнөхдөө тэрээр бас гэтэлгэл, аврал нүглээс ангижрах, өршөөл нигүүсэл болон гэрлийн талаар ярьсан (Лук 1:68–79). Тэрээр эдгээрийг ярихдаа хэний талаар өгүүлж байсан бэ? (Есүс Христ.) Ангийн гишүүнийг Иохан 1:6–9-ийг уншихыг хүс. Баптисм хүртээгч Иохан шиг бид бусдыг Христ рүү ирэхэд туслахад өөрсдийн үйлчлэлээ чиглүүлэх ёстой гэдгийг гэрчил.

- Иохан төрснийхөө дараа тэрээр өсч, “сүнсээр хүчирхэг болсон” (Лук 1:80). Иохан үүргээ биелүүлэх боломжтой болохын тулд яагаад сүнсээр хүчирхэг болох хэрэгтэй байсан гэж та нар бодож байна вэ? Сүнсээр хүчирхэг болохын тулд бид юу хийж чадах вэ?

2. Мариа Бурханы Хүүгийн Эх Болно Гэдгийг Мариа, Иосеф Хоёр Мэдэв.

Лук 1:26–56, Матай 1:18–25-аас сонгосон шүлгийг уншаад ярилц. Мэдээлэл: Сахиулсан Тэнгэр Габриел Мариа Дээр Ирсэн нь зургийг үзүүл.

- Мариа Тэнгэр элч Габриелээс юу мэдэж авсан бэ? (Лук 1:26–33-ыг үз.) Аврагч яагаад мөнх бус эх, мөнх Эцэгийн хүү байх хэрэгтэй байсан бэ?

Есүс Христийн тухайд, Ахлагч Брүс Р.МакКонки заахдаа:

“Бурхан түүний Эцэг байсан бөгөөд энэ мөнх Их Хүнээс . . . тэрээр үүрд амьдрах хүч болох үхэшгүй байдлын хүчийг өвлөсөн буюу үхэхийг сонгосон нь үхэшгүй байдалд дахин амилах хүчийг, хожим нь дахин ялзралыг үзэлгүй үүрд амьдрах явдал юм. . . .

“Мариа түүний эх байсан бөгөөд тэрхүү мөнх бус эмэгтэйдээс . . . үхэх хүч болох мөнх бус байдлын хүчийг өвлөсөн. . . .

“Иймээс . . . нэг хүнд тэнгэрлэг болон мөнх бус шинж хосолж, бидний Их Эзэн төгсгөлгүй болон мөнхийн цагаатгалыг гүйцэтгэх боломжтой болсон. Эцэг нь Бурхан, Мариа эх нь байсан учраас түүнд амьдрах эсвэл үхэх хүч байсан, тэрээр өөрөө сонгож, амиа өгснөөрөө үүнийг буцааж авах хүчийг олж, улмаар бидэнд үл ойлгогдох замаар тэрхүү дахин амилалтын үр нөлөөг бүх хүмүүст дамжуулж, ингэснээр бүгд үхлээс амилах болно” (*The Promised Messiah* [1978], 470–71).

- Тэнгэр элч, Елизабет хоёртой ярьсан ярианаас нь бид Мариагийн талаар юу мэдэж болох вэ? (Лук 1:26–38; 45–49-ийг үз Мөн Алма 7:10-ыг үз.) Ангийн гишүүдийн хариултыг дүгнэж самбарт бич. Та өсвөр насныханд зааж байгаа бол Мариаг зөв шударга залуу эмэгтэйн жишээ гэж үзэхийг тэдэнд зөвлөж болно.)
 - а. Мариа Бурханы ивээлийг олсон (Лук 1:28, 30). Бурханы ивээлийг олно гэж юу гэсэн үг вэ? Зарим хүмүүс бусад ямар замаар ивээл хүртэхийг эрэлхийлдэг вэ? Эдгээр бусад арга замаар ивээл хүртэхийг хайх нь хэрхэн Бурханы ивээлийг олоход хэцүү болгох вэ?
 - б. Мариа Их Эзэнийг өөртэйгөө хамт байлгах зохистой байсан (Лук 1:28). Энэ адислалыг хүртэх зохистой байхын тулд бид юу хийж болох вэ?
 - в. Мариа Их Эзэний хүсэлд даруу бөгөөд дуулгавартай хандсан (Лук 1:38, 48). Их Эзэний хүсэлд нийцүүлэх нь бидэнд яагаад чухал вэ? Бид хэрхэн илүү даруу, дуулгавартай болж чадах вэ?
 - г. Мариа Аврагчийн төлөө баяртай байсан (Лук 1:47). Бид Аврагчийн төлөө хэрхэн талархан баярлаж болох вэ?
- Мариаг айлчлан ирэхэд Елизабет болон түүний төрөөгүй хүү яагаад баярласан бэ? (Лук 1:39–44-ийг үз. Мөн Лук 1:5-ыг үз. Ариун Сүнсний гол үүргүүдийн нэг нь Есүс Христийг гэрчлэх явдал юм гэдгийг цохон тэмдэглэ.) Боломжтой бол Есүс Христийн талаарх гэрчлэлээ олж авахад Ариун Сүнс танд хэрхэн тусалсан тухай ярьж, мөн бусдыг ийн ярихыг хүс.

- Мариаг хайрлах Иосефийн хайрыг хэрхэн шалгасан бэ? (Матай 1:18-ыг үз). Мариаг хүүхэдтэй болсон гэдгийг мэдээд Иосеф яасан бэ? (Матай 1:19-ийг үз. Хуулийн дагуу бол Иосеф гэрлэлтийн гэрээг зөрчсөнийх нь төлөө Мариаг буруутгаж, түүнийг олон нийтийн шүүхэд өгч болох байсан гэдгийг цохон тэмдэглэ. Тийм шүүх үхэх ял оноож болох байсан. Үүний оронд тэрээр гэрлэлтийн гэрээгээ түүнээс нууцаар цуцлахаар шийдсэн.)
- Мариагийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч, мөн өөрийнхөө үүрэг хариуцлагад бэлтгэхэд Тэнгэрлэг Эцэг Иосефт хэрхэн тусалсан бэ? (Матай 1:20–23). Энэ зүүдний хариуд Иосеф юу хийсэн бэ? (Матай 1:24–25.) Энэ хариу түүний зан төрхийн талаар юуг илчилдэг вэ?

Дүгнэлт

Ангийн гишүүнийг Лук 1:46-г уншихыг хүс. Энэ шүлэгт байгаа *дээдэлнэ* гэсэн үг нь Их Эзэнийг магтан дуулж, түүний алдар цууг харахад бусдад туслах Мариагийн зүтгэл чармайлтыг илэрхийлж байгаа юм.

- Елизабет, Захариа, Баптисм хүртээгч Иохан, Мариа, Иосеф нарын үлгэр жишээ нь Аврагчийн алдар цууг харж, түүнд итгэх итгэлээ нэмэгдүүлэхэд танд яаж тусалдаг вэ? Бид бусдыг Есүс Христэд итгэл итгэлээ нэмэгдүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ?

Елизабет, Захариа, Баптисм хүртээгч Иохан, Мариа, Иосеф нарын зөв шударга үлгэр жишээний төлөө талархлаа илэрхийл. Ярилцсан үнэнийхээ талаар гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Тэдгээр Зүйлсийн Талаарх Гарцаагүй Үнэнийг Танд Таниулахын Тулд”

- Лук өөрийн гэрчлэлээ Теофил гэдэг хүнд хандан хэлсэн (Лук 1:3). Лукийн гэрчлэлээ бичсэн зорилго нь юу байсан бэ? (Лук 1:3–4-ийг үз. Өмнө нь заасан зүйлсийн гарцаагүй үнэнийг ойлгоход Теофилд туслах гэж). Таны урьд нь сонссон номлол болон сайн мэддэг судрын хэсгийг бусад хүмүүсээс сонсоод та хэрхэн урам зориг ордог вэ?

“Аврагч . . . Та Нарын Төлөө Мэндэллээ”

Хичээл
3

Лук 2; Матай 2

Зорилго Ангийн гишүүдийг Есүс Христийг мэндэлсэнд баярлан талархаж, залуу насандаа түүний “бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олсон” үлгэр жишээг дагахад уриалах.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Лук 2:1–7. Есүс Христ мэндэллээ.
 - б. Лук 2:8–39. Есүсийг мэндэлсэнд тэнгэрийн элч нар болон бусад олон хүмүүс баяр хөөр болсон.
 - в. Матай 2. Дорно зүгийн зурхайчид Есүс дээр айлчлан ирж бэлэг өгдөг. Херод, Иудейчүүдийн Хаан мэндэлсэнд бачимдан, Бетлехем болон түүний ойр орчимд байгаа хоёр болоод түүнээс доош насны бүх хүүхдүүдийг хөнөөлгөхөөр хүн явуулав. Их Эзэний тэнгэр элч Мариа, Есүс хоёрыг аваад Египет рүү зугт хожим тэдэнтэй Израилд буцаж ир гэж Иосефийг удирддаг.
 - г. Лук 2:40–52. Эцэгээрээ удирдуулан, Есүс өсч том болж, бага залуудаа өөрийн үйлчлэлд бэлтгэгддэг.
 2. Нэмэлт Уншлага: Joseph Smith Translation, Matthew 3:24–26; 1 Нифай 11:1–23; Хиламан 14:1–8; 3 Нифай 1:4–21; 27:13–16; Сургаал ба Гэрээ 93:11–20.
 3. Дараах материалууд байгаа бол заримаас нь хичээлдээ хэрэглэ:
 - а. *New Testament Video Presentations* (53914)-ээс “Лук II” зургаан минутын бичлэг.
 - б. Дэн Буудалд Өрөө Байхгүйг дүрсэлсэн зурагнууд (62115); Есүс Мэндэлсэн нь (62116; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 200); Есүс Мэндэлсэн нь (62495; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 201); Хоньчдод Христийн Мэндэлснийг Тунхагласан нь (62117; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 202); Мэргэд, Зурхайчид (62120; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 203); Египет рүү Зугтсан нь (62119; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 204); Есүс Хүү Ариун Сүмд (62500; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 205); Есүс Христийн хүүхэд Нас (62124; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 206) болон Есүс ба Түүний Эх (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 242)
 4. Заахад зориулсан зөвлөмж: Сүнснийг урихын тулд тохирох зураг болон дүрс бичлэгийг ашигла, хичээлд олон янзын арга барил хэрэглэж, ярилцаж байгаа судрын утгыг санахад ангийн гишүүдэд тусал.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Дараах хүмүүсийг самбарт жагсааж бич: *хоньчин, Симеон, дорно зүгээс ирсэн зурхайч, Херод, дэн буудлын хүн, Анна, тэнгэр элч, Мариа.*

Есүс Христийг мэндэлсний хариуд хэлсэн дараах хариултыг унш. Хариулт бүрийг хэлсэн хүнтэй нь тохируулахыг ангийн гишүүдээс хүс:

1. Би түүнийг олохын тулд хол газрыг туулж, түүнд бэлэг өгч, түүнд сөгдөн мөргөсөн. (Дорно зүгээс ирсэн зурхайч; Матай 2:1–2, 9–11.)
2. Би түүнд өрөө гаргаж өгөөгүй. (Дэн буудлын хүн; Лук 2:7.)
3. Ариун Сүнснээс гэрчлэл хүлээн аваад би хүүхдийг гар дээрээ авсан бөгөөд амар амгалан насан эцэслэнэ гэдгээ мэдэж байсан. (Симеон; Лук 2:25–32.)
4. Би “дээд өндөрт алдар нь Бурхан байх болтугай, доор газарт амар амгалан нь хүмүүст байх болтугай” гэж хэлсэн. (Тэнгэр элч; Лук 2:13–14.)
5. Би түүнийг харахаар яаран явсан. (Хоньчин; Лук 2:15–26.)
6. Би балмагдаж түүнийг алахыг хичээсэн. (Херод; Матай 2:3–4, 16.)
7. Ариун сүмд түүнийг харсныхаа дараа би талархлаа илэрхийлээд, түүний мэндэлсэн мэдээг тараасан. (Анна; Лук 2:36–38.)
8. Би үйл явдлыг зүрхэндээ тунгаан бодсон. (Мариа; Лук 2:19.)

Дараах асуултуудыг хичээл дээр эргэцүүлэн бодохыг ангийн гишүүдээс хүс:

- Аврагч мэндэлсэн тухай мэдээ танд ямар сэтгэгдэл төрүүлдэг вэ? Түүний амьдрал, үхэл, цагаатгал болон дахин амилалтын талаар та ямар сэтгэгдэлтэй явдаг вэ?

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгийг заахдаа Аврагч мэндэлсэнд бид яагаад бахдан баярлах ёстой вэ гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд тусал. Түүний бага залуудаа үзүүлсэн үлгэр жишээг дагах арга замын талаар ярилц.

1. Есүс Христ Мэндэллээ

Лук 2:1–7-г уншаад ярилц. “Бэлтгэл” хэсэгт жагсааж бичсэн зарим зургийг үзүүл.

- “Дэлхийг бүтээхээс өмнө” Есүс Тэнгэрлэг Эцэгтэй хамт сүр жавхлантай байсан (Иохан 17:5). Тэр тэнгэр, газрыг бүтээсэн (Мозая 3:8). Жэховагийн хувьд тэр зарлигууд болон сайн мэдээний үнэнийг Хуучин Гэрээний бошиглогчдод илчилсэн (3 Нифай 15:2–5). Есүс яагаад дэлхийд ирсэн бэ? (3 Нифай 27:13–16-г үз.)
- Есүсийг мэндлэхэд нөхцөл байдал ямар байсан бэ? (Лук 2:7-г үз.) Эдгээр нөхцөл байдал түүний мөнх бус номлол болон цагаатгалын золиослолын дохио хэрхэн болсон бэ? Өнөөдөр хүмүүс амьдралдаа, Аврагчид өрөө гаргаж өгөхөөс ямар байдлаар татгалздаг вэ? Бид амьдралдаа түүнд өрөө гаргаж өгөхийн тулд юу хийж чадах вэ?

2. Есүсийг Мэндэлсэнд Тэнгэрийн Элч Нар болон Бусад Олон Хүмүүс Бахдан Баясдаг.

Лук 2:8–39-ийг ярилц. Сонгосон шүлгийг чангаар уншихыг ангийн гишүүдээс хүс. “Бэлтгэл” хэсэгт жагсааж бичсэн зарим зургийг үзүүл.

Та “Лук II” дүрс бичлэгийг хэрэглэх бол одоо үзүүл.

- Есүсийг мэндэлснийг зарлахдаа тэнгэрийн элч нар юу гэж хэлсэн бэ? (Лук 2:13–14-ийг үз.) Есүс Эцэгийгээ хэрхэн магтан дуулсан бэ? Тэрээр хэрхэн бүх хүмүүст болон танд амар амгалан, сайн сайхныг авчирсан бэ? Бид Хүүгээ бэлэглэсэнд нь Бурханд талархах талархлаа хэрхэн илэрхийлж чадах вэ?
- Дөнгөж мэндэлсэн Аврагчийг харсныхаа дараа хоньчид юу хийсэн бэ? (Лук 2:17–18.) Тэдний жишээг дагахын тулд бид юу хийж болох вэ? Аврагчийн талаарх гэрчлэлээ хуваалцаж болох хэн нэгнийг бодохыг ангийн гишүүдээс хүс.
- Есүсийг төрүүлж, мөн хоньчдыг айлчилсны дараа Мариа юу хийсэн бэ? (Лук 2:19-ийг үз.) Энэ нь Мариагийн талаар юуг илтгэж байна вэ? Эрхэм нандин явдлыг дээдлэн хайрлаж, эргэцүүлэн бодох цаг гаргах нь яагаад чухал вэ?
- Есүс хүүг харахын тулд Симеон, Анна нар хэрхэн бэлтгэгдсэн бэ? (Лук 2:25–26, 37-г үз.) Тэд түүнийг хараад юу гэж хэлсэн бэ? (Лук 2:27–35, 38-ыг үз.) Тэдний зөгнөлөөс бид Аврагчийн талаар юу сурч болох вэ?

3. Есүс хүүг шүтэн бишрэхээр мэргэд ирсэн. Херод түүнийг алахыг оролдсон.

Матай 2-оос сонгосон шүлгийг уншаад ярилц. “Бэлтгэл” хэсэгт жагсааж бичсэн зарим зургийг үзүүл.

- “Дорно зүгээс ирсэн зурхайчид” яагаад Есүсийг эрэлхийлсэн бэ? (Матай 2:1–2-ыг үз.) Тэд түүнийг олоод юу хийсэн бэ? (Матай 2:11-ийг үз. Тэднийг Есүсийг олж уулзах үед тэр “балчир хүүхэд” байсан болохоос дөнгөж төрсөн хүүхэд байгаагүй гэдгийг тайлбарла.) Их Эзэнд бид ямар бэлэг өгч болох вэ?
- Херод яагаад Есүсийг олж авахыг хүссэн бэ? (Матай 2:3–6, 13. Тэр балмагдаж, Есүсийг алахыг хүссэн.) Есүс Христ мэндэлсэн нь яагаад хааныг балмагдуулсан бэ? (Матай 2:2, 6-г үз. Зөгнөлийн дагуу Есүс Израилыг захирах байсан.)
- Есүсийг Херодоос хэрхэн хамгаалсан бэ? (Матай 2: 13–15-ыг үз.) Египет рүү буцахыг Иосеф яаж мэдсэн бэ? (Матай 2:19–23-ыг үз.) Иосеф яагаад Бурханаас энэ удирдамжийг хүлээн авах боломжтой байсан гэж та нар бодож байна вэ? Өнөөгийн эцэг эхчүүд гэр бүлийнхээ талаар илчлэлт хүлээн авах боломжтой байхын тулд юу хийж болох вэ? Гэр бүлийнхээ төлөө түүний удирдамжийг эрэлхийлж байхад Бурхан танд хэрхэн тусалсан бэ?

4. Эцэгээрээ удирдуулан, Есүс өсч том болж, бага залуудаа өөрийн үйлчлэлд бэлтгэгддэг.

Лук 2:40–52-ыг уншаад ярилц. “Бэлтгэл” хэсэгт жагсааж бичсэн зарим зургийг үзүүл. Мариа, Иосеф болон бусад итгэлтэй Иудейчүүд жил бүр Иерусалимд Дээгүүр Өнгөрөх баярыг тэмдэглэдэг байсан гэдгийг тайлбарла. Уламжлал ёсоор Есүс 12 нас хүрээд тэдэнтэй хамт явав (Лук 2:41–42).

- Иерусалимд Дээгүүр Өнгөрөх баярыг тэмдэглэж, Мариа, Иосеф хоёр Назар уруу буцаж яваад 12 настай Есүс тэдэнтэй хамт байхгүй байгааг анзаарчээ (Лук 2:43–45). Тэд түүнийг хаанаас олсон бэ? (Лук 2:46-г үз.) Хэрэв эцэг эх юмуу хайртай бусад хүмүүс чинь чамайг хаана байгааг мэдэхгүй бол, чамайг Тэнгэрлэг Эцэгийнхээ сэтгэлд нийцсэн зүйлийг хийж байгаа гэдэгт тэд итгэлтэй байж чадах уу?
- Лук 2:46-гийн Иосеф Смитийн Орчуулгад ариун сүмд Есүсийг сонсож байсан хүмүүс түүнээс асуулт асууж байв гэж өгүүлжээ. Энэ нь Есүсийн бага залуу нас, бэлтгэлийн талаар юу илэрхийлж байна вэ?
- Мариа, Иосеф хоёр Есүсийг олоод, Мариа түүнд “Эцэг бид хоёр чинь санаа зовон чамайг эрж хайлаа” гэж хэлжээ (Лук 2:48). Тэр “эцэг тань” гэж хэлэхдээ хэний талаар ярьсан бэ? (Иосеф.) Мариагийн сэтгэлийг зовоосон зүйлд Есүс юу гэж хариулсан бэ? (Лук 2: 49-ийг үз.) Есүс “Эцгийн минь ажил ” гэж хэлэхдээ хэний талаар ярьсан бэ? (Тэнгэрлэг Эцэг.) Энэ нь урьдчилан томилогдсон номлолынхоо талаар залуу Есүс ямар ойлголттой байгаа талаар бидэнд юу хэлж өгч байна вэ?
- Есүс бага залуудаа Мариа, Иосеф хоёрт яаж хандаж байсан бэ? (Лук 2:51-ийг үз. Хэдийгээр тэр Бурханы Хүү байсан ч, тэрээр өөрийн эх болон Иосефт захирагддаг байсан.) Энэ жишээнээс бид юу сурч болох вэ?
- Бага залуудаа Есүс “бие болон мэргэн ухаанаар өссөөр байсан бөгөөд Бурхан болон олон түмний тааллыг олжээ” (Лук 2:52). Өөрөөр хэлбэл тэр оюун ухаан, бие махбод, сүнслэг байдал болон хүнтэй нийцтэй зангаа хөгжүүлсэн. Оюун ухаан, бие махбод, сүнслэг болон хүнтэй нийцтэй байдлаа хөгжүүлэхийн тулд бид ямар тодорхой зүйлүүдийг хийж болох вэ?
- Бидний Гэтэлгэгч болохоор бэлтгэхдээ Есүс бүхий л хэрэгцээтэй оюун ухаан, хүч чадал, мэргэн ухаан, алдар хүндийг нэг дор хүлээж аваагүй. Тэр эдгээр зүйлсийг ивээл ивээлээр, бага багаар хүлээн авсан. (С ба Г 93: 11–17-г үз.) Энэ үнэн бидэнд хэрхэн хамаарах вэ? (С ба Г 93:18–20-ийг үз.)

Дүгнэлт

Энэ хичээл дээр яригдсан үнэний талаар гэрчил. Аврагчийг мэндэлсэнд бахдан баясаж, түүний бага залуудаа үзүүлсэн үлгэр жишээг дагахыг ангийн гишүүдэд уриал.

**Заах Нэмэлт
Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Мариа энэ бүх зүйлсийг зүрхэндээ тунгаан бодож, нандигнан хадгалсан юм” (Лук 2:19)

Есүсийг мэндлэхэд хэлсэн Мариагийн даруу үгийг ярилцахдаа хүүхдүүдийнхээ нэгийг төрөхөд ямар сэтгэгдэлтэй байсан талаар нь яриулахаар нэг эхийг урь.

2. Өсвөр Насныханд Зориулсан Үйл Ажиллагаа

Хичээлээс судрын таван чухал хэсгийг сонгоод, ангийн гишүүдэд хэсэг бүрийн агуулгыг танилцуул. Дараа нь ангийн гишүүдийн Библийг хаалга.

Таны шалгаж байгаа судрын хэсгийг олоход ангийн гишүүдэд туслах түлхүүр үгийг өгч, түлхүүр бүрийг тайлбарла, тэгснээр ямар хэсгийн талаар ярьж байгааг тань олоход эргэлзэх зүйлгүй болно. (Жишээ нь та “Энэ шүлэгт Есүсийг мэндлэхэд Бурханыг магтан дуулсан тэнгэр элч нарын үг бий” гэж хэлж болно. Ганц зөв хариулт нь Лук 2:14.) Түлхүүрийг уншиж өгснийхөө дараа ангийн гишүүдийн Библийг нээлгэж, зөв хэсгийг эрж олуул. Өрсөлдөхөөс илүү судрын хэсгүүдийг илүү сайн мэддэг болоход нь энэ үйл ажиллагааг ашигла. Үүнд цөөхөн минут зарцуул.

Зорилго

Нүглээ наманчилж, усан баталгааныхаа гэрээг даган, уруу таталтын эсрэг зогссоноор Аврагчтай улам ойр болоход ангийн гишүүдэд урам хайрлах.

Бэлтгэл


1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 3:1–12. Баптисм хүртээгч Иохан Их Эзэн Есүс Христийн замыг бэлтгэн нүглээ наминчлахыг номлож, усаар баталдаг.
 - б. Матай 3:13–17. Есүс Баптисм хүртээгч Иоханаар усаар батлуулав.
 - в. Матай 4:1–11. Есүс цөлд Сатаны уруу таталтын эсрэг зогсдог.
 - г. Иохан 1:35–51. Баптисм хүртээгч Иоханы зарим шавь нар Есүсийг дагахаар шийддэг.
2. Нэмэлт Уншлага: Марк 1:1–13; Лук 3:1–22; 4:1–14; Иохан 1:19–34; 2:1–25; 2 Нифай 31.
3. Дараах зурагнууд байгаа бол тэдгээрийг хичээлдээ хэрэглэ: Иохан Цөлд Номлосон нь (62132; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 207) ба Усаар Батлагч Иохан Есүсийг Усаар Баталсан нь (62133; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 208).
4. Заахад зориулсан зөвлөмж: Хичээлийн цагийг ухаалгаар ашигла. Хичээлийн хэсэг бүрт юу ярилцах болон хэдий хугацаа зарцуулахаа Сүнсээр удирдуулан төлөвлө. Зөвхөн бүх хичээлийг багтааж заахын тулд чухал ач холбогдолтой ярилцлагыг бүү зогсоо. Хичээлийн бүх санааг ярилцахаас илүү ангийн гишүүдийн сурч мэдэж, Сүнсийг мэдрэх нь илүү чухал.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Дараахыг самбарт бичээд энэ нь юу хэлж байгааг мэдэх эсэхийг ангийн гишүүдээс асуу:



Мессиа хэмээх нь тослуулсан гэсэн утгатай Еврей үг гэдгийг тайлбарла. Зөгнөлийн дагуу тэдний тослуулсан Хаан ба Чөлөөлөгч болох Мессиагийн ирэлтийг Иудейчүүд олон зуун жил хүлээсэн. Грек хэлэнд *Мессиа* гэдэг нь *Христ* гэсэн үг. Есүс Христ нь хүсэн хүлээсэн Мессиа байсан бөгөөд Баптисм хүртээгч Иохан нь түүний замыг бэлтгэхээр ирсэн бошиглогч байсан.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Дараах судрын хэсэгт гарах сургаалууд нь биднийг Аврагчтай улам ойртоход хэрхэн тусалж болохыг ярилц. Хичээл дэх асуулт бүрийг тавьж, санаа болгоныг ярилцах нь хэцүү тул ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх хэсгийг залбирч сонго.

1. Баптисм хүртээгч Иохан Их Эзэний замыг бэлтгэдэг.

Матай 3:1–12-ыг уншаад ярилц. Иоханы номлож байгаа зургийг үзүүлж, дараах мэдээллийг өөрийнхөө үгээр хуваалц:

Иоханыг мэндлэхээс олон зуун жилийн өмнө олон бошиглогчид түүний үйлчлэлийг урьдчилан харж, Мессиагийн замыг бэлтгэх нэгэн болох түүний алдар цууг гэрчилсэн (Исаиа 40:3; 1 Нифай 10:7–10). Иоханы үйлчлэлийн бэлтгэл болгож тэнгэр элч Габриел Иоханы мэндлэх тухай зарлаж (Лук 1:3–19), Захариа Иоханыг нэрлэж, хөвч хөндүүлэх ёслолын өдрийг нь зөгнөж (Лук 1: 67–79), мөн тэнгэр элч найман настай Иоханыг номлолд нь томилсон (С ба Г 84: 27–28). “Эмэгтэйгээс төрөгсдийн дунд Баптисм хүртээгч Иоханаас илүү агуу нэгэн байхгүй” (Лук 7:28) гэсэн Иоханы талаар агуу мэдэгдлийг Аврагч өөрөө хэлсэн.

Иохан Есүсээс ойролцоогоор зургаан сарын өмнө төрсөн. Есүсийг мэндлээд удаагүй байхад Херод Иудейчүүдийн шинэ хаан төрсөн гэсэн зарыг сонсоод балмагдаж “Бетлехем болон түүний ойр орчимд байгаа хоёр болон түүнээс доош насны бүх хүүхдүүдийг хөнөөлгөсөн” (Матай 2:16). Есүсийг хамгаалахын тулд тэнгэр элч Иосефийн зүүдэнд үзэгдэж, түүнийг Есүс, Мариа хоёрыг аваад Египет рүү явахыг зааварлав (Матай 2:13–15). Иоханыг хамгаалахын тулд “Захариа [Елизабетийг] түүнтэй хамт уул уруу явуулж, тэнд тэрээр царцаа, зэрлэг зөгийн бал идэж өссөн” (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 261). Иохан өөрийн олон түмэнд үйлчлэх үйлчлэлээ олон жилийн дараа эхэлж, эхлээд цөлд, дараа нь Иерусалимд, мөн “Иордан хавийн бүх газар нутагт” номлосон.

- Баптисм хүртээгч Иоханы номлол гэж юу байсан бэ? (Лук 1:76–79; 3:3–4.) Их Эзэний замыг хэн нэгэн бэлтгэх нь яагаад чухал байсан гэж та нар бодож байна вэ?
- Аврагчийг ирэхэд зориулан хүмүүсийг бэлтгэхдээ Иохан ямар мэдээг номлосон бэ? (Матай 3:1–2-ыг үз). Наманчлах гэдэг нь юу гэсэн үг вэ? (Энэ асуултыг ангийн гишүүдийг ярилцаж байхад дор үзүүлсэн наманчлах зарим байдлыг самбарт жагсааж бич. Та холбогдох судруудаас ангийн гишүүдийг уншихыг урьж болно.)
 - а. Нүглийнхээ төлөө Бурханы хүслийн дагуу гашуудах (2 Коринт 7:9–10).
 - б. Буруугаа хүлээж түүнийгээ орхих (С ба Г 58:42–43).
 - в. Боломжтой бол буруу хийсэн зүйлээ засаж залруулах (Лук 19:8).
 - г. Зарлигуудыг дуулгавартай дагах (С ба Г 1:31– 32).
 - д. Их Эзэнд хандаж, түүнд үйлчлэх (Мозая 7:33).

- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй хамт амьдрахад бэлтгэхэд наманчлал бидэнд хэрхэн тусалдаг вэ? (3 Нифай 27:19-ийг үз.) Тэдэнтэй өдөр бүр улам ойртоход наманчлал бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Фарисайчууд болон Садукайчууд Иоханы гүйцэтгэж буй усан баталгааг гэрчилсэн боловч усаар батлуулахгүй байхыг сонгов (Матай 3:7; Лук 7:29–30). Иохан тэднийг зэмлэн, гэмшилд зохистой үр жимс гаргаж, наманчил гэж шаардсан. (Иосеф Смитийн Орчуулга, Матай 3:35; *үр жимс* гэсэн үг нь үр дүн гэсэн утгыг илэрхийлж байгааг тайлбарла.) Наманчлалын үр жимс гэж юу вэ? (Моронай 8:25–26.)
- Иохан “гэмшлийн төлөө усаар” баталдаг бөгөөд Есүс “Ариун Сүнсээр хийгээд галаар” баталгаа хийх болно гэж амласан (Матай 3:11). “Ариун Сүнсээр хийгээд галаар” баталгаа хийнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? Бид толгой дээр гар тавиулан Ариун Сүнсний бэлэг хүлээн авахдаа Ариун Сүнс хийгээд галаар баталгаа хийлгэдэг (С ба Г 20: 41). “Ариун Сүнсний бэлэг гэдэг нь хэн нэгэн зохистой байгаа ямар ч үедээ Ариун Сүнсстэй хамт байх эрх юм. . . . Энэ нь хүнийг бүх нүглээс нь цэвэрлэж, ариусгах цэвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс үүнийг үргэлж ‘гал’ хэмээн хэлдэг” (Bible Dictionary, “Holy Ghost,” 704).

2. Есүс Баптисм хүртээгч Иоханаар усаар батлуулав.

Матай 3:13–17-г уншаад ярилц. Иохан Есүсийг усаар баталж байгаа зургийг үзүүл.

- Иохан яагаад Есүсийг усаар батлахаас татгалзаж байсан бэ? (Матай 3:14-ийг үз.) Есүс яагаад усаар батлуулах хэрэгтэй байсан бэ? (Матай 3:15; 2 Нифай 31: 6–7, 9–11-ийг үз.) Бид нар яагаад усаар батлуулах хэрэгтэй вэ? (2 Нифай 31: 5, 12–13, 17–18; С ба Г 20:71; 49:13–14-ийг үз.)
- Бид усаар батлуулахдаа ямар гэрээ байгуулдаг вэ? (С ба Г 20:37-г үз.) Эдгээр гэрээ нь бидний өдөр тутмын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх ёстой вэ? (Мозая 18: 8– 10-ыг үз.)

3. Есүс цөлд Сатаны уруу таталтын эсрэг зогсдог.

Матай 4:1–11-ийг уншаад ярилц.

- Есүсийг усаар батлуулсны дараа Сүнс түүнийг Бурхантай байлгахын тулд цөл рүү хөглөв (Joseph Smith Translation, Matthew 4:1). Энэ явдал нь Есүсийг Сатаны уруу таталтын эсрэг зогсоход хэрхэн бэлтгэсэн гэж та нар бодож байна вэ? Мацаг барилт, залбирал болон “Сүнсээр . . . хөтлүүлэх” нь биднийг уруу таталтын эсрэг хэрхэн зоригжуулдаг вэ?
- Есүсийг мацаг барьж байхад чулууг талх болгохыг хүсч уруу татахыг хичээж байхдаа Сатан ямар хүсэл зорилготой байсан бэ? (Матай 4:2–3-ыг үз. Тэр бие махбодын хоол идэх хүслийг төрүүлэхээр хичээж байсан.) Сатан биднийг бие махбодын хүсэлдээ татагдахад хэрхэн уруу татдаг вэ? Эдгээр уруу таталтыг бид хэрхэн таньж эсэргүүцэх вэ?
- Уулын орой дээрээс үсэрч, тэнгэрийн элч нараар авруулах хүч чадалтайгаа батал гэж Сатан Есүсийг уруу татаж байхдаа бардам занг нь гаргуулахыг хичээсэн (Матай 4:5–6). Сатан хэрхэн бидний бардам занг гаргуулахыг хичээдэг вэ? Бид хэрхэн бардамнах хүслээ гүйцэлдүүлэх уруу таталтыг таньж, түүний эсрэг зогсож чадах вэ?

- Хэрэв Есүс түүнийг бишрэн шүтвэл Сатан түүнд юу санал болгосон бэ? (Матай 4:8–9-ийг үз.) Сатан биднийг дэлхийн эд баялаг болон хүч чадлаар хэрхэн уруу татдаг вэ? Эдгээр уруу таталтыг бид хэрхэн таньж, эсэргүүцэх вэ? (Матай 4:10-ыг үз.)
- Сатаны Есүст дэлхийн хаант улсыг өгөхийг санал болгосны юу нь буруу байсан бэ? (С ба Г 104:14-ийг үз.) Өнөөдөр биднийг нүгэл үйлдэхэд уруу татдаг Сатаны ямар зарим худал саналууд байдаг вэ?
- Сатаны уруу таталт бүрт Есүс судраас иш татан хариулсан (Матай 4:3–4; 6–7, 8–10). Уруу таталтын эсрэг зогсоход судрууд биднийг хэрхэн зоригжуулдаг вэ? (Хиламан 3: 29–30-ийг үз.)
- Есүсийг Бурханы Хүү мөн эсэхийг Сатан хоёр ч удаа асуусан (Матай 4:3, 6). Сатан яагаад энэ асуултыг асуусан гэж та нар бодож байна вэ? Энэ асуултыг тэр өнөөдөр дэлхийд хэрхэн тавьдаг вэ? Уруу татагдах үед маань биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг мэдэхэд энэ нь хэрхэн тусалдаг вэ? (Мозес 1:12–22-ыг үз.)
- Бурханы Хүү Есүс бидэнд тулгардагтай адил уруу таталттай тулгарсан гэдгийг мэдэхэд энэ нь бидэнд хэрхэн тусалдаг вэ? (Ангийн гишүүдийг энэ асуултын талаар ярилцахад, та тэд нараар Еврей 4:14–15-ыг уншуулж болно.)

Ахлагч Иосеф Б.Вөртлин хэлэхдээ: “Их Эзэн бидний мөнх бус байдлыг маш сайн мэддэг. Тэр бидний сул дорой байдлыг мэддэг. Тэр бидний өдөр тутмын амьдралын сорилтыг ойлгодог. Тэрээр газар дэлхийн хүсэл сонирхлын уруу таталтыг ихэд ойлгон өршөөдөг (Conference Report, Apr. 1996, 46; or *Ensign*, May 1996, 34).

4. Баптисм хүртээгч Иоханы зарим шавь нар Есүсийг дагахаар шийддэг.

Иохан 1:35–51-ээс сонгосон шүлгийг уншаад ярилц.

- Есүс өөрийн мөнх бус үйлчлэлийг эхлэхэд Баптисм хүртээгч Иохан өөрийн шавь нартаа юу хийхийг уриалсан бэ? (Иохан 1:35–37-г үз.) Есүс Баптисм хүртээгч Иоханы хоёр шавь Түүнийг дагахыг хараад Тэр юу хийсэн бэ? (Иохан 1: 38–39-ийг үз.)
- Андрей Аврагчийг сонсож, таниад юу хийсэн бэ? (Иохан 1:40–42-ыг үз.) Есүс бол Мессиа гэдэг гэрчлэлийг хүлээн авсныхаа дараа Натанаелын эргэлзээнд Филип юу гэж хариулсан бэ? (Иохан 1:43– 46-г үз.) Аврагчийг “ирж хар” гэж бусдыг урихын тулд бид юу хийж болох вэ?

Дүгнэлт

Аврагчийг “ирж хар” гэсэн урилга нь бид бүгдэд ирсэн гэдгийг гэрчил. Бид наманчилж, усаар батлуулж, усан баталгааныхаа гэрээг сахиж, уруу таталтын эсрэг зогссоноор тэр урилгыг хүлээн авч чадна гэдгийг тайлбарла.

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Аврагчийн усан баталгааны утга учир

Матай 3:16–17-г тоймлон үз.

- Аврагчийн усан баталгаа нь усан баталгааг усанд умбуулан гүйцэтгэх ёстой гэдгийг хэрхэн харуулдаг бэ? (Матай 3:16-г үз; мөн Иохан 3:23-ыг үз; Ром 6:3–6; 3 Нифай 11:23–26-г үз; Bible Dictionary, “Baptism,” 618, усан баталгаа гэдэг үг нь “дүрэх эсвэл усанд умбуулах гэсэн Грек үгнээс гаралтай” гэдгийг тайлбарла.)
- Есүсийг усаар баталсныхаа дараа Иохан юу харсан бэ? (Матай 3:16-г үз.) Тэр хэний дууг сонссон бэ? (Матай 3:17-г үз.) Аврагчийн усан баталгааны үйл явдал Бурхан тэргүүтний мөн чанарын талаар юу заадаг вэ? (Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ, Ариун Сүнс гурав тус тусдаа оршдог.)

2. Есүс эхдээ хүндэтгэл, хайраа үзүүлдэг

Есүс усаар батлуулсныхаа дараа шавь нартайгаа Канад хуриманд оролцсон гэдгийг тайлбарла (Иохан 2:1–11). Эх нь түүнд найранд хэрэглэх дарс байхгүй байна гэж хэлэхэд тэр хариуд нь, та надаар юу хийлгэмээр байна би түүнийг тань хийе гэжээ. (Иосеф Смитийн Орчуулга, Иохан 2:4-ийг үз.)

- Есүсийн хэлсэн үг нь түүний ээждээ хандах хандлагын талаар юу илэрхийлж байна вэ? Түүнд туслахын тулд тэр юу хийсэн бэ? (Иохан 2:6–11-ийг үз. Энэ нь Шинэ Гэрээнд бичигдсэн Есүсийн анхны гайхамшиг гэдгийг цохон тэмдэглэ.)

3. Есүс ариун сүмийг цэвэрлэснээрээ бишрэл хүндэтгэлээ үзүүлсэн.

Худалдаачид, мөнгө солигчид ариун сүмийг бузарлаж байгааг Есүс олж мэдсэн тухай өгүүлдэг Иохан 2:13–17 хэсгийг ангийн гишүүдээр уншуул. Хэрэв Есүс Ариун Сүмийг Цэвэрлэсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 224) зураг байгаа бол үзүүл. Тэр “бүгдийг нь сүмээс туун гаргаад . . . мөнгө солигчдын зооснуудыг тараан хаяж ширээг нь хөмрүүлэхдээ” (Иохан 2:15) Есүс бишрэл, хүндэтгэл үзүүлсэн гэдгийг цохон тэмдэглэ. Тэнгэрлэг Эцэгтээ бишрэл хүндэтгэл үзүүлнэ гэдэг нь зөвхөн Сүм дээр чимээгүй суухаас илүү ихийг агуулдаг гэдгийг тайлбарла. Үүнд бид түүнд хайртай бөгөөд түүний хүч чадлыг мэддэгээ өөрсдийн үйлдлээрээ харуулах нь багтдаг.

Иохан 3–4


Зорилго	Ангийн гишүүд мөнхийн амьдралыг хүлээн авахын тулд бид “дахин төрж,” мөн Есүс Христийг үргэлжлүүлэн дагах ёстой гэдгийг ойлгоход туслах.
----------------	--

Бэлтгэл	<ol style="list-style-type: none">Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:<ol style="list-style-type: none">Иохан 3:1–22. Бурханы хаант улсад орохын тулд бүгд ус болон Сүнснээс төрөх ёстой гэж Есүс Никодемд заадаг. Тэр хүн төрөлхтнийг аврахын тулд илгээгдсэн Бурханы Заяасан Ганц Хүү гэдгээ Есүс заадаг.Иохан 4:1–42. Есүс Иаковын худаг дээр Самарийн нэгэн эмэгтэйд заадаг.Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэх бол ангид дараах зүйлсийг авчир:<ol style="list-style-type: none">Эрүүл, сайн усалсан ургамал болон услаагүй гандсан ургамал (эсвэл самбарт эрүүл болон гандсан ургамал зур.)Устай домбоДараах материалууд байгаа бол заримаас нь хичээлдээ хэрэглэ:<ol style="list-style-type: none">Худаг Дээрх Эмэгтэй, зураг (62169; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 217)<i>New Testament Video Presentations</i> (53914)-ээс “Woman at the Well” найман минутын бичлэг.Шинэ Гэрээний үеийн Палестины газрын зурагЗаахад зориулсан зөвлөмж: “Сүм дээр заах гол зорилго бол хүмүүсийн амьдралд хэрэгцээтэй өөрчлөлтийг авчрахад туслах явдал юм. Эрдэмлээл нь хувь хүмүүст сайн мэдээний үнэн болон зарчмуудын талаар бодож, мэдэрч, дараа ямар нэг зүйлийг хийх урмыг өгдөг” (Rex A. Skidmore, quoted in <i>Teaching—No Greater Call</i>, 83).
----------------	---

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах Ажиллагаа	Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ: Эрүүл болон гандсан ургамлыг үзүүл (“Бэлтгэл” хэсгийг үз.) эсвэл дараагийн хуудсанд үзүүлснийг самбарт зур. Түүнчлэн устай домбыг үзүүл.
-----------------------------	--



- Ургамлыг услахгүй бол яах вэ? Бид усгүй бол яах вэ?

Хэрэв бид бодит усгүй бол бие махбод маань үхдэг, харин сүнслэг усгүй бол Сүнсээр үхэх болно гэдгийг тайлбарла. Энэ хичээл ус болон Сүнснээс төрөх тухай мөн Есүсийн санал болгодог амьдралын усны тухай сургаалынх нь талаар заана.

Судрын Ярилцлага ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Бурханы хаант улсад орохын тулд бүгд ус болон Сүнснээс төрөх ёстой гэж Есүс Никодемд заадаг.

Иохан 3:1–22-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгийг чангаар уншихыг урь. Никодем Иудейчүүдийн удирдагчдын нэг байсан гэдгийг тайлбарла. Есүс бол “Бурханаас ирсэн багш” гэдгийг мэддэг учраас тэр Есүс дээр ирсэн. (Иохан 3:2.)

- Бурханы хаант улсад орохын тулд юу хийх ёстой талаар Есүс Никодемд юу заасан бэ? (Иохан 3:5-ыг үз.) “Уснаас төрнө” гэж юу гэсэн үг вэ? (Иохан 3:5; усаар батлуулах). Усан баталгаа нь дахин төрөлтийн билэг тэмдэг хэрхэн болдог вэ? (Усанд умбуулж байгаа нь үхэл эсвэл бидний урьдах нүглийг оршуулж байгааг, уснаас гарч ирэх нь бид шинэ амьдралыг эхэлж байгааг бэлэгддэг.) “Сүнснээс . . . төрнө ” гэж юу гэсэн үг вэ? (Иохан 3:5; Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах).
- Ахлагч Брүс Р.МакКонки “Сүмийн гишүүд нь зөвхөн усаар батлуулснаар дахин төрдөггүй” гэж заасан (*Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [1966–73], 1:142). Усаар батлуулж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авахаас өөр ямар зүйл дахин төрөхөд хэрэгтэй вэ? (Иохан 3:16, 18; Мозая 5:1–7; 27:25–26; Алма 5:14–35; 22:15–18-ыг үз. Та эдгээр шүлгүүдээс дахин төрөхтэй холбоотой хэсгийг ангийн гишүүдээр тэмдэглүүлж болно. Загвар болох жагсаалтыг дор өгөв. Мормоны Номноос авсан шүлгүүд дахин төрөх гэж юу болохыг тодруулж өгч байгааг цохон тэмдэглэ.)
 - а. Есүс Христэд Итгэх (Иохан 3:16, 18).
 - б. Зүрх сэтгэлдээ агуу их өөрчлөлтийг хийх, тэгснээр бид нүгэл хилэнц хийх ямар ч хүсэлгүй болж, үргэлж сайныг хийх хүсэлтэй болно (Мозая 5:2; мөн Алма 5:12–14, 26-г үз).

- в. “Зуурдын болон уналтын байдлаас зөв шударгын байдал уруу өөрчлөгдөх” (Мозая 27:25).
- г. “[Бурханы] охид, хөвгүүд” болох (Мозая 5:7; 27:25).
- д. “Шинэ хүн ” болох (Мозая 27:26).
- е. Бурханы дүр төрхийг [өөрсдийн] царайн дээрээ сийлсэн” байх (Алма 5:19; мөн 14-р шүлгийг үз.)
- ж. Наманчлах, тэгснээр бидний “гармент [Христийн] цусаар бүх толбоноосоо салж цэвэрлэгдэх” (Алма 5:21; мөн Алма 5:19, 33–34; 22:18-ыг үз).
- Ахлагч МакКонки дахин төрөх нь “агшин зуур болдоггүй. [Энэ] нь үйл явц юм” гэж мөн заасан (“Jesus Christ and Him Crucified,” in *1976 Devotional Speeches of the Year*, 399). Энэ үйл явцыг амьдралынхаа туршид үргэлжлүүлэхийн тулд юу хийж болох вэ? (2 Нифай 31:19–20-ийг үз.) Бид сүнслэг байдлаар өсч хөгжихдөө шантрах буюу үүнийг хойш тавих байдлаа хэрхэн даван туулж чадах вэ? Дахин төрөх үйл явцдаа өөртөө буюу хэн нэгэнд гарсан ямар өөрчлөлтүүдийг та ажигласан бэ?
 - Ангийн гишүүдийг Иохан 3:14–18-ыг чангаар уншихыг урь. Аврагчийн номлолын талаарх эдгээр үнэнүүд бид дахин төрнө гэсэн түүний зарлигтай ямар холбоотой вэ?
 - Есүс Никодемд заахдаа гэрэл ба харанхуй гэсэн ойлголтуудыг хэрэглэдэг (Иохан 3:19–21). Зарим хүмүүс яагаад гэрлийг харанхуйгаас илүүд үзэж сонгодог вэ? Харанхуйгаас зугтаж гэрлийг хайрлах чадварыг бид хэрхэн баримтлах вэ? Гэрэл рүү ирдэг хүмүүст Их Эзэн юу амласан бэ? (С ба Г 50: 24; 88:67.)

2. Есүс Иаковын худаг дээр Самарийн нэгэн эмэгтэйд заадаг.

Иохан 4:1–42-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Палестины газрын зургийг үзүүл. Есүс болон түүний шавь нар Иудейг орхин Галил уруу (та эдгээр газруудыг газрын зураг дээр зааж болно) аялж байхдаа Самари дах Иаковын Худаг дээр саатаж амарсан гэдгийг тайлбарла. Есүсийг худгийн дэргэд сууж байхад Самарийн нэгэн эмэгтэй ус татахаар ирсэн.

Худаг дээрх эмэгтэйн зургийг үзүүл. Хэрэв та “Худаг Дээрх Эмэгтэй” гэсэн бичлэгийг хэрэглэх бол одоо үзүүл.

- Иудейчүүд “Самаричуудтай харьцдаггүй байсан” (Иохан 4:9) бөгөөд аялж байхдаа ихэнхдээ Самариар явдаггүй байв. Гэсэн ч Есүс Самари дундуур зориуд явжээ. Энэ нь түүний талаар юу илэрхийлж байна вэ? Одоо дэлхий дээр “Самаричууд” гэж хэн бэ? (Хариултанд дорд гаралтай гэж тооцогддог ямар ч хүн эсвэл бүлэг орж болно.) Бид тэдэнд хэрхэн хандах ёстой вэ?
- Самари эмэгтэйд заахад Есүст яагаад хялбар байсан бэ? (Иохан 4:9, 11–12, 15, 19, 25. Хариултанд, тэр даруу байсан, илүү ихийг мэдэхийг хүссэн, мөн тэр түүний үгэнд итгэсэн зэрэг орж болно.) Аврагчийн сургаалыг илүү хялбархан хүлээн зөвшөөрдөг болохын тулд бид юу хийж чадах вэ?
- Есүсийг түүнтэй ярьж байхад Самари эмэгтэй хэрхэн өөрчлөгдсөн бэ? Энэ өөрчлөлтөнд хүрэхэд Есүс түүнд хэрхэн тусалсан бэ? (Хариултанд, тэр түүний ойлгож чадах түвшинд нь заасан, тэр өөрийгөө гэрчилсэн, тэр усны бэлэг тэмдгийг сайн хэрэглэж мөн хайр энэрэл үзүүлсэн зэрэг орж болно.) Бид бусдад заахдаа түүний жишээг хэрхэн дагах вэ?

- Есүс Самари эмэгтэйд “амьдралын усыг” өгч чадна гэж хэлсэн (Иохан 4:10). “Амьдралын ус” гэж юу гэсэн үг гэж та нар бодож байна вэ? (1 Нифай 11:25; С ба Г 63:23-ыг үз. Хариултанд сайн мэдээний номлолууд, Бурханы хайр ба Цагаатгал зэрэг нь орж болно.) Бид амьдралын усыг хэрхэн олж авч чадах вэ? Энэ амьдралын ус таныг хэрхэн адисалсан бэ?
- Самари эмэгтэй ус авахаар худаг дээр ирсэн (Иохан 4:7). Хэдий тийм ч тэр Есүстэй ярилцсаныхаа дараа устай домбоо худаг дээр орхиод тохиолдсон явдлынхаа талаар бусдад хэлэхээр явсан (Иохан 4:28–29). Түүний жишээнээс бид юу сурч болох вэ?
- Самари эмэгтэйн итгэлийн улмаас бусад хүмүүс хэрхэн адислагдсан бэ? (Иохан 4:39–42-ыг үз.) Их Эзэнд итгэснээр та хэрхэн адислагдсан болон бусад хүмүүс хэрхэн адислуулахыг харсан бэ? Бидний эргэн тойронд байгаа хүмүүст итгэл маань хэрхэн нөлөөлөх вэ?

Дүгнэлт

Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэсэн бол, ургамал болон домбыг дахин үзүүл. Амьдрахын тулд ургамалд ус хэрэгтэйн адилаар дахин төрж, мөнхийн амьдралтай болохын тулд бид Аврагчийг болон түүний сургаалыг дагах хэрэгтэй.

Хичээл дээрээ ярилцсан үнэнийг гэрчил. Ангийн гишүүдийг Есүс Христийг эрэлхийлж, түүнийг даган, дахин төрөх үйл явцаа үргэлжлүүлэхийг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Би бол Христ биш, гэхдээ . . . Би түүний өмнө илгээгдсэн” (Иохан 3:28)

- Иохан 3:25–36-д Аврагчтай харилцах өөрийн үүрэгтээ Иохан яаж хандаж байсан бэ? Иоханы байдал нь үнэнч шавь болохоо хэрхэн харуулдаг вэ? Бид энэ байдлыг Сүмд үйлчлэх өөрсдийн үйлдэлдээ хэрхэн хэрэгжүүлж чадах вэ?

2. “Талбай . . . цайрч хураалтанд бэлэн болжээ” (Иохан 4:35)

- Иохан 4:35–38-д Есүсөөрийн номлолын ажлын талаар шавь нартаа юу заасан бэ? Тэр талбай цайрч хураалтанд бэлэн болжээ гэж хэлэхдээ ямар утгаар хэлсэн бэ? (С ба Г 4:1–4; 75:3–5-ыг үз.) Бусадтай сайн мэдээг хуваалцсан тохиодлоосоо хуваалцахыг ангийн гишүүдээс хүс.

3. Есүс түшмэлийн хүүг эдгээв

Иохан 4:46–54-ийг уншаад ярилц.

- Түшмэл Есүсээс юу хүссэн бэ? (Иохан 4:46–47-г үз.) Есүсийн эхний хариулт юу байсан бэ? (Иохан 4:48-ыг үз.) Түшмэл юу гэж хариулсан бэ? (Иохан 4:49-ийг үз.)
- Түшмэлд өгсөн Есүсийн хоёр дахь хариулт юу байсан бэ? (Иохан 4:50-ийг үз.) Түшмэлийн хариу үйлдэл юу байсан бэ? (Иохан 4:50-ийг үз.) Түшмэлийн итгэлийн үр дүн нь юу байсан бэ? (Иохан 4:51–54-ийг үз.) Бид энэ явдлаас итгэлийн хүч чадлын талаар юу сурч болох вэ?

“Тэд Даруй Тороо Орхив”

Хичээл

6

Лук 4:14–32; 5; 6:12–16; Матай 10

Зорилго Ангийн гишүүд Төлөөлөгчид нь Есүс Христийн тусгай гэрч байхаар дуудагддаг бөгөөд тэднийг дэмжин, дагавал бид адислагдана гэдгийг ойлгоход туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Лук 4:14–32. Есүс Назарын сүмд заадаг бөгөөд тэр бол Исаиагийн зөгнөсөн Мэссаяа мөн гэдгийг гэрчилдэг. Хүмүүс ууртайгаар түүнийг эсэргүүцдэг.
 - б. Лук 5:1–11, 27–28; 6:12–16. Есүс Арван Хоёр Төлөөлөгчөө дууддаг.
 - в. Матай 10. Есүс Арван Хоёр Төлөөлөгчийг томилж, тэдэнд зааварладаг бөгөөд тэднийг сайн мэдээг номлуулахаар илгээдэг.
2. Нэмэлт Уншлага: Исаиа 61:1–2; Матай 4:18–22; Марк 1:16–20; 3:13–19; 6:7–13; Лук 9:1–6; 12:1–12; Сургаал ба Гэрээ 107: 23–24, 33–35, 39, 58.
3. Хэрэв дараах зурагнууд байгаа бол тэдгээрийг хичээлдээ хэрэглэ: Загасчдыг Дуудсан нь (62496; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 209) эсвэл Есүс ба Загасчид (62138; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 210); Христ Төлөөлөгчдөө Томилсон нь (62557; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 211); болон одоогийн Арван Хоёрын Чуулгын зураг (хамгийн сүүлийн чуулганы дугаартай Олон Улсын Сэтгүүлээс)
4. Заахад зориулсан зөвлөмж: Ангийн гишүүн бүрийн нэрийг сурч, хэрэглэ. Таныг ийн хийхэд ангийн гишүүд өөрсдийг нь хайрлан халамжилдаг гэдгийг харна. Ангийн гишүүдийн нэрийг мэдэх нь мөн тодорхой хүмүүст шууд асуулт тавих бололцоо олгож тэдний хичээлийн идэвхийг нэмэгдүүлэхэд танд тусалдаг.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Есүсийн Хоёр Дахь Ирэлтийн үеэр хүн бүр түүнийг Аврагч гэдгийг нь танина гэдгийг тайлбарла (Мозая 27:31-ий үз). Түүний нэг дэх ирэлт дээр энэ нь биелээгүй. Иудейчүүд олон зууны туршид Аврагчийн талаарх зөгнөлийг судалсан боловч Есүсийг сонссон ихэнх хүмүүс түүнийг Аврагч гэдгийг таниагүй. Мэссаяа Иудейчүүдийг Ромын дарангуйллаас чөлөөлнө гэж найдаж байсан бөгөөд Есүс үүнийг хийгээгүй тул тэдний олонх нь түүнийг болон түүний мэдээг эсэргүүцэж байсан.

Энэ хичээлийн эхний хэсэгт тэрээр удаан хүлээлгэсэн Мэссаяа мөн гэж Есүсийг анх зарлахад юу болсон талаар ярилцана гэдгийг цохон тэмдэглэ. Хичээлийн бусад хэсэгт Есүс өөрийн мэдээгээ түгээхэд туслах Төлөөлөгчдийг дууддаг талаар ярилцана.

1. Есүс өөрийгөө Мэссаяа мөн гэж зарладаг.

Лук 4:14–32-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгийг уншихыг урь. Назарын сүмд үйлчилж байхдаа Есүс судрын хэсгээс уншиж, үүний тухай бодлоо хэлэхээр уригдсан.

- Ангийн гишүүдээр Лук 4:16–19-ийг уншуул. (18–19-ээр шүлгүүдийг Исаиа 61:1–2- оос иш татсан гэдгийг цохон тэмдэглэ. Лук 4:17 дээр Исаиаг “Исаиа” гэж нэрлэсэн.) Эдгээр шүлгүүд юуны тухай вэ? (Эдгээр нь Мессиагийн хийнэ гэсэн зүйлүүдийн талаар зөгнөсөн тайлбар юм; 1-р хичээлийг үз.)
- Есүс Исаиагийн номноос уншиж дуусаад ямар гэрчлэл хуваалцсан бэ? (Лук 4:21- ийг үз. Тэр бол Исаиагийн зөгнөсөн болон Иудейчүүдийн олон зуун жил хүлээсэн Мэссаяа мөн гэдгээ тэрээр тунхагласан.) Есүсийн тунхаглалыг сонсоод сүмд байсан хүмүүс ямар хариу өгсөн бэ? (Лук 4:22–29-ийг үз.)
- Сүмд байсан хүмүүст Есүсийг Мессиа мөн гэж хүлээн зөвшөөрөхөд яагаад хэцүү байсан гэж та нар бодож байна вэ? (Лук 4:22-ыг үз. Хариултанд, тэд түүнийг мэддэг байсан ба өсч том болохыг нь харсан учраас түүнийг тэдний хүсэн хүлээж байсан агуу Мессиа мөн гэж хэлж чадахгүй байсан зэрэг нь орж болно.) Өнөөгийн зарим хүмүүст Есүс Христийг хүлээн зөвшөөрөх нь яагаад хэцүү байдаг гэж та нар бодож байна вэ? Есүс бол Аврагч гэсэн гэрчлэлээ бид хэрхэн бэхжүүлэх вэ?

2. Есүс Арван Хоёр Төлөөлөгчөө дууддаг.

Лук 5:1–11, 27–28, 6:12–16-гаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Есүс ба загасчид болон одоогийн Арван Хоёр Төлөөлөгчийн зургийг үзүүл. Судрын хэсгээс ярилцахдаа, Төлөөлөгчид нь Назарын сүмд Есүсийн хийсэнтэй адил — тэр бол Мэссаяа, Аврагч мөн гэдгийг тунхаглахаар дуудагдсан гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд тусал.

- Симон Петр, Иаков, Иохан нар Есүсийг тэдэн рүү ирэхэд юу хийж байсан бэ? (Лук 5:1–2-ыг үз.) Есүс өөрийг нь дагавал тэдний амьдрал хэрхэн өөрчлөгдөх талаар тэдэнд юу гэж хэлсэн бэ? (Лук 5:10-ыг үз.) Есүс Христийг дагах шийдвэр чинь тань амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Загасны торны гайхамшиг Петр, Иаков, Иохан нарыг “хүмүүсийн загасчид” болохын дохио хэрхэн болсон бэ? (Марк 1:17). Дараах хэсгийг ангийн гишүүдээр авч хэлэлцүүл:
 - а. Лук 5:5: “Таны хэлснээр би тороо хаяад үзье” (Тэд Есүсийн удирдсаны дагуу ажиллана).
 - б. Лук 5:6: “Тэд маш их хэмжээний загас барьж, тор нь урагдав.” (Тэд сайн мэдээг хүлээн зөвшөөрөх олон хүмүүсийг олох болно.)
 - в. Лук 5:7: “Тэд бусад нөхөддөө ирж туслахыг дохив.” (Тэд ажилдаа туслуулахаар бусдыг дуудах болно.)

- Лук 5:1–11-д Есүс Петр, Иаков, Иохан нарыг шавиа болгохоор дуудсан гэдгийг цохон тэмдэглэ. Хожим нь тэр тэднийг Төлөөлөгчид болгохоор дуудна. Самбарт *Шавь* ба *Төлөөлөгч* гэж бич. Шавь болон Төлөөлөгч хоёрын ялгаа нь юу вэ?

Шавь гэдэг нь Есүс Христийг дагадаг ямар ч хүнийг хэлдэг. Төлөөлөгч бол Христийн тусгай гэрч байхаар дууддагдсан шавь (С ба Г 107:23) юм гэдгийг тайлбарла. *Төлөөлөгч* гэдэг үг нь “илгээгдсэн нэгэн” гэсэн утгатай. Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд нь Есүс Христ бол хүн төрөлхтний Аврагч ба Гэтэлгэгч гэдгийг дэлхий дахинаа гэрчлэхээр илгээгдсэн.

- Есүс Төлөөлөгчдийг дууддаг нь яагаад чухал байсан бэ? (Матай 9:36–38; 6:19; Марк 3:4–15; Иохан 20:19–21, 23; Ефес 4:11–15. Тэд Есүсийг явсны дараа сайн мэдээг номлож, Сүмийг удирдаж, пристийн зэргийн эрх мэдлийг үргэлжлүүлэн барина.) Их Эзэн Төлөөлөгчдийг өнөө үед дууддаг нь яагаад чухал вэ?
- Есүс анхны Арван Хоёр Төлөөлөгчийг хэрхэн сонгосон бэ? (Лук 6:12–13-ыг үз.) Тэднийг дуудахын тулд Есүс хэрхэн өөрийгөө бэлтгэсэн бэ? Үүнийг өнөөдөр Төлөөлөгчид байж, Сүмийн бусад дуудлагат ажилд үйлчлэхэд хүмүүсийг сонгох аргатай харьцуулахад ямар байдаг вэ? (Сүмийн удирдагчид дуудлага бүрт Их Эзэн хэнийг үйлчлүүлэхийг нь мэдэхийн тулд залбирч, урам онгод эрэлхийлдэг.)
- Төлөөлөгч байлгахаар Есүсийн дуудсан хүмүүсийн намтар, зан байдлын талаар судрууд бидэнд юу хэлдэг вэ? (Лук 5:5, 8, 11, 27–28. Хариултанд тэд үйлчлэхийн тулд албан ёсоор бэлтгэгдээгүй ч даруу, дуулгавартай, ажилсаг, Их Эзэнийг дагахад бүх зүйлээ золиослоход бэлэн байсан зэрэг нь орж болно.) Их Эзэнд үйлчлэх шаардлагыг хангахад хүн юу хийх ёстой талаар энд юу гэж зөвлөж байна вэ? (С ба Г 4:3, 5–6; Мөн Итгэлийн Тунхаг 1:5-ыг үз.)

3. Есүс Арван Хоёр Төлөөлөгчийг томилж, тэдэнд зааварладаг.

Матай 10-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Христ Төлөөлөгчдөө томилж байгаа зургийг үзүүл.

- Есүс Арван Хоёр Төлөөлөгчөө дуудсаны дараа тэдэнд пристийн зэргийн хүч чадлыг өгч, тэдний хариуцлагын талаар зааварчилгаа өгдөг. Бид Матай 10-аас Есүсийн Төлөөлөгчдийнхөө хүч чадал, хариуцлагын талаар өгсөн зөвлөмжийн талаар юу сурч авдаг вэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич. Хариултанд дор жагсаасан зүйлүүд орж болно.)
 - а. Тэдэнд сүнслэг болон бие махбодын өвчнийг эдгээх хүч бий (шүлэг 1).
 - б. Тэд тэнгэрийн хаанчлал ойрхон байна гэж номлохоор Израилийн төөрсөн хонинууд уруу илгээгдсэн (шүлэг 6–7).
 - в. Тэд хүмүүсийг адислаж, эдгээхэд пристийн зэргийн хүчээ ашиглах ёстой (шүлэг 8).
 - г. Тэд сайн мэдээг сонсохоор бэлтгэгдсэн хүмүүсийг хайх ёстой (шүлэг 11–14).
 - д. Тэд Сүнсээр удирдуулан заах ёстой (шүлэг 19–20).
 - е. Тэд бүх амьдралаа Аврагчийн ажилд зориулах ёстой (шүлэг 39).

- Анхны Төлөөлөгчдөд өгсөн хүч чадал болон хариуцлагыг хожмын үеийн Төлөөлөгчдөд өгсөнтэй нь харьцуулахад ямар байна вэ? (С ба Г 107:23; 33, 35, 112:14, 19–22, 30–31.) Хожмын үеийн Төлөөлөгчдийг эдгээр хариуцлагаа хэрхэн биелүүлэхийг та харсан уу?
- Төлөөлөгчдийг дагадаг хүмүүст ямар адислалуудыг амласан бэ? (Матай 10:40–42- ыг үз; мөн С ба Г 124:45–46-г үз.)

Ахлагч Спэнсэр В. Кимболл хэлэхдээ: “Их Эзэн өөрийн Сүмдээ томилсон Сүмийн Эрх Мэдэлтнүүдтэй нягт холбоотой байдаг энэ Сүмийн хэн ч хэзээ ч төөрөлдөж алга болохгүй. Энэ Сүм хэзээ ч төөрөлдөж алга болохгүй; Арван Хоёрын Чуулга та нарыг хэзээ ч буруу зам уруу хөтөлж байгаагүй, хэзээ ч хөтлөхгүй” гэсэн (Conference Report, Apr. 1951, 104).

Дүгнэлт

Есүс Христ бол жинхэнэ Мэссаяа мөн бөгөөд Арван Хоёр Төлөөлөгч нь түүний тусгай гэрч гэдгийг гэрчил. Та Төлөөлөгчийн зөвлөмжийг дагаснаар амьдрал тань адислагдсан тохиолдлоосоо хуваалцаж болно.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Одоогийн Арван Хоёр Төлөөлөгч

Одоогийн Арван Хоёр Төлөөлөгчийн зургийг үзүүлж, тэдний нэрсийг мэддэг болоход тусал. Та дараах сорилтыг ашиглаж болно:

Ангийн гишүүн бүрт хуудас цаас, харандаа өгч, цаасан дээрээ 1-ээс 12 хүртэл дугаар тавихыг тэднээс хүс. Төлөөлөгч бүрийн зургийг нэрийг нь хэлэлгүйгээр үзүүлээд тохирсон дугаарын ард нэрийг нь цаасан дээрээ бичихийг ангийн гишүүдээс хүс. Бүх зургийг үзүүлснийхээ дараа зөв хариултыг хэл.

2. Анхны Арван Хоёр Төлөөлөгч

Ангийн гишүүдийг анхны Арван Хоёр Төлөөлөгчийн нэрсийг мэддэг болоход тусал. (Матай 10:2–4.) Төлөөлөгчид нь сударт хэрхэн янз янзаар нэрлэгдсэнийг ангийн гишүүдийг ойлгоход туслахын тулд дараах мэдээллийг өөрийнхөө үгээр ярьж өг:

Зебедеен хүү Иаков болон Алфайн хүү Иаков гэсэн Иаков нэртэй хоёр Төлөөлөгч байсан. Симон Петр болон Канаан Симон буюу Зеалотын Симон “зеалот” гэж дуудуулдаг байсан Симон нэртэй хоёр Төлөөлөгч байсан. Иудас (бас Лэббаус Таддай гэгддэг) болон Христээс урвасан Искаротын Иудас гэсэн Иудас нэртэй хоёр Төлөөлөгч байсан. Лук 5:27–28-д Матайг Леви гэж нэрлэсэн байдаг. Түүнчлэн Томасыг “ихэр” гэсэн утгатай Дидимас гэж дууддаг байв. Матай, Марк, Лукийн сайн мэдээнүүдэд Бартоломай хэмээх Төлөөлөгч, Иоханы сайн мэдээн дэх Натанаел гэгч энэ хоёрыг нэг хүн гэж таамагладаг.

3. “Эцгийгээ эсвэл эхийгээ надаас илүү хайрладаг хүн миний хувьд зохистой нэгэн биш юм” (Матай 10:37)

Ангийн гишүүдээр Матай 10:35–38-ыг уншуул.

- Хүмүүсийг Сүмд нэгдэх үед 35, 36-р шүлгүүд заримдаа хэрхэн биелдэг вэ? Их Эзэн бидний гэр бүлийг амар амгалан, нэгдмэл байлгахыг хүсдэг гэдгийг мэддэгийн хувьд тэр яагаад энэ мэдэгдлийг хийсэн гэж та нар бодож байна вэ? Бид хэнийг нэн тэргүүнд тавьж, хамгаас хүчтэйд тооцох ёстой вэ? (37–28-р шүлгийг үз. Мөн Лук 14:33-ыг үз.)

4. Дүрс бичлэг

New Testament Video Presentations-ээс сонгож “New Testament Customs”-ын эхний хэсгийг энэ хичээлд хэрэглэж болно. Энэ хэсэгт Есүс өөрийгөө тослуулсан нэгэн буюу Мэссаяа гэж тунхаглах нь ямар утгатай байсан талаар (Лук 4:18); сүмд бишрэн шүтэх талаар болон Есүс Төлөөлөгчиддөө хийхийг удирдамж болгосон шиг богцгүй эсвэл хүүдийгүйгээр сайн мэдээг номлох (Матай 10:9–10) гэдэг нь юу гэсэн утгатайн тухай мэдээлэл бий.

“Бидний Сул Дорой Байдлыг [Тэр] Өөртөө Авч, Бидний Өвчнийг Үүрсэн”

Марк 1–2; 4:35–41; 5; Лук 7:11–7

Зорилго

Аврагчийн бүтээсэн гайхамшгуудын зарим шалтгааныг ойлгоход ангийн гишүүдэд туслах.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Марк 1:14–15, 21–45. Есүс сайн мэдээг зааж, чөтгөрийг зайлуулж, өвчтөнийг эдгээж, Галил даяар аялдаг. Тэр хүнээс бузар сүнснийг нь зайлуулж, Симон Петрийн хадам эхийг эдгээдэг ба уяман өвчнөөс цэвэрлэдэг.
 - б. Марк 2:1–12. Есүс нэгэн эрийн нүглийг өршөөдөг бөгөөд саа өвчтэй хүнийг эдгээдэг.
 - в. Марк 4:35–41; 5:1–20; Лук 7:11–17. Есүс ширүүн салхитай далайг намдаадаг, маш олон чөтгөрийг зайлуулдаг ба Найны бэлэвсэн эмэгтэйн хүүг үхлээс амилуулдаг.
 - г. Марк 5:21–43. Есүс цус алддаг өвчинтэй нэгэн эмэгтэйг эдгээдэг ба Иайрын охиныг үхлээс амилуулдаг.
2. Нэмэлт Уншлага: Матай 8–9; Лук 4:33–44; 5:12–32; 8:22–56; Алма 7:11–12; Мормон 9:7–20; Морунай 7:27–29, 33–37.
3. Шуургыг Намжаасан нь (62139; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 214) ба Есүс Иайрын Охиныг Адисалсан нь (62231; Ариун сургаалын Уран Зургийн Цуглуулга 215) зурагнууд байгаа бол тэдгээрийг хичээлдээ ашигла.
4. Заахад зориулсан зөвлөмж: Судрууд дахь сургаалууд нь өнөөдөр яагаад чухал болохыг ангийн гишүүд мэдэх хэрэгтэй байдаг. Та хичээл бүрийг бэлтгэхдээ, ангийн гишүүдийг сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь уриалах талаар юу хийж чадахаа залбирч бодож үз.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

- Гайхамшиг гэж юу вэ? (Тэнгэрлэг болон сүнслэг хүч чадлаар хийгдсэн ер бусын үйл явдал.)
- Та нарын гэрч болохыг хүсдэг Аврагчийн үзүүлсэн гайхамшгуудын нэг нь юу вэ? Яагаад? (Ангийн гишүүдийг энэ асуултанд хариулахад нь туслахын тулд Христийн гайхамшгуудын заримыг самбарт бичиж болно.)

Энэ хичээл Аврагчийн үзүүлсэн гайхамшгуудын заримыг, мөн тэдгээрийг үзүүлэх болсон шалтгааны талаар ярилцана гэдгийг тайлбарла.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилц. Есүс бидний амьдралд гайхамшгуудыг бүтээсээр байгаа гэдгийг онцлон тэмдэглэ. Боломжтой бол ангийн гишүүдэд тохиолдсон гайхамшгаасаа хуваалцахыг уриал. (Та зарим тохиолдлууд нь их нандин байх тул хуваалцах хэрэггүй гэдгийг ангийн гишүүдэд сануулж болно. Тохиолдсон явдлаа хуваалцах нь зохистой эсэхийг мэдэхэд Ариун Сүнс тэдэнд тусалж чадна.)

1. Есүс сайн мэдээг зааж, гайхамшгийг үзүүлсээр Галил даяар аялдаг.

Марк 1:14–15, 21–45-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон хэсгийг чангаар уншихыг урь.

- Есүс сайн мэдээг зааж Галил даяар аялахдаа өвчтөнийг эдгээж, чөтгөрийг зайлуулан олон гайхамшгийг үзүүлсэн (Марк 1:34, 39). Есүс үйлчлэлийнхээ үеэр яагаад эдгээр болон бусад гайхамшгийг үзүүлсэн бэ? (Хариултанд дор жагсаасан зүйлүүд орж болно.)
 - а. Хайр болон энэрэл үзүүлэхийн тулд (Марк 5:19-ийг үз. Мөн 3 Нифай 17:6–7-г үз.)
 - б. Итгэлийг өсгөж, бататгахын тулд (Матай 9:27–30-ийг үз.)
 - в. Өөрийн бурханлаг шинж болон хүч чадлаа нотлохын тулд (Марк 1:27; 2:10–11-ийг үз.)

Ангийн гишүүдийн хариултыг самбарт бичээд, уг жагсаалтаа самбарт хичээлийн туршид байлга. Есүсийн үзүүлсэн гайхамшгуудын талаар ярилцахдаа гайхамшиг бүрээр гүйцэлдүүлсэн зарим зорилгуудын талаар ярилц. Хичээлийн үеэр дурьдагдсан зорилгуудыг жагсаалтанд нэм.

- Капернаум дахь сүмд байсан хүмүүс яагаад Есүсийн сургаалыг, мөн бузар сүнсийг хөөх түүний чадварыг нь гайхсан бэ? (Марк 1:22, 27-г үз.) Есүс ямар эрх мэдлээр зааж, гайхамшиг үзүүлж байсан бэ? (Хуулийн багш нарт байгаагүй пристийн зэргийн хүч чадлаар). Өнөөдөр бидэнд энэ хүч чадал, эрх мэдлийг олох ямар арга зам байгаа вэ?
- Марк 1:41-ийн дагуу Есүс уяман өвчнийг эдгээсэн нэг шалтгаан нь юу байсан бэ? Есүс зөвхөн нэг хүнийг шууд адисалсан олон гайхамшгийг үзүүлсэн гэдгийг цохон тэмдэглэ. Эдгээр явдлууд Есүс хүн нэг бүрийг анхаарч ханддаг гэдгийг хэрхэн баталж байна вэ? Тэр танд хайр, энэрлийг хэрхэн үзүүлдэг вэ?
- Бид эргэн тойрондох хүмүүстээ Христийн адил хайр, энэрлийг хэрхэн үзүүлж чадах вэ? Танд бусад хүмүүс Христийн адил хайр, энэрлийг хэрхэн үзүүлсэн вэ?

2. Есүс нэгэн эрийн нүглийг өршөөдөг бөгөөд саа өвчтэй хүнийг эдгээдэг.

Марк 2:1–12-ыг уншаад ярилц.

- Саа өвчтэй эрийг эдгээхэд хэний итгэл тус нэмэр болсон бэ? (Марк 2:3, 5-ыг үз.) Эдгээр хүмүүс өөрсдийн итгэлээ хэрхэн харуулсан бэ? (Марк 2:1–4-ийг үз.) Бид бусдын тусын тулд итгэлээ хэрхэн хөгжүүлж болох вэ? Танд болон таны мэддэг хэн нэгэнд бусдын итгэл хэрхэн тусалж байсан бэ?

- Есүс саа өвчтэй хүнд түүний нүгэл өршөөгдсөн гэж хэлэхэд хуулийн багш нарын зарим нь юу гэж бодсон бэ? (Марк 2:5–7-г үз.) Тэдгээр хуулийн багш нарт Есүс юу гэж хариулсан бэ? (Марк 2:8–11-ийг үз.) Тэр эрийн саа өвчин эдгэрэх нь гайхамшиг байсан шиг нүглээ өршөөлгөх нь түүнд бас гайхамшиг байсан гэдгийг цохон тэмдэглэ. Биднийг наманчлахад энэхүү гайхамшиг нь бидэнд тохиолдох боломжтой болдгийг онцлон тэмдэглэ.
- Аврагчийн бие махбодыг эдгээх хүч чадал нь илүү агуу ямар эдгээх хүч чадлыг бэлэгдэж болох вэ? (Исаиа 53:5; 2 Нифай 25:13; 3 Нифай 9:13-ыг үз.) Есүсийн эдгээх хүч чадал таны оюун санааг хэрхэн адислаж байсан бэ? Бид оюун санаагаараа эдгэрэхийг хэрхэн эрэлхийлж чадах вэ?

3. Есүс далайг намдааж, чөтгөрийг зайлуулдаг ба Найны бэлэвсэн эмэгтэйн хүүг үхлээс амилуулдаг.

Марк 4:35–41; 5:1–20 ба Лук 7:11–17-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Есүс шуурга намдааж байгаа зургийг үзүүл.

- Аврагчийн гайхамшгуудын бодит байдал нь ихэнхдээ сүнслэг үнэнийг бэлэгддэг. Дараах гайхамшгуудаас бид ямар сүнслэг үнэнийг мэдэж авч болох вэ? (Зохих хариултууд нь хаалтанд өгөгдсөн.)
 - а. Марк 4:35–41. Есүс далайг намжаадаг. (Тэр бидэнд амар амгаланг авчирч чадна.)
 - б. Марк 5:1–20. Есүс маш олон чөтгөрүүдийг зайлуулдаг. (Тэр бидний амьдралаас Сатаныг болон түүний нөлөөг зайлуулж чадна.)
 - в. Лук 7:11–17. Есүс залуу эрийг үхлээс амилуулдаг. (Түүний Цагаатгалын улмаас бид үхлээс Дахин Амилалтаар амилах болно.)

Аврагчийн үзүүлсэн бусад гайхамшиг болон тэдгээр гайхамшгаас бидний мэдэж авах сүнслэг үнэнүүдийг дурдахыг ангийн гишүүдээс хүс.

- Эдгээр гурван гайхамшгийг суралцсанаар та өөр ямар гүнзгий ойлголтыг олж авсан бэ?

4. Есүс цус алддаг өвчинтэй нэгэн эмэгтэйд эдгээж, Иайрын охиныг үхлээс амилуулдаг.

Марк 5:21–43-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Цус алддаг өвчинтэй эмэгтэй итгэлээ хэрхэн харуулсан бэ? (Марк 5:25–29-ийг үз.) Түүний эдгэрсэн шалтгаан нь юу байсан бэ? (Марк 5:34-ийг үз.) Энэ нь Есүсийн хувцсанд хүрснээс бус түүний хүч чадалд итгэснээс болсон гэдгийг онцлон тэмдэглэ.)
- Есүс Иайрын охиныг адислаж байгаа зургийг үзүүл. Аврагчид итгэх итгэлээ Иайр хэрхэн харуулсан бэ? (Марк 5:22–23-ыг үз.) Иайр охин нь нас барчихлаа гэдгийг сонсох үед Есүс Иайрын итгэлийг батжуулахын тулд юу гэж хэлсэн бэ? (Марк 5:36-г үз.) Та нар эдгээр үгсийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж чадах вэ?
- Итгэл яагаад гайхамшгийн өмнө нь байх ёстой гэж та нар бодож байна вэ? (Ифэр 12:12, 18; Моронай 7:37-г үз; мөн дараах ишлэлийг үз.) Гайхамшиг нь яагаад дан ганцаараа итгэлийн баттай суурь болдоггүй вэ?

Бригэм Янг хэлэхдээ, “Гайхамшгууд буюу Бурханы хүч чадлын ер бусын эдгээр илрэлүүд нь итгэлгүй нэгэнд бус, харин тэдгээр нь Гэгээнтнүүдийг

тайвшруулж, Бурханд хайртай, түүнээс айдаг, мөн түүнд үйлчилдэг хүмүүсийн итгэлийг бэхжүүлж, бататгахад зориулагдсан” гэжээ (*Discourses of Brigham Young*, sel. John A. Widtsoe [1941], 341).

- Есүсийн мөнх бус амьдралдаа бүтээсэн гайхамшгууд нь яагаад та нарт чухал вэ? Тэр өнөөдөр ч гайхамшгуудыг бүтээсээр байгаа гэдгийг мэдэх нь та нарт яагаад чухал вэ? Өнөөгийн гайхамшгуудын зарим жишээ нь юу вэ?

Дүгнэлт

Аврагч сүнслэг болон бие махбодын эмгэгийг хоёуланг нь эдгээж чадна гэдгийг гэрчил. Бидний төлөө хийсэн бүх зүйлд нь талархаж явдгаа илэрхийл. Боломжтой бол таны амьдралыг адисалсан гайхамшгийн талаар ярьж болно.

Ангийн гишүүдээс тэдэнд тохиолдсон гайхамшгуудаа чимээгүйхэн эргэцүүлэн бодохыг хүс. Тэдний амьдрал дахь гайхамшгуудыг танин мэдэж, талархлаа илэрхийлэхийг тэдэнд уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. Хуучин Гэрээний гайхамшгууд

Гайхамшгууд нь Иудейчүүдийн хувьд шинэ зүйл биш байсан гэдгийг тайлбарла. Гайхамшгууд нь урьд нь Иудейчүүдийн хүндэтгэдэг байсан Хуучин Гэрээний бошиглогчдоор бүтээгдэж байсан. Дараах жишээнүүдийг товчхон тоймлон үз.

- а. Бошиглогч Элиа нэгэн хүүг үхлээс амилуулсан (Хаадын дээд 17:17–24).
 - б. Бошиглогч Елиша хэсэгхэн хоолоор олон хүнийг хооллосон (Хаадын дэд 4:42–44).
 - в. Бошиглогч Елиша Нааманыг уяман өвчнөөс нь эдгээсэн (Хаадын дэд 5:1–19).
- Эдгээр бошиглогчид ямар хүчээр гайхамшгуудыг үзүүлсэн бэ? (Пристийн зэрэг, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн тэдэнд өгсөн тэнгэрлэг хүч чадал.)

2. “Эрүүл хүмүүст эмч хэрэггүй” (Марк 2:17)

- Фарисайчууд болон хуулийн багш нар, тэдний хувьд нүгэлтэн гэж үздэг хүмүүстэй хамт Есүсийг хооллож байхыг хараад яасан бэ? (Марк 2:15–16-г үз.) Есүс тэдэнд юу гэж хэлсэн бэ? (Марк 2:17-г үз.) Энэ нь юу гэсэн үг вэ? Ямар замаар бид бүгдэд “. . . эмч хэрэгтэй” байдаг вэ?

Зорилго

Ангийн гишүүдийг Уулан Дээрх Номлолдоо түүний заасан зарчмуудыг хэрэгжүүлэн Христэд ирэхэд уриалах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 5:1–12. Галил дах уулан дээр Есүс шавь нартаа Ерөөл адислалын тухай заадаг.
 - б. Матай 5:3–16. Түүний шавь нар бол “газрын давс” ба “дэлхийн гэрэл” гэж Есүс тунхагладаг.
 - в. Матай 5:17–48. Есүс Мосегийн хуулийг гүйцэлдүүлэхээр ирсэн гэдгээ тунхагладаг бөгөөд тэр илүү дээд хуулийг заадаг.
 2. Нэмэлт Уншлага: Лук 6:17–36, Мозая 13:28–35; Алма 34:13–16; 3 Нифай 12; Эфэр 12:11.
 3. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэх бол ангийн гишүүн бүрт үзэг харандаа болон хуудас цаас өг.
 4. Хэрэв дараах материалууд байгаа бол тэдгээрийг хичээлдээ хэрэглэ.
 - а. Уулан Дээрх Номлол зураг (62166; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 212)
 - б. Давстай сав ба ширээний чийдэн
 5. Заахад зориулсан зөвлөмж: Есүс Христ бол Гарамгай Багш. Та Уулан Дээрх Номлолыг суралцахдаа түүний заах арга барилыг ажиглаж, түүнийг багшийн хувьд нь дууриах арга замыг хай.
-

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүн бүрт хуудас цаас, үзэг харандаа өг. Аврагчаас ирсэн олон урилгыг Сударт агуулсан байдгийг тайлбарла. Та ангийн гишүүдээр Матай 11:28–29-өөс Аврагчийн урилгыг уншуулж болно. (мөн 3 Нифай 27:27-г үз.) Ангийн гишүүдээс цаасныхаа дээд хэсэгт *Аврагч намайг . . . урьдаг* гэж бичихийг хүс. Дараа нь энэ хичээл Аврагчийн олон урилгыг агуулдаг Уулан дээрх Номлолын тухай голлон өгүүлэхийг тайлбарла. Ангийн гишүүдийг хичээлийн үеэр урилгуудыг хайж олоод, тэдгээрийг цаасан дээрээ бичихэд уриал.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал. Хичээлийн асуулт бүрийг тавьж эсвэл

санаа болгоныг ярилцах нь хэцүү тул ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх хэсгийг залбирч сонго.

1. Есүс шавь нартаа Ерөөл адислалын тухай заадаг.

Мөнх бус амьдралын өмнөх амьдралд байхдаа Христ Синаи Уулан дээр Мосегийн хуулийг өгснөөс хойш олон зуун жилийн дараа мөнх бус Мэссаяа Уулан Дээрх Номлолоо өгөхдөө нэгэн дээд хуулийг тунхаглахаар өөр уулан дээр гарсан гэдгийг тайлбарла. Уулан Дээрх Номлолын зургийг үзүүл.

Энэ номлол дахь анхны сургаалыг Ерөөл адислал гэж нэрлэдэг (Матай 5:1–12). *Ерөөл Адислал* гэдэг нь хувьтай, аз жаргалтай эсвэл адислагдсан гэсэн утгатай Латины *биатас* гэдэг үгнээс гаралтай. Ерөөл Адислалыг уншаад, үүний тухай дор дурьдсаны дагуу ярилц.

- *Матай 5:3.* “Сүнсэн дотроо ядуу” байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (Даруу байх. Мөн 3 Нифай 12:3-ыг үз.) Бид яагаад даруу байх нь чухал вэ? Бид хэрхэн илүү даруу болж чадах вэ?
- *Матай 5:4.* Биднийг тайтгаруулахын тулд Их Эзэн ямар арга замыг бидэнд өгдөг вэ? (Иохан 14:26–27-г болон зарим жишээг Мозая 18:8–9-ээс үз.) Гашуудаж гунигласан үедээ та тайтгарлыг хэрхэн олж байсан бэ?
- *Матай 5:5.* Дөлгөөн байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (Эелдэг, өршөөнгүй эсвэл сайн санаатай байх) Бид дөлгөөн байдлаа хэрхэн хөгжүүлж чадах вэ? (Мозая 3:19; Алма 7:23; 13:28-ыг үз.)
- *Матай 5:6.* “Зөв шударга байдлын төлөө өлсөж цангагч” хүмүүст Есүс юу амласан бэ? (Матай 5:6; 3 Нифай 12:6-г үз.) Бид хүсэл сонирхлоо дэлхийн зүйлүүдээс зөв шударга зүйлүүд рүү өөрчлөхийн тулд юу хийж болох вэ?
- *Матай 5:7.* Бид бусдад хэрхэн нигүүлсэл үзүүлж чадах вэ? Их Эзэний нигүүлсэл бидэнд яагаад хэрэгтэй вэ? (Алма 42:13–15-ыг үз.)
- *Матай 5:8.* Цэвэр ариун зүрх сэтгэлтэй байна гэдэг нь юу гэсэн үг вэ? Бид зүрх сэтгэлээ хэрхэн ариусгаж чадах вэ? (Хиламан 3:35-ыг үз.) Хэрэв бид Бурханыг харж, түүнтэй хамт амьдрах гэж байгаа бол яагаад цэвэр ариун зүрх сэтгэлтэй байх ёстой вэ? (Мосе 6:57-г үз.)
- *Матай 5:9.* Бид өөрсдийн гэр орон, нийгэмдээ хэрхэн амар тайвныг тогтоогч байж чадах вэ?
- *Матай 5:10–12.* Заримдаа зөв шударга хүмүүсийг яагаад хавчдаг вэ? Бид хавчлагыг хэрхэн давж туулах ёстой вэ? (Матай 5:44; Лук 6:35-ыг үз.)

Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол ангийн гишүүдийг өөрсдөд нь хэрэгтэй гэж бодогдож байгаа Ерөөл Адислалын урилгыг жагсааж бичихийг хүс.

2. Түүний шавь нар бол “газрын давс” ба “дэлхийн гэрэл” гэж Есүс тунхагладаг.

Матай 5:13–16-г уншаад ярилц. Та эдгээр шүлгүүдийг ярилцах зуураа давстай сав болон ширээний чийдэнг үзүүлж болно.

- Түүний шавь нар бол “газрын давс” гэж Есүс хэлсэн (Матай 5:13; С ба Г 101:39). Давсыг юунд ашигладаг вэ? (Хариултанд, давс бол амт оруулах

болон хүнсийг муудахаас хамгаалах бодис зэрэг нь орж болно.) Хожмын Үеийн Гэгээнтнүүд хэрхэн “газрын давс” байж чадах вэ?

- Биднийг дэлхийн гэрэл, хүн төрөлхтний аврагч байх болно гэж Аврагч заасан. Бид хүн төрөлхтний аврагч байхаа боливол, амтаа алдсан давстай адилхан байх болно (С ба Г 103:9–10-ыг үз.) Бид хэрхэн “хүн төрөлхтний аврагч” байж чадах вэ? (Хариултанд сайн мэдээг хуваалцах, ариун сүмийн ажил хийх зэрэг нь орж болно.)
- Хожмын Үеийн Гэгээнтнүүд хэрхэн “дэлхийн гэрэл” байж чадах вэ? (Матай 5:14; мөн шүлэг 16-г үз.) Лааг “савны дор” тавибал яах вэ? (Матай 5:15; сав гэдэг нь том сав гэдгийг тайлбарла.) Сүмийн гишүүд бид заримдаа, гэрлээ савны доор хэрхэн тавьдаг вэ? Бусдыг “тэнгэр дэх . . . Эцгээ алдаршуулахад” хөтлөхийн тулд бид өөрсдийн гэрлээ хэрхэн гэрэлтүүлж болох вэ? (Матай 5:16; 3 Нифай 8:24-ийг үз.)

3. Есүс Мосегийн хуулиас илүү дээд хуулийг заадаг.

Матай 5:17–48-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгийг чангаар уншихыг урь.

- Есүс Мосегийн хуулийг хэрэгсэхгүй болгохын тулд бус гүйцэлдүүлэхийн тулд ирсэн гэдгээ заадаг (Матай 5:17–18). Тэр Мосегийн хуулийг хэрхэн гүйцэлдүүлсэн бэ?

Мосегийн хууль нь шударга бус явдал хийхдээ түргэн бөгөөд Бурхан Их Эзэнээ санахдаа удаан, зөрүүд хүмүүс байсан Израилийн хүүхдүүдэд өгөгдсөн гэдгийг тайлбарла. Энэ нь Израильчуудад Бурханыг болон түүнд хандах үүргүүдээ санахад нь тусалж, өдрөөс өдөрт чандлан сахих ёстой байсан ёслолууд болон үйлдлүүдийн хууль байсан. (Мозая 13:29–30-ийг үз.) Энэ хуулийг ойлгосон хүмүүс нь хуулийг гүйцэлдүүлэх хүртлээ Христ рүү тууштайгаар тэмүүлсэн. Энэ шалтгааны улмаас уг хууль өгөгдсөн юм. (2 Нифай 25:24–25-ыг үз.)

Аврагч бидний нүглийг цагаатгахдаа Мосегийн хуулийг гүйцэлдүүлсэн (Алма 34:13–16). Цагаатгалаас хойш хүмүүс дунд Мосегийн хуулийн нэг хэсэг болох Есүс Христийн цагаатгалын золиослолыг бэлэгдэх амьтны золиослол үйлдэх тушаал үгүй болсон. Үүний оронд даруу зүрх, наманчлах сэтгэлээр өргөл өргөхийг хүмүүст тушаасан. (3 Нифай 9:20; мөн шүлэг 19-ийг үз.)

- Есүс шавь нарынх нь зөв шударга байдал “фарисайчууд болон хуулийн багш нарын зөв шударга байдлаас илүү гарах” ёстой гэж хэлсэн (Матай 5:20). Фарисайчууд болон хуулийн багш нарын “зөв шударга байдалд” юу дутаж байсан бэ? (Тэд зөвхөн хуулийн гадаад байдлыг голлон анхаарч, доторх итгэлийн чухлыг үл тоомсорлосон. Хэрэв тэд хуулийг өгөгдсөнөөр нь дагаж байсан бол Есүсийг Мэссаяа мөн хэмээн таних байсан.)

Самбарын зүүн дээд өнцөгт *Энэ айлдварыг та нар сонссон* гэж бич. Уулан Дээрх Номлолдоо Есүс Мосегийн хуулийн нэг хэсэг байсан зарлигуудын тухай ярихдаа эдгээр үгсийг хэрэглэсэн. Самбарын баруун дээд өнцөгт *Харин би та нарт хэлье* гэж бич. Есүс өөрийн дээд хуулийг шавь нартаа заахдаа эдгээр үгсийг хэрэглэсэн гэдгийг цохон тэмдэглэ.

- Матай 5:21 дээр Есүс эртний ямар хуулийн талаар ярьсан бэ? (*Энэ айлдварыг та нар сонссон* гэдгийн доор *Хүн алж болохгүй* гэж бич.) Энэ зарлигтай холбоотой ямар дээд хуулийг Есүс өгсөн бэ? (Матай 5:22-ыг үз. *Харин би та нарт хэлье* гэдгийн доор *Бүү хилэгнэ* гэж бич.) Уур хилэнгээс зайлсхийх гэсэн зарлиг нь хүн алахыг хориглосон зарлигаас хэрхэн илүү дээд хууль байх вэ? Уур хилэн нь Бурхан бидний хоорондын харьцаанд хэрхэн нөлөөлөх вэ? Бид уур хилэнгээ барьж, үүнийг амьдралаасаа зайлуулахыг эрэлхийлэхийн тулд юу хийж болох вэ?
- Аврагч тахилын ширээнд золиослолын өргөл өргөх эртний зан үйлтэй холбоотой “тахилын ширээнд бэлэг” авчрах талаар ярьсан (Матай 5:23). Есүс шавь нартаа, тэд тахилын ширээнд бэлэг авчрахаар бэлтгэж байхдаа ууртай байвал юу хийх ёстой гэж хэлсэн бэ? (Матай 5:23–24-ийг үз.) Энэ нь бидэнд хэрхэн хамаарах вэ?
- Хэн нэгэн биднийг гомдоосон үед бид юу хийх ёстой вэ? (Матай 5:24; 18:15; С ба Г 64:8–11-ийг үз.) Биднийг гомдоосон хүнийг биднээс өршөөл гуйхыг нь хүлээхийн муу тал юу вэ?
- Матай 5:27-д Есүс эртний ямар хуулийн талаар ярьсан бэ? (*Энэ айлдварыг та нар сонссон* гэдгийн доор *Завхайрч болохгүй* гэж бич.) Энэ зарлигийг орлох ямар хуулийг Есүс өгсөн бэ? (Матай 5:28-ыг үз. *Харин би та нарт хэлье* гэдгийн доор *Тачаангуй бодлоос зайлсхий* гэж бич.) Бузар санааны зарим үр дагавар юу вэ? (Мозая 4:30; Алма 12:14; С ба Г 63:16-г үз.) Бид бодол санаагаа цэвэр ариун байлгахын тулд юу хийж болох вэ?
- Матай 5:29–30-д дурьдсанаар нүд болон гар нь гэм нүглийг төлөөлдөг гэж Иосеф Смитийн Орчуулганд өгүүлсэн байдаг. Эдгээр шүлгүүд бидэнд гэм нүглээ хэрхэн цайруулах талаар юу заадаг вэ?
- Матай 5:33-т бичсэнчлэн Хуучин Гэрээний үеийн хүмүүс үнэнийг хэлж байгаагаа хэрхэн баталдаг байсан бэ? (*Энэ айлдварыг та нар сонссон* гэдгийн доор *Их Эзэнд амласнаа биелүүл* гэж бич.) Есүс энэ зан үйлийг орлох ямар хуулийг өгсөн бэ? (Матай 5:34–37-г үз. Ахлагч Брүс Р.МакКонкийн хэлсэн дараах мэдэгдлийг унш. Дараа нь *Харин би та нарт хэлье* гэдгийн доор *Хэлснээ биелүүл* гэж бич.)
 Ахлагч Брүс Р.МакКонки хэдэхдээ: “Тангараглах гэдэг нь Мосегийн хуулийн дагуу ердийн зүйл байсан бөгөөд амьдрал дээр тангараглаж хийгдээгүй зүйлд үнэний хувь бага байдаг гэх мэт олон янзын нөхцөл байдлыг хамардаг байсан. . . . Христийн төгс хуулийн дагуу бол хүн бүрийн хэлсэн үг үнэн байх бөгөөд хэлсэн бүх зүйлүүд нь тангараглаж хэлсэн үг нэг бүртэй адил үнэн юм” гэжээ (*The Mortal Messiah*, 4 vols. [1979–81], 2:140).
- Матай 5:38-д Есүс эртний ямар хуулийн талаар ярьсан бэ? (*Энэ айлдварыг та нар сонссон* гэдгийн доор *Нүдийг нүдээр* гэж бич. “Нүдийг нүдээр” гэдэг нь бусдыг гэмтээсэн хүн шийтгүүлэхдээ адилхан гэмтэл авах болно гэсэн утгатай гэдгийг тайлбарла. Левит 24:17–21-ийг үз.) Ямар зарлиг энэ хуулийг орлодог вэ? (Матай 5:39–40-ийг үз. *Харин би та нарт хэлье* гэдгийн доор *Нөгөө хацраа тавьж өг* гэж бич.) Биднийг цохих хэн нэгэнд нөгөө хацраа тавьж өг, мөн бидний хүрмийг авах хэн нэгэнд өөрсдийн нөмрөгийг өг хэмээн ярихдаа Есүс ямар зарчмыг заасан бэ?

- Матай 5:43-т Есүс эртний ямар зан үйлийн талаар ярьсан бэ? (Энэ айлдварыг та нар сонссон гэдгийн доор *Хөршөө хайрла, дайснаа үзэн яд* гэж бич.) Ямар зарлиг энэ зан үйлийг орлох вэ? (Матай 5:44–47-г үз. *Харин би та нарт хэлье* гэдгийн доор *Дайснуудаа хайрла* гэж бич.) Дайснаа хайрлах хайрыг бид хэрхэн хөгжүүлэх вэ? (Моронай 7:47–48-аас нэг жишээг үз.) Дайснаа хайрласнаар бидний амьдрал хэрхэн өөрчлөгдөх вэ? Тэдний амьдрал хэрхэн өөрчлөгдөж болох вэ?

Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол ангийн гишүүдийг самбар руу харж, Матай 5:17–47-д байгаа урилгуудаас ялангуяа тэдэнд ашиг тустайг нь жагсааж бичихийг хүс.

- Бид төгс төгөлдөр болно гэсэн Аврагчийн тушаалыг бид юу гэж ойлгох вэ? Төгс төгөлдөр гэдэг үгийн өөр нэг Грек орчуулга нь бүрэн, дууссан, гүйцэд хөгжсөн гэсэн үг. Төгс төгөлдөр байх гэсэн тушаал нь биднийг санаагаар унагахаас илүү хэрхэн эрч хүчтэй байлгадаг вэ?

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит хэлэхдээ:

“Тэнгэр дэх Эцэг маань төгс төгөлдөр шиг бид төгс төгөлдөр байх ёстой гэж Их Эзэний хэлсэнд би итгэдэг. Энэ нь нэг өдөр л бий болчихдоггүй, харин шугаман дээр шугам, тушаалын дээр тушаал, жишээн дээр жишээгээр бий болох бөгөөд зөвхөн энэ мөнх бус амьдралд бус, төгс төгөлдөр байдалд хүрч, Бурхантай адил болох хүртлээ бид үхлээс цааш ч явах болно.

“Гэвч бид энд суурийг нь тавьдаг. Тэр төгс төгөлдөр байдалд биднийг бэлтгэх Есүс Христийн сайн мэдээний эдгээр энгийн үнэнүүдийг бид энд, энэ сорилтын байдалд заалгах юм. Бид өнөөдөр өчигдөр байснаасаа илүү сайн, маргааш өнөөдрөөсөө илүү сайн байх нь бидний үүрэг юм. . . . Хэрэв бид Их Эзэний зарлигуудыг дагаж байгаа бол төгс төгөлдөр байдалд хүрэх зам дээр байна” гэсэн (*Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 vols. [1954–56], 2:18–19; мөн С ба Г 93:11–14, 19–20-ийг үз.)

- Аврагчийн Цагаатгал биднийг төгс төгөлдөр байдалд хүрэхэд хэрхэн тусалдаг вэ? (Моронай 10:32–33; С ба Г 76:68–70-ыг үз.) Уулан Дээрх Номлолын сургаалууд биднийг Христэд ирж, түүгээр дамжин төгс төгөлдөр болоход хэрхэн тусалдаг вэ?

Дүгнэлт

Уулан Дээрх Номлолын сургаалууд биднийг Христэд ирж, түүгээр дамжин төгс төгөлдөр болоход тусалдаг гэдгийг гэрчил. (Моронай 10:32-ыг үз.) Ангийн гишүүдэд тэдгээр сургаалуудыг амьдралдаа хэрэгжүүлэхийг уриал. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол ангийн гишүүдээс жагсааж бичсэн урилгаа харж, ирэх долоо хоногийн туршид тэдгээрийн нэг юмуу хоёрыг нь голлон анхаарч үзэхээр сонгохыг хүс.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Илүү Давуу Зам” (1 Коринт 12:31)

Ангийн хэдэн гишүүнээс Матай 5 дахь сургаалууд гэрт нь, сургууль дээр болон ажил дээр нь тэдэнд хэрхэн тусалж болох талаар санаа бодлоо хуваалцахад бэлтгэж ирэхийг урь.

2. Гэр бүл салалтын талаарх Аврагчийн номлол

Хэрэв танд болон ангийн гишүүдэд Матай 5:31–32-ын талаар асуулт байвал 14-р хичээлийн заах нэмэлт санаануудын тавдугаарыг үз. (хуудас 60-г үз.)

3. Дүрс бичлэг

New Testament Video Presentations (53914)-ээс сонгож “New Testament Customs”-ын хоёр дахь хэсэгт Мосегийн хуулийг дүрслэн үзүүлэхийн тулд Галат 3:24–25-д хэрэглэсэн *зааварлагч* гэсэн хэллэгийг тайлбарласан. Хэрэв та энэ хэсгийг үзүүлбэл Мосегийн хууль хүмүүсийг Христ руу авчрахад хэрхэн зааварлагч болсон бэ гэдгийг ярилц.

“Эхлээд Бурханы Хаант Улсыг Хайгтун”

Матай 6–7

Зорилго

Ангийн гишүүдийг Есүс Христэд улам илүү бүхнээ зориулсан шавь нар болоход уриалах болно.

Бэлтгэл

1. Уулан Дээрх Номлолын үргэлжлэл болох дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 6:1–6, 16–21. Есүс шавь нартаа өглөг өгөх, залбирах ба нууцаар мацаг барихыг мөн газар дээрхийн оронд тэнгэр дэх эд баялгийг хураахыг заадаг.
 - б. Матай 6:7–13; 7:7–11. Тэр шавь нартаа хэрхэн залбирахыг үзүүлж, хэрэгцээтэй зүйлсээ гуйн асуусан хүмүүсийг Тэнгэрлэг Эцэг адислана гэдгийг заадаг.
 - в. Матай 6:14–15; 7:1–6, 12. Есүс шавь нартаа бусдыг өршөөж, шударгаар шүүн, хүмүүс та нарт яаж хандаасай гэж хүсдэг тэр байдлаараа бусдад хандахыг заадаг.
 - г. Матай 6:22–34; 7:13–29. Тэр шавь нартаа Тэнгэрлэг Эцэгт үйлчлэн, түүний хүслийг гүйцэлдүүлснийхээ төлөө адислагдана гэдгийг заадаг.
2. Нэмэлт Уншлага: Лук 6:37–49; 11:1–13; 34–36; 12:22–34; 16:3; 3 Нифай 13–14.
3. Хэрэв дараах материалууд байгаа бол хичээлдээ хэрэглэ:
 - а. Уулан Дээрх Номлол зураг (62166; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 212)
4. Заахад зориулсан зөвлөмж: Түүх нь ангийн гишүүдийн анхаарлыг татаж, сайн мэдээний зарчмыг зарим Заахад зориулсан адилаар дүрслэн үзүүлж чаддаг. Есүс чухал хичээл заахдаа эсвэл хийсвэр санаануудыг ойлгомжтой болохын тулд байнга түүх ашигладаг байсан. Та хичээлээ бэлтгэхдээ ангийн гишүүдийг сайн мэдээний зарчмуудыг ойлгоход туслах түүхийг хэрхэн ашиглаж болох талаар бодож үз. Та түүхийг ярихдаа энэ нь үнэн явдал уу эсвэл уг утга санааг илэрхийлэхээр зохиосон түүх үү гэдгийг ангийн гишүүдэд ойлгуулахад анхаар.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Далын Ахлагч Виллиамс Р.Брадфорд нэг удаа үйл ажиллагаандаа зарцуулах мөнгө олохоор ажилласан өсвөр насныхны хэсгийн бишоптой ярилцсан юм. Бишоп Ахлагч Брадфордоос өсвөр насныхныг, хийсэн зүйлийнх нь төлөө ямар нэгэн урамшлыг авахад тусална уу гэж гуйв. Ахлагч Брадфорд ийм юм

хийхгүй гэж хэлсэн нь бишопын гайхлыг төрүүлэв. Тэрээр залуу хүмүүс сайн ажилласанд талархаж байгаа боловч хийсэн ажлынхаа төлөө олон нийтээс урамшил хүлээн авах нь чухал биш гэж хэлэв.

Өсвөр насныхан мөнгөө үйл ажиллагаандаа зарцуулахын оронд Сүмийн номлогчийн ерөнхий санд хандивлахаар шийдээд, хандив өгөхдөө Ахлагч Брандфордтой хамт зургаа авахуулж, сонинд өгүүллэг бичиж зурагтайгаа хамт тавихыг хүсэв. Ахлагч Брандфорд “үгүй” гэж хэлснээр дахин тэдний гайхлыг төрүүлжээ. Тэрээр бишопт хэлэхдээ: “Та залуучууддаа урамшлын дээд хуулийг мэдэж авахад нь туслах талаар бодож үзээрэй. Дээрээс ирдэг урамшил нь намуухан байдаг. Энэ нь тэндээ үнэн зөв бөгөөд чимээгүйхэн бичигддэг. Тэд баяр баясгаланг мэдэрч, зүрх сэтгэл болон сүнсээрээ харамгүй, намуухан үйлчлэлээс ирдэг эрдэнэсийг олж аваг” гэсэн (Conference Report, Oct. 1987, 90–91; or *Ensign*, Nov. 1987, 75).

- Ахлагч Брандфордын өсвөр насныханд өгсөн хариултаас бид юу сурч болох вэ?

Бусад хүмүүсээс урамшил авахын тулд биш харин Бурханд хайртай бөгөөд түүнийг баярлуулахыг хүсдэг учраас бид сайн зүйлийг хийх ёстой гэдэг нь бидний сурч болох нэг хичээл хэмээн цохон тэмдэглэ. Энэ нь Есүс Христийн үнэнч шавийн шинжүүдийн нэг юм.

Самбарт *Үнэнч Шавь нар* гэж бич. Та Уулан Дээрх Номлолын тухай ярилцахдаа энэ номлолд Аврагчийн заасан үнэнч шавийн шинж чанарыг жагсааж бич.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Дараах судрын хэсгүүдийг заахдаа ангийн гишүүн бүрийг бүхнээ зориулсан, чин үнэнч Христийн шавь болохын тулд юу хийх хэрэгтэйн талаар бодохыг уриал. Ангийн гишүүдийг үнэнч шавийн зарчимтай холбоотой хувийн туршлагаасаа хуваалцахыг уриал.

1. Үнэнч шавь нар зөв шалтгааны улмаас зөвийг хийдэг.

Матай 6:1–6, 16–21-ийг уншаад ярилц.

- Есүс яагаад зарим хүмүүсийг өглөг өгөх (ядууст өгөх), залбирах мөн мацаг барих гэх мэт зөв зүйл хийснийх нь төлөө буруутгаж байсан бэ? (Матай 6:1–2, 5, 16-г үз. Тэд буруу шалтгааны улмаас эдгээр зүйлийг хийж байсан.) Эдгээр хүмүүсийг Есүс хоёр нүүртэй хүмүүс гэж нэрлэсэн. Хоёр нүүртэй хүн гэж хэнийг хэлж байгаа вэ? (Тодорхой нэг чадвартай мэт дүр үзүүлдэг ч тэдгээрийг эзэмшээгүй эсвэл зөв шударга мэт харагдахыг хичээдэг ч тийм биш хүнийг хэлнэ. Мөн хоёр нүүрт хүнийг Грекээр дүр үзүүлэгч гэж бас орчуулдаг. Матай 15:8; Лук 11:39-ийг үз.)
- Бусдад харуулан сайн зүйлийг хийдэг хүмүүсийн шагнал нь юу байх вэ? (Матай 6:2, 5, 16-г үз.) Бурханыг баярлуулахын оронд бусдад харуулахын тулд бид ямар зүйлийг хийдэг байж болох вэ? Бусад сайн үйлийг хийж, үйлчилснээрээ бид хэрхэн шинэ эрч хүчийг олох вэ?
- Энэ номлолд Есүс юуг илүү их дээдлэх ёстойн талаар бидэнд юу заасан бэ? (Матай 6:19–21-ийг үз.) “Тэнгэрт эд баялгийг хураа” гэдэг нь юу гэсэн үг вэ? Бидний эрэлхийлж болох зарим тэнгэрлэг эд баялаг юу вэ? (С ба Г 18:14–6 ба 130:18–19-өөс хоёр жишээг үз.)

- “Та нарын эд баялаг хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно” гэж юу гэсэн үг вэ? Бид юуг эрхэмлэн дээдлэхээ хэрхэн тодорхойлж чадах вэ? (Нэг арга нь ямар нэгэн зүйлд зориулдаг цаг, мөнгө болон бодол санаагаа дүгнэж үзэх юм.) Хүмүүс өнөөдөр юуг дээдэлдэг вэ? Ангийн гишүүдийг дээдэлдэг зүйлүүдийнхээ тухай бодож, эдгээр эд баялаг нь тэдний зүрх сэтгэл хаана байгаа талаар юу хэлж буйг чимээгүйхэн эргэцүүлэхийг хүс.

2. Үнэнч шавь нар Аврагчийн залбирлын жишээг дагадаг.

Матай 6:7–13; 7:7–11-ийг уншаад ярилц. Матай 6:9–13-ыг Их Эзэний Залбирал хэмээдэг гэж цохон тэмдэглэ.

- Бид хэрхэн залбирах ёстой талаар Их Эзэний Залбирал юу гэж заадаг вэ? (Матай 6:9–13-ыг үз)
- Есүсийн Тэнгэрлэг Эцэгт үзүүлдэг хүндэтгэл, бишрэлийг Их Эзэний Залбирал хэрхэн харуулдаг вэ? Бид залбирахдаа Тэнгэрлэг Эцэгтээ хүндэтгэл, бишрэлээ хэрхэн үзүүлж чадах вэ?

Ахлагч Даллин Х.Өүкс биднийг залбирахдаа хэрэглэх ёстой үг хэллэгийн талаар саналаа хэлсэн: “Залбирлын тусгай хэллэг нь өөр өөр хэлд янз янзын хэлбэртэй байдаг боловч зарчим нь үргэлж адилхан байдаг. Бид Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахдаа тухайн хэлээр ярьж буй хүмүүс хайр, хүндэтгэл, бишрэл болон дотно байдлаар хэрэглэдэг үгсийг хэлэх ёстой. . . . Хүндэтгэлээ үзүүлэхийг хүссэн хүмүүс залбирлын тусгай хэлийг сурах цаг гаргаж чадна” (Conference Report, Apr. 1993, 17, 20; or *Ensign*, May 1993, 16, 18).

- Бид залбирахдаа “утгагүй хоосон үг” хэрэглэхээс хэрхэн зайлсхийж болох вэ? (Матай 6:7-г үз)
- Тэнгэрлэг Эцэг биднийг залбирахаас өмнө юу хэрэгтэйг маань мэддэг ч гэсэн (Матай 6:8) бид яагаад залбирах хэрэгтэй вэ? Гуйх, хайх, тогших (Матай 7:7) нь биднийг сүнслэг байдлаараа өсч хөгжихөд яагаад шаардлагатай байдаг вэ? Бид Тэнгэрлэг Эцэгийн туслалцааг хэрхэн илүү хичээнгүйгээр эрэлхийлж чадах вэ?
- “Гуйдаг хүн авна” гэсэн Аврагчийн амлалтыг бид хэрхэн ойлгох ёстой вэ? (Матай 7:8.) Бид заримдаа яагаад тэр дороо эсвэл хүсч байснаараа гуйсан зүйлээ хүлээн авдаггүй вэ? (3 Нифай 18:20-ийг үз.) Бурхан та нарт юу хамгийн сайныг мэддэг хэмээн та нар хэрхэн мэдэж авсан бэ?

3. Үнэнч шавь нар бусадтай эелдэг, шударга харьцдаг.

Матай 6:14–15; 7:1–6, 12-ыг уншаад ярилц.

- Яагаад Аврагч бидэнд бусдыг өршөөхийг тушаасан гэж та нар бодож байна вэ? Бид хэрхэн илүү өршөөнгүй болж чадах вэ?
- Иосеф Смитийн Орчуулга Матай 7:1-д бид шударга бусаар шүүх ёсгүй тэгснээр бид шүүгдэхгүй байх болно; харин зөв шударга шүүлтээр шүүх ёстой гэсэн залруулга хийсэн. (Иосеф Смитийн Орчуулга, Матай 7:2-ыг үз.) Зөв шударга шүүлт гэж юу вэ? Хэрэв бид шударга бусаар шүүвэл бидний шүүсэн хүмүүст болон бидэнд ямар уршиг ирэх вэ? Бид

шударгаар шүүж байгаагаа хэрхэн баталж чадах вэ? (Матай 7:3–5; Моронай 7:14–18-ыг үз.)

- Бусдыг шударга бусаар буруутгахыг хичээдэг хүн нь хоёр нүүрт хүн гэж Есүс хэлсэн (Матай 7: 4–5). Шударга бусаар шүүх нь хоёр нүүр гаргаж байгаа шинж тэмдэг хэрхэн болдог вэ?
- Матай 7:12-т заасан зарчмын үнэ цэнийг танд ямар явдал харуулсан бэ? Энэ зарчим нь биднийг хэрхэн Есүс Христийн илүү сайн шавь нар болгодог вэ?

Ахлагч Марвин Ж.Аштон хэсэг Сүмийн гишүүд “Хэн нэгнийг Есүс Христэд чин сэтгэлээсээ итгэж байгааг нь та хэрхэн хэлж чадах вэ?” гэсэн асуултын талаар ярилцсан хурлыг ийнхүү тодорхойлж бичсэн:

“Оролцогчид дөчин таван минутын туршид энэ асуултын хариу болгон олон саналыг хэлж удирдагч нь хариулт бүрийг том самбарт нямбай бичсэн. Тэдгээр нь бүгд л гүн утгатай, зохих ёсны саналууд байлаа. Гэвч цагийн дараа энэ агуу багш бичсэн бүх зүйлээ арилгав. Дараа нь тэрбээр бүх саналууд зөв байсан гэдгийг үнэлэн талархаад, нэн чухал нэг зарчмыг заасан: ‘Биднийг сүнслэг байдлаар өсч хөгжин, Христэд ирж байгааг харуулах хамгийн сайн, хамгийн тодорхой зүйл бол бусад хүмүүст хандах бидний хандлага юм.’

Ахлагч Аштон: “Тэр бүлийн гишүүд, найз нөхөд болон бидэнтэй өдөр тутам ажилладаг хүмүүст хандах байдал маань заримдаа бидний онцлон үздэг илүү анхаарал татсан зарим сайн мэдээний зарчмууд шиг чухал байдаг.” гэж нэмж хэлсэн (Conference Report, Apr. 1992, 25; or *Ensign*, May 1992, 20).

4. Үнэнч шавь нар Бурханд үйлчилж, түүний хүссэнийг хийдэг.

Матай 6:22–34; 7:13–29-өөс сонгосон шүлгийг уншаад ярилц.

- Бурхан болоод эд баялаг буюу дэлхийн зүйлд хоёуланд нь үйлчлэх нь яагаад боломжгүй вэ? (Матай 6:24-ийг үз.) Түүнд үйлчилсэн хүмүүст Бурхан ямар адислалуудыг амладаг бэ? (Матай 6:25–33; С ба Г 11:7-г үз.)
- Хэрэв бид “эхлээд Бурханы хаант улсыг хайвал” бидэнд хэрэгтэй бусад бүх зүйлс бидэнд өгөгдөх болно гэж Есүс амласан (Матай 6:33). Энэ амлалтын гэрчлэлийг олж авахад танд ямар тохиолдол тусалсан бэ?
- Дэлхийн эд зүйл нь бидний шударга зан болон үйлчлэлийг Бурханаас хэрхэн холдуулдаг вэ? Бурханы зүйлээс түрүүнд дэлхийн зүйлийг эрж хайн уруу таталтанд оруулдаг зарим зүйлүүд нь юу вэ? (Хариултанд, бид хүссэн буюу хэрэгтэй зүйлээ авах хүртлээ аравны нэгээ төлөхөө хойшлуулдаг эсвэл дэлхийн эд зүйлийг хүссэний улмаас номлолд үйлчлэхгүй байхаар шийдэх зэрэг нь орж болно.)
- Есүс номлолынхоо төгсгөл үед тэнгэрийн хаант улсад орох талаар юу заасан бэ? (Матай 7:13–14, 21–23-ыг үз.) Сүйрэлд хүрэх зам нь өргөн байхад мөнхийн амьдралд хүрэх зам нь нарийн байх нь яагаад ач холбогдолтой вэ?
- Уулан Дээрх Номлолын төгсгөлд Есүс мэргэн хүн болон мунхаг хүний тухай сургаалт үлгэрийг өгүүлсэн (Матай 7:24–27). Энэ сургаалт үлгэр

бидэнд хэрхэн хамаарах вэ? Бид сууриа болгож дээр нь барих ёстой тэр “хад” гэж юу вэ? (Хиламан 5:12-ыг үз.) Зарим хүмүүс амьдралаа элстэй зүйрлүүлж болох ямар зүйл дээр барьдаг вэ?

Дүгнэлт

ЕсүсХристийг дагахын чухлын талаар гэрчил. Ангийн гишүүдэд Христийн илүү сайн шавь нар болохын тулд юу хийх хэрэгтэйгээ бодож үзэхийг уриал.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Та нар тэднийг үр жимсээр нь танина” (Матай 7:20)

- Есүс дагалдагч нартаа хуурамч бошиглогчид—хуурамч номлол заадаг эсвэл хүмүүсийг Христээс холдуулахыг хичээдэг хүмүүсийн талаар анхааруулдаг (Матай 7:15.) Бид хуурамч болон жинхэнэ бошиглогчдыг хэрхэн ялгаж чадах вэ? (Матай 7:6–20; мөн Моронай 7:5, 10–11-ийг үз.) Матай 7:20 нь бидэнд болон бошиглогчдод хэрхэн хамаарч болох вэ?

2. Дүрс Бичлэг

New Testament Video Presentations (53914)-ээс сонгож “New Testament Customs”-ын хоёр дахь хэсэгт Иудейчүүд магнайн ба гарын сахиус, цацаг хэрэглэдэг тухай тайлбарладаг. Хэрэв та энэ хэсгийг үзүүлбэл нэгэн цагт Бурханд дуулгавартай байдлаа харуулахад хэрэглэгдэж байсан эдгээр зүйлүүд бишрэн мөргөхдөө “хүмүүст харагдах” гэсэн Фарисайчуудын хүслийн бэлэг тэмдэг хэрхэн болсон талаар ярилц (Матай 6:5).

3. Өөрийн нүдэн дэх дүнзийг олох нь

Дотроо гомдсон нэгэн эгчид өөрийнхөө нүдэн дэх дүнзийг олж харахыг Бошиглогч Иосеф Смит хэрхэн заасан тухай дараах түүхийг хуваалц:

Бошиглогч Иосеф Смит дээр нэгэн эмэгтэй ирээд түүний тухай Сүмийн нэг гишүүний ярьсан зарим зүйлд уурлаж байгаагаа хэлжээ. Бошиглогч түүнд, хэрэв тэр хүний хэлсэн зүйл худал бол үнэн үлдэж, худал зүйл үгүй болдог учраас тэр асуудлыг бүү тоо гэж хэлжээ. Эмэгтэй хэлсэн зүйлийг худлаа байсныг мэдсэн ч асуудлыг тоохгүй өнгөрөх нь түүнд хангалттай биш байв. Бошиглогч тиймэрхүү зүйлийг яаж зохицуулдаг аргаа ярьжээ:

“Заримдаа дайснууд нь түүний тухай гүжирдсэн зүйлийг ярихад тэрээр шүүмжлэхээ азнаж, энэ яриаг гаргах болгоомжгүй үг, үйлдэл хийсэн эсэхээ санах гэж уг явдлын талаар эргэж боддог байв. Хэрэв тэр ийм явдал гаргаснаа олж мэдвэл зүрх сэтгэлдээ дайснаа өршөөж, мэдэхгүй явсан сул талаа анхаарахыг сэрэмжлүүлсэнд нь талархдаг байсан гэж хэлэв.”

Тэр хүний ийнхүү ярих болсон шалтгааныг санамсаргүйгээр бий болгосон эсэхээ сайн бодож үзэх ёстой гэж Бошиглогч энэ эгчид хэлэв. Ихэд бодсоны эцэст тэр эгч ийм зүйл бий болгосноо хүлээж, Бошиглогчид талархсанаа илэрхийлээд, салж одлоо (Jesse W. Crosby, quoted in Hyrum L. Andrus and Helen Mae Andrus, comps., *They Knew the Prophet*-ыг үз [1974], 144.)

4. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Матай 6 ба 7-гоос авсан дараах хэсэг тус бүрийг нэг нэг хөзөр дээр бич.

Зүүн гартаа бүү мэдэгд (6:3)	Баруун гарынхаа юу хийж буйг (6:3)
Нууцаар харагч Эцэг чинь (6:6)	Чамд буцааж төлнө (6:6)
Бүү хэрэглэ (6:7)	Хоосон үг (6:7)
Хүмүүсийг уучил (6:14)	Тэдний алдааг (6:14)
Өөрсөддөө хураа (6:20)	Тэнгэр дэх эд баялаг (6:20)
Та үйлчилж чадахгүй (6:24)	Бурхан болон эд баялаг хоёрт (6:24)
Та эхлээд . . . эрэлхийл (6:33)	Бурханы хаант улсыг (6:33)
Дүнзийг авч хая (7:5)	Өөрийнхөө нүднээс (7:5)
Асуу (7:7)	Та нарт өгөгдөнө (7:7)
Хай (7:7)	Та нар олно (7:7)
Болгоомжил (7:15)	Хуурамч бошиглогчдоос (7:15)
Жимсээр нь (7:20)	Та нар тэднийг . . . танина (7:20)

Хөзрөө ширээ буюу шалан дээр доош нь харуулж тавь. Ангийн гишүүдийг хоёр багт хуваагаад, багуудыг ээлжлүүлэн хоёр хөзөр авахуул. Хэрэв тухайн багийн хөзөр ижилсвэл тэдгээрийг өөр газар тавиад дахин сугална. Хэрэв хөзөр ижилсэхгүй бол тэдгээрийг байсан байранд нь буцаан тавьж нөгөө баг сугална. Бүх ижлийг нь гаргал үргэлжлүүл.

“Буулгыг минь Өөр Дээрээ Авч Надаас Суралц”

Матай 11:28–30; 12:1–13; Лук 7:36–50; 13:10–17

Зорилго

Ангийн гишүүдэд Аврагчийн буулгыг өөрсөд дээрээ авч мөн түүний хүслийг гүйцэтгэвэл бид түүний амласан амар амгалан, баяр баясгаланг олно гэдгийг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 11:28–30. Есүс эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн бүх хүмүүсийг түүн рүү ирж, буулгыг нь өөр дээрээ авч түүнээс суралц гэж урьдаг.
 - б. Матай 12:1–13; Лук 13:10–17. Есүс өөрийгөө Хүндэтгэлийн өдрийн Их Эзэн хэмээн тунхагладаг. Тэр Хүндэтгэлийн өдөр өвчтөнийг эдгээж түүнийхээ төлөө шүүмжлүүлдэг.
 - в. Лук 7:36–50. Өршөөл хүссэн нэгэн эмэгтэй Их Эзэний хөлийг нулимсаараа угаадаг; нүгэлт эмэгтэйг Өөртөө хүргэсэнд нь Есүсийг Фарисайн Симон шүүмжилдэг. Есүс Симонд хоёр зээлэгчийн тухай сургаалт үлгэрийг заадаг ба тэр эмэгтэйг өршөөдөг.
2. Нэмэлт Уншлага: Исаиа 58:13–14; Матай 11:16–19; 12:14–50; 26:6–13; Марк 2:23–3:12; 14:3–9; Лук 6:1–11; Сургаал ба Гэрээ 59:9–19.
3. Хэрэв дараах материалууд байгаа бол хичээлдээ хэрэглэ:
 - а. *New Testament Video Presentations* (53914)-ээс “Come unto Me” долоон минутын бичлэг.
 - б. Хөллөсөн хоёр шарын зурагтай, Мэри Филдинг ба Иосеф Ф.Смит нар Тал Газрыг Туулан Гарсан нь зураг (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 412)
4. Заахад зориулсан зөвлөмж: Та хичээл бүрийг бэлтгэхдээ ангийн гишүүн бүрийг оролцохыг хэрхэн уриалах талаар залбирч бодож үз. Үзүүлэнг толилуулах, баг болгож ярилцлага явуулах, жүжигчилсэн тоглолт хийх болон бусад зохих үйл ажиллагаанууд нь ангийн гишүүдийг илүү идэвхтэй оролцоход тусалдаг.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн нэг гишүүнийг ангийнхны өмнө гарч ирээд, гараа урагш сунгахыг хүс. Энэ хүний гар дээр ном эсвэл өөр хүнд зүйлүүдийг тавь. Түүнийг ядартал эд зүйлсийг гар дээр нь тавь. Дараа нь:

- Та нар амрахаар зогсох хүртлээ энэ ачааг хэр хол үүрч явж чадах вэ?
Та нар ачааг хол газар үүрч явахын тулд ямар бэлтгэл хийх ёстой вэ?

Олон төрлийн ачаа эсвэл дарамт байдаг гэдгийг тайлбарла. Сүнслэг, сэтгэлийн гэсэн харагддаггүй нь байхад, зарим нь бодит зүйлүүд байдаг.

Үл үзэгдэх олон дарамтыг ганцаараа үүрэх нь бидний хэр чадлаас хэтэрсэн байдаг бөгөөд бид сульдаж ядардаг. Энэ хичээлд Их Эзэн бидний ачааг хэрхэн хөнгөлж, биднийг амраадаг тухай ярилцана.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Есүс түүний буулгыг өөрсөд дээрээ авч түүнээс суралц гэж биднийг урьдаг.

Матай 11:28–30-ийг уншаад ярилц.

- “Эцэж туйлдан, хүнд дарамт үүрсэн” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Матай 11:28). Энэ амьдралд бидний үүрдэг зарим ачааны жишээ юу вэ? Их Эзэн хэрхэн эдгээр ачаанаас “[бидэнд] амралтыг өгч” чадах вэ?
- Буулга гэж юу вэ? (Мэри Филдинг болон Иосеф Ф.Смитийн зургийг үзүүлж, зураг дээрх хөллөөтэй шарыг онцолж заа. Буулга гэдэг нь хүнд ачаа зөөх, чирэхийн тулд нэг юмуу хоёр хүн эсвэл амьтныг холбон хөллөсөн дамнуурга мод гэдгийг тайлбарла. Буулга ачааг тэнцвэржүүлж, авч явахад хялбар болгодог. Үүний үгчилсэн утга дээр нэмж хэлэхэд олон сударт буулга гэдгийг шилжүүлсэн утгаар эрхшээлд байх эсвэл боолчлол гэж хэрэглэдэг; Иеремиа 28:2; Алма 44:2-ыг үз.) Христийн буулгыг өөрсөд дээрээ авна гэдэг нь юу гэсэн үг вэ? (Түүний хүслийг даруухнаар биелүүлж, түүгээр өөрсдийн амьдралаа удирдан чиглүүлүүлэх.)

Хэрэв та “Come unto Me” дүрс бичлэгийг хэрэглэж байгаа бол эхний хэсгийг одоо үзүүл. Бичлэгийг Ерөнхийлөгч Ховард В. Хантэр ярьж дуусангуут зогсоо.

- Их Эзэн “Миний буулга амархан, миний ачаа хөнгөн” гэж өгүүлсэн (Матай 11:30). Аврагчийн буулга ямар утгаараа амархан бэ? Зарим хүмүүс яагаад Их Эзэний сургаалууд нь хэт хязгаарлагдмал гэж боддог вэ? Их Эзэнийг дуулгавартай дагаж, үйлчлэх нь бидний ачааг хэрхэн хөнгөлдөг вэ?

2. Есүс өөрийгөө Хүндэтгэлийн өдрийн Их Эзэн хэмээн тунхагладаг.

Матай 12:1–13 болон Лук 13:10–17-г ярилц. Сонгосон хэсгийг чангаар уншихад ангийн гишүүдийг урь.

- Хүндэтгэлийн өдөр Есүсийн шавь нарыг тариан түрүү шувтран идэж байхыг Фарисайчууд хараад юу хийсэн бэ? (Матай 12:1–2-ыг үз. Мосегийн хуулинд өгдөг Фарисайчуудын тайлбар нь үнэн сүнс ба Хүндэтгэлийн өдрийн зорилгыг үл тоомсорлож, үүний оронд Хүндэтгэлийн өдрийн үйл ажиллагааг ихэд хязгаарласан зан заншилд голлон анхаарсан байдаг гэдгийг тайлбарла.) Их Эзэн тэдний буруушаалтанд хариулахдаа юу заасан бэ? (Матай 12:3–8-ыг үз.)
- Есүс “Би тахилыг бус энэрлийг хүсдэг” гэж хэлэхдээ ямар утгаар хэлсэн бэ? (Матай 12:7. Тэрээр хүмүүс зөвхөн олон нийтийн шашны ёслол гүйцэтгэхэд биш, бусдыг хайрлахад гол анхаарлаа чиглүүлэхийг хүссэн.) Бид энэ зарчмыг хүндэтгэлийн өдрийн үйл ажиллагаагаа зохицуулахад хэрхэн ашиглаж болох вэ?
- Есүс хатингар гартай эрийг болон өвчинд нэрвэгдсэн эмэгтэйг эдгээхдээ Хүндэтгэлийн өдрийн зорилгын талаар юу заасан бэ? (Матай 12:10–13;

Лук 13:10–17-г үз.) Марк 2:27–28-д Хүндэтгэлийн өдрийн талаар тэр юу заасан бэ? (Иосеф Смитийн Орчуулгын Марк 2:26 нь Хүндэтгэлийн өдөр нь амралтын өдөр ба Бурханыг алдаршуулах өдөр байхаар өгөгдсөн гэж тайлбарласныг цохон тэмдэглэ.) Хүндэтгэлийн өдөр Бурханыг алдаршуулахын тулд бид юу хийж болох вэ? Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих нь бидний ачааг хэрхэн хөнгөлж, биднийг амраадаг вэ?

3. Есүс Фарисайн Симоны гэрт нэгэн эмэгтэйг өршөөдөг.

Хэрэв та “Come unto Me” дүрс бичлэгийг хэрэглэж байгаа бол үлдсэн хэсгийг одоо үзүүл. Дараа нь Лук 7:36–50-иас сонгосон хэсгийг уншаад ярилц.

- Фарисайн Симоны гэрт орж ирсэн тэр эмэгтэй нүгэлтэй эмэгтэй байсан (Лук 7:37). Есүс түүний ачааг авахын тулд тэр эмэгтэй юу хийсэн бэ? (Лук 7:38, 44–50-ийг үз.) Аврагч бидний амьдралаас нүглийн ачаа дарамтыг маань зайлуулахын тулд бид юу хийж болох вэ?
- Нүгэлт эмэгтэйн болон Фарисайн Симоны Есүст хандах хандлага ямар ялгаатай байсан бэ? (Эмэгтэйн наманчлал, хүндэтгэл, төлөв түвшин байдал ба хайрыг Симоны бардамнал, бүдүүлэг байдал ба шүүмжлэмтгий зантай харьцуул. Мөн доорх ишлэлийг үз.) Эмэгтэйд байсан чанарууд нь биднийг наманчилж, өршөөл хүсэхэд яагаад чухал вэ? Симонд байсан чанарууд биднийг наманчлахаас хэрхэн холдуулдаг вэ?

Ахлагч Жэймс И.Талмаж: “алдар цуутай зочинд ихэд анхаарал тавин, морилохыг хүсэн үнсэж, хөлийг нь угаах ус, толгой болон сахлыг нь тослох тос авчирч угтах нь тэр үеийн ёс заншил байсан. Симон эдгээр бүх зэлдэг халамжийг үзүүлээгүй.” (*Jesus the Christ*, 3rd ed. [1916], 261.)

- Симоны тэр эмэгтэйд хандах хандлага нь түүний ачааг хэрхэн илүү хүнд болгосон бэ? Бид заримдаа бусдыг, нүглийн ачаа нь улам хүнд болсон мэт санахад хэрхэн хүргэдэг вэ? Эмэгтэйд хэлсэн Аврагчийн үгнээс бид юу сурч болох вэ?
- Хэдийгээр тэр уригдаагүй ч, мөн Симон болон түүний гэр бүлийнхэн түүнд муу хандана гэдгийг мэдсэн ч, тэрээр Христийн хаана байгааг мэдмэгцээ түүн рүү шууд очсон (Лук 7:37). Түүний жишээнээс бид юу сурч болох вэ? Наманчилж, Христ рүү очиход бидэнд юу саад болдог вэ? Эдгээр саадыг бид хэрхэн даван туулах вэ?
- Хоёр зээлэгчийн тухай сургаалт үлгэрээс бид юу сурч болох вэ? (Лук 7:41–50-ийг үз). Нүглийг өртэй хэрхэн зүйрлэж болох вэ? (Лук 7:44–50-ийг үз). Христийг “зээлдүүлэгчээ” болгох нь бидний ачааг хэрхэн хөнгөлөх вэ?

Дүгнэлт

Бид өөрсөд дээрээ дэлхийн ачааг эсвэл Христийн буулгыг авах сонголт хийж болно гэдгийг гэрчил. Христийн сургаалууд үнэн бөгөөд түүнийг дагаснаар бид амар тайвныг олно гэдгийг гэрчил. Ангийн гишүүдийг Христийн талаар сурч мэдэж, түүний сургаалыг дуулгавартай дагаснаар амар тайван ба амар амгаланг олно гэдгийг уриал.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Нэгдмэл байхын ач холбогдол

Матай 12:22–30-ийг уншаад ярилц.

- Заримдаа бид гэр бүл дотроо, гэртээ эсвэл хэсэг дотроо бие биентэйгээ хэрхэн зөрчилддөг вэ? Бид илүү нэгдмэл болохын тулд юу хийж болох вэ?
- Есүс Фарисайчуудад “Надтай хамт байдаггүй хүн миний эсрэг байна” гэж хэлсэн (Матай 12:30). Яагаад ийм байдаг вэ?

2. “Бодлогогүй хэлсэн үг болгон” (Матай 12:36)

Матай 12:33–37-г уншаад ярилц.

- Бидний хэлдэг үгс өөрсдийн маань талаар юу илэрхийлдэг вэ? Бидний хэлдэг үгсийг Есүс яагаад чухалчилдаг вэ? “Бодлогогүй хэлсэн үг”-ийн зарим жишээ юу вэ? (Хариултанд, егөөдөл, хов жив, худал яриа, хараалын үг, бүдүүлэг зан зэрэг нь орж болно.) Бид зөвхөн боловсон яриа хэрэглэнэ гэсэн өөрсдийн амлалтаа хэрхэн батжуулж болох вэ?

3. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Ангийн гишүүн бүрт дараах үгийн сүлжээтэй хуудас цаасыг бэлтгэ. Өгөгдсөн зүйлийг уншиж, ярилцсаныхаа дараа үгийн сүлжээгээ тараа. Ангийн гишүүдээс хичээлтэй холбоотой үгсийг үгийн сүлжээнээс олохыг хүс. Үгс нь босоо, хэвтээ эсвэл ташуу байрлалд байж болно. Хэдэн минутын дараа ангийн гишүүдэд тусламж хэрэгтэй бол тэдгээр нуугдсан үгсийг агуулсан шүлгүүдийг дахин уншуул (Матай 11:28–30: дарамт, хүнд ачаа, буулга; Матай 12:1–13; Хүндэтгэлийн өдөр, эдгээх; Лук 7:36–50: сургаалт үлгэр, зээлдэгч, уучлагдсан).

Х	Р	Б	А	Р	Д	Х	Ө	З	Б	Ь	Б	Ө	Л	Э	Д
Р	Ү	Г	Я	У	А	О	С	Л	Ё	Л	Р	Д	З	Э	У
Н	Г	Н	Ү	К	Р	В	З	Э	Э	Л	Д	Э	Г	Ч	Ц
Х	Х	О	Д	Э	А	Р	Р	О	Л	З	Г	Э	У	Ц	Ц
Б	Ө	Т	Й	Э	М	О	У	А	Л	Ө	Ё	Б	Р	В	Ё
Ц	У	Э	Н	Г	Т	Г	Н	Ү	З	Э	С	У	Х	Р	Х
Б	Ё	М	С	Ё	Ч	Г	И	О	Л	А	Ө	У	У	Ц	Х
С	Ё	Ч	Т	Э	Д	Г	Э	Э	Х	А	С	Л	Ё	Т	У
Л	С	С	У	Р	Г	А	А	Л	Т	Ү	Л	Г	Э	Р	В
М	А	Х	Ө	О	Т	Б	Ж	Э	И	Р	О	А	О	Б	Ч
Х	Ө	Б	Ц	Й	Ц	Б	Э	Ш	Р	Й	Н	Э	Ө	Р	Э
А	О	У	У	Ч	Л	А	Г	Д	С	А	Н	Э	Б	Ө	А
Б	С	Т	М	Ш	О	Л	Р	А	Ө	Ө	Б	Ө	Б	У	Р
М	А	О	Х	Ү	Н	Д	А	Ч	А	А	Ө	Б	Д	Б	Ы
Ф	Ц	У	Ж	Э	Н	Н	Г	Ш	Ү	Р	О	Б	С	Ө	Н
Я	Ч	Ё	С	М	Т	С	Б	Х	Р	Х	Ө	Б	У	Б	Р

“Тэрээр Тэдэнд Олон Зүйлийг Сургаалт Зүйрлэлээр Хэлсэн”

Матай 13

Зорилго

Ангийн гишүүдийг “сонсох чихээ” хөгжүүлэхэд тусалж тэгснээр Есүсийн сургаалт үлгэрүүд тэдэнд хэрхэн хамааралтайг тэд ойлгох болно (Матай 13:9).

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 13:1–17. Есүс тариачны тухай сургаалт үлгэр ярьж, сургаалт үлгэрийг яагаад хэрэглэдгээ тайлбарладаг.
 - б. Матай 13:18–23. Тэрээр тариачны тухай сургаалт үлгэрийг тайлбарладаг.
 - в. Матай 13: 24–53. Есүс дэлхий дээрх тэнгэрийн хаант улсын тухай (Есүс Христийн Сүм) буудай ба зэрлэг өвс, гичийн үр, хөрөнгө, талбайд нуусан эрдэнэ, агуу их үнэт сувд ба тэнгист хаясан загасны торны тухай сургаалт үлгэрүүдийг ашиглан заадаг.
2. Нэмэлт Уншлага: Марк 4:1–34; Лук 8:4–18; 13:18–21; Сургаал ба Гэрээ 86:1–7.
3. Заахад зориулсан зөвлөмж: Ахлагч Боид К.Пакер хэлэхдээ: “Самбараас илүү гарах тийм сайн Заахад зориулсан хэрэгсэл гэж үгүй. Цөөхөн хэдэн зүйл л үүнтэй эн зэрэгцэж болох юм. . . . Та хичээлийн үндсэн хэсгийг зааж байхдаа оюутнуудын нүдийг нэг зүйл дээр төвлөрүүлэхээр самбарыг хэрэглэж болно. Та ярьж байхдаа тэдний анхаарлыг татах хэдэн зүйлийг самбарт бичээд, гол санааг нь ярьж өгч болно. Гэхдээ үзүүлэн таниулах зүйлийг хэтэрхий их хэрэглэвэл энэ нь зааж байгаа хичээлээс илүү сонирхол татах тул хэзээ ч бүү хэтрүүл” гэсэн.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүдийг автобусанд явж байна гэж төсөөлөхийг урь. Явж байхдаа автобусны цонхоор гадаад орчноо ажиглан харна.

- Нэг автобусанд хамт аялсныхаа дараа та бусад зорчигчидтой адил зүйлийг ажигласан байх уу? Яагаад эсвэл яагаад үгүй гэж?

Адилхан нөхцөлд байгаа хүмүүс үргэлж адилхан зүйлийг ажигладаггүй гэдгийг цохон тэмдэглэ. Үүнтэй адил, Есүсийг сургаалт үлгэрээр зааж байхыг сонссон бүх хүмүүс сургаалт үлгэрүүд нь хэрхэн тэдэнд хамаатайг ойлгоогүй. Энэ хичээлд Есүсийн сургаалт үлгэрүүдийг хэрхэн ойлгож, мөн хэрэглэж болох талаар ярилцана.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Та дараах сургаалт үлгэрүүдийг ярилцахдаа өөр өөр хүмүүс, эд зүйлс болон үйл хөдлөлүүд нь юуг төлөөлж байгааг ангийн гишүүд мэдэж буй эсэхийг бататга. Энэ нь тэднийг сургаалт үлгэрүүдийг ойлгож, амьдралдаа хэрэглэхэд нь тусална.

1. Есүс тариачны тухай сургаалт үлгэр ярьж, сургаалт үлгэрийг яагаад хэрэглэдгээ тайлбарладаг.

Матай 13:1–17-г уншаад ярилц.

- Хурсан олныг эрэг дээр цуглахад Есүс “тэдэнд олон зүйлийг сургаалт үлгэрээр ярьж өгсөн.” (Матай 13:3.) Сургаалт үлгэр гэж юу вэ? (Сайн мэдээний үнэнийг дэлхийн зүйлтэй харьцуулан заадаг бэлэгдэл түүх юм.) Есүс, сургаалт үлгэрээр заах түүний зорилго нь юу байсан гэж хэлсэн бэ? (Шавь нартаа өөрийн мэдээгээ нэг дор зааж, үл итгэгчдээс үүнийг нуух гэж. Матай 13:10–13-ыг үз.)

Ангийн нэг гишүүнээс тариачны тухай сургаалт үлгэрийг чангаар уншихыг хүс (Матай 13:3–8). Ангийн бусад гишүүдийг түүний хамт уншиж, сургаалт үлгэрт гарч буй зүйлс, үйл хөдлөл нь сайн мэдээний үнэнийг төлөөлж байгаа хэсгийг санахыг хүс.

- Замын хажуугаар унасан үр яагаад нахиалдаггүй вэ? (Матай 13:4-ийг үз. Самбарт *Замын хажуу дахь үр—шувууд идчихсэн* гэж бич.)
- Чулуурхаг хөрсөн дэх үр яагаад хатдаг вэ? (Матай 13:5–6; Лук 8:6-г үз. Самбарт *Чулуурхаг хөрсөн дэх үр—үндэсгүй* гэж бич.)
- Зарим үр өргөсөн дунд унаад яасан бэ? (Матай 13:7-г үз. Самбарт *Өргөсөн дундах үр—өргөсөнд бариулсан* гэж бич.)
- Сайн хөрсөнд унасан үр яасан бэ? (Матай 13:8-ыг үз. Самбарт *Сайн хөрсөн дэх үр—ургац өгсөн* гэж бич.)

Самбарт бичсэн үгээ арилгалгүй орхиод, тэдгээрийн төлөөлдөг үнэнүүдийн тухай хэдэн минутын дараа ярилцана гэдгээ тайлбарла.

- Хүмүүс энэ сургаалт үлгэрийг ямар ч тайлбаргүйгээр сонсоод яах вэ? (Зарим хүмүүс үүнийг ойлгохгүй учраас сэтгэл нь гонсойж магад. Зарим нь ойлгосон ч энэ нь тэдэнд хамаагүй гэж бодно. Зарим нь үүнийг эргэцүүлэн бодож, ойлготлоо асуулт тавьж, амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхийг мэдэж авдаг.)
- Есүс тариачны тухай сургаалт үлгэрийг ярьсныхаа дараа юу гэж хэлсэн бэ? (Матай 13:9-ийг үз.) Та нар энэ урилгын *сонсох* гэсэн үгийн утгыг юу гэж бодож байна? Харсан боловч хардаггүй ба сонссон боловч сонсдоггүй гэдэг нь юу гэсэн үг вэ? (Матай 13:13–15-ыг үз.)

Бошиглогч Иосеф Смит: “Хурсан олон. . . . Түүний хэлж байгааг хүлээж аваагүй. . . яагаад гэвэл тэд нүдээрээ харж, чихээрээ сонсохыг хичээгээгүй; тэд чадахгүй байсандаа биш, сонсох харах эрхгүй байсандаа ч биш харин тэдний зүрх сэтгэл шударга бус явдал болон зэвүүцлээр дүүрэн байсан юм. . . . Хурсан олон яагаад Түүний сургаалт үлгэрийн тайлбарыг ойлгоогүй гэвэл . . . тэдний үл итгэх байдлаас болоод тэр юм” гэж хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 96–97).

2. Есүс тариачны тухай сургаалт үлгэрийг тайлбарладаг.

Матай 13:18–23-ыг уншаад тариачны тухай сургаалт үлгэр дэх эд зүйлс, үйл хөдлөлийн утга учрыг ярилц.

Үр

- Тариачны тухай сургаалт үлгэрт үр нь юуг төлөөлдөг вэ? (Матай 13:19; Лук 8:11-ийг үз. Самбарт *Үр = Бурханы үг* гэж бич.)

Замын хажуу

- Замын хажуу юуг төлөөлдөг вэ?(Матай 13:19-ийг үз. Самбарт *Замын хажуу = Бурханы үгийг сонссон боловч ойлгодоггүй хүмүүс* гэж бич (хүсвэл товчил).
- Бурханы үгийг ойлгоход саад болох ямар зүйлийг бид хийдэг байж болох вэ? (Мозая 26:1–3 нэг боломжийн хариултыг хар.) Бурханы үгийг ойлгож чаддаг болохын тулд бид юу хийх хэрэгтэй вэ? (Алма 32:27-г үз.) Ойлгохгүй байх нь Сатан бидний зүрх сэтгэлээс үгийг зайлуулахад хэрхэн хялбар болгодог вэ? (Матай 13:19-ийг үз.)

Чулуурхаг Газар

- Чулуурхаг газар юуг төлөөлдөг вэ? (Матай 13:20–21-ийг үз.) Самбарт *Чулуурхаг Газар = Бурханы үгийг сонсоод хүлээн авсан боловч үүгээр өөрсдийгөө үндэслүүлдэггүй хүмүүс* гэж бич (хүсвэл товчил).
- Зарим хүмүүс яагаад Бурханы үгээр өөрсдийгөө үндэслүүлдэггүй вэ? (Матай 3:21; Марк 4:5-ыг үз.) Бид хэрхэн тэр үгээр өөрсөддөө гүн үндэс суулгуулж болох вэ? (Алма 32:41–43-ыг үз.) Энэ нь бидэнд зовлон, хавчлага, гомдлыг давахад хэрхэн туслах вэ?

Өргөст Газар

- Өргөст газар юуг төлөөлдөг вэ? (Матай 13:22; Марк 4:19; Лук 8:14-ийг үз.) Самбарт *Өргөст Газар = Бурханы үгийг сонссон боловч дэлхийн зовнилд анхаарал нь сарнисан хүмүүс* гэж бич (хүсвэл товчил).
- Хүн үр жимсгүй болно гэдэг нь юу гэсэн үг вэ? Ямар “өргөс” хүмүүсийг үр жимсгүй болгодог вэ? (Матай 13:22; Марк 4:19; Лук 8:14-ийг үз.) Өнөө үед дэлхий дээр эдгээр өргөснүүд нь хэрхэн илэрхий харагддаг вэ? Бидэнд байгаа Бурханы үгийг эдгээр өргөснүүдэд бариулахаас хэрхэн сэргийлж болох вэ?

Сайн Хөрс

- Сайн хөрс юуг төлөөлдөг вэ? (Матай 13:23-ыг үз.) Самбарт *Сайн Хөрс = Бурханы үгийг сонсоод ойлгодог ба зөв шударга үйлс хийдэг хүмүүс* гэж бич (хүсвэл товчил).
- Үр ашиггүй газраас жимс гаргаж авахын тулд юу хийж болох вэ? (Замын хажууг хагалж бордож болно, чулуунуудыг зайлуулж мөн өргөсийг авч болно.) Энэ нь Бурханы үгийг илүү сайн хүлээн авах бидний чармайлтад хэрхэн нөлөөлж чадах вэ?
- Тариачны тухай сургаалт үлгэр нь тариачин эсвэл үрнээс илүү хөрсөн дээр яагаад төвлөрсөн гэж та нар бодож байна вэ?

3. Есүс сургаалт үлгэрийг ашиглан дэлхий дээрх тэнгэрийн хаант улсын (Есүс Христийн Сүм) тухай заадаг.

Матай 13:24–53-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Эдгээр шүлгүүд дэх “тэнгэрийн хаант улс” гэсэн хэллэг нь дэлхий дээрх тэнгэрийн хаант улс болох Есүс Христийн Сүмийг хэлж байгаа гэдгийг тайлбарла.

- Буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт үлгэрийн утга учир нь юу вэ? (Матай 13:24–30, 36–43; С ба Г 86:1–7. Та самбарт тариачны тухай сургаалт үлгэр дээр хийсэн шиг жагсаал гаргаж болно. Тариачин, талбай, сайн үр, зэрлэг өвс, дайсан, ургац болон хадагчаар хэнийг эсвэл юуг төлөөлүүлснийг жагсааж бич.)
- Буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт үлгэрт тариачин яагаад үйлчлэгчдээ зэрлэг өвс, хогийн ургамлыг тэр дор нь цуглуулахыг зөвшөөрөөгүй вэ? (Матай 13:27–30-ийг үз; мөн Матай 13:30-ийг тодорхой болгодог С ба Г 86:5–7-г үз.)
- Бошиглогч Иосеф Смит гичийн үр ба гурил исгэгчийн тухай сургаалт үлгэрүүд нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн тухай юм гэж заасан (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 98–100). Аврагчийн гичийн үртэй зүйрлүүлсэн дахин сэргэсэн Сүмийн талаар бид юу сурч болох вэ? (Матай 13:31–32-ыг үз.) Хөрөнгөтэй? (Матай 13:33-ыг үз. *Хөрөнгө* гэдэг нь талхыг хөөлгөдөг гурил исгэгч гэдгийг тайлбарла.) Та эдгээр сургаалт үлгэрүүдэд дүрслэгдсэнээр Бурханы ажил өсөхийг хэрхэн харсан бэ?
- Бид эрдэнэ ба агуу их үнэт сувдны тухай сургаалт үлгэрүүдээс юу сурч болох вэ? (Матай 13:44–46-г үз.) Бид сайн мэдээний эрдэнийг олж авахын тулд ямар золиослолыг хийх хүсэлтэй байх хэрэгтэй вэ? Сайн мэдээний төлөө та болон таны мэдэх хүмүүс ямар золиослол хийсэн бэ? Тэдгээр золиослолын үр дүнд ямар адислал авсан бэ?
- Тэнгист хаясан загасны торны тухай сургаалт үлгэр дэх загасны тор юуг төлөөлдөг вэ? (Матай 13:47-г үз.) Тор дүүрмэгц гэдэг нь юу гэсэн үг вэ? Сайныг нь саванд хийж мууг нь хаях үйл явцаар юуг төлөөлүүлсэн бэ? (Матай 13:48–50-ийг үз. Та 49-ээр шүлгийн “дэлхийн төгсгөл” гэсэн нь бусармаг явдалтнуудын устал юм гэж тайлбарлахын тулд Иосеф Смит—Матай 1:4-ийг ашиглаж болно.) Сүмдээ итгэлтэй байхад туслахын тулд бид өөрсөддөө болон бусдад юу хийж болох вэ?

Дүгнэлт

Есүс ойлгохыг хичээсэн хүмүүст сургаалт үлгэрийнхээ талаар тайлбарлаж өгсөн гэдгийг цохон тэмдэглэ. Чин сэтгэлээсээ ойлгохыг хүсэн Есүсийн сургаалт үлгэрээс суралцсанаар бид өнөөгийн амьдралдаа тэдгээрийг хэрхэн хэрэглэж болохыг харна гэдгийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

Биет зүйл хэрэглэх хичээл

Хичээлд гарсан сургаалт үлгэрийг ойлгож, санахад нь ангийн гишүүдэд туслахын тулд тэдгээрт гарсан зарим бодит зүйлүүдийг үзүүл. Жишээ нь та ус, элсэн чихэртэй хөрөнгийг холиход хэрхэн урвалд орохыг үзүүлж болно. Та нэг хөрөнгөтэй талх, нэг хөрөнгөгүй талх жигнэж ирээд ангийн гишүүдэд ялгааг нь харуулж мөн амтлуулж болно. Түүнчлэн та биет зүйлтэй заах зөвлөмжинд гичийн үрийг (эсвэл яг хар гичийн үр шиг харагддаг нунтаг чинжүүг) үзүүлж болно.

Иохан 5–6; Марк 6:30–44; Матай 14:22–33

Зорилго

Ангийн гишүүд Есүс Христийг мөнхийн амьдралын эх сурвалж “амьдралын талх” гэдэгт итгэхэд туслах болно (Иохан 6:47–48).

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Иохан 5. Есүс нэгэн эрийг Хүндэтгэлийн өдөр эдгээдэг. Иудейн удирдагчид өөрийгөө Бурханы хүү гэж Есүсийг тунхагласнаас болж түүнийг хөнөөхийг санаархдаг.
 - б. Иохан 6:1–14; Марк 6:30–44. Есүс гайхалтайгаар 5000 гаруй хүнийг хооллодог.
 - в. Иохан 6:15–21; Матай 14:22–33. Есүс далай дээр алхаж, Петрийг өөр лүүгээ ирэхийг урьдаг бөгөөд салхийг намжаадаг.
 - г. Иохан 6:22–71. Есүс өөрийгөө “амьдралын талх” гэдэг бөгөөд түүнд итгэсэн хүмүүс мөнх амьдралтай болно гэдгийг тунхагладаг. Энэ номлолыг олон хүмүүс эсэргүүцдэг боловч, Петр болон бусад Төлөөлөгчид Есүстэй хамт үлддэг.
2. Нэмэлт Уншлага: Матай 14:1–21; Марк 6:1–29, 45–52; Лук 9:10–17.
3. Ангийн нэг гишүүнээс Есүс Бетзада цөөрмийн дэргэд нэгэн эрийг эдгээсэн явдлын тухай товч дүгнэлтийг хуваалцахад бэлтгэж ирэхийг хүс (Иохан 5:1–9).
4. Хэрэв Таван Мянган Хүнийг Хооллосон нь (62143) ба Христ Усан Дээгүүр Явсан нь (Ариун Сургаалын уран Зургийн Цуглуулга 243) зургууд байгаа бол тэдгээрийг хичээлдээ хэрэглэ.
5. Заахад зориулсан зөвлөмж: Аврагч сайн мэдээний зарчмуудын талаар заахын тулд талх, үр гэх мэт өдөр тутам тохиолддог биет зүйлсийг байнга ашигладаг байсан. Та хичээл бүрийг бэлтгэхдээ ангийн гишүүдийн анхаарлыг татах эсвэл чухал санааг дүрслэхийн тулд биет зүйлсийг хэрхэн ашиглаж болох талаар бодож үз.


Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Самбарт дараах дүрсийг зур.



- Эдгээр зүйлс юугаараа адилхан вэ?

Ангийн гишүүдээр асуултанд тохирох хариултыг товчхон ярилцуул. Дараа нь тэд нараар Хиламан Есүс Христийг чулуутай зүйрлэсэн Хиламан 5:12 болон Есүс өөрийгөө “дэлхийн гэрэл” гэж тунхагласан Иохан 8:12-ыг уншуул. Хичээлийн төгсгөлд Есүс хэрхэн “амьдралын талх” болох талаар ярилцана гэдгийг тайлбарла (Иохан 6:35).

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та энэ хичээлийг заахдаа ангийн гишүүдийг “судраас судлахад” (Иохан 5:39) тусал. Тэднээс ярилцах зарчимтай холбоотой туршлагаасаа хуваалцахыг уриал.

1. Есүс нэгэн эрийг Хүндэтгэлийн өдөр эдгээдэг бөгөөд өөрийгөө Бурханы Хүү гэж тунхагладаг.

Иохан 5-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгийг чангаар уншихыг урь.

- Есүс Бетзада цөөрмийн дэргэд нэгэн эрийг эдгээсэн явдлын тухай дүгнэж ярихыг урьдчилан даалгасан ангийн гишүүнээс урь (Иохан 5:1–9). Дараа нь тэр өдөртөө Есүс уг эрийг ариун сүмд хараад түүнд ямар удирдамж өгсөн бэ? (Иохан 5:4-ийг үз.) Нүглийн үр дагавар нь яагаад бие махбодын доройтлоос илүү “муу зүйл” вэ?
- Иудейн удирдагчид яагаад Есүсийг хөнөөхийг санаархсан бэ? (Иохан 5:16–18-ыг үз.) Есүс ууртай Иудейчүүдэд хариулахдаа Эцэгтэй холбоотой талаараа юуг илчилсэн бэ? (Иохан 5:19–23, 30-ийг үз.)
- Есүс өвчтөнийг эдгээхээс ч илүү “агуу ажлыг” удахгүй хийх болно гэж хүмүүст хэлдэг (Иохан 5:20). Эдгээр агуу ажлууд нь юу байна гэж тэр хэлсэн бэ? (Иохан 5:21–29-ийг үз. Тэр Дахин Амилалтыг өгнө, бүх хүмүүсийг шүүнэ, мөн итгэлтэй хүмүүст мөнх амьдрал өгнө.)
- Өөрийг нь гэрчилсэн ямар гэрчүүдийн талаар Аврагч өгүүлсэн бэ? (Иохан 5:32–39, 45–47-г үз.) Эдгээр гэрчүүдийг байлгах нь яагаад чухал вэ? (Иаков 4:6-г үз.) Бид хэрхэн Аврагчийн гэрч байж чадах вэ?
- Есүс Иудейн удирдагчдыг “судраас судал” гэж уриалдаг. (Иохан 5:39.) Судрыг судлах, тэдгээрийг унших хоёрын ялгаа нь юу вэ? (Та энэ асуултыг

ярилцахдаа хичээлийн төгсгөлд байгаа заах нэмэлт санаануудын нэгдүгээрийг ашиглаж болно.) Та нар хувийн болон гэр бүлийн судрын сургалтаа хэрхэн илүү утга учиртай болгосон бэ? Та нар судраас судалснаар хэрхэн адислагдаж байсан бэ?

- Иохан 5:39-ийн дагуу Иудейн удирдагчид судраас судалж, үүнд итгэсэн бол тэд юу мэдэж авах байсан бэ? (Судрууд нь Есүс Христийг гэрчилдэг гэдгийг тэд мэдэх байсан. Иохан 5:40, 46–47-г бас үз.) Судрууд хэрхэн Христэд итгэх итгэлийг тань батжуулсан бэ?

2. Есүс 5000 гаруй хүнийг гайхалтайгаар хооллосон.

Иохан 6:1–14 ба Марк 6:30–44-өөс сонгосон шүлгийг уншаад ярилц. Есүс хурсан олныг хооллосон нь зургийг үзүүл.

- Есүс болон түүний шавь нар яагаад уул өөд гарсан бэ? (Иохан 6:1–3-ыг үз. Иосеф Смитийн Орчуулгын Марк 6:31 нь Есүс болон түүний шавь нар зэлүүд газар руу явсан гэдэг.) Хурсан олон түүн рүү ирэхэд Есүс тэдэнд хэрхэн хандсан бэ? (Марк 6:33–34; Матай 14:14.) Түүний нинжин сэтгэлийн жишээг бид хэрхэн дагаж болох вэ?
- Есүс хурсан олныг хэрхэн хооллосон бэ? (Иохан 6:5–13-ыг, мөн Матай 14:21-ийг үз.) Есүст талх болон загасаа өгсөн хүүгийн жишээг бид хэрхэн дагаж болох вэ? Хүүгийн нэгэн адил бид Түүнд үйлчлэхэд байгаа бүхнээ зориулахад Их Эзэн биднийг хэрхэн адисладаг вэ?

Ахлагч Жэймс И. Фауст хэлэхдээ:

“Ердөө л таван талх, хоёр жижиг загас хүртсэн тэр олон хүмүүстэй тэнцэх бэлэгтэй олон нэр нь үл мэдэгдэх хүмүүс дуудлагаа эрхэмлэн биелүүлж, анхаарал болон урамшуулалтгүйгээр үйлчлэн мянга мянган хүнийг хооллодог. . . . Тэдгээр нь бүх хавсралт байгууллагууд болон пристийн зэргийн чуулгууд дахь мянга мянган удирдагч, багш нар болох гэрийн багш нар, Нийгмийн Халамжийн Бүлгийн айлчлагч багш нар юм. Тэд нар нь албан ёсоор бэлтгэгдээгүй ч, ихэд эрхэмлэн биелүүлж, үргэлж суралцаж байдаг Их Эзэн болон хэсгийнхээ хүмүүст үйлчлэх гэсэн даруу хүсэлтэй Сүмийн олон арван даруу бишопууд юм. . . .

“Даруухнаар эхэлж өнөөг хүртэл хүчирхэг болон өссөн энэ сүмийн гол шалтгаан нь Эзэндээ үйлчлэхийн тулд зориулсан тавхан талх, хоёрхон загастай сая сая даруу бөгөөд бүх сэтгэлээ зориулсан тэр хүмүүсийн итгэл, үнэнч байдал юм. Тэд өөрсдийнхөө сонирхлоос эрс татгалзаж, ингэснээрээ ‘бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар амгаланг’ олж авсан (Филиппой 4:7) гэжээ” (Conference Report, Apr. 1994, 4–5; or *Ensign*, May 1994, 5–6).

- Тэд Их Эзэнд үйлчлэхдээ Түүнээс адислал хүртсэн хүмүүсийн талаар та нарын харж байсан зарим жишээнүүд юу вэ?
- Таван талх хоёр загасны гайхамшигт найр нь Аврагчийн бидэнд санал болгодог сүнслэг найрыг хэрхэн бэлэгдсэн бэ?

3. Есүс далай дээгүүр алхаж, Петрийг өөр лүүгээ ирэхийг урьдаг бөгөөд салхийг намжаадаг.

Иохан 6:15–21 ба Матай 4:22–33-ыг уншаад ярилц. Есүс хурсан олныг хооллосныхоо дараа шавь нартаа, завинд сууж далайн нөгөө эрэг рүү явах удирдамж өгдөг гэдгийг тайлбарла. Дараа нь тэр хурсан олныг тараагаад,

залбирахаар уул өөд явдаг. Шавь нар нь далайг гаталж байхдаа хүчтэй шуургатай тааралддаг.

- Есүсийг усан дээгүүр алхан тэдэн рүү ирж явахыг хараад шавь нар нь яасан бэ? (Матай 14:26; Иохан 6:19-ийг үз.)

Христ усан дээгүүр явсан нь зургийг үзүүл.

- Петр Аврагчийн дууг сонсоод яахыг хүссэн бэ? (Матай 14:28–29-ийг үз.) Петрийг усан дээр алхаж байхад итгэл нь яагаад буурсан бэ? (Матай 14:30-ийг үз.) Зарим үед хүнд байдал тулгарахад бид иймэрхүү алдааг хэрхэн гаргадаг вэ?
- Петр живж эхлэх үедээ яасан бэ? (Матай 4:30-ийг үз.) Есүс яасан бэ? (Матай 14:31–32-ыг үз.) Энэ нь Их Эзэн, бид нарын хоорондын холбооны талаар юу илэрхийлж байна вэ? Аврагч танд хүч өгч, таныг тайтгаруулж байгааг та нар хэрхэн мэдэрсэн бэ?

4. Есүс өөрийгөө “амьдралын талх” гэж тунхагладаг.

Иохан 6:22–71-ээс сонгосон шүлгийг уншаад ярилц.

- Есүсийн талх болон загасны гайхамшгийн дараах өдөр хүмүүс Капернаум руу түүнийг дагаж явсан. Тэд яагаад түүнийг дагасан бэ? (Иохан 6:26-г үз.) Есүс урьд өдрийн гайхамшгийн талаарх хүмүүсийн сэтгэлийн хөөрлийг номлолынхоо тухай гэрчлэхэд хэрхэн ашигласан бэ? (Иохан 6:27–35-ыг үз.)

Ахлагч Жэффри Р.Холланд: “Аврагчийн Галил дах үйлчлэлийн үед, ердөө таван талх, хоёр загасаар 5000 хүнийг хооллосон гэж Түүний талаар сонссон хүмүүс одоо үнэгүй хоол горьдон Түүн рүү хошуурсныг Тэрээр зэмлэсэн. Тэрхүү хоол нь хоол утгаараа чухал биш харин энэ нь Түүний тэд нарт өгөхийг хичээсэн жинхэнэ хоол тэжээлтэй холбоотой байсан” хэмээн дүгнэжээ (Conference Report, Oct. 1997, 87; or *Ensign*, Nov. 1997, 65).

- “Амьдралын талх” нь Аврагч болон түүний бидэнд санал болгодог адислалыг хэрхэн зөвөөр дүрсэлдэг вэ? (Иохан 6:35; 47–51-ийг үз.) “Хэзээ ч өлсөхгүй” “хэзээ ч цангахгүй” гэдэг нь юу гэсэн үг вэ? Бид хэрхэн “амьдралын талхыг” хүртэх вэ? (Иохан 6:47, 51–54; Матай 26:26–28; Алма 5:33–35; С ба Г 20:77-г үз.)

Ерөнхийлөгч Ховард В.Хантэр зөвлөхдөө: “Бид Христийг мэддэгээсээ илүү мэдэх хэрэгтэй; бид түүнийг дурсан санадгаасаа илүү ойр ойрхон дурсах хэрэгтэй; бид түүнд үйлчилдгээсээ илүү их шийдэмгий үйлчлэх хэрэгтэй. Тэгвэл бид мөнхийн амьдрал руу оргилох уснаас ууж, амьдралын талхыг идэх болно” гэсэн (Conference Report, Apr. 1994, 84; or *Ensign*, May 1994, 64).

Зарим хүмүүс Есүсийг “Иосефийн хүү” гэдгээр нь харсан учраас түүнд итгээгүй гэдгийг цохон тэмдэглэ (Иохан 6:42). Есүсийн шавь нар гэгддэг зарим нь түүнийг амьдралын талх гэж тунхагласны сүнслэг утгыг мөн түүний махыг идэж, цусыг нь уух хэрэгтэй гэсэн сургаалыг ойлгохгүй байна хэмээн гомдол гарган, түүнээс нүүр бууруулсан (Иохан 6:51–66).

- Зарим хүмүүс Есүсийн номлолыг эсэргүүцэх үед Есүс Арван Хоёр Төлөөлөгчөөсөө юу гэж асуусан бэ? (Иохан 6:67-г үз.) Петрийн хариулт юу байсан бэ? (Иохан 6:68-ыг үз.) Хүмүүс Есүсийг ойлголгүй орхин явахад Петр болон бусад Төлөөлөгчид түүний талаар юуг ойлгосон бэ? (Иохан 6:69-ийг үз.)

Есүс Христ бол “амьдралын талх” бөгөөд түүнд “мөнхийн амьдралын үгс” байдаг гэдгийг гэрчил (Иохан 6:35, 68). Ангийн гишүүдийг Амьдралын Талхны тухай Номлолын “Над уруу ирдэг хүн хэзээ ч өлсөхгүй; надад итгэдэг хүн хэзээ ч цангахгүй. . . . Надад итгэдэг хүн мөнхийн амьдралтай” (Иохан 6:35; 47) гэсэн түүний амлалтыг хэрэгжүүлэхийг уриал.

Заах Нэмэлт

Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Судраас судал” (Иохан 5:39)

Таныг чангаар уншиж байхад ангийн гишүүдээс Иохан 5:20–30-ыг хамтдаа чимээгүй уншихыг урь. Ямар ч зогсолтгүйгээр буюу ямар ч шүлгийг тайлбарлаж ярилцалгүйгээр хурдан унш.

Та, дөнгөж сая Иохан 5:20–30-ыг *уншсан* харин одоо тэр хэсгээ хамтдаа *судлах* болно гэж тайлбарлан хэл. Ангийн гишүүдийг гурав юмуу дөрвөн хэсэгт хуваа. Хэсэг бүрт Иохан 5:20–30-ийн дараах хэсгүүдээс ядахдаа нэгийг өг: 20–22, 23–24, 25–27 ба 28–30. Хэсгүүдэд хамтдаа ажиллах хэдэн минут өг. Урьдчилан даалгаж өгсөн шүлгүүдийг тэд нараар уншуулж, шүлгүүдээс хамгийн чухал гурван үгийг сонгуулан, эдгээр үгс нь яагаад чухал болохыг тайлбарлахад бэлтгүүл.

- Та судраас судлаад бидний хурдан уншихдаа ажиглаагүй юуг ажигласан бэ? Бид судраас бие даан судлахын тулд юу хийж болох вэ?

Бошиглогч Иосеф Смит Иохан 5:29-ийг эргэцүүлэн бодсоныхоо дараа хаант улсын алдруудын тухай үзэгдлийг хүлээн авсан гэдгийг тайлбарла. Түүнийг тойроод Их Эзэний алдар суу гэрэлтсэн бөгөөд тэр Эцэгийн баруун гар тал дахь Хүүгийн алдар сууг харсан бөгөөд түүний бүрэн дүүрэнг хүлээн авсан. (С ба Г 76:15–20-ийг үз.)

- Иосеф Смит Иохан 5:29-ийг судалсан учраас бид ямар мэдлэгээр адислагдсан бэ?

2. “Бетзада цөөрмийн дэргэд хүлээж буй хүмүүст санаа тавь”

Ахлагч Бойд К.Пакер Иохан 5:1–9 дэх явдлыг, бид тахир дутуу хүмүүст туслах ёстой хэмээн онцлон тэмдэглэхэд ашигласан. Тэрээр бие махбодын болон оюун санааны согог нь “төгс төгөлдөр болно. Иймээс бид Бетзада цөөрмийн дэргэд хүлээж байгаа хүмүүст санаа тавих хэрэгтэй” гэж хэлсэн (Conference Report, Apr. 1991, 8; or *Ensign*, May 1991, 9).

- Бие махбодын болон оюун санааны согогтой хүмүүст туслахын тулд бид юу хийж болох вэ?

“Би Та Нарт Хаант Улсын Түлхүүрийг Өгнө”

Хичээл
13

Матай 15:21–17:9

Зорилго Ангийн гишүүдийн, Есүс бол Христ бөгөөд Хувиралтын Уулан дээр өгсөн пристийн зэргийн түлхүүрүүд дахин сэргээгдсэн гэсэн гэрчлэлийг батжуулах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 15:21–39. Есүс нэгэн Харь үндэстэн эмэгтэйн охиныг эдгээдэг ба ихэнх нь Харь үндэстнүүд байсан 4000 гаруй хүнийг гайхалтайгаар хооллодог.
 - б. Матай 16:13–19. Петр Есүс бол Христ гэж гэрчилдэг. Есүс түүний Сүм илчлэлтийн чулуун дээр баригдсан гэж заадаг ба Петрт хаант улсын түлхүүрүүдийг өгнө гэж амладаг.
 - в. Матай 17:1–9. Есүс Петр, Иаков, Иохан нарын өмнө хувирч өөрчлөгддөг.
2. Нэмэлт Уншлага: Марк 7:24–9:10; Лук 9:18–36; 12:54–57.
3. Шинэ Гэрээний үеийн Палестины газрын зураг байгаа бол хичээлдээ хэрэглэ. Та газрын зургийг томруулан хувилбал ангийн гишүүд илүү сайн харах боломжтой болно.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Дараах түүхийг хуваалц:

Олон жилийн өмнө Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл болон Сүмийн бусад хэдэн удирдагчид Бэртэл Торвалдсэний Есүс Христ болон Арван Хоёр Төлөөлөгчийн алдарт хөшөө байдаг Данийн Копенхаген дэх жижиг дуганд айлчилсан. Энэ явдлын талаар Ахлагч Рэкс Д.Пинигэр ярихдаа: “Бид тэдгээр сайхан урлагийн бүтээлүүдийг харж байхдаа Петрийн баримлыг гарт нь том түлхүүрүүд бариулж хийснийг ажигласан. . . . Биднийг дуганаас гарах гэж байхад Дани хаалгач . . . бидний гарахыг хүлээн хаалганы дэргэд зогсож байлаа. Ерөнхийлөгч Кимболл түүний гарыг барин дуганд зочлуулсан сайхан сэтгэлд нь талархсан. Тэгээд Ерөнхийлөгч Есүс Христийн байгуулсан сүмийн талаар, мөн энэ нь бидэнд ямар чухал байдаг тухай тайлбарлаж эхэлсэн. . . . Ерөнхийлөгч Таннэр, Ахлагч Монсон болон Ахлагч Пакэрийг өөртөө ойртуулаад ерөнхийлөгч үргэлжлүүлэн, ‘Бид нар бол Их Эзэн, Есүс Христийн амьд төлөөлөгчид. Арван Хоёр Төлөөлөгч болон Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөл болох гурван хүн байдаг. Бид Петрийн атгасантай адил жинхэнэ түлхүүрүүдийг атгадаг бөгөөд тэдгээрийг өдөр болгон хэрэглэдэг. Тэдгээр нь үргэлж хэрэглэгдэж байдаг’ гэв” (Conference Report, Oct. 1976, 104; or *Ensign*, Nov. 1976, 69).

Энэ хичээлд пристийн зэргийн түлхүүрүүд болон Петр тэдгээрийг Хувиралтын Уулан дээр хэрхэн хүлээн авсныг ярилцана гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Хэрэв боломжтой бол Шинэ Гэрээний үеийн Палестины газрын зургийг үзүүл. Энэ хичээл дээр ярилцах үйл явдлууд Тир, Сидон, Декаполис, Цезарь Филипп болсон гэдгийг цохон тэмдэглэ. Газрын зураг дээрээс эдгээр газруудыг олоход ангийн гишүүдэд тусал. Энэ газраар аялснаар Есүс олон Харь үндэстнүүдтэй (Израил хүмүүс биш) уулзсан гэдгийг тайлбарла.

1. Есүс нэгэн Харь үндэстэн эмэгтэйн охиныг эдгээдэг ба 4000 гаруй хүнийг хооллодог.

Матай 15:21–39-ийг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгийг чангаар уншихыг урь.

- Канаанаас ирсэн эмэгтэй Есүсийг юу хийхийг хүссэн бэ? (Матай 15:22). Есүс яагаад түүний хүсэлтийг шууд биелүүлээгүй вэ? (Матай 5:24. Тэр Иудей хүн байгаагүй бөгөөд тэр үед сайн мэдээний адислалуудыг харь үндэстнүүдээс түрүүлж Иудейчүүдэд өгдөг байсан.) Эцэст нь Есүс яагаад тэр охиныг эдгээсэн бэ? (Матай 15:28-ыг үз.) Энэ эмэгтэйгээс бид юу сурч болох вэ? (Хариултанд, сайн мэдээний бүрдлийг олж аваагүй ч агуу итгэлтэй хүмүүс, бид хүссэнээрээ хурдан адислуулаагүй үедээ итгэлээ алдах ёсгүй зэрэг нь орж болно.)
- Аврагч Декаполисоор аялан Галил нуур уруу очив (Марк 7:31). Декаполист олон Харь үндэстнүүд амьдардаг байсан ба Галил Нуурын зүүн хэсэгт оршдог. Тэндхийн хүмүүст Их Эзэн энэрлээ хэрхэн үзүүлсэн бэ? (Матай 15:29–31-ийг үз.) Хурсан олон хэрхэн хандсан бэ? (Матай 5:31-ийг үз.) Өнөө үед Бурханыг алдаршуулахад та нарт ямар гайхамшиг нөлөөлсөн бэ?
- Хурсан олон Есүстэй гурван өдөр хамт байсан бөгөөд тэднийг явах болоход Есүс тэднийг өлсөж байхад нь явуулахыг хүсээгүй. Тэр тэдний төлөө ямар гайхамшигийг үзүүлсэн бэ? (Матай 15:32–38-ыг үз.)

Ихэнх нь Харь үндэстнүүд байснаараа энэ гайхамшиг урьд нь 5000 хүн хооллосноос ялгаатай (Матай 14:15–21) гэдгийг тайлбарла. Ахлагч Брүс Р.МакКонки, Есүс 5000 хүн хооллосноор “Амьдралын Талх болох зүйрлэшгүй номлолынхоо суурийг тавьсан” гэж тайлбарласан (Иохан 6:22–69; 12-р хичээлийг үз). Хожим нь 4000 хүн хооллохдоо Есүс ирээдүйд Харь үндэстэн ард түмэнд амьдралын талхыг санал болгогдох болно гэдгийг бэлэгдэн зааж байсан гэж тайлбарласан (Doctrinal New Testament Commentary, 3 vols. [1966–73], 1:375).

2. Петрт хаант улсын түлхүүрүүдийг өгөхийг амласан.

Матай 16:13–19-ийг уншаад ярилц.

- Есүс Декаполисоос явж шавь нараасаа “Та нар намайг хэн гэж хэлэх вэ?” (Матай 16:15) гэж асуусан газар болох Цезарь Филип уруу очсон. Петр юу гэж хариулсан бэ? (Матай 16:16-г үз.) Петрийн гэрчлэлийн эх сурвалж юу байсан бэ? (Матай 16:17-г үз.) Энэ явдлаас бид өөрсдийнхөө гэрчлэлийн талаар юу сурч болох вэ?

- Есүс Петрт “Энэ хадан дээр Би өөрийн сүмээ босгоно” гэж хэлсэн (Матай 16:18). Бошиглогч Иосеф Смит Есүсийн ярьсан тэр хад бол илчлэлт юм гэдгийг заасан (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 274). Илчлэлт нь юугаараа Их Эзэний Сүмийн суурь болдог вэ?
- Аврагч Петрт “тэнгэрийн хаант улсын түлхүүрүүдийг” өгнө гэж амладаг (Матай 16:19). Тэдгээр түлхүүрүүд нь юу вэ? Тэдгээр нь яагаад хэрэгтэй вэ? (С ба Г 128:9–10; 132:46-г үз.) Өнөөдөр тэдгээрийг хэн атгадаг вэ?

Ерөнхийлөгч Иосеф Ф. Смит заахдаа:

“Пристийн зэрэг нь ерөнхийдөө Бурханы өмнөөс үйлдэх эрчүүдэд өгөгдсөн эрх мэдэл юм. Эрэгтэй хүн бүр Пристийн Зэргийн ямар нэгэн зэрэгт томилогддог бөгөөд энэ эрх мэдэл түүнд олгогддог.

“Тэхдээ энэ эрх мэдлийн дор гүйцэтгэгдэх үйлдэл болгон зөв цаг, зөв газарт, зөв аргаар мөн зөв дэс дараатайгаар хийгдэх шаардлагатай байдаг. Эдгээр ажлыг удирдах хүч нь Пристийн зэргийн *түлхүүрүүдийг* бүрдүүлдэг. Түлхүүрүүдийг нэгэн зэрэг зөвхөн нэг хүн, бошиглогч ба Сүмийн ерөнхийлөгч атгадаг. Тэрээр энэ хүч чадлын ямар нэгэн хэсгийг өөр хэн нэгэнд олгож болох ба энэ тохиолдолд тэр хүн тэр тодорхой ажлын түлхүүрийг атгадаг” гэж заасан (*Gospel Doctrine*, 5th ed. [1939], 136).

- Бошиглогч тэдгээр түлхүүрүүдийг атгадаг гэсэн итгэл үнэмшил нь яагаад бидний гэрчлэлийн чухал хэсэг болдог вэ?

3. Есүс Петр, Иаков, Иохан нарын өмнө хувирч өөрчлөгддөг.

Матай 17:1–9-ийг уншаад ярилц. Петрт хаант улсын түлхүүрүүд амласнаас бараг долоо хоногийн дараа тэр Иаков, Иоханы хамт Аврагчийн Хувиралтыг гэрчилдэг бөгөөд чухал мэдлэг болон түлхүүрүүдийг хүлээн авдаг. Энэ нь Шинэ Гэрээн дэх хамгийн гол үйл явдлуудын нэг байсан. Энэ нь Есүсийг Цагаатгалд бэлтгэхэд тусалсан бөгөөд гурван Төлөөлөгчийг удахгүй Сүмийн удирдагчдын хувьд нэмэлт үүрэг хариуцлагатай болоход зоригжуулдаг.

- *Хувиралт* гэж юу гэсэн үг вэ? (Хүний гадаад байдал болон шинж чанарт түр зуурын өөрчлөлт орохыг, илүү сүрлэг байдалд хувирахыг хэлнэ. Энэ нь Бурханы хүчээр хийгддэг. С ба Г 67:11; Мосе 1:11-ийг үз.)
- Матай 17:1–5-ын дагуу Хувиралтын Уулан дээр Есүс Петр, Иаков, Иохан нарыг байхад юу тохиолдсон бэ? (Та самбарт ангийн гишүүдийн хариултыг жагсааж бичиж болно.)
 - а. Есүсийн царай нар мэт гэрэлтэж, хувцас нь нүд гялбам цагаан болсон.
 - б. Мосе болон Елиа үзэгдсэн.
 - в. “Гэрэлт үүл тэднийг бүрхэн авахад” тэд Хүүгээ гэрчилж буй Эцэгийн дууг сонссон.

Элиа гэдэг нэр нь сударт хэд хэдэн янзаар хэрэглэгдсэн гэдгийг та тайлбарлаж болно. Матай 17:3–4-т энэ нь Иудейн *Элижа* гэдэг нэрний Грек орчуулгаар ордог. Бусад хэсэгт (Матай 17:10–13 гэх мэт) энэ нь өвөг эсвэл бэлтгэгч гэсэн хэн нэгнийг дүрслэх нэр юм.

Хувиралтын Уулан дээр юу болсон талаар хожмын үеийн бошиглогчид илүү ихийг заасан байдаг гэдгийг тайлбарла. Ангийн гишүүдийн хамт дараах номлолыг тоймлон үз. Хүсвэл тэдгээрийг самбарт бич:

- а. Петр, Иаков, Иохан нар Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн үеийн дэлхийн өөрчлөлтийн талаарх үзэгдлийг харсан (С ба Г 63:20–21).
 - б. Тэд “[Христийн] өмнө хувирсан” байсан (*Teachings of the Prophet Joseph Smith*. 158).
 - в. Тэд Аврагчийн үхэл ба дахин амилалтын талаар заалгасан (Joseph Smith Translation, Luke 9:31).
 - г. Тэд Есүс, Мосе болон Елиагаас Аврагчийн үхлийн дараа Сүмийг удирдахад тэдэнд хэрэг болох пристийн зэргийн түлхүүрүүдийг хүлээн авсан (*Teachings of the Prophet Joseph Smith*, 158; Joseph Fielding Smith, *Doctrines of Salvation*, 3 vols. [1954–56], 2:110).
- 1836 онд Мосе, Елиа нар дэлхийд дахин ирсэн. Тэд Иосеф Смит болон Оливэр Каудри нарын толгой дээр гараа тавьж Петр, Иаков, Иоханд өгсөнтэй адил түлхүүрүүдийг дахин сэргээсэн. Мосе ямар түлхүүрүүдийг дахин сэргээсэн бэ? (С ба Г 110:11-ийг үз. Израилийн цугларалтын түлхүүрүүд.) Елиа ямар түлхүүрүүдийг дахин сэргээсэн бэ? (С ба Г 110:13–16-г үз. Холбох хүч чадлын түлхүүрүүд.) Эдгээр түлхүүрүүдийг өнөөдөр хэрхэн хэрэглэж байгаа вэ? (Сүмийн Ерөнхийлөгчийн удирдлаган дор явуулдаг ариун сүмийн болон номлолын ажилд.)
 - Ахлагч Дэвид Б.Хэит Есүсийн Хувиралт нь “бидний болон биеэрээ гэрч болсон тэд нарын сүнслэг гэгээрлийн тулд байсан юм” гэж заажээ (Conference Report, Apr. 1977, 8; or *Ensign*, May 1977, 7). Бидэнд сүнслэг дэмжлэг хэрэгтэй үед тусламж авахын тулд Хувиралтаас бид юу сурч болох вэ?

Та Ахлагч Хэитийн заасан дараах санаануудыг тоймлон үзэж болно (Conference Report, Apr. 1977, 9–10; or *Ensign*, May 1977, 7–9).

- а. Сүнслэг дэмжлэг хэрэгтэй үедээ бид Аврагчийн жишээг даган хичээнгүйлэн залбирах ёстой (Лук 9:28). Хувиралтын талаар Ахлагч Хэит хэлэхдээ: “Мэдээж Есүс зөвхөн Өөрийн Эцэгтэйгээ ганцаарчлан уулзах завшаанаас ирэх тэнгэрлэг тайтгарлыг мэдрээгүй, харин түүнээс ч илүү, энэ дэлхийн бус тэрхүү болох гэж байгаа явдлаар дамжуулан Тэрээр дэмжлэг авахаа мэдэрсэн. Тэрээр Эцэгтээ хандан залбирахдаа Түүнийг эсэргүүцсэн дэлхийн эргэлзээ төөрөгдөл, бусармаг явдлаас хол тусгаарлагдаж, гэгээрсэн байсан” гэв.
- б. Есүс Петр, Иаков, Иохан нарын адил биднийг зоригжуулна гэдэгт бид найдаж болно. Ахлагч Хэит хэлэхдээ, “Тэрээр гурван Төлөөлөгчөө Өөрийнх нь алдар сууг харсныхаа дараа гэгээрч, тэднийг болох гэж буй доромжлол, гутамшигтай явдалд бэлтгэн итгэл нь батжина гэдэгт итгээд өөртэйгөө хамт авч явсан” гэжээ.
- в. Бид Аврагчийн тухай гэрчлэл болон сайн мэдээний номлолоор дамжуулан зоригжиж болно. Ахлагч Хэит хэлэхдээ, “Сонгогдсон гурван төлөөлөгч болох гэж буй [Аврагчийн] үхэл, мөн Түүний дахин амилалт, өмнө нь байгаа үйл явдлаар дүүрэн өдрүүдийг үзэхэд тэднийг зоригжуулах номлолын талаар заалгасан байсан” гэжээ.

Дүгнэлт

Хожмын үеийн Гэгээнтнүүдийн хувьд бидэнд Хувиралтын Уулан дээр болсон явдлыг ойлгоход туслах мэдээлэл бий гэдгийг онцлон тэмдэглэ. Өнөөдөр Сүмд байгаа илчлэлт, мөн пристийн зэргийн түлхүүрүүдийн чухал ач

холбогдлын талаар гэрчил. Бид Петрийн адилаар Ариун Сүнсээр дамжуулан Есүс бол Христ, Амьд Бурханы Хүү гэдгийг мэдэж чадна гэдгийг ангийн гишүүдэд бататган хэл.

**Заах Нэмэлт
Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэхүү санааг хичээлдээ хэрэглэж болно.

Эцэг нь Хүүгийнхээ талаар гэрчилсэн Тохиолдлууд

Эцэг нь Хүүгээ танилцуулж, гэрчилсэн дөрвөн тохиолдол сударт бичигдсэн байдаг. Тэдгээрийн нэгийг энэ хичээлд ярилцсан. Нөгөө гурвыг нь нэрлэхийг ангийн гишүүдээс урь.

1. Есүсийн усан баталгаа (Матай 3:13–17)
2. Хувиралт (Матай 17:1–9)
3. Нифайчуудад үзэгдсэн Есүсийн үзэгдэл (3 Нифай 11:1–7)
4. Иосеф Смитийн Анхны Үзэгдэл (Иосеф Смит—Түүх 1:13–17)

Зорилго

Ангийн гишүүдийг даруу байж, бусдыг өршөөх болон бие биендээ энэрэл үзүүлэхэд нь туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 18:1–6, 10–11, 14. Тэнгэрийн хаант улсад орохын тулд бид хүүхдүүдтэй адил болж өөрчлөгдөх ёстой гэж Есүс заадаг.
 - б. Матай 18:15, 21–35. Өршөөдөггүй боолын тухай сургаалт үлгэрээр Есүс өршөөлийн тухай заадаг.
 - в. Лук 10:25–37. Сайн санаат Самари хүний тухай сургаалт үлгэрээр Есүс энэрлийн тухай заадаг.
2. Нэмэлт Уншлага: Марк 9:33–50; Мозая 3:17–21; 4:16–19, 26.
3. Дараах материалууд байгаа бол хичээлдээ хэрэглэ:

Христ ба Хүүхдүүд (62467; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 216) ба Сайн Санаат Самари Хүн (62156; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 218) зурагнууд.
4. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл үйл ажиллагаанд үзүүлсний дагуу ангийнханд яриа өгөх эцэг эхийг урь.
5. Заахад зориулсан зөвлөмж: Яриа өгөх, түүх хуваалцах, гэрчлэлээ хуваалцах эсвэл бусад ямар нэгэн замаар хичээлд туслуулахын тулд үе үе ангийн гишүүдийг (эсвэл өөр хэсгийн гишүүдийг) урь. Үүрэг өгөхдөө та уг хүнээр ноуг, ямар хугацаанд хийлгэхийг хүсэж байгаагаа тодорхой хэл.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

(Гурваас таван настай) хүүхэдтэй эцэг эхийг хүүхдийнхээ хамт ирж, хүүхдээ танилцуулж, түүний биширмээр сайн зан чанарын зарим нэгийг товч ярихыг урь. Эцэг эхийг ярьсны дараа ангийн гишүүдийг Есүсээс бидэнд байгаасай хэмээх хүсэх хүүхдийнх шиг зан чанарын талаар бодохыг хүс. Хариултыг самбарт жагсааж бич.

Энэ хичээлд хүүхдийнхтэй адил зан чанарыг хөгжүүлэхийн ач холбогдол болон бүх хүмүүстэй төлөв төвшин, эелдэг боловсон харьцах талаар ярилцана гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа төлөв төвшин байдал, өршөөл болон энэрлийн талаарх Аврагчийн сургаалыг бид хэрхэн дагаж болохыг ярилц.

1. Есүс биднийг бяцхан хүүхдүүдтэй адил болох ёстой гэж заадаг.

Матай 18:1–6, 10–11, 14-ийг уншаад ярилц.

- Их Эзэний хаант улсад хэн нь хамгийн агуу байх талаар шавь нар нь яагаад санаа зовж байсан гэж та нар бодож байна вэ? (Матай 18:1; Марк 9:33–34). Бид заримдаа хэрхэн иймэрхүү алдаа гаргадаг вэ? Бид иймэрхүү сэтгэл зовоосон зүйлсээс хэрхэн зайлсхийж болох вэ?
- Христ ба Хүүхдүүд зургийг үзүүл. Түүний хаант улсад жинхэнэ алдар сууд хүрэхийг хүссэн хүмүүст Есүс юу гэж зөвлөсөн бэ? (Матай 18:2–4; Марк 9:35-ыг үз.) Энэ зөвлөгөөг дагахад заримдаа яагаад хэцүү байдаг вэ? Алдар сууд хүрэх талаар дэлхийн зааж буй зүйлтэй энэ зөвлөгөөг хэрхэн харьцуулах вэ?
- Бяцхан хүүхдүүдтэй адил болох гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 3:19-ийг үз. Хүүхдүүд төгс төгөлдөр биш ч гэсэн тэнгэрийн хаант улсыг өвлөхийн тулд бидний хөгжүүлэх ёстой зан чанаруудын ихэнх нь тэдэнд байдаг. Эдгээр зан чанаруудад төлөв түвшин байдал, номхон дөлгөөн болон итгэх хүсэлтэй байх зэрэг ордог.) Хүүхдүүдээс та нар юу сурсан бэ? Бид хэрхэн Тэнгэр дэх Эцэгийнхээ хүслийн дагуу илүү дуулгавартай байж мөн хүүхэдтэй илүү адил болж чадах вэ?
- “Эдгээр багачуудаас нэгийг нь гомдоох” гэдэг нь ямар утгатай вэ? (Энэ хэсэгт *гомдоох* гэдэг нь бүдрүүлэх гэсэн утгатай.) Хүүхдүүдийг бүдрэхэд хүмүүсийн нөлөөлдөг зарим зүйлс юу вэ? (Хариултанд тэдэнд муу үлгэр дууриал үзүүлэх, эелдэг бусаар шүүмжлэх, тэдэнд зааж сургахгүй байх болон тэднийг хүчирхийлэх зэрэг нь орж болно.) Эдгээр зөрчлийг Их Эзэн юу гэж үздэг вэ?

Ахлагч М. Рассэл Баллард мэдэгдэхдээ: “Хүүхдүүдийг хүчирхийлж Христийн Сүнснээс маш их холдсон эцэг эх эсвэл асран хүмүүжүүлэгчдийн тухай сэтгэл сэртхийлгэсэн мэдээллүүдийг бид сонсдог. Энэ хүчирхийлэл нь бие махбодын, хэл амаар доромжлох эсвэл илэрхий биш ноцтой сэтгэл санааны доромжлолтой адил байсан ч энэ нь бузар булай явдал бөгөөд Бурханы хувьд ноцтой зөрчил юм” гэжээ (Conference Report, Apr. 1991, 107; or *Ensign*, May 1991, 80).

- Бид өөрсдөө хүүхэд адил байх нь бидэнд хүүхдүүдийг хэрхэн халамжлахад туслах вэ? “Эдгээр багачуудын нэг нь ч эрсдэх ёсгүй” гэсэн Бурханы хүслийг биелүүлэхийн тулд бид юу хийж болох вэ? (Матай 18:14).

2. Өршөөдөггүй боолын тухай сургаалт үлгэрээр Есүс өршөөлийн тухай заадаг.

Матай 18:15, 21-35-ыг уншаад ярилц.

- Матай 18:15-д хэрэв бид гомдсон бол юу хийх ёстой гэж Их Эзэн хэлсэн бэ? Энэ нь яагаад маргааныг шийдэх хамгийн сайн арга вэ?
- Хэдэн удаа уучлах ёстой вэ гэж Петрийг асуухад Есүс юу гэж хариулсан бэ? (Матай 18:22-ыг үз. Бид үргэлж бусдыг уучлах ёстой гэдгийг заахын тулд Есүс энэ их тоог хэрэглэсэн гэдгийг тайлбарла.) Заримдаа яагаад уучлах нь хэцүү байдаг вэ? Та нар бусдыг уучилж эсвэл тэд нараар уучлуулснаар хэрхэн адислагдсан бэ?

- Бусдыг уучлахын чухлыг цаашид онцлон тэмдэглэхийн тулд Есүс өршөөдөггүй боолын тухай сургаалт үлгэрийг ярьсан (Матай 18:23–35). Хаан болон боолууд нь хэнийг төлөөлдөг вэ? (Матай 18:35-ыг үз. Хаан Тэнгэрлэг Эцэгийг, боол нь биднийг төлөөлдөг.) Их Эзэнд өртэйгөөрөө бид хааны боолтой хэрхэн адилхан бэ? (Матай 18:24–27-г үз.) Өөрсдийн “өрийг” өршөөлгөхийн тулд бид юу хийх ёстой вэ?
- Хааны жишээнээс бусдыг өршөөхийн тулд бид юу хийх ёстой вэ? (Матай 18:33-ыг үз.) Бусдыг өршөөхгүй байхын сөрөг тал юу вэ? (Матай 18:34–35-ыг үз.)

3. Сайн Санаат Самари хүний тухай сургаалт үлгэрээр Есүс энэрлийн тухай заадаг.

Лук 10:25–37-г уншаад ярилц. Сайн Санаат Самари хүний зургийг үзүүл.

- Мөнхийн амьдралыг өвлөхийн тулд юу хийх ёстойгоо асуусан хуульчид Есүс юу гэж хэлсэн бэ? (Лук 10:25–28-ыг үз.) Бурханыг хайрла, хөршүүдээ хайрла гэсэн зарлигууд нь хэрхэн сайн мэдээг бүхэлд нь хамардаг вэ? Бид энэ хоёр зарлигийг хэрхэн илүү бүрэн гүйцэд дагаж чадах вэ?
- “Миний хөрш гэж хэн бэ?” гэж хуульчийг асуухад Есүс юу гэж хариулсан бэ? (Лук 10:29–37-г үз.) Энэ сургаалт үлгэр нь бидний хөрш хэн болох талаар юу заадаг бэ?

Ерөнхийлөгч Ховард В. Хантэр хэлэхдээ: “Хэдийгээр бид найзуудаа олдог ч Бурхан бидний хөршийг хаа сайгүй бий болгосон гэдгийг бид санах хэрэгтэй. Хайранд хязгаар байх ёсгүй, бидний шударга байдал өчүүхэн байх ёсгүй” гэжээ (Conference Report, Oct. 1986, 44; or *Ensign*, Nov. 1986, 35).

- Дээрэмдүүлж, шархадсан хүнийг хараад прист болон Леви хүн юу хийсэн бэ? (Лук 10:31–32-ыг үз.) Хүмүүст өнөөдөр ямар тусламж хэрэгтэй вэ? Бусдад хэрэгтэй зүйлд нь бид ямар шалтгаанаар тусалдаггүй вэ? (Нэг жишээг Мозая 4:16–19-өөс үз.)
- Дээрэмдүүлж, шархадсан хүнд сайн санаат Самари хүн яаж тусалсан бэ? (Лук 10:33–35-ыг үз.) Сайн хөршийн ямар зан чанарууд тэр Самари хүнд байсан бэ? “Сайн Санаат Самари” хүн та нарыг хэрхэн адисалдаг бэ? Бид хэрхэн “сайн санаат Самари хүн” болж болох вэ? (Мозая 4:26-г үз.)

Дүгнэлт

Даруу байж, бусдыг өршөөх, мөн бие биендээ энэрэл үзүүлснээр Аврагчийн жишээг дагахын чухал ач холбогдлыг гэрчил. Эдгээр номлолын дагуу амьдрахыг ангийн гишүүдэд уриал.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Мариа ба Марта

Ангийн гишүүнээр Лук 10:38–42-ыг уншуул.

- Марта Их Эзэнд хэрхэн үйлчилж байсан бэ? Мариагийн сонгосон “сайн зүйл” нь юу байсан бэ? Заримдаа бид хэрхэн “үйлчлэлдээ түүртэж”

Есүсийг зохих ёсоор нь хүлээн авдаггүй вэ? Эдгээр шүлгүүдээс бид юу сурч болох вэ?

2. “Хүүхдүүдийг над руу ирэхийг зөвшөөр” (Марк 10:14)

Та бид хүүхдүүд шиг болох ёстой гэсэн Аврагчийн сургаалыг ярилцахдаа Марк 10:13–16-д хүүхдүүдийг адисалсан талаарх мэдээллийг бас ярилцаж болно.

- Хүүхдүүдийг Есүс рүү авчрахад түүний шавь нар юу гэж хариулсан бэ? (Марк 10:13-ыг үз.) Есүс шавь нартаа юу гэж хэлсэн бэ? (Марк 10:14–15-ыг үз.) Хүүхдүүдийн төлөө Есүс юу хийсэн бэ? (Марк 10:16-г үз.) Энэ зүйлээс бид Есүсийн талаар юу сурч болох вэ? Энд түүний үзүүлсэн үлгэр жишээг бид хэрхэн илүү сайн дагаж болох вэ?

3. Матай 18-ын нэмэлт ярилцлага

- Матай 18:8–9 ба Марк 9:43–48-ыг ярилц (мөн Матай 5:29–30-ийг үз). Эдгээр шүлгүүд ямар утгатай вэ? (Иосеф Смитийн Орчуулгад эдгээр гомдоогч зүйлүүдийг биднийг буруу зам руу дагуулдаг хүмүүстэй адил юм гэж тайлбарласан байдаг. Биднийг гэм нүгэл хийхэд уруу татдаг хүмүүсийг дагаснаас тэднээс холбоогоо тасалсан нь дээр байдаг.)
- Иосеф Смитийн Орчуулгын Матай 18:11-д Есүс хүүхдүүд наманчлах хэрэггүй гэж хэлснээр бичигдсэн байдаг. Яагаад тэр вэ? (Моронай 8:11–12-ыг үз.) Хүүхдүүд нь Христийн дотор хэрхэн амьд вэ? (Моронай 8:12; С ба Г 29:46–47-г үз.) Христ дотор амьд байхын тулд бид юу хийх хэрэгтэй вэ? (Матай 18:4; Мозая 3:19; Моронай 8:10-ыг үз.)
- Матай 18:11–14-ийг унш. Бид алдагдсан хонины тухай сургаалт үлгэрийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ? Энэ сургаалт үлгэрийн зарчмыг дагаснаар та болон таны мэдэх хэн нэгэн хэрхэн адислагдсан бэ?

4. “Их Эзэн өөр далан хүнийг бас томилсон” (Лук 10:1)

- Лук 10:1–24-ийг ярилц. Матай 10-ын Их Эзэний Арван Хоёрт өгсөн удирдамжийг Далд өгсөн удирдамжтай нь хэрхэн харьцуулах вэ? Өнөөгийн Далынхан ямар үүрэг хариуцлагатай вэ? (С ба Г 107:25, 34, 38, 93–97.)

5. Гэрлэлтийн холбооны цэвэр ариун байдал

Матай 19:1–12-т хууль ёсны салалтын талаар Есүсээс асуун түүнийг урхидахыг хичээсэн Фарисайчуудын байдлыг дүрсэлсэн гэдгийг тайлбарла (мөн Марк 10:1–12-ыг үз). Иудейн эрдэмтэд, удирдагчид салалтын тухай асуудлыг их хэлэлцэж байсан бөгөөд тэдний асуулганд хариулах Есүсийн хариулт нь Иудейчуудын уур хилэнг бадраах боломжийг тэдэнд өгнө гэж Фарисайчууд найдсан. Ангийн гишүүнээр Матай 19:3–9-ийг чангаар уншуул.

- 3-р шүлэгт Фарисайчуудын асуулганд Есүс юу гэж хариулсан бэ? (Матай 19:4–6-г үз. Тэрээр тэдэнд салалт нь Бурханаас заагдсан зүйл биш гэж хэлсэн.) Мосе яагаад Израильчуудад салахыг зөвшөөрсөн бэ? (Матай 19:7–8-ыг үз.)

Эртний Израильд эрэгтэй хүн эхнэрээ ялихгүй шалтгаанаар хаях буюу эхнэрээсээ салж болдог байсан гэдгийг тайлбарла. Есүс селесчел хаант улс

гэх мэт төгс төгөлдөр дэлхийд салалт байдаггүй гэж заасан. Энэ дэлхий нь хараахан төгс төгөлдөр биш учраас салалт байдаг боловч, хамгийн ноцтой шалтгаанаас бусад тохиолдолд байх учиргүй юм. Матай 19:9-т садар самуунаас өөр шалтгаанаар эхнэрээсээ салсан эр Бурханы нүдэнд түүнтэй гэрлэсэн хэвээр байх ба хэрэв тэр өөр эмэгтэйтэй гэрлэвэл садар самуун явдал үйлдсэн болно гэж заадаг.

- Бат бэх гэрлэлтэнд төлөв түвшин байдал, өршөөл болон энэрэл нь ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Христтэй адил болохын төлөө зүтгэх нь бидний гэрлэлт болон бусад харьцаанд хэрхэн тусалж чадах вэ?
- Салалтаас болж шаналж буй хүнд бид хэрхэн тусалж чадах вэ?

6. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Жижиг хуудас цаасан дээр хичээлийн талаарх асуултуудыг бич (эсвэл ангийн гишүүдээр бичүүл). (Та давтлага үйл ажиллагаа болгож хичээлийн хэсэг бүрээс гол асуултуудыг сонгож болно.) Хуудас цааснуудаа уут буюу хайрцганд хий. Ангийн гишүүдээр сандлуудыг тойруулан тавиулаад, тойргийн төвд сандал дээр уут буюу хайрцгаа тавь. Ангийн гишүүдээр уут буюу хайрцагнаас ээлжлүүлэн асуулт сугалуулаад, тэдгээрт хариулуул.

“Би бол Ертөнцийн Гэрэл Мөн”

Хичээл
15

Иохан 7–8

Зорилго Ангийн гишүүдийн Есүс Христ бол бидний Аврагч ба түүнийг дагаснаар бид жинхэнэ эрх чөлөөг олж авна гэсэн гэрчлэлийг батжуулах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Иохан 7. Есүс Майхан Баярт оролцдог ба ариун сүм дотор заадаг. Зарим хүмүүс түүнийг Христ гэж итгэж байхад бусад нь түүнийг мэхлэгч гэж боддог.
 - б. Иохан 8:1–11. Есүс рүү завхайрч байгаад баригдсан эмэгтэйг авчирдаг. Тэрээр түүнд нигүүсэлтэй ханддаг.
 - в. Иохан 8:12–36. Есүс “Би бол ертөнцийн гэрэл” гэж тунхагладаг. Тэрээр өөрт нь итгэсэн Иудейчүүдэд өөрийг нь дагавал сүнслэг боолчлолоос тэднийг чөлөөлнө гэж сургадаг.
2. Заахад зориулсан зөвлөмж: Хичээлээ дор хаяж долоо хоногийн өмнөөс тоймлон үз. Та сонгосон судруудыг эртхэн судалбал долоо хоногийн туршид хичээлийг заахад тань туслах санаа болон бодлуудыг хүлээн авах болно. Та долоо хоногийн туршид хичээлийг эргэцүүлэн бодохдоо Сүнсний удирдамжийг хайж залбирч, Их Эзэн таныг адислана гэсэн итгэлтэй бай.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Гэрлээ унтрааж, мөн хөшиг буюу цонхны хаалтыг хааж аль болохоор өрөөг харанхуй болго. Ангийн гишүүнээс судрын хэсгийг чангаар уншихыг хүс. Ангийн гишүүнийг эдгээр шүлгүүдийг уншиж байх (эсвэл уншихыг оролдох) үед түүнээс ийн асуу:

- Эдгээр шүлгүүдийг уншихад хэцүү байсан уу? Үүнийг илүү хялбар болгох зүйл нь юу вэ? (Илүү гэрэл гэгээ)

Гэрлээ асааж, хөшиг, цонхны хаалтыг нээ. Ангийн гишүүнээс нөгөө хэсгээ дахин уншихыг хүс. Сударт гардаг гэрэл нь бүгд Есүс Христийг бэлэгддэг. (С ба Г 93:1–2-ыг үз.) Есүс өөрөө энэ бэлэгдлийг ариун сүм дотор зааж байхдаа хэрэглэсэн. Энэ хичээлд Есүс Христ бидэнд хэрхэн гэрэл болох талаар ярилцана.

Хэрэв та өрөөг харанхуй болгох боломжгүй бол оронд нь самбарт гэрэлт цамхаг зур (эсвэл гэрэлт цамхгийн зургийг үзүүл). Гэрэлт цамхгийн зорилго нь усан онгоцыг аюулаас сэрэмжлүүлж тэдгээрийг аюулгүй удирдах юм гэдгийг тайлбарла. Дараа нь номлолынхоо болон бидэнтэй холбогдох холбооныхоо тухай заахдаа Есүсийн хэрэглэдэг байсан бэлэгдлүүдийн нэг

нь гэрэл байсан гэдгийг тайлбарла. Энэ хичээлд, Есүс бидэнд сүнслэг байдалд хүрэх замыг үзүүлдэг гэрэл хэрхэн болдог тухай ярилцана.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрыг заахдаа тохиромжтой үед нь Есүс Христийн талаар гэрчлэлээ хуваалц. Бас ангийн гишүүдийг гэрчлэлээ хуваалцмаар санагдвал Есүс Христийн талаарх гэрчлэлээ хуваалцахыг уриал.

1. Есүс Майхан Баярт оролцдог ба ариун сүм дотор заадаг.

Иохан 7-г ярилц. Ангийн гишүүдийг сонгосон хэсгийг чангаар уншихыг урь. Майхан Баяр нь Дээгүүр Өнгөрөх Баяраас зургаан сарын дараа жил бүр болдог Иудейн баяр байсан гэдгийг тайлбарла. Энэ нь найман хоног үргэлжилдэг ба цөлд аялж байхад Израилийн хүүхдүүдэд өгсөн Их Эзэний адислалуудыг дурсан тэмдэглэдэг баяр юм. Түүнчлэн энэ нь жилийн ургац хураалт болон ургац хураалтын улирлын төгсгөлийг тэмдэглэдэг. Иудейчүүд энэ баярыг бүх баярынхаа хамгийн агуу нь бөгөөд хамгийн баяр баясгалантай нь гэж үздэг. (Левит 23:34–43-ыг үз.)

Есүс ариун сүмд энэхүү баярт оролцохоор Галилаас Иерусалим руу аялсан гэдгийг цохон тэмдэглэ (Иохан 7:1–10).

- Баярт байсан хүмүүс Есүсийн ирэхийг хүлээж байхдаа түүний тухай юу гэж ярьсан бэ? (Иохан 7:12-ыг үз.) Есүсийг зааж эхлэхэд хүмүүс яагаад гайхсан бэ? (Иохан 7:14–15-ыг үз.)
- Ариун сүмд байсан хүмүүст Есүс сургаалынхаа талаар юу гэж хэлсэн бэ? (Иохан 7:16-г үз.) Тэрээр өөрийнхөө сургаалын талаар гэрчлэл олж авахын тулд хүмүүст юу хийхийг зааварласан бэ? (Иохан 7:17-г үз.) Бид энэ удирдамжийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

Далын Ахлагч Жон К.Кармак хэлэхдээ: “Есүс ‘хэрэв хэн нэгэн Түүний хүслийг үйлдэхийг хүсч байвал тэрээр энэ сургаал Бурханаас ирсэн үү эсвэл Би өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ’ гэдгийг тайлбарласан (Иохан 7:17). Өөрөөр хэлбэл та оролдоод үзвэл үнэн гэдгийг нь мэдэх болно. Оролдоод үзэхэд итгэл шаардагддаг боловч энэ нь сүнслэг нотолгоо өгдөг. Туршилт хийхийг оролдож үзсэн шавь нарт үнэмшил, мэдлэг болон гэрэл ирэх болно” гэжээ (Conference Report, Oct. 1988, 32; or *Ensign*, Nov. 1988, 26).

Ангийн гишүүдээс сайн мэдээний дагуу амьдарснаар сайн мэдээний зарчмын талаарх тэдний гэрчлэл хэрхэн батажсаныг ярихыг урь (та өөрийн туршлагаасаа хуваалцаж болно). Иохан 7:17 дахь амлалтын эсрэг утга нь ч бас үнэн: хэрэв бид сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахгүй бол бидний гэрчлэл сулрах болно гэдгийг цохон тэмдэглэ.

- Есүсийг зааж байхад хүмүүс түүний тухай үзэл бодлоороо хуваагдсаар байсан. Тэр бол Христ гэдэгт хүмүүс итгэх зарим шалтгаанууд нь юу байсан бэ? (Иохан 7:31, 37–41-ийг үз.) Тэр бол Христ гэдэгт итгэхгүй байсан зарим шалтгаанууд юу байсан бэ? (Иохан 7:27, 41–42, 52-ыг үз.) Есүсийг хаанаас ирсэн тухай хүмүүс юу мэддэг байсан бэ? (Тэд түүний гэрийнхнийг болон төрсөн нутгийг мэдэж байсан.) Түүний хаанаас ирсэн талаар хүмүүс юуг нь мэдээгүй вэ? (Иохан 7:28–29; 8:14, 19, 23–29-ийг үз. Түүнийг Тэнгэрлэг Эцэгээс илгээгдсэн гэдгийг тэд ойлгоогүй.)

- Есүс Христийн номлолын талаарх гэрчлэлээ бид хэрхэн батжуулж болох вэ?

2. Есүс рүү завхайрч байгаад баригдсан эмэгтэйг авчирдаг.

Иохан 8:1–11-ийг уншаад ярилц.

- Хуулийн багш нар болон Фарисайчууд яагаад Есүс рүү завхай эмэгтэйг авчирсан бэ? (Иохан 8:4–6-г үз. Тэд эмэгтэйг цаазлах эсвэл Мосегийн хуулийг үгүйсгүүлж Есүсийг урхидахыг хүссэн.) Есүс хуулийн багш нарт болон Фарисайчуудад юу гэж хэлсэн бэ? (Иохан 8:7-г үз.) Тэд яагаад эмэгтэй рүү чулуу шидээгүй вэ? (Иохан 8:9-ийг үз.)
- Есүс эмэгтэйн нүглийг хүлээн зөвшөөрөөгүй ч тэрээр түүнийг зэмлээгүй (Иохан 8:10–11). Аврагчийн жишээнээс бид ноцтой гэм нүгэл үйлдсэн хүмүүст хэрхэн хандах ёстой талаар юу сурч болох вэ?

Ахлагч Марвин Ж.Аштон: “Хуулийн багш нар болон Фарисайчууд завхайрч байгаад баригдсан эмэгтэйг Аврагч руу авчирдаг. Тэдний зорилго хайраа тэр эмэгтэйд ч, Аврагчид ч үзүүлэх биш харин ичээж, Есүсийг буруутгах шалтаг олох байсан. . . . Есүс садар самуун явдлыг өршөөгөөгүй; зохих ёс суртахууныг Тэр баримталдаг байсанд эргэлзэх зүйл алга. [Гэхдээ] Тэрээр хуулийн багш нар болон Фарисайчуудад хүний сайн сайхны төлөө үйлчлэх хэрэгтэй гэдгийг харуулж, мөн урхидаж, ичээхийн хор хөнөөлтэй хүчийг харуулж тэдэнд хайраар заах замыг сонгосон юм (Conference Report, Apr. 1981, 31–32; or *Ensign*, May 1981, 24).

3. Есүс “Би бол ертөнцийн гэрэл” гэж тунхагладаг.

Иохан 8:12–36-г уншаад ярилц.

- Майхан Баярын үеэр Иерусалим дахь ариун сүмийг дөрвөн агуу том салаалсан лааны сууриас гарах галын дөлөөр гэрэлтүүлсэн байсан. Галын дөлийг хот даяар харж болох байсан. Энэ нь яагаад Есүс “Би бол ертөнцийн гэрэл” гэж зарлах тохиромжтой орчин байсан бэ? (Иохан 8:12). Есүс бол ертөнцийн гэрэл гэдэг нь ямар утгатай вэ? (Иохан 8:12; Алма 38:9, 3 Нифай 15:9, С ба Г 88:6–13-ыг үз.)
- Хүмүүс Есүстэй адил болохыг хичээснээр тэд ч бас түүний гэрлийг тусган авч ертөнцийн гэрэл болдог (Матай 5:14, 3 Нифай 18:24). Бусдыг Христийн санал болгодог гэрлийг харахад бид хэрхэн тусалж чадах вэ? (Матай 5:16, 28:18–20; Филиппой 2:14–15-ыг үз.)
- Есүс ариун сүмд байсан хүмүүст тэрээр үргэлж Эцэгтээ тааламжтай зүйлсийг үйлддэг гэж хэлсэн (Иохан 8:29). Тэнгэрлэг Эцэгт тааламжтай зүйлсийг хийхийн тулд бид хэрхэн илүү шийдэмгий болж болох вэ?
- Есүс Тэнгэр дэх Эцэгээ гэрчлэхэд “олон хүн түүнд итгэв” (Иохан 8:30). Хэрэв тэд түүнийг дагасаар байвал тэдгээр хүмүүст Есүс юу амласан бэ? (Иохан 8:31–32-ыг үз.) Үнэн биднийг юунаас чөлөөлдөг вэ? (Иохан 8:33–34-ийг үз.) Нүгэл үйлдэх нь биднийг хэрхэн эрхшээлд оруулдаг вэ? (Алма 12:11; 34:35-ыг үз.) Үнэнийг мэдэх нь та нарыг хэрхэн чөлөөтэй болгосон бэ?
- Хожим нь Есүс өөрийгөө “үнэн” гэж нэрлэдэг (Иохан 14:6). Энэ нь Иохан 8:32 дахь амлалтын талаарх та нарын ойлголтонд хэрхэн нөлөөлдөг вэ?

Аврагчийг мэддэг байх нь бид нарыг хэрхэн чөлөөлдөг вэ? Бид хэрхэн түүнийг мэддэг болж болох вэ?

Дүгнэлт

Есүс Христ бол бидний Аврагч бөгөөд зөвхөн тэр л биднийг нүглийн боолчлолоос чөлөөлж чадна гэдгийг гэрчил. Ангийн гишүүдэд “ертөнцийн гэрэл” Христийг дагахыг уриал, тэгснээр тэр тэднийг аюулгүй сүнслэг байдал руу хөтөлнө.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. Амьдралын ус

Майхан Баярын үеэр хийдэг ёслолуудын нэг дээр прист Силоамын цөөрмөөс ус авчирч өргөлийн тавцан дээр тавьдаг. Энэ өргөлийг хур бороо хүсэж, дараа жил арвин их ургац хураахын төлөө өргөдөг. Баярын сүүлчийн өдөр Есүс ариун сүм дотор зааж байхдаа хүмүүсийг амьдралын уснаас хүртэхийг урьсан (Иохан 7:37–38).

- Есүс амьдралын усны талаар өөр хаана дурдсан бэ? (Иохан 4:5–15-ыг үз.) “Амьдралын ус ” гэж юу вэ? Бид үүнийг хэрхэн хүртэх вэ?

2. Есүс Христ бол Жэхова

Иохан 8:37–59-ийг уншаад ярилц.

- Есүс үл итгэх Иудейчүүдэд хандан яагаад тэд бол Абрахамын хүүхдүүд биш гэж хэлсэн бэ? (Иохан 8:39–40-ийг үз. Хэдийгээр тэд Абрахамын жинхэнэ үр удам байсан боловч тэд Абрахам шиг зөв шударга үйлс хийдэггүй байсан.) Есүс яагаад тэднийг Бурханы хүүхдүүд биш гэж хэлсэн бэ? (Иохан 8:41–44-ийг үз.) Бид Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд гэдгээ өөрсдийн үйлдлээр хэрхэн харуулж чадах вэ?
- Иудейчүүд Абрахамын тухай хэлсэн Есүсийн үгэнд яагаад уурласан бэ? (Иохан 8:51–53, 56–57-г үз.) Тэд Есүс сүнсний үхлийг даван туулах өөрийн чадвар (51-р шүлэг) болон мөнх бус амьдралын өмнөх амьдралаа ярьж байгааг анзаараагүй. (56–57-р шүлэг.) “Абрахамыг бий болохоос өмнө Би байдаг” (Иохан 8:58) гэсэн Есүсийн мэдэгдэл нь түүний талаар юуг ойлгоход бидэнд тусалдаг вэ? (Египетээс гарсан нь 3:13–14-ийг үз. Есүс бол Жэхова, Агуу “Би байдаг,” Абрахам, Исаак болон Иаковын Бурхан юм.) Есүс мөнх бус амьдралынхаа өмнө Жэхова байсан гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ?

“Би Сохор Байсан, Одоо Би Харж Байна”

Хичээл
16

Иохан 9–10

Зорилго

Ертөнцийн Гэрэл болон Сайн Хоньчных нь хувьд Есүс Христийг илүү их ойлгож, түүнд талархахад ангийн гишүүдэд туслах болно.

Бэлтгэл

- Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - Иохан 9. Есүс Ертөнцийн Гэрэл гэдгээ баталдаг ба төрөлхийн сохор нэгэн эрийг эдгээдэг. Эдгэрсэн хүн Есүсийг Фарисайчуудад гэрчилж, түүнийг бишрэн шүтдэг.
 - Иохан 10:1–15, 25–28. Есүс би бол Сайн Хоньчин бөгөөд хониныхоо төлөө амиа өгнө гэж заадаг. Их Эзэний хонь нь түүнийг сонсож, дагадаг хүмүүс юм.
- Дараах материалууд байгаа бол хичээлдээ хэрэглэ:
 - Есүс Хараагүй Хүнийг Эдгээсэн нь зураг (62145; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 213).
 - New Testament Video Presentations* (53914)-ээс “New Testament Customs”-ын 3-р хэсэг (53914).
- Заахад зориулсан зөвлөмж: “Бурханы өмнө төлөв түвшин байх нь амжилтын нэгэн түлхүүр юм. Их Эзэний өмнө даруу байдаг багш нар бүх мэдлэг болон хүч чадлын эх сурвалжаас хүртдэг бөгөөд үүнээс тасралтгүйгээр авдаг. Өөрийн чадалдаа итгэсэн багш Сүнснийг алдах болно. Бурхангүйгээр [бид] юу ч хийж чадахгүй. Түүнтэй байхад бүх зүйл боломжтой” (*Teaching—No Greater call*, 5).

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүдээс Есүс мөнх бус үйлчлэлийнхээ үеэр эдгээсэн хэд хэдэн бие махбодын өвчлөлтийг бодохыг хүс. Тэдний хариултыг самбарт бич. Энэ хичээлийн нэг хэсэг бол түүний байнга бүтээж байсан гайхамшгийн нэг—Есүс сохор эрийг эдгээсэн тухай юм гэдгийг цохон тэмдэглэ.

- Аврагчийн үйлчлэлд сохор хүнийг эдгээх нь яагаад тийм онцгой гайхамшиг байсан гэж та нар бодож байна вэ? Сохор хүнийг эдгээх нь сүнслэг талаараа юуг бэлэгдсэн байж болох вэ? (Сүнсээрээ сохор байх явдлыг даван туулж, сүнслэг үнэнийг “харах” буюу ойлгоход бидэнд туслах Аврагчийн хүч чадал.)

Энэ хичээлд судалсан судрууд нь Аврагчийг сонсох ба харах, мөн үүнийг хийхэд бусдад туслах бидний үүрэг хариуцлага дээр төвлөрдөг.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Есүс төрөлхийн сохор нэгэн эрийг хараа оруулдаг.

Иохан 9-ийг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгийг уншихыг урь. Есүс хараагүй эрийг эдгээсэн нь зургийг үзүүл.

- Төрөлхийн сохор эрийг эдгээхийнхээ өмнө Есүс “Би бол ертөнцийн гэрэл” гэж тунхагладаг (Иохан 9:5). Есүс сохор эрд ямар замаар гэрэл өгсөн бэ? (Иохан 9:6–7, 35–38- ыг үз.)
- Хараагүй байсан эр Есүс түүнийг эдгээсэн гэж хэд хэдэн удаа гэрчилдэг (Иохан 9:10–11, 15, 17, 24–25, 27, 30–33. Та ангийн гишүүдийг судар дээрээ эдгээр хэсгийг тэмдэглэж авахыг уриалж болно). Энэ эрийн жишээнээс бид юу сурч болох вэ? (Хариултанд бид гэрчлэлээ хуваалцах үүрэгтэй гэдэг нь орж болно. Хэдийгээр түүний гэрчлэлийг эсэргүүцэж, түүнийг хавчсан ч тэр эр олон хүнд зоригтойгоор гэрчилсэн гэдгийг цохон тэмдэглэ.)
- Энэ эр гэрчлэлээ үргэлжлүүлэн хуваалцсанаар түүний гэрчлэл хэрхэн өссөн бэ? (11, 17, 33, 38-р шүлгүүдтэй харьцуул.) Гэрчлэлээ хуваалцснаар та нарын гэрчлэл хэрхэн өссөн бэ?
- Фарисайчууд гайхамшгийн талаар сонсоод яасан бэ? (Иохан 9:16-г үз.) Есүс Бурханы хүчээр энэ гайхамшгийг үзүүлсэн гэдгийг тэд хүлээн зөвшөөрөхөөс яагаад татгалзсан гэж та нар бодож байна вэ? (Хариултанд, бардамнал, Есүс Хүндэтгэлийн өдөр өвчнийг эдгээсэнд уурласан, тэд хүч чадал эсвэл алдар хүндээ алдана гэхээс айсан гэх мэт зүйлүүд орж болно.) Фарисайчууд Есүсийн нэр төрийг унагаахаар хэрхэн хичээсэн бэ? (Иохан 9:16, 18–20, 24, 28–29, 34-ийг үз.) Өнөө үед зарим хүмүүс Бурханы хүч чадлыг хэрхэн үгүйсгэдэг вэ?
- Фарисайчууд хараагүй байсан эрийн эцэг эхээс гайхамшгийн талаар асуухад тэд юу гэж хариулсан бэ? (Иохан 9:18–23-ыг үз.) Эцэг эх нь яагаад ингэж хариулсан бэ? (Иохан 9:22-ыг үз.) Бид заримдаа хэрхэн энэ эрийн эцэг эхтэй адил байдаг вэ? Бид гэрчлэхдээ хэрхэн илүү шийдэмгий байж чадах вэ?
- Есүс өөрийг нь эдгээсэн гэж тэр эрийг үргэлжлүүлэн гэрчлэхэд Фарисайчууд түүнийг хэрхэн шийтгэсэн бэ? (Иохан 9:34-ийг үз. Хөөн гаргасан гэдэг нь гишүүн байх эрхийг хасах гэсэн утгатай гэдгийг тайлбарла.) Гэрчилснээсээ болоод тэр эр хөөгдсөн гэдгийг Есүс сонсоод юу хийсэн бэ? (Иохан 9:35–37-г үз.) Бэрхшээл тулгарсан үед итгэлтэй байсны чинь төлөө Их Эзэн та нарыг хэрхэн адисалсан бэ?

Хэрэв та дүрс бичлэг хэрэглэж байгаа бол “The Synagogue” бичлэгийг одоо үзүүл.

- Фарисайчууд ямар үед харж, ямар үед сохор байсан бэ? (Иохан 9:39–41-ийг үз. Тэд хуулийг маш сайн мэддэг байсан боловч үүний жинхэнэ зорилгыг хардаггүй байсан. Тэд Есүс хуулийг гүйцэлдүүлэхээр ирсэн гэдгийг харахыг хүсээгүй.) Өөрсдийн нүдээр харах болон сүнслэгээр

“харах” буюу ойлгох хоёрын ялгаа нь юу вэ? Сүнсээрээ сохор байх зарим шалтгаан нь юу вэ? Бид энэ мэдээллээс сүнсээрээ сохор байх явдлыг хэрхэн даван туулах талаар юу сурч болох вэ?

2. Би бол Сайн Хоньчин хэмээн Есүс заадаг.

Иохан 10:1–15, 25–28-ыг уншаад ярилц. Эдгээр шүлгүүдэд Есүс, хоньчин хэрхэн өөрийн хонио хамгаалж, малладгийг дүрсэлдэг. Есүсийн үед хонинуудыг хонины хашаанд шөнөдөө оруулдаг байсан гэдгийг тайлбарла. Бусдыгаа амрахаар гэртээ харьсан үед хоньчдын нэг нь хаалгыг манадаг. Хэрэв зэрлэг амьтан хонины хашаанд орвол тэр хоньчин хонио хамгаалж, шаардлагатай бол амиа өгдөг. Өглөөд хоньчин бүр ирээд хонио дууддаг. Хонь эзнийхээ дууг таньдаг бөгөөд бэлчээр рүү түүнийг дагаж явдаг.

- Хоньчин ба хонины тухай Есүсийн ярьсан ярилцлаганд хонь хэнийг төлөөлдөг вэ? (Иохан 10:4, 27-г үз.) Хоньчин нь хэн бэ? (Иохан 10:11-ийг үз.) Сайн хоньчны зарим шинж чанарууд юу вэ? (Та самбарт эдгээр шинж чанаруудыг дор дурьдсанаар жагсааж бичиж болно.)
 - а. Тэр өөрийн хонио мэддэг, тэдгээрийг нэрээр нь дуудаж, тэднийг дагуулдаг (Иохан 10:3–4, 14).
 - б. Тэр бол хонинуудыг аварч тэжээл олгохоор сүрэгт нийлүүлэх боломж олгодог хонины үүд (Иохан 10:7, 9).
 - в. Тэр хониндоо “бялхсан амьдрал” өгдөг (Иохан 10:10).
 - г. Тэр хониныхоо төлөө амиа өгдөг (Иохан 10:11, 15).
- Хоньчин, хөлсний хүн хоёрын ялгаа нь юу вэ? (Иохан 10:11–14-ийг үз.) Есүс нь хоньчны төгс төгөлдөр жишээ хэрхэн болдог вэ? (Самбарт бичсэн жагсаалтаа ашиглаад Есүс эдгээр шинж чанар бүрийн үлгэр жишээ хэрхэн болсныг ярилц. Есүс хэрхэн хонины үүд болох талаар ярилцахдаа 2 Нифай 9:41–42-ыг үз. Бидний төлөө сайн дураараа амиа өгөх Есүсийн тухай ярилцахдаа Иохан 10:17–18-ыг үз.)
- Хонинууд хэрхэн хоньчноо таньдаг вэ? (Иохан 10:3–4-ийг үз.) Бид хэрхэн Их Эзэний дууг сонсож чадах вэ? (С ба Г 1:37–38; 18:33–36; 97:1-ийг үз.) Сайн Хоньчны дууг таньж, дагах үед бид хэрхэн хамгаалуулах вэ?

Хэрэв та дүрс бичлэг хэрэглэж байгаа бол “The Shepherd” ба “The Sheepfold” бичлэгийг одоо үзүүл.

- Хонины хашаанд орохыг оролддог хулгайч, дээрэмчин гэж хэн бэ? (Иохан 10:1-ийг үз. Тэд нар бол Их Эзэний дагалдагчдыг хорлох эсвэл тэдний замыг алдуулахыг оролддог хүмүүс юм.) Бид хэрхэн жинхэнэ хоньчин ба бидний замыг алдуулахыг оролддог хүмүүс хоёрыг ялгах вэ? (Иохан 10:10-ыг үз.)
- Сайн Хоньчныг дагасныхаа төлөө хонь хэрхэн шагнуулах вэ? (Иохан 10:9–10, 28-ыг үз.) Аврагчийг дагаснаараа та нар хэрхэн адислагдсан бэ?

Дүгнэлт

Есүс бол Ертөнцийн Гэрэл ба Сайн Хоньчин гэдгийг гэрчил. Тохиромжтой бол Их Эзэн танд сүнслэгээр харж, түүнийг дагахад хэрхэн тусалсныг ангийн гишүүдтэй хуваалц.

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Хоньчид байх бидний үүрэг

- Бид бас хэрхэн Их Эзэний сүргийн хоньчид болдог вэ? Сайн Хоньчны дууг сонсож, дагахад нь бид бусдад туслахын тулд юу хийж болох вэ?

Ахлагч Брус Р.МакКонки заахдаа: “Сүмийн ямар нэгэн үүрэгт ажилд үйлчилж байгаа хэн ч Их Эзэний ямар ч хүүхдийн сүнслэг эсвэл материаллаг сайн сайхны төлөө хариуцлага хүлээж тэдгээр хонины хоньчин нь байдаг. Их Эзэн өөрийн сүргийн аюулгүй байдал (авралын) төлөө өөрийн хоньчиддоо хариуцлага хүлээлгэдэг” гэжээ (*Mormon Doctrine*, 2nd ed. [1966], 710).

2. “Өөр хонин сүрэг надад бий” (Иохан 10:16)

- Иохан 10:16-д Есүс хэний тухай ярьсан бэ? (3 Нифай 15:21–24-ийг үз.) Аврагчийн дууг эдгээр “өөр хонинууд” хэзээ сонссон бэ? Энэ шүлэг Сүмийг сонирхож байгаа хэн нэгэнд Мормоны Номын талаар илүү сайн ойлголттой болоход хэрхэн тусалж чадах вэ?

Ахлагч Ховард В.Хантэр заахдаа: “Библийн номнуудын талаарх өөрсдийн мэдлэгээрээ Эзэний амьдрал болон сургаал номлолтой танил хүмүүс, түүний ярьж байсан өөр хонинууд болох—Дэлхийн Бөмбөрцгийн Баруун Хагасын хүмүүст үзэгдсэн түүний үзэгдлийн талаарх бичээс бас байдаг гэдгийг мэдэхийг сонирхоно. Энэ нь Америк тивийн хүмүүсийн тухай баримтыг бичиж дуусган, хураангуйлсан бошиглогчийн нэрээр Мормоны Ном гэж нэрлэгдсэн. Мормоны Ном нь Христийн өөр гэрч бөгөөд Шинэ Дэлхий дээрх өөр хонин сүрэгт заасан түүний сургаалын бичээс юм (Conference Report, Apr. 1983, 19; or *Ensign*, May 1983, 16).

3. Харах өөр өөр аргууд

Биднийг харахад тусалдаг Аврагчийн арга замуудыг улам бүрэн дүүрэн үнэлэхэд ангийн гишүүдэд туслахаар *харах* гэдэг үгийн хэд хэдэн өөр утгатай үгийн хайчилбар хий (дор санал болгосон утгууд бий). Үгийн хайчилбараа малгай буюу хайрцганд хийгээд ангийн гишүүдээр ээлжлүүлэн хайчилбарыг сонгуулж, тодорхойлогдсон аргаар Аврагч хэрхэн биднийг харахад тусалдаг талаар тайлбарлуул. Энэ санаа нь ялангуяа өсвөр насныханд гарцаагүй үр дүнгээ өгөх болно.

нүдээр харж хүлээн авах

ойлгох

ухамсарлах

боломжтойгоор нь төсөөлөх

танин мэдэх

анхаарлаа хандуулах

тодорхой санал бодлын үүднээс харах

“Би Мөнхийн Амьдралыг Өвлөн Авахын Тулд Юу Хийх Вэ?”


Марк 10:17–30; 12:41–44; Лук 12:13–21; 14; 16

Зорилго

Ангийн гишүүд тэнгэрийн хаант улсад багтахын тулд бид энэ дэлхийн зүйлсийг золиослох хүсэлтэй байх ёстой гэдгийг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Марк 10:17–30; 12:41–44. Нэгэн баян залуу мөнхийн амьдралыг авахын тулд юу хийх хэрэгтэйгээ асуудаг ба Есүс эд баялагтаа найдах нь тэр хүнийг Бурханы хаант улсаас гаргана гэж заадаг. Есүс нэгэн ядуу бэлэвсэн эмэгтэйг эрдэнэсийн санд өгсөн хоёр зэс зоосных нь төлөө магтдаг.
 - б. Лук 12:13–21. Тэнэг баяны тухай сургаалт үлгэрээр Есүс шунахайрахын аюулыг заадаг. Тэрээр дагалдагчиддаа газар дэлхийн эд баялгаас илүүтэйгээр тэнгэрлэг эд баялгийг эрэлхийл гэж уриалдаг.
 - в. Лук 14:15–33. Оройн их зоогийн тухай сургаалт үлгэрээр Есүс түүнийг дагадаг хүмүүс нь бүхнээсээ татгалзахад бэлэн байх ёстой гэдгийг заадаг.
 - г. Лук 16:1–12. Шударга бус няравын тухай сургаалт үлгэрээр Есүс түүний дагалдагчид дэлхийн эд баялгийг хайдаг хүмүүстэй адил урамтайгаар сүнслэг эд баялгийг хайхыг заадаг.
2. Нэмэлт Уншлага: Матай 19:16–30; Лук 18:18–30; 21:1–4; Жэкоб 2:8–19.
3. Хэрэв Христ ба Залуу Баян Захирагч (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 244) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэ.
4. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэж байгаа бол урхи хийх буюу самбарт зур (дор дурьдсан дүрслэлийг үз). Урхи хийхийн тулд тагтай хайрцаг авчир. Хайрцгаа таглаж сайн бэхлээд, хайрцагны нэг талд гараа зангидаж биш шургуулж орохоор нүх гарга. Хайрцган дотроо хэрчим жимс эсвэл жаахан самар хий.



5. Заахад зориулсан зөвлөмж: Нифай судруудыг “энэ нь бидэнд эрдэм болон тус байж болохын тулд би бүхий л судруудыг өөрсөдтэйгөө адилтгасан билээ” гэж хэлсэн (1 Нифай 19:23-ыг үз). Ангийн гишүүдэд судруудыг амьдралтайгаа адилтгаж хэрэгжүүлэхэд тусал.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Хийсэн буюу зурсан урхиа үзүүл (“Бэлтгэл” хэсгийг үз). Иймэрхүү урхийг сармагчин барихад хэрэглэж болно гэдгийг тайлбарла. Савыг газартай бэхэлж, (самар, жимс гэх мэт) амттанг дотор нь байрлуулдаг. Саван дахь нүх нь сармагчны хоосон гар чөлөөтэй орохоор том боловч амттаныг атгасан гар багтаж гарахгүй. (та үүнийг дүрслэн үзүүлж болно). Сармагчин амттанг хараад авахаар гараа оруулна. Сармагчин амттанг барихад тэр амттанг сармагчин авч явахын оронд өөрөө баригддаг. Үүнээс илүү агуу зүйл болох эрх чөлөөтэй болоход ийм золиослол хэрэггүй.

Заримдаа бид сармагчны гаргасантай төстэй алдаа гаргадаг гэдгийг цохон тэмдэглэ. Бид сонирхол татсан зарим зүйлийг олж авсан үедээ, энэ нь үүнээс илүү зүйлийг алдах явдалд хүргэж болох хэдий ч бид хаях дургүй байдаг. Энэ хичээлд хамгийн агуу адислал болох Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй хамт мөнхийн амьдралыг хүлээн авахын тулд бид зарим зүйлийг золиослох болдог тухай гарна.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгийг заахдаа Бурханы хаант улсын төлөө хүн болгоноос өөр өөр зүйл золиослохыг шаардах болно гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд тусал. Бурхан биднээс юу ч хүссэн бид золиослох хүсэлтэй байх ёстой.

1. Эд баялагт найдах нь тэр хүнийг Бурханы хаант улсаас гаргадаг.

Марк 10:17–30; 12:41–44-ийг уншаад ярилц. Христ ба залуу баян захирагчийн зургийг үзүүл.

- Есүс мөнхийн амьдралыг хэрхэн хүлээн авах талаар асуусан залуу баянд юу гэж хэлсэн бэ? (Марк 10:16–21-ийг үз.) Эдгээр зааварчилгаа нь яагаад залууд уйтгар гуниг авчирсан бэ? (Марк 10:22-ыг үз.) Их Эзэн яагаад түүнийг бүх өмч хөрөнгөө тарааж өг гэж хүссэн гэж та нар бодож байна вэ? Залуу баянд өгсөн Их Эзэний зааварчилгаа нь бидэнд хэрхэн хамаарах вэ?

Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит хэлэхдээ: “Тэр залууд хэцүү байсан зүйл нь гэвэл түүнд агуу их эд хөрөнгө байсан ба тэрээр Христийг дагаж, бүх зүйлээсээ татгалзахаас илүүтэйгээр өөрийн эд баялагтаа найдах явдал байсан. . . . Мөнхийн амьдралын бэлгийг олж авахын тулд газар дэлхийн бүх зүйлсийг золиослоход бэлэн байхгүй л бол хэн ч үүнийг хүртэж чадахгүй” гэсэн (*Gospel Doctrine*, 5th ed. [1939], 261).

- Есүс эд баялагтай байх, Бурханы хаант улсыг өвлөн авах хоёрын хоорондох холбооны талаар юу заасан бэ? (Марк 10:23–25-ыг үз.) Эд баялагтай байх болон эд баялагтаа найдах хоёрын ялгаа нь юу вэ? Газар

дэлхийн эд хөрөнгөнд хандах зохистой хандлагыг бид хэрхэн баримталж болох вэ? (Мозая 4:19, 21-ийг үз.)

Түүнчлэн ерөнхийлөгч Смит заахдаа: “Бурхан хүний хөрөнгө чинээг харгалзан үздэггүй юм. Хэрэв баян хүн Бурханы хуулинд болон үнэний зарчимд өөрийн зүрх сэтгэл, хайраа хандуулбал; хэрэв тэр Бурханыг хайрлаж, зүрх сэтгэлдээ үнэнийг хүлээн авч, мөн Бурханы зорилгыг биелүүлэхийн тулд бие сэтгэлээ зориулж, хайр болон итгэл найдвараа дэлхийн эд зүйлтэй холилдуулахгүй бол баян хүн ядуу хүний адил тэнгэрийн хаант улсад чөлөөтэй орох болно” гэсэн (*Gospel Doctrine*, 260–61)

- Марк 12:41:44 дэх ядуу бэлэвсэн эмэгтэйг баян залуутай харьцуул. Залуу баяны хийхийг хүсээгүй ямар зүйлийг ядуу бэлэвсэн эмэгтэй хийхийг хүссэн бэ? (Марк 12:44-ийг үз. Бурханы хаант улсын төлөө тэр эмэгтэй байгаа бүхнээ өгөхөд бэлэн байсан.) Бид ядуу бэлэвсэн эмэгтэйнх шиг занг хэрхэн хөгжүүлж чадах вэ?

2. Газар дэлхийн эд баялгаас илүүтэйгээр тэнгэрлэг эд баялгийг эрэлхийл.

Лук 12:13–21-ийг уншаад ярилц.

- Есүс өөрийн өв хөрөнгөнийхөө талаар санаа зовж байсан эрд юу гэж хэлсэн бэ? (Лук 12:13–15-ыг үз.) Шунахай зан гэж юу вэ? (Эд хөрөнгөнд болон бусдын хөрөнгөнд санаархах хүчтэй хүсэл.) Хүмүүс өнөөдөр ямар зүйлст шунадаг вэ? Шунахайрах нь яагаад аюултай вэ?
- Ихэвчлэн материаллаг зүйлсийг ихэд үнэлж үздэг дэлхий дээр, бидэнд хэр хэмжээний эд зүйл байгаагаар өөрсдийн хувь хүний үнэ цэнийг тодорхойлж болохгүй гэдгийг бид хэрхэн санаж чадах вэ? (Лук 12:15-ыг үз.) Материаллаг баялгаас илүү ямар адислалууд чухал вэ? (Зарим жишээг Лук 12:31–34; С ба Г 6:7-гоос үз.)
- Тэнэг баяны тухай сургаалт үлгэр дэх эр хэрхэн адислагдсан бэ? (Лук 2:16-г үз.) Тэрээр илүү гарсан зүйлээ яахаар шийдсэн бэ? (Лук 12:18-ыг үз.) Түүний үйлдэл юуг нотолж байна вэ? (Лук 12:19–21-ийг үз. Тэр зүрх сэтгэлээ эд баялагтаа зориулсан байсан.) Хэрэв тэрээр дэлхийн эд баялгаас илүүтэйгээр тэнгэрлэг эд баялгийг хайж байсан бол өөрийн элбэг дэлбэг зүйлээрээ юу хийж болох байсан бэ? (Мозая 4:26; С ба Г 52:40-ийг үз.)
- Хэдийгээр эд баялаг нь түр зуурын зүйл гэдгийг ихэнх хүмүүс мэддэг ч яагаад материаллаг зүйлд зүрх сэтгэлээ зориулдаг вэ? Бид материаллаг баялагт илүү санаа тавьж байгаа үгүйгээ хэрхэн тодорхойлж болох вэ? Бид материаллаг эд баялаг болон цаг зав, авъяас билиг гэх мэт бусад адислалдаа хэрхэн илүү өглөгч байж чадах вэ? (Та ангийн гишүүдэд эдгээр асуултыг хичээлээс гадуур өөртөө болон гэр бүлийн гишүүдтэйгээ бодож үзэхийг уриал.)

3. Христийн дагалдагчид жинхэнэ шавь нар нь байхын тулд бүх зүйлээсээ татгалзах хүсэлтэй байх ёстой.

Лук 14:15–33-аас сонгосон шүлгийг уншаад ярилц.

- Ахлагч Жэймс И.Талмаж оройн их зоогийн тухай сургаалт үлгэрийг тайлбарлахдаа уригдсан зочид нь гэрээт хүмүүс буюу Израилийн гэрийг төлөөлсөн гэж заасан. Үйлчлэгч (Есүс) тэднийг найранд ирэхийг урихад

(сайн мэдээг хүлээн зөвшөөрөх) тэд шалтаг тоочиж, очихоос татгалздаг (*Jesus the Christ*, 3rd ed. [1916], 452). Израильчууд яагаад найранд ирээгүй вэ? Найранд ирсэн “ядуу, тахир дутуу, сохор болон хазгар доголтон” хүмүүс гэж хэн бэ? (Лук 14:21).

- Оройн их зоогийн тухай сургаалт үлгэр бидэнд хэрхэн хамаарах вэ? Бид Их Эзэний ширээн дээр найрлахгүй байх буюу өөрөөр хэлбэл судраа уншихгүй эсвэл ариун сүмд орохгүй байх ямар шалтаг тоочдог вэ? Найранд урих Их Эзэний урилгыг хүлээн авч байгаагаа бид хэрхэн харуулах вэ?
- Түүний шавь нар нь тэднээс юу ч хүссэн түүнийг золиослох хүсэлтэй байх ёстой гэж Есүс заасан (Лук 14:26–33). Эрт цагийн шавь нараас золиослохыг хүссэн зарим зүйлс юу байсан бэ? Шавь нараас өнөөдөр золиослохыг хүссэн зарим зүйлс юу вэ? Их Эзэн та нараас юу золиослохыг хүссэн бэ? Эдгээр золиослолыг хийснийхээ төлөө та нар хэрхэн адислагдсан бэ?

4. Сүнслэг эд баялгийг эрч хүчтэйгээр, мөн урам зоригтойгоор эрэлхийл.

Лук 16:1–12-оос сонгосон шүлгийг уншаад ярилц. Шударга бус няравын тухай сургаалт үлгэрийг ангийн гишүүдийг ойлгоход туслахын тулд дараах мэдээллийг хуваалц:

Ахлагч Жэймс И.Талмаж “дэлхий дээр мөнгө олохын тулд анхаарал халамж, бодол санаа, бүхнээ зориулах явдал, мөн сүнслэг баялгийг олж авахыг оролдож байгаа мэтээр зүрх сэтгэлийнхээ хагасыг үүнд зориулах явдал хоёрын хоорондох харьцааг” үзүүлэх гэж Их Эзэн энэ сургаалт үлгэрийг хэрэглэснийг тайлбарласан. Их Эзэн биднийг шударга бус үйлчлэгчийн хийсэн нүгэлт зүйлийг дууриаж хийхийг зөвлөөгүй, харин бид энэ үйлчлэгч материаллаг эд баялгийг олоход гаргасантай адил хүсэл, чармайлт оролдлоготойгоор сүнслэг баялгийг эрэлхийлэх ёстой.

Ахлагч Талмаж үргэлжлүүлэн, “‘Тэрлийн хүүхдүүд’ буюу сүнслэг баялагт итгэдэг тэдгээр хүмүүсийг ертөнцийн бүх эд зүйлээс өөрсдийгөө дээгүүр тавин нэг их эрч хүчтэй, хэрсүү, ухаалаг бус байхад дэлхийн эд зүйлд анхаарлаа тавьдаг хүмүүс ирээдүйдээ зориулж нөөцлөх явдалд хайнга хандалгүй, үе үе элбэг дэлбэг, их хэмжээгээр олж авах нүгэлт хүсэлтэй байдаг” гэв (*Jesus the Christ*, 463).

- Ангийн гишүүдээс мөнгө болон эд баялгаа арвижуулахын тулд зориулдаг цаг зав, бодол санаа, хүч чадлаа сүнслэг эрдэнэсийг эрэлхийлэхийн төлөө зориулдаг цаг зав, бодол санаа болон хүч чадалтай харьцуулан бодохыг хүс. Бид сүнслэг эрдэнэсийг эрэлхийлэхдээ хэрхэн бүхнээ зориулж, урам зоригтой байж чадах вэ?

Дүгнэлт

Бид мөнхийн амьдралыг хүртэхийн тулд дэлхийн зүйлсийг хойш нь тавьж, Их Эзэнд бүх зүрх, сэтгэл, оюун ухаан болон бүх хүчээрээ үйлчлэх хүсэлтэй байх ёстой гэдгийг гэрчил. Ангийн гишүүдээс газар дэлхийн адислалдаа талархаж, тэдгээрийг зөв талаас нь харж дүгнэхийг хичээхэд уриал.

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Төлөв түвшин байдал

Лук 14:7–11-ийг уншаад ярилц.

- Лук 14:11 дэх Есүсийн мэдэгдлийн үнэн байдлыг та нар хэрхэн харсан бэ?

2. Жинхэнэ энэрэл

- Лук 14:12–14-өөс бид хэрхэн үйлчлэх талаар юу сурч болох вэ? (Хариултанд, бид хариуд нь ямар нэгэн зүйл авах зорилгоор үйлчлэх ёсгүй бөгөөд бидэнд хариу барих буюу баярлах хүмүүст үйлчлэх үйлчлэлээ хязгаарлах ёсгүй зэрэг орж болно.) Бидний үйлчлэх болсон шалтгаан юу байх ёстой вэ?
- Жинхэнэ энэрэл нь биднийг Их Эзэнтэй илүү ойртоход хэрхэн туслах вэ?

3. Баян хүн ба Лазарын тухай сургаалт үлгэр

Ангийн гишүүдээр Лук 16:19–31-ийн сургаалт үлгэрийг уншуулаад ярилцуул.

- Баян хүн үхсэнийхээ дараа Эцэг Абрахамаас өөрийн ах дүү нарын төлөө юу хийхийг хүссэн бэ? (Лук 16:27–28-ыг үз.) Абрахам юу гэж хариулсан бэ? (Лук 16:29:31-ийг үз.) Энэ нь бошиглогчдыг сонсох талаар бидэнд юу зааж байна вэ?
- Энэ сургаалт үлгэр бидэнд ядуусыг халамжлахын чухал ач холбогдлын талаар юу зааж байна вэ?

Энэ сургаалт үлгэрээр жүжигчилсэн тоглолт хийхийг хүүхдүүд сонирхож магад. Ангийн хоёр гишүүнийг (Абрахам ба Лазар) сандлын эгнээ (агуу том ангал) гэх мэт саадын нэг талд, өөр нэгэн гишүүнийг (баян хүн) нөгөө талд нь зогсоо. Дөрөв дэх гишүүнийг өгүүлэгч болго. Ангийн гишүүдийн тоглож буй хэсгүүдийг Лук 16:19–31-ээс шууд уншуул, өгүүлэгч дүрүүдэд хамааралгүй зүйлийг уншина.

Лук 15; 17

Зорилго Бид наманчилж, мөн бусдад наманчлахад нь тусалснаас ирэх баяр баясгаланг ойлгоход ангийн гишүүдэд туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Лук 15:1–10. Алдагдсан хонины тухай сургаалт үлгэр болон мөнгөн зоосны тухай сургаалт үлгэрээр Есүс бидэнд хүний үнэ цэний талаар заадаг.
 - б. Лук 15:11–32. Үрэлгэн хүүгийн тухай сургаалт үлгэрээр Есүс нүглээ наманчлагчийг өршөөснөөр Тэнгэрлэг Эцэг агуу баяр баясгаланг мэдэрдэг гэдгийг заадаг. Түүнчлэн Аврагч дагалдагчиддаа өршөөнгүй бай гэж заадаг.
 - в. Лук 17:11–19. Есүс уяман өвчнийг нь эдгээхэд нэг хүн түүнд талархахаар буцаж ирдэг.
2. Нэмэлт Уншлага: Матай 18:11–14
3. Үрэлгэн Хүү (62155; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 220) болон Уяман Өвчтэй Арван Хүн (62150; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 221) зургууд байгаа бол хичээлдээ хэрэглэ.
4. Заахад зориулсан зөвлөмж: Есүс өөрийн заасан зарчмуудыг хэрэгжүүлэхийг сонсогчиддоо уриалахын тулд байн байн асуулт тавьдаг байсан (Матай 16:13–16; Лук 7:41–42-ыг үз). Ангийн гишүүдийг ярилцлаганд оролцоход уриалж, заасан зарчмуудыг ойлгож, хэрэгжүүлэхэд тэдэнд туслах асуултуудыг залбирч бэлтгэ.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ямар нэгэн чухал зүйлээ гэсэн эсвэл гэр бүлийн гишүүн нь олдохгүй байсан үеийн талаар ярихыг ангийн гишүүдээс урь. Тэгээд дараах асуултыг тавь:

- Эд зүйл буюу хүнийг алга болсон үед таны сэтгэл санаа ямар байсан бэ? Эд зүйл буюу хүнийг олдох үед таны сэтгэл санаа ямар байсан бэ?

Алдчихаад дараа нь олсон явдлынхаа талаар ярихыг та ангийн гишүүдээс хүсч болно.

Есүс сүнслэг хичээлийг хүмүүст нийтлэг тохиолддог зүйлтэй холбон заадаг байсан гэдгийг тайлбарла. Энэ хичээлд алдагдсан тэдгээр хүмүүсийг эрж, олохын чухал ач холбогдлыг заасан зарим сургаалт үлгэрийг ярилцана.

Та дараах судрын хэсгүүдийг ярилцахдаа Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ бид бүгдэд хайртай бөгөөд биднийг буцаж очин тэдэнтэй дахин хамт амьдрахыг хүсдэг хэмээн ангийн гишүүдийг ойлгоход тусал.

1. Аврагч хүний үнэ цэний талаар заадаг.

Лук 15:1–10-ыг уншаад ярилц. Есүс Фарисайчууд, хуулийн багш нарыг “Энэ хү нүгэлтнүүдийг хүлээн аван тэдэнтэй хамт хооллодог” гэж дургүйцэхэд нь алдагдсан хонины тухай сургаалт үлгэр болон мөнгөн зоосны тухай сургаалт үлгэрийг ярьдаг (Лук 15:2)

- Алдагдсан хонины тухай сургаалт үлгэрт хоньчин алдагдсан нэг хонио олохын тулд ерэн есөн хонио орхидог (Лук 15:4). Мөнгөн зоосны тухай сургаалт үлгэрт тэр эмэгтэй алдсан нэг зоосоо хичээнгүйлэн хайдаг (Лук 15:8). Хоньчин болон эмэгтэйн үйлдлээс бид юу сурч болох вэ? (С ба Г 18:10–13-ыг үз.)
- Хүн ямар байдлаар “алдагдаж” болох вэ? Алдагдсан хүмүүсийн өмнө хүлээх бидний хариуцлага юу вэ? (Лук 15:4–5, 8; Алма 31:34–35-ыг үз.)

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“Бидний зарим нь . . . өвдөж, шаналж, ганцаардсандаа уйлдаг. Бидний агуу бөгөөд чандлан сахих үүрэг бол тэдэнд хүрч тусалж, тэднийг асарч, өлссөн бол хооллож, үнэн, зөв шударгын төлөө цангасан бол тэдний сүнсийг тэтгэх явдал юм. . . .

“. . . Нэгэн цагт итгэлтэй байсан хүмүүсийн итгэл харин одоо буурчээ. Тэдний олон нь буцаж ирэхийг хүсдэг ч үүнийг яаж хийхээ мэддэггүй. Тэдэнд нөхөрсгөөр угтах гар хэрэгтэй. Жаахан л зүтгэл чармайлт гаргавал тэдний олонхыг нь Их Эзэний найрын ширээний дайллаганд буцааж авчирч болно.

“Ах эгч, дүү нар минь, бид бүгдээрээ тусламж хэрэгтэй байгаа, цөхөрч, хэцүү байдалд орсон хүмүүсийг хайж олж, тэдний сүнсийг хүчит гар, хайрын сэтгэлээрээ бүлээцүүлэх, тэднийг тайтгаруулж, дэмжих, аз жаргал, үр бүтээлтэй амьдралд нь хөтлөн оруулах Сүмийн хайранд өлгийдөн асарна гэдэгт би найдан, залбирч байна” гэсэн. (Conference Report, Oct. 1996, 118; or *Ensign*, Nov. 1996, 86.)

- Алдагдсан хүнийг эргээд ирэхэд бид яах ёстой вэ? (Ангийн гишүүдээр Лук 15:5, 6, 9-өөс давтагдан гарсан санаануудыг харуул. Мөн 7 ба 10-р шүлэг болон С ба Г 18:15–16-г үз.)

2. Тэнгэрлэг Эцэг нүглээ наманчлагчийг өршөөхдөө баярладаг хэмээн Есүс заадаг.

Лук 15:11–32-ыг уншаад ярилц. Үрэлгэн хүүгийн зургийг үзүүл.

- Үрэлгэн хүүгийн тухай сургаалт үлгэрт тэр залуу өөрийн өв хөрөнгөөрөө юу хийсэн бэ? (Лук 15:13-ыг үз.) Өнөөгийн хүмүүс үрэлгэн хүүтэй адил хэрхэн алддаг вэ?
- Үрэлгэн хүү бүх өв хөрөнгөө үрэн таран хийснийхээ дараа яасан бэ? (Лук 15:14–16-г үз.) Энэ нь бидний өнөөгийн амьдралд юугаараа хамаатай вэ?

- Үрэлгэн хүүг гачигдаж байх үед харийн нутагт хэн түүнд тусалдаг вэ? (Лук 15:16-г үз.) Үүнээс бид юу сурч болох вэ?
- Харийн оронд хэн ч түүнд туслахгүй болохоор үрэлгэн хүү хэнийг бодсон бэ? (Лук 15:17-г үз.) Бид үрэлгэн хүүгийн байгаа байдлаас наманчлалын тухай юу сурч болох вэ? (Лук 15:18:19-ийг үз.)
- Хүүгээ буцаж ирэхийг хараад эцэг нь юу хийсэн бэ? (Лук 15:20-ийг үз.) Эцэг нь хүүгийнхээ гэмшилд юу гэж хариулсан бэ? (Лук 15:21–24-ийг үз.) Тэр эцгийн хариулт нь биднийг наманчлах үед Их Эзэний өгдөг хариулттай хэрхэн адилхан бэ? (Лук 15:7; Мосая 26:30; С ба Г 58:42-ыг үз.)
- Бид юугаараа үрэлгэн хүүтэй адил вэ? (Доорх ишлэлийг үз.) Үрэлгэн хүүгийн тухай сургаалт үлгэр нь бидэнд ямар найдлага төрүүлдэг вэ?
 Үрэлгэн хүүгийн тухай сургаалт үлгэрийн талаар Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Би та нараас тэр түүхийг уншихыг хүсэж байна. Эцэг эх бүр үүнийг дахин дахин унших ёстой. Энэ нь гэрийн хүн нэг бүрт хамаарах том зүйл бөгөөд бүх хүн төрөлхтөнд ч гэсэн хамаатай юм. Учир нь бид бүгд нүглээ наманчилж, Тэнгэрлэг Эцэгийнхээ энэрэнгүй нигүүлслийг хүртэж, улмаар Түүний жишээг дагах хэрэгтэй үрэлгэн хүү, охид биш гэж үү?” (“Of You It Is Required to Forgive,” *Ensign*, June 1991, 5).
- Эцэг нь бага хүүгээ хүлээн авсан байдалд том хүү нь яагаад уурласан бэ? (Лук 15:25–30-ийг үз.) Том хүүгээ гомдоллоход эцэг нь юу гэж хариулсан бэ? (Лук 15:31–32-ыг үз.) Наманчилсан “үрэлгэн хүүг” найрсгаар угтаж авах нь заримдаа яагаад хэцүү байдаг вэ? Буцаж ирж буй хүүдээ хандсан энэ эрийн хандлагаас бид юу сурч болох вэ? (Лук 15:32-ыг үз.)

3. Есүс уяман өвчнийг нь эдгээхэд нэг хүн түүнд талархахаар буцаж ирдэг.

Лук 17:11–19-ийг уншаад ярилц. Уяман өвчтэй арван хүний зургийг үзүүл.

- Аврагч Иерусалим уруу яваад уяман өвчтэй арван хүнийг эдгээдэг (Лук 17:11–14). Тэдгээр уяман өвчтэй арван хүнээс хэд нь талархлаа илэрхийлэхээр буцаж ирсэн бэ? (Лук 17:15–16-г үз.) Ач санадаггүй уяман өвчтэй есөн хүнтэй адил зарим ямар шалтгаанаар бид үргэлж хүлээн авсан адислалынхаа төлөө талархлаа илэрхийлдэггүй вэ? Бид Их Эзэнд талархлаа илэрхийлэх нь яагаад чухал вэ?
- Хэдийгээр уяман өвчтэй арван хүн бүгд цэвэршсэн ч зөвхөн буцаж ирсэн тэр эр л эрүүл болсон байсан (Лук 17:14, 19). Эдгэрэх ба эрүүл болох хоёрын ялгаа нь юу вэ? (Доорх ишлэлийг үз.) Биднийг эрүүл болоход талархал болон итгэл маань хэрхэн тусалдаг вэ?

Бишоп Мэррил Ж.Бэйтман заахдаа: “Эрүүл хүн болохдоо тэр ач санадаг уяман өвчтэй хүн гаднаа эдгэрсэн шигээ дотроо ч бас эдгэрсэн. Тэр өдөр уяман өвчтэй есөн хүн өнгөцхөн эдгэрсэн харин зөвхөн итгэлтэй байсан нэг нь эрүүл болсон” гэжээ (Conference Report, Apr. 1995, 16; or *Ensign*, May 1995, 14).

Бид наманчилж, Их Эзэн рүү буцаж очин, мөн бусдыг буцаж очиход туслахдаа агуу баяр баясгаланг мэдэрдэг гэдгийг гэрчил. Есүсийн сургаалт үлгэр, мөн хүүхдүүдээ хайрладаг Бурханы хайр болон биднийг бие биенээ хайрлаасай гэсэн түүний хүслийг харуулдаг бусад номлолынх нь төлөө талархлаа илэрхийлж болно.

Заах Нэмэлт

Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Зохисгүй боолын тухай сургаалт үлгэр

Зохисгүй боолын тухай сургаалт үлгэрийг уншаад ярилц (Лук 17:5–10).

- “Итгэлийг маань өсгөөч” гэж Төлөөлөгчид нь хүссэний дараа Есүс энэ сургаалт үлгэрийг ярьсан (Лук 17:5). Бид итгэлээ хэрхэн өсгөх талаар энэ сургаалт үлгэрээс юу сурч болох вэ? (Хариултанд, Их Эзэнд шаргуу үйлчилснээр бид итгэлдээ өсдөг гэдэг нь орж болно.)
- Бид Их Эзэний тушаасан болгоныг гүйцэтгэдэг ч яагаад зохисгүй боолууд вэ? (Мозая 2:20–25-ыг үз.) Энэ нь биднийг хайрладаг Их Эзэний хайрын талаар юуг илэрхийлдэг вэ?

2. Усан үзмийн талбай дахь ажилчдын тухай сургаалт үлгэр

Усан үзмийн талбай дахь ажилчдын тухай сургаалт үлгэрийг уншаад ярилц (Матай 20:1–16).

- Энэ сургаалт үлгэрийн усан үзмийн талбайн ажилчин бүр юу авсан бэ?

Нэг цаг ажилласан хүмүүс бүхэл өдөржин ажилласан хүмүүстэй адил хөлс авсан гэдгийг онцлон тэмдэглэ. Бид хэн хамгийн ихийг авсан эсвэл хэн Их Эзэнд илүү их үйлчилсэн гэдэгт анхаарал тавих ёсгүй. Бидний зүрх сэтгэлийг мэддэг бүгдийн төгс төгөлдөр Шүүгч бидэнд нигүүсэл үзүүлж шүүн, бидэнд “зөв бүхнийг” өгнө (Матай 20:4, 7).

3. Дүрс бичлэг

New Testament Video Presentations (53914)-ээс “New Testament Customs”-ын дөрөв дэх хэсгийг Шинэ Гэрээний үед уяман өвчтэй хүмүүсийг юу гэж үздэг байсан, Христээр өвчнөө эдгээлгэнэ гэдэг нь уяман өвчтэй арван хүнд ямар агуу амьдрал өөрчилсөн адислал байсныг тайлбарлахад хэрэглэж болно.

Түүнчлэн энэ хэсэг нь Шинэ Гэрээн дэх Иудейчүүд цагийг хэрхэн тооцдог байсан тухай мэдээллийг агуулдаг. Хэрэв та усан үзмийн талбайн ажилчдын тухай сургаалт үлгэрийн (заах нэмэлт санаануудын хоёрдугаарыг үз) талаар ярилцвал “гуравдугаар цагийн орчим” мөн зургадугаар, есдүгээр, арван нэгдүгээр цагт гадагш гарсан газрын эзний тухай (Матай 20:3, 5–6) илүү сайн ойлгоход нь ангийн гишүүдэд туслахын тулд энэ хэсгийг үзүүлж болно.

Лук 18:1–8, 35–43; 19:1–10; Иохан 11

Зорилго Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд итгэх агуу итгэлийг хөгжүүлэхэд ангийн гишүүдэд туслах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Лук 18:1–8. Шударга бус шүүгч ба бэлбэсэн эмэгтэйн тухай сургаалт үлгэрээр Есүс хичээнгүй залбирлын чухал ач холбогдлыг заадаг.
 - б. Лук 18:35–43. Сохор эр итгэлээ харуулан Есүс түүнийг эдгээдэг.
 - в. Лук 19:1–10. Есүс Закхайгийн гэрт зочилдог.
 - г. Иохан 11:1–54. Есүс Лазарыг үхлээс босгосноор тэнгэрлэг шинжээ гэрчилдэг.
 2. Нэмэлт Уншлага: Марк 10:46–52; Лук 11:5–13.
 3. Есүс Хараагүй Хүнийг Эдгээсэн нь (62145; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 213) ба Есүс Лазарыг Үхлээс Амилуулсан нь (62148; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 222) зургууд байгаа бол хичээлдээ хэрэглэ.
 4. Заахад зориулсан зөвлөмж: Ерөнхийлөгч Дэвид О.МакКэй хэлэхдээ, “Та өөрийн биеэр мэдэрснээ л зөвхөн үр дүнтэй зааж чадна” гэжээ (*Gospel Ideals* [1953], 190). Та зааж байгаа зарчмуудынхаа талаарх гэрчлэлээ бэхжүүлэхийн тулд суралцаж, залбирч, дуулгавартай байдлыг эрэлхийл.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ахлагч Хью Брауныг номлолд явахын өмнө ээж нь түүнд :

“Хью, чи жаахан байхдаа муухай зүүд зүүдлэн шөнө дунд айн сэрдэг байснаа санаж байна уу? Чамайг өрөөнөөсөө ‘Ээж ээ та байна уу?’ гэж дуудахад би чамайг тайтгаруулж, айдсыг чинь алга болгохыг хичээдэгсэн. Одоо чамайг олны дунд номлолд явахад айх, хулчийх, ганцаардах, мөн бэрхшээлтэй цаг мөчүүд ирнэ. Чи намайг дууддаг байсан шигээ Тэнгэрлэг Эцэгээ ‘Аав аа та байна уу? Надад таны тусламж хэрэгтэй байна.’ гэж дуудаж болно гэдгийг мэдээсэй хэмээн би хүсэж байна. Тэр тэнд байгаа бөгөөд хэрэв чи өөрийн үүргээ гүйцэтгэн, адислалыг хүртэхээр зохистой амьдарвал Тэр чамд туслахад бэлэн байх болно гэсэн мэдлэгтэйгээр үүнийг хийгээрэй. Би Тэр тэнд байгаа бөгөөд чиний сайн сайхны төлөө залбиралд чинь болон хэрэгцээнд чинь хариулах болно гэдгийг чамд дахин батлан хэлэхийг хүсэж байна” гэжээ (Marvin J. Ashton, “Know He Is There,” *Ensign*, Feb. 1994, 50).

Энэ хичээлээр бид Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ бид бүгдийг мэддэг бөгөөд хүн нэг бүрт хайртай гэдэг агуу итгэлийг хөгжүүлэхэд бидэнд туслах судраас суралцана гэдгийг тайлбарла.

Ангийн гишүүдийн хэрэгцээг хамгийн сайн хангах судрын хэсэг, асуулт болон хичээлийн бусад материалыг залбирч сонго. Сонгосон судруудыг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилц. Ангийн гишүүдийг судрын зарчмуудтай холбогдолтой тохиолдсон явдлаасаа хуваалцахыг уриал.

1. Есүс шударга бус шүүгч ба бэлбэсэн эмэгтэйн тухай сургаалт үлгэрийг өгүүлдэг.

Лук 18:1–8-ыг уншаад ярилц. Энэ сургаалт үлгэрийг Есүс хэсэг Фарисайчуудад өгүүлсэн гэдгийг тайлбарла.

- Лук 18:1-д хэлсэнчлэн Есүс яагаад шударга бус шүүгч ба бэлбэсэн эхнэрийн тухай сургаалт үлгэр ярьсан бэ? Энэ сургаалт үлгэр “үргэлж залбирах ёстойг” бидэнд хэрхэн заадаг вэ? (Лук 18:1–8-ыг үз.)

Ахлагч Жэймс И.Талмаж, “Гэм нүгэлтэй шүүгч эцэст нь Бурханы хийх байснаар хүсэлтийг болгоосон гэдгийг Есүс харуулах гээгүй харин Тэрээр Бурханаас эмээдэггүй, хүмүүсийг ч хүндэлдэггүй энэ шүүгч хүртэл бэлбэсэн эхнэрийн гуйлтыг сонсоод ёсоор болгосон учраас Энэрэнгүй, Шударга Бурхан сонсоно, хариулна гэдэгт хэн ч эргэлзэх ёсгүй юм гэдгийг онцлон заасан” гэж заасан (*Jesus the Christ*, 3rd ed. [1916], 436)

- Үргэлж залбирах гэдэг нь юу гэсэн үг вэ? (Лук 18:7; Алма 34:27-г үз.)
Үргэлж залбирснаар бидэнд ямар адислалууд ирж болох вэ? (Лук 18:7–8; 2 Нифай 32:9; С ба Г 90:24-г үз.)

- Цөхрөлтгүй залбирал нь итгэлийг хэрхэн харуулдаг вэ? Бид цөхрөлтгүй залбираад хариулт хүлээн авсангүй гэж бодох үедээ юу хийх ёстой вэ?

Ахлагч Ричард Ж.Скотт хэлэхдээ:

“Бидний залбирал болгоны хариу шууд л ирдэг гэж бодох нь буруу юм. Зарим залбирал бидний зүгээс тодорхой хэмжээний чармайлтыг шаарддаг. . . .

“Биднийг [Тэнгэрлэг Эцэгтээ хандан] бэрхшээл болон гаргасан саналаа тайлбарлахад Тэр заримдаа тийм, заримдаа үгүй гэж хариулдаг. Тэрээр заримдаа залбирлыг маань хариулахдаа удаан байдаг нь бидэнд санаа тавихгүй байгаа явдал биш харин Тэр биднийг үнэхээр төгс их хайрладаг учраас юм. Түүний өгсөн үнэнүүдийг биднийг хэрэгжүүлэхийг Тэр хүсдэг. Бид өсч хөгжихийн тулд зөв шийдвэр гаргах чадвартаа найдах хэрэгтэй байдаг. Бид зөв гэж бодсон зүйлээ хийх хэрэгтэй. Цаг нь болохоор Тэр хариулна. Тэр биднийг баллахгүй” (Conference Report, Oct. 1989, 38; or *Ensign*, Nov. 1989, 30–31).

- Та нар цөхрөлтгүй залбирснаар юу сурч авсан бэ?

2. Сохор эр итгэлээ харуулан, Есүс түүнийг эдгээдэг.

Лук 18:35–43-г уншаад ярилц. Есүс хараагүй хүнийг эдгээсэн нь зургийг үзүүл.

- Иерихогийн ойролцоо байсан сохор эр Их Эзэнд итгэх итгэлээ хэрхэн харуулсан бэ? (Лук 18:38–42-ыг үз.) Та нар Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлснээр хэрхэн адислуулж байна вэ?

- Тэр эр хараа орохдоо талархлаа хэрхэн илэрхийлсэн бэ? (Лук 18:43-ыг үз; мөн Марк 10:52-ыг үз.) Бид Их Эзэнд өөрсдийн талархлаа хэрхэн илэрхийлж чадах вэ?

3. Есүс Закхайгийн гэрт зочилдог.

Лук 19:1–10-г уншаад ярилц.

- Закхай гэж хэн бэ? (Лук 19:2-ыг үз. Тэдгээр татвар хураагчид нь Ромын засаг төрд татвар хураагчаар ажиллаж байсан Иудейчүүд байсан гэдгийг тайлбарла. Иудейчүүд ерөнхийдөө тэдгээр татвар хураагчдад дургүй байсан ба тэднийг урвагчид болон нүгэлтнүүд гэж үздэг байсан.)
- Есүсийг харах гэсэн агуу хүслээ Закхай хэрхэн харуулсан бэ? (Лук 19:3–4-ийг үз.) Түүнийг модон дээр байхыг харсны дараа Есүс Закхайд юу гэж хэлсэн бэ? (Лук 19:5-ыг үз.) Есүсийн хэлсэн үгэнд Закхай хэрхэн хариулсан бэ? (Лук 19:6-г үз.) Аврагчийг гэртээ баяр хөөртэйгөөр хүлээн авахын тулд бид юу хийж болох вэ?
- Есүсийг Закхайгийн хонгоглохоор явахад хүмүүс үүнийг хэрхэн хүлээн авсан бэ? (Лук 19:7-г үз.) Закхайд хэлсэн Есүсийн үг бусад хүмүүсийн хэлсэн үгнээс ямар ялгаатай вэ? (Лук 19:5-ыг үз.) Энэ мэдээлэл дэх Есүсийн жишээнээс бид юу сурч болох вэ?
- Татвар хураагч гэсэн түүний мэргэжлийнх нь улмаас олон хүмүүс Закхайгаас цэрвэдэг байсан (Лук 19:2, 7). Бид заримдаа ямар байдлаар бусдыг шүүдэг вэ? Бид тэднээс илүү гэж бусдыг үл тоомсорлохгүй, мөн ингэж бодохгүй байх нь яагаад чухал вэ? (Алма 5:54–56; 38:13–14-ийг үз.) Бид бусдын талаар муугаар боддог явдлаа хэрхэн таслан зогсоож чадах вэ?

Ахлагч Жой Ж.Крисченсэн хэлэхдээ: “Өглөө болгон сэрэхдээ өнөөдөр бусад нь тэдэнд яаж хандах бол гэж сургууль уруугаа эсвэл Сүмийн үйл ажиллагаанд явахдаа айж байдаг хүмүүс байдаг. Тэдний амьдралыг сайн сайхан болгон өөрчлөх хүч та нарт бий. . . Их Эзэн та нарыг дэмжигч байж, тэдэнд урам хайрлах нэгэн мөн гэж тооцдог. Өөрийнхөө талаар бага бодож өөртөө байгаа бусдад, бүр өөрийнхөө гэр бүлд байдаг хүмүүст тусалж дэмжих хүчнийхээ талаар илүү их бод” гэжээ (Conference Report, Oct. 1996, 54; or *Ensign*, Nov. 1996, 39).

4. Есүс Лазарыг үхлээс босгодог.

Иохан 11:1–54-өөс сонгосон хэсгийг уншаад ярилц. Есүсийг Закхайгийн очсоны дараахан тэрээр түүний найз Мариа, Марта нараас тэдний ах, Есүсийн эрхэм найз Лазар өвчтэй байна гэсэн мэдээг хүлээн авдаг (Иохан 11:1–5). Хоёр хоногийн дараа Есүс шавь нартаа Мариа, Марта болон Лазарын амьдардаг Иудейн Бетан хот руу өөртэйгөө явахыг уриалдаг (Иохан 11:6–7).

- Есүсийг Бетанд буцаж ирэхэд Лазар нас бараад дөрөв хоносон байлаа (Иохан 11:17). Есүсийн ирж явааг сонсоод Марта юу хийсэн бэ? (Иохан 11:20-ийг үз.) Аврагчийн тэнгэрлэг номлолын талаарх Мартагийн гэрчлэлийн юу нь та нарын сэтгэлийг ихэд хөдөлгөдөг вэ? (Иохан 11:21–27-г үз.)
- Мариа болон гашуудаж буй бусад олныг хараад Есүс юу хийсэн бэ? (Иохан 11:33–35-ыг үз.) Энэ явдал нь Есүсийн талаарх та нарын сэтгэгдэлд хэрхэн нөлөөлдөг вэ?

- Лазарын булшнаас хадыг холдуул гэж Есүсийг хүсэхэд хэдийгээр хүчтэй гэрчлэлтэй байсан ч Мартагийн итгэл дорой болсон мэт байсан (Иохан 11:39). Есүс түүнд хэрхэн тусалсан бэ? (Иохан 11:40-ийг үз.) Их Эзэн биднээс юуг хүсдэг талаар эндээс бид юу сурч болох вэ?
- Лазарыг босгохын өмнө Есүсийн хэлсэн залбирал Эцэгтэйгээ ямар холбоотой болох талаар бидэнд юу зааж болох вэ? (Иохан 11:41–42-ыг үз.) Бид хувийн болон гэр бүлийн залбиралдаа Есүсийн жишээг хэрхэн дагаж болох вэ?

Есүс Лазарыг үхлээс босгож буй зургийг үзүүл мөн ангийн нэгэн гишүүнээс Иохан 11:43–44-ийг уншихыг урь.

- Есүс урьд нь хоёр ч хүнийг үхлээс босгосон (Марк 5:22–24, 35–43; Лук 7:11–17). Лазарыг үхлээс босгох нь өмнөх хоёр тохиолдлоос юугаараа ялгаатай байсан бэ? (Иайрын охин болон Найны бэлбэсэн эмэгтэйн хүү хоёрын бие махбод, сүнсийг дөнгөж салсны дараахан үхлээс босгосон. Тэднийг булшлаагүй байсан. Лазар нас бараад дөрвөн хоног болсон байсан бөгөөд түүний бие махбодыг аль хэдийн оршуулсан байсан.)
- Лазарыг үхлээс босгосон гайхамшиг нь хэрхэн Аврагчийн тэнгэрлэг номлолын гэрч болсон бэ? Үүнийг харж гэрчилсэн хүмүүст энэ гайхамшиг хэрхэн нөлөөлсөн бэ? (Иохан 11:45–46-г үз.) Энэ гайхамшиг Аврагчид итгэх та нарын итгэлийг хэрхэн бэхжүүлэх вэ?

Дүгнэлт

Таны ярилцсан зүйлд заасан зарчмууд нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд итгэх бидний итгэлийг бэхжүүлж чадна гэдгийг тайлбарла. Судрын хэсгийг тоймлон үзсэнийх дараа Ахлагч Томас С.Монсоны дараах мэдэгдлийг унш:

“Өнгөрөх цаг хугацаа хүмүүний амьдралыг өөрчлөх Гэтэлгэгчийн хүчин чадлыг өөрчлөөгүй юм. Тэрээр нас барсан Лазарт хэлсэнчлэн та нарт ч мөн надад ч ‘. . . гараад ир’ гэж хэлдэг (Иохан 11:43). Цөхөрч туйлдсан эргэлзээнээс гараад ир. Нүглийн гуниг зовлонгоос гараад ир. Үл итгэх байдлаас ирдэг үхлээс гараад ир. Шинэхэн амьдрал уруу гарч ир. Гараад ир” (Conference Report, Apr. 1974, 72; or *Ensign*, May 1974, 50).

Ангийн гишүүдэд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлэх арга замыг хайхыг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэхүү санааг хичээлдээ хэрэглэж болно.

Фарисай ба татвар хураагчийн тухай сургаалт үлгэр

Фарисай ба татвар хураагчийн тухай сургаалт үлгэрийг уншаад ярилц (Лук 18:9–14).

- Энэ сургаалт үлгэр дэх Фарисай хүний залбирлыг та нар хэрхэн дүрслэх вэ? Татвар хураагчийн залбирлыг та нар хэрхэн дүрслэх вэ?
- “Өөрийгөө өргөмжилдөг аливаа хүн номхруулагдаж, өөрийгөө даруу байлгагч нь өргөмжлөгдөнө” гэсэн нь юу гэсэн утгатай вэ? (Лук 18:14; Ифэр 12:27-г үз.)

“Хоёр Нүүрт Хүмүүс . . . Та Нар Золгүй еэ”

Хичээл
20

Матай 21–23; Иохан 12:1–8

Зорилго Ангийн гишүүдэд хоёр нүүр гаргахыг танин мэдэж, үүнээс зайлсхийж, Есүс Христтэй хийсэн амлалтаа батжуулахад туслах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Иохан 12:1–8. Мариа хөлийг нь тосолсон Бетан руу Есүс явдаг. Мариаг үнэтэй тос хэрэглэсэнд нь Иудас шүүмжилдэг.
 - б. Матай 21:1–11. Есүс Дээгүүр Өнгөрөх баяраар Иерусалимд буцаж очдог. Тэрээр хот руу илжигний дудран унаж сүр жавхлантайгаар орж ирдэг.
 - в. Матай 21:23–46. Ахлах прист болон ахлагчид ариун сүмд Есүс дээр ирээд түүний эрх мэдлийг сорьдог. Тэдний асуултанд хариулахын оронд Есүс тэдэнд хоёр хүүгийн тухай, мөн газрын эзний тухай сургаалт үлгэрүүдийг ярьдаг.
 - г. Матай 22:15–46. Хуулийн багш нар болон Фарисайчууд түүнийг буруушааж, нэр төрийг нь гутаах зүйлийг хэлж Есүсийг занганд оруулахыг хичээдэг.
 - д. Матай 23. Есүс хуулийн багш нар болон фарисайчуудын хоёр нүүр гаргадгийг буруушаадаг.
 2. Нэмэлт Уншлага: Матай 26:6–13; Марк 11–12; 14:3–9; Лук 11:37–51; 19:29–48; 20; Иохан 12:12–18.
 3. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл гадна дотор нь цэвэрхэн нэг аяга, мөн гаднах нь цэвэр дотор нь бохир нэг аяга авчир.
 4. Сүр Жавхлант Оролт (62173; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 223) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэ.
 5. Заахад зориулсан зөвлөмж: Та заахад бэлтгэхдээ судруудыг зүгээр л уншихаас илүү зүйл хийх ёстой. Судар бүрийг ядахдаа гурван удаа уншиж судал. Эхний удаа уншаад тэр хэсэг юу агуулсныг тунгаан бод. Дараа нь зарчмууд, сургаал болон тэмдэглэлт үйл явдлуудыг анхааралтай судал. Дараа нь дахин уншаад ангийг гишүүдийн хэрэгцээнд аль хэсэг нь хамгийн сайн тохирохыг тодорхойлоод тэдгээр хэсгүүдээ ярилцах аргыг төлөвлө.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Хоёр аягаа үзүүл. (“Бэлтгэл” хэсгийг үз.) Ангийн гишүүдэд аягануудын зөвхөн гадна талыг харуулахаа анхаар.

- Та нар энэ хоёр аяганы алинаас нь уух вэ?

Ангийн гишүүдэд аягануудын дотор талыг харуул.

- Одоо та нар аль аяганаас нь уух вэ? Яагаад?

Есүс Фарисайчуудыг гаднах нь цэвэр дотор нь бохир аягатай зүйрлэсэн (Матай 23:25–26). Фарисайчууд өөрсдийгөө зөв шударга харагдуулах гаднах ёслолууд болон үйлдэлд маш их анхаарал тавьдаг боловч үнэндээ зүрх сэтгэлдээ зөв шударга байхад санаа тавьдаггүй байсан. Энэ хичээлд зөв шударга харагдахыг хичээдэг ч зөв шударга амьдрахыг хичээдэггүй хоёр нүүрт хүмүүсийн талаар Аврагчийн буруушаасан явдлыг ярилцах болно.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгийг заахдаа эдгээр нь хоёр нүүр гаргахаас зайлсхийх талаар юу зааж байгааг ярилц. Ангийн гишүүдийг бусдын амьдрал дахь хоёр нүүр гаргах явдлыг олж харахаасаа илүү үүнийг өөрсдөөсөө олж, засахад голлон анхаарахыг уриал.

1. Мариа Есүсийн хөлийг тосолдог.

Иохан 12:1–8-ыг уншаад ярилц. Есүс цовдлуулахаасаа таван өдрийн өмнө найз нөхөдтэйгөө Бетанд нэг үдшийг өнгөрөөсөн. Тэнд Марта, Лазар нарын дүү Мариа маш үнэтэй цэвэр нардын үнэрт тосоор Аврагчийн хөлийг тосолсон (Иохан 12:1–3). Ахлагч Жэймс И.Талмаж түүний яагаад ийн хийснийг тайлбарлахдаа:

“Зочныхоо толгойг жирийн тосоор тослох нь түүнийг хүндэлж буй хэрэг; хөлийг тослох нь мөн ер бусын, онцгой хүндэтгэл үзүүлж буй хэрэг; харин маш их цэвэр нардын тосоор толгой, хөлийг тосолсон нь хаадуудад ч хүртэл ховорхон үзүүлдэг бишрэл хүндэтгэлийн үйлдэл байсан. Мариагийн үйлдэл нь бишрэлийн илэрхийлэл байсан ба энэ нь шүтлэг болон хайраар бялхах зүрх сэтгэлийн илрэл байсан юм” гэжээ (*Jesus the Christ*, 3rd ed. [1916], 512).

- Мариа Их Эзэнийг хайрлах хайраа харуулж хөлийг нь тосолсон. Бид Их Эзэнд хайраа хэрхэн харуулдаг вэ?
- Мариагийн үйлдлийг Иудас шүүмжилдэг. Тэр энэ тосыг юунд зориулж болох байсан гэж хэлсэн бэ? (Иохан 12:4–5.) Иудас хэрхэн хоёр нүүр гаргасан бэ? (Иохан 12:6-г үз. Хэрэв та анхаарал татах ажиллагааг Ашиглалтгүй бол үйл ажиллагаан дахь мэдээллийг хоёр нүүр гаргах гэж юу болохыг тайлбарлахаар хэрэглэ. Хичээлийн төгсгөл хэсэгт хоёр нүүр гаргах талаар Аврагч юу гэж боддог тухай ярилцана гэдгийг цохон тэмдэглэ.)

2. Есүс Иерусалимд сүр жавхлантайгаар орж ирдэг.

Матай 21:1–11-ийг уншаад ярилц. Есүсийн сүр жавхлантай оролт зургийг үзүүл. Есүсийг Дээгүүр Өнгөрөх Баяраар Иерусалимд буцаж ирэхэд Лазарыг үхлээс амилуулсан гэдгийг нь сонссон олон хүмүүс түүнийг харахаар ирсэн (Иохан 12:17–18). Есүсийг хотод ойртож ирэхэд ер нь хаад болон булаан эзлэгчдэд үзүүлдэг хүндэтгэл болох хувцсаа түүний зам дээр дэвсэж далдуу модны мөчрөөр түүн рүү далласан үй түмэн олон хүмүүс угтаж авсан. Энэ нь Зехариагийн бошгийг (Зехариа 9:9) биелүүлсэн бөгөөд Есүс амлагдсан Мессиа мөн гэдгийг илүү гэрчилсэн юм.

- Есүсийн Иерусалимд энгийн боловч сүр жавхлантайгаар орсон явдлын юу нь та нарын сэтгэлийг ихэд хөдөлгөдөг вэ? Хэрэв та нар тэр өдөр тэнд байсан бол ямар сэтгэгдэлтэй байх байсан гэж бодож байна вэ?
- Далдуу модны мөчрөөр Есүс рүү далласан хүмүүс түүнийг бошиглогч, хаан мөн гэдгийг нь таньсан (Матай 21:9, 11; Лук 19:38), харин бусад нь түүний номлолыг буруу ойлгосон буюу түүнийг эсэргүүцсэн. Өнөө үед

хүмүүс ямар байдлаар Аврагчийг буруу ойлгож эсвэл эсэргүүцдэг вэ? Бид амьдралдаа түүнийг хэрхэн илүү бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч, талархан угтаж авч болох вэ?

3. Есүс хоёр хүүгийн тухай сургаалт үлгэр болон газрын эзний тухай сургаалт үлгэрийг ярьдаг.

Матай 21:23–46-г уншаад ярилц.

- Хоёр хүүгийн тухай сургаалт үлгэрт ууган хүү нь удаах хүүгээс илүү дуулгавартай болохоо хэрхэн харуулсан вэ? (Матай 21:28–30-ийг үз.) Энэ сургаалт үлгэрийг Есүс сонсогчиддоо хэрхэн хамааруулж заасан бэ? (Матай 21:31–32-ыг үз.) Татвар хураагчид ба янхнууд хэрхэн ууган хүүтэй адил байсан бэ? (Эхэндээ тэд Бурханы зарлигуудыг эсэргүүцсэн боловч Иоханыг тэдэнд номлох үед Христийг хүлээн зөвшөөрч, нүглээ наманчилсан.) Ахлах прист ба ахлагч нар хэрхэн удаах хүүтэй адил байсан бэ? (Тэд Бурханыг дагадаг гэдэг боловч Иоханы сургаалыг эсэргүүцэж мөн Есүсийг биечлэн харсан ч гэсэн эсэргүүцсэн.) Удаах хүү нь яагаад хоёр нүүрт вэ?
- Бид Их Эзэнд ямар амлалтуудыг өгсөн бэ? (Та усан баталгаагаар хийдэг, ариун ёслол хүртэхдээ болон пристийн зэргийг хүлээн авахдаа хийдэг амлалтуудын талаар ярилцаж болно.) Заримдаа бид нар хэрхэн удаах хүү шиг байдаг вэ? Их Эзэнд өгсөн амлалтаа бид хэрхэн батжуулж болох вэ? Мөн энэ амлалтаа сахихад бие биендээ хэрхэн тусалж чадах вэ?
- Газрын эзний тухай (Матай 21:33–41) сургаалт үлгэрт газрын эзэн буюу усан үзмийн талбайн эзнээр хэнийг төлөөлүүлсэн бэ? (Бидний Тэнгэр дэх Эцэг.) Тариаланчдаар? (Есүсийн үеийн шашны Иудей удирдагчид.) Боолоор? (Бошиглогчид.) Тариаланчдын гарт амь үрэгдсэн хүүгээр? (Есүс Христ.)
- Шашны Иудей удирдагчид хэрхэн тариаланчид шиг байсан бэ? Усан үзмийн талбайн эзнийг ирэхэд тариаланчдад юу тохиолдоно гэж ахлах прист болон ахлагч нар бодсон бэ? (Матай 21:41.)
- “Барилгачдын голсон чулуу” нь хэн байсан бэ? (Матай 21:42; Үйлс 4:10–12). Барилгачид нь хэн байсан бэ? Есүс булангийн чулууг голсон барилгачдад юу тохиолдоно гэж хэлсэн бэ? (Матай 21:43–44-ийг үз.) Шүлэг 43 дээрх Есүсийн үгс бидэнд хэрхэн хамаатай байж болох вэ?
- Эдгээр сургаалт үлгэрүүдэд Есүс тэдний тухай ярьж байгааг ахлах прист болон Фарисайчууд ойлгоод юу гэж хариулсан бэ? (Матай 21:45–46-г үз.) Биднийг нүглээ наманчлах шаардлагатай болсон үед гарч ирэх бардамнал, ээвүүцлийг бид хэрхэн давж чадах вэ?

4. Хуулийн багш нар болон Фарисайчууд Есүсийг занганд оруулахыг хичээдэг.

Матай 22:15–46-гаас сонгосон шүлгийг уншаад ярилц. Фарисайчууд болон Садукайчууд түүнийг буруушааж мөн нэр төрийг нь гутаах зүйлийг хэлж Есүсийг занганд оруулахыг гурван удаа хичээсэн тухай эдгээр шүлгүүдэд бичсэн байдгийг тайлбарла.

- Фарисайчууд эхлээд Есүсийг занганд оруулахаар хэрхэн оролдсон бэ? (Матай 22:15–17-г үз. Хэрэв Есүс асуултанд тийм гэсэн бол тэд, үзэн ядаж буй Ромын засаглалыг дэмжиж байна гэж түүнийг буруушаах байсан.

Хэрэв тэр үгүй гэсэн бол засаглалын эсрэг бослого гаргаж байна гэж буруушаах байсан гэдгийг тайлбарла.) Есүст асуулт тавьсан хүмүүсийн талаар тэр юу мэдэж байсан бэ? (Матай 22:18-ыг үз. Их Эзэн бидний зүрх сэтгэл, бодлыг мэддэг гэдгийг цохон тэмдэглэ. Бид түүнээс юу ч нууж чадахгүй.) Есүс асуултанд хэрхэн хариулсан бэ? (Матай 22:19–21-ийг үз.) Энэ хариулт биднийг Бурханд болон газар дэлхийн засаглалд үнэнч байхад хэрхэн удирдаж чадах вэ? (Итгэлийн Тунхаг 1:12.)

- Садукайчууд Есүсийг хэрхэн занганд оруулахаар оролдсон бэ? (Матай 22:23–28-ыг үз.) Садукайчууд асуултандаа хэрхэн хоёр нүүр гаргасан бэ? (Матай 22:23-ыг үз. Тэд дахин амилалтын дараа гэрлэлт ямар байх талаар санаа зовж байгаа дүр үзүүлсэн боловч дахин амилалтанд итгэдэггүй байсан.) Есүс тэдний асуултанд хэрхэн хариулсан бэ? (Матай 22:29–30-ийг үз. Сургаал ба Гэрээ 132:15–16, 19-т Есүсийн номлолыг тодотгодог гэдгийг тайлбарла. Ариун сүмийн гэрлэлтийн гэрээнүүдийг хийж, дагадаггүй хүмүүс тэнгэрт ганц бие байх болно. Эдгээр гэрээнүүдийг хийж, дагадаг хүмүүсийн гэрлэлт мөнхөд үргэлжлэх болно.)
- Есүсийг занганд оруулах гурав дах оролдлого юу байсан бэ? (Матай 22:34–36-г үз.) Энэ асуултыг шийдэхийн тулд Есүс хэрхэн хариулсан бэ? (Матай 22:37–40-ийг үз.) Эдгээр хоёр агуу зарлигууд яагаад тийм чухал гэж та нар бодож байна вэ? Эдгээр зарлигуудын дагуу илүү бүрэн амьдрахын тулд бид юу хийж чадах вэ?

Ахлагч Ховард В. Хантэр хэлэхдээ: “Их Эзэнд бүх зүрх сэтгэлээрээ хайртай тэр хүн . . . түүнийг алдаршуулж, баярлуулахын тулд бууж өгч, юу ч хийж эсвэл золиослоход бэлэн байдаг. Бурханд бүх зүрх сэтгэлээрээ хайртай . . . тэр хүн түүний төлөө амьдралаа өгөхөд мөн түүнийг алдаршуулахын тулд дэлхий дээрх эд зүйлээс татгалзахад бэлэн байдаг. Бурханд бүх хүчээрээ хайртай тэр хүн өөрийн бие болон сүнснийхээ бүх хүчийг Бурханы үйлчлэлд дайчилдаг. Бурханд бүх ухаан бодлоороо хайртай тэр хүн өөрийгөө зөвхөн Бурхан болон түүний хүслийг мэдэхэд зориулж, бүх л зүйл дээр Бурханыг олж харж, түүнийг бүх л талаар хүлээн зөвшөөрдөг” гэжээ (Conference Report, Apr. 1965, 58; or *Improvement Era*, June 1965, 512).

5. Есүс хоёр нүүр гаргагчдын нүглийг буруушаадаг.

Матай 23-аас сонгосон шүлгийг уншаад ярилц.

- Хуулийн багш нар болон Фарисайчууд аравны нэгээ төлж, ядууст өглөг өгөн, бишрэлийн цуглаанд оролцож, ариун сүм рүү тогтмол явдаг байсан. Тэднийг буруушаахад Их Эзэнд юу нөлөөлсөн бэ? (Матай 23:5, 14, 23–28-ыг үз. Тэд эдгээр зүйлүүдийг итгэсэндээ биш харин бусдад зөв шударга нэгэн мэт харагдахыг хүссэндээ хийдэг байсан.) Тэд ямар “чухал нөхцөлүүдийг” орхигдуулсан гэж Их Эзэн хэлсэн бэ? (Матай 23:23-ыг үз.) Бид амьдралдаа эдгээр “чухал нөхцөлүүдийг” орхигдуулдаггүй гэсэн баталгааг хэрхэн өгөх вэ?
- Сүмийн гишүүд бид заримдаа хэрхэн хоёр нүүр гаргадаг вэ? (Жишээ нь, бид Сүмийн цуглаанд оролцохдоо Бурханыг бишрэхээсээ илүү бусдад харагдахдаа санаа тавьдаг байж болох юм. Бид хүмүүсийн анхааралд нэг их өртдөггүй үйлчлэл болох Сүмийн үүрэгт ажлын талаар гомдоллодог байж болно. Сүмийн удирдагчдыг дэмжсэн хэрнээ тэдний шийдвэрийг шүүмжилдэг байж болох юм.)

- Бид хоёр нүүр гаргахаас хэрхэн зайлсхийх вэ? Ангийн гишүүдээс эдгээр асуултуудыг дотроо тунгаан бодохыг хүс: Би аравны нэгээ төлж, ядууст өглөг өгч, цуглаанууддаа оролцож, өөрийнхөө алдар хүндийн төлөө эсвэл Бурханы алдар хүндийн төлөө бусдад үйлчилж байна уу? Бүх л үйлдэлдээ би Тэнгэр дэх Эцэг, Есүс Христэд илүү ойртохыг эрэлхийлдэг үү?

Дүгнэлт

Ангийн гишүүдэд өөрсдийн амьдрал дахь хоёр нүүр гаргах байдлыг дүгнэж үзээд, үүнээсээ ангижрахыг эрэлхийлэхийг уриал. Түүнд итгэх итгэл, түүнийг хайрлах хайраар хөтлүүлсэн, Есүс Христийг дуулгавартай дагаж, үйлчлэх чин сэтгэлийн хүсэл нь биднийг түүнд илүү ойртуулж, хайр, итгэлийг маань өсгөнө гэдгийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Есүс хоёр нүүр гаргах байдлын шинж тэмдэг болох үр жимсгүй инжрийн модыг хараадаг.

Матай 21:17–22-ыг уншаад ярилц. Хоёр нүүр гаргах байдлын өөр нэгэн шинж тэмдэг бол Иерусалим руу явах замдаа Есүсийн харсан инжрийн мод байсан гэдгийг тайлбарла.

- Олон навчтай атлаа ямар ч жимсгүй модыг олоод Есүс юу хийсэн бэ? (Матай 21:19-ийг үз.) Инжрийн мод хэрхэн хоёр нүүр гаргахтай адилхан байсан бэ?

Ахлагч Жэймс И.Талмаж тайлбарлахдаа: “[Мод] нь навчтай боловч үржил шимгүй байсан учраас Их Эзэний хараах зүйл болдог бөгөөд сургамжтай сургаалыг заах шалтгаан болсон. Ёс суртахууны чөлөөт сонголт модыг эзэлсэн байсан гэж үзвэл бид үүнийг хоёр нүүр гаргагч гэх нь зүйтэй; үүний нүцгэн байдал нь элбэг их навчистай нийлээд хүн төрөлхтний хоёр нүүр гаргалтын шинж тэмдэг болж байгаа юм” гэжээ (*Jesus the Christ*, 3rd ed. [1916], 527).

2. Дүрс бичлэг

New Testament Video Presentations (53914)-ээс сонгосон “New Testament Customs”-ын хоёр дахь хэсэгт Иудейчүүд магнайн ба гарын сахиус болон цацаг хэрэглэдэг тухай тайлбарладаг. Хэрэв та энэ хэсгийг 9-р хичээлд үзүүлээгүй бол ангийн гишүүдэд Матай 23:5-г (“тэд магнайн ба гарын сахиусаа өргөсгөж, унжлагаа уртасгадаг”) ойлгоход туслахын тулд одоо үзүүлж болно. Эдгээр зүйлс нь хэрхэн хуулийн багш нар болон Фарисайчуудын хоёр нүүр гаргах явдлын шинж тэмдэг болдог байсан бэ?

3. “Тэд хүний алдрыг таалсан” (Иохан 12:43)

- “Тэд хүний алдрыг Бурханы алдраас илүү таалсан” учраас Есүст итгэсэн олон хүмүүс итгэлээ харуулахыг хүсээгүй гэж Иохан бичсэн (Иохан 12:42–43). Бид заримдаа “хүний алдрыг” хүлээн авах гэж хэрхэн хэт их санаа тавьдаг вэ? “Хүний алдрыг” эрэлхийлсний сөрөг үр дагавар нь юу вэ? Бусдаас магтаал, шагналыг эрэлхийлэх хүслээ бид хэрхэн дарж чадах вэ? (С ба Г 82: 19; 88:67-г үз.)

“Таны Заларч Ирэх Үеийн Тэмдэг Юу Байх Вэ?”

Матай 24

Зорилго Ангийн гишүүдэд Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн өмнө болох тэмдгүүдийг танин мэдэж, мөн гишүүдийг энэ агуу үйл явдалд бэлтгэхэд уриалахад туслах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 24:1–5, 9–13, 15–22. Есүс Иерусалимд нүүрлэсэн сүйрлийг урьдчилан хэлдэг.
 - б. Матай 24:6–8, 14, 23–51. Есүс өөрийн Хоёр дахь Ирэлтийн өмнө болох шинж тэмдгүүдийг дүрсэлдэг ба энэ ирэлтэнд түүний сонгогдогсод хэрхэн бэлтгэж болох талаар заадаг.
 2. Нэмэлт Уншлага: Марк 13; Лук 21:5–36; Сургаал ба Гэрээ 45:15–55.
 3. Хоёр дахь Ирэлт (62562; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 238) зураг байгаа бол хичээлд хэрэглэ.
 4. Заахад зориулсан зөвлөмж: Заахаар дуудагдах нь танаас сайн мэдээний тухай бүгдийг мэдэхийг шаарддаггүй учраас хэрэв ангийн гишүүд таны хариулж чадахгүй асуулт асуувал та ичих хэрэггүй юм. Санаанаасаа зохиож хариулахын оронд та мэдэхгүй гэдгээ хэлээд хариулыг олж мэдэхийг хичээнэ гэж санал болго.
-

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүдийг цонхоор харуулан, тэнгэрийг ажиглуул. Ангид цонх байхгүй бол ангийн гишүүдээс сүм рүү ирэхэд цаг агаар ямар байсныг асуу. Дараа нь цаг агаарын талаар үнэмшмээргүй таамаглал дэвшүүл. Жишээлбэл, тэнгэр цэлмэг, гадаа халуун байвал хэдэн цагийн дараа цас орно гэсэн таамаглал дэвшүүл. Гадаа бороотой, хүйтэн бөгөөд бороо хэсэг хугацаанд үргэлжлэхээр байвал таван минутын дотор гадаа халуун болж, хуурай болно гэсэн таамаглал гарга.

Ангийн гишүүдээс таны таамаглалын талаар юу гэж бодож байгааг асуу. Тэднийг бодлоо хэлсний дараа дараах асуултуудыг тавь:

- Ойрын хэдэн цагт цаг агаар ямар байх талаар та нар юу гэж таамаглаж байна вэ? Юу та нарыг ийм таамаглал дэвшүүлэхэд хүргэсэн бэ?
- Болох гэж буй цаг агаарын байдлын шинж тэмдэг бидний хийх зүйлст хэрхэн нөлөөлж болох вэ? (Хариултанд, бид ихэнхдээ эдгээр шинж тэмдгүүдэд тулгуурлан бэлтгэл хийдэг. Жишээ нь, цаг агаар тааламжтай байхаар бол бид гадаа үйл ажиллагаа хийхээр төлөвлөж болно эсвэл

хүчтэй шуургыг тэсвэрлэн өнгөрөөх тусгай бэлтгэл хийж болно зэрэг нь орж болно.)

Цаг агаарыг урьдчилан таамаглах нь болох гэж буй үйл явдлуудад бэлтгэхэд бидэнд туслах шинж тэмдгүүдэд найдах нэг нөхцөл юм гэдгийг цохон тэмдэглэ. Хэрэв бид шинж тэмдгүүдийг ажиглавал бэлтгэлгүй байдлаа багасгадаг. Үүний адил Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн шинж тэмдгүүдийг ажиглах нь тэр агуу үйл явдалд бэлтгэхэд бидэнд туслах болно. Энэ хичээлд Есүсийн Хоёр дахь Ирэлтийн өмнө болох түүний зөгнөсөн зарим шинж тэмдгүүдийн талаар ярилцана. (Та бошиглол нь ямар нэгэн зүйл *болно* гэж онцолдог бол таамаглал нь ямар нэгэн зүйл *болж магадгүй* гэж онцолдог гэдгийг цохон тэмдэглэж болно. Цаг агаарын талаарх таамаглал буруу байж болох юм, харин Хоёр дахь Ирэлтийн талаарх судрын бошиглолууд бүгд биелнэ.)

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа Их Эзэн Хоёр дахь Ирэлтэндээ бэлтгэхэд бидэнд туслах мэдээллүүдийг илчилсэн гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд тусал. Сүүлчийн өдрүүдийн зовлон зүдгүүрийг үл хайхран бид баяр баясгалантайгаар энэ агуу үйл явдлын хүлээж чадна.

Матай 24-т Иерусалимын сүйрэл, мөн Хоёр дахь Ирэлтийн талаарх Аврагчийн бошиглолууд гардаг гэдгийг тайлбарла. Цаг хугацааны явцад энэ бүлгийн шүлгүүдийг зарим үед чухам ямар шүлэг нь аль үйл явдлыг дүрслэн харуулж байгааг ойлгоход хэцүү болгон өөрчилж, дахин эмхтгэсэн. Аз болоход Бошиглогч Иосеф Смит Библийг илчлэлтээр орчуулахдаа хоёр бошиглол болон дахин сэргээгдсэн нэмэлт мэдээллийг тодотгож өгсөн. Бошиглогчийн илчлэлт хүлээн авч орчуулсан Матай 24 нь Агуу Үнэт Сувд номны Иосеф Смит—Матайд бий.

Энэ хичээлд Иосеф Смит—Матайд гардаг шүлгүүдийн дарааллыг тусгаж, мөн тэр орчуулгад өгөгдсөн зарим нэмэлт мэдээлэл орсон болно. Хичээлийн туршид Хоёр дахь Ирэлт зургийг үзүүл.

1. Есүс Иерусалимд нүүрлэсэн сүйрлийг урьдчилан хэлдэг.

Матай 24:1–5, 9–13, 15–22-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг уншихыг урь. (Бошиглогч Иосеф Смитийн хэлснээр бол 6–8 ба 14 шүлгүүд Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн талаар өгүүлдгийг тайлбарла. Эдгээрийн тухай дараагийн хэсэгт ярилцана.)

- Есүсийг цовдлогдохоос хэдэн өдрийн өмнө зарим шавь нар нь Чидун Уул уруу түүнийг дагалдан явсан. Шавь нар нь Есүст ямар хоёр асуулт тавьсан бэ? (Матай 24:3-ыг үз.)

“Эдгээр зүйлс хэзээ болох юм бэ?” гэсэн тэдний эхний асуулт нь Есүсийн зөгнөсөн ариун сүм болон Иерусалим хотын сүйрэлтэй холбоотой (Матай 24:1–2; мөн Лук 19:41–44; 21:5–6-г үз). “Таны заларч ирэхэд болон дэлхийн төгсгөлд ямар шинж тэмдэг байх вэ?” гэсэн тэдний хоёр дахь асуулт Аврагчийн Хоёр дахь Ирэлттэй холбоотой. Иосеф Смитийн орчуулгад “дэлхийн төгсгөл” гэдэг нь дэлхийн оршин тогтнолын төгсгөл биш, Хоёр дахь Ирэлтийн үеэрх хорон санаатнуудын сүйрлийг харуулсан гэсэн утгатай гэдгийг тодотгож өгдөг хэмээн тайлбарла (Иосеф Смит—Матай 1:4).

- Иерусалимын сүйрлийн өмнө ямар шинж тэмдгүүд илэрнэ гэж Аврагч зөгнөсөн бэ? (Матай 24:4–5, 9–12-ыг үз.)
- Сүйрлээс зайлсхийхийн тулд юу хий гэж Есүс дагалдагчиддаа хэлсэн бэ? (Матай 24:13, 15–18-ыг үз.) Нэгэнт зугтсан бол тэд гэр лүүгээ буцаж явахгүй байх нь яагаад чухал байсан бэ? (Лук 9:62; С ба Г 133:14–15-ыг үз.)

Хэдийгээр олон Иудейчүүд тэдний агуу хот болон ариун сүм нурах болно гэдэгт итгээгүй ч Их Эзэний бошиглолууд МЭ 70 онд биелсэн гэдгийг тайлбарла. Мэссаяа ирж тулалдаанд нь тэдэнд тусална гэдэгт итгэн Иудейчүүд МЭ 66 онд Ромын эсрэг боссон. Дөрвөн жилийн дараа Ромчууд бүхэл хотыг устгасан. Аврагчийн зөвлөмжийг даган уул руу зугтсан хүмүүс амь хэлтэрсэн. Энэ зөвлөмжийг анхаараагүй хүмүүс сарнин бутарч, сүйрсэн.

2. Есүс Хоёр дахь Ирэлтийнхээ өмнө болох шинж тэмдгүүдийг дүрсэлдэг.

Матай 24:6–8, 14, 23–51-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Шавь нарын тавьсан хоёр дахь асуулт нь Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн талаар ярьсан гэдгийг ангийн гишүүдэд сануул. Иосеф Смитийн орчуулгын Матай 24-т Хоёр дахь Ирэлтийн өмнө болох олон шинж тэмдгүүд нь МЭ 70 оны Иерусалимын сүйрлийн өмнө болсон тэдгээр шинж тэмдгүүдтэй адил байна гэж заадгийг цохон тэмдэглэ. Аврагчийг буцаж ирэхээс өмнө Иерусалим дахин сүйрнэ. Хоёр дахь Ирэлтийн өмнө болох шинж тэмдэг ба зовлон зүдгүүрийг ярилцах явцдаа тэдгээрийг самбарт жагсааж бич.

- Матай 24:6-д Хоёр дахь Ирэлтийн ямар шинж тэмдгүүдийг дурьдсан байдаг вэ? Эдгээр бошиглолуудын биелж байгаа ямар нотолгоог та нар харж байна вэ? Бид дайн болон дайны сураг чимээнээс “айж сандрахгүй байх” хэрэгтэй гэж Их Эзэн заасан. Иймэрхүү хэцүү үед бид амар амгаланг хэрхэн олж чадах вэ? (Матай 11:28–30; 1 Иохан 4:16–18; С ба Г 6:34–36; 45:34–35; 59:23-ыг үз.)

Ахлагч М.Рассел Баллард найдвар, урам зориг авчирсан дараах зөвлөмжийг өгсөн:

“Хэдийгээр бошиглолууд эдгээр зүйлс болно гэж бидэнд хэлдэг боловч улам олон хүмүүс дэлхий даяарх гай гамшгийн өсөлтийн илрэлүүдээс ирэх зүйлээс ихэд сэрэмжилж байна. . . . Үнэнийг хэлэхэд хүн төрөлхтний гэр бүлд тулгарч байгаа шийдвэрлэж болшгүй мэт харагдах асуудлуудад яаралтай хариулт өгч чаддаггүй учраас бидэнд ихэд санаа зовох хангалттай шалтгаан бий. Гэхдээ эцсийн эцэст улам дордох энэ хар зургийг эс хайхран бид хэзээ ч найдлагаа таслах ёсгүй! . . .

“. . . Их Эзэн хянаж байгаа. Тэр төгсгөлийг эхнээс нь мэддэг. Тэр ямар ч хямралын үед дагах юм бол хамгаалах хангалттай зааварчилгааг бидэнд өгсөн. Түүний зорилго биелэх бөгөөд хэзээ нэгэн өдөр бид эдгээр үйл явдлуудын бүгдийнх нь мөнхийн шалтгааныг ойлгоно. Түүнчлэн, өнөө үед бид хэтрүүлэхгүй мөн хэт их бэлтгэл хийхгүй байхад анхаарах ёстой. Харин бид юу хийх ёстой вэ гэвэл Бурханы зарлигуудыг дагаж, хэзээ ч найдвараа алдахгүй байх ёстой!

“Гэвч бид ийм үймээн самуун, гай зовлон дундаас найдвараа хаанаас олох вэ? Нэлээн хялбархнаар бол ийм үймээн самуунтай цаг үед сүнслэг байдлаараа аюулгүй байх бидний найдах нэг зүйл бол бодол санаа, зүрх сэтгэлээ Есүс Христэд хандуулах явдал юм. . . . Итгэлийн бамбайг барьж, Бурханы зарлигуудыг биелүүлэхээр бүхнийг хийвэл юу ч тохиолдлоо гэсэн бидний бүх юм хэвийн байна гэдгийг мэдэн өдөр тутмынхаа олон сорилтуудыг давж гарч, өөрсдийн хамгийн сул дорой байдал, айдсаа ялж чадна” (Conference Report, Oct. 1992, 41–43; or *Ensign*, Nov. 1992, 31–32).

- Матай 24:7-д Хоёр дахь Ирэлтийн ямар шинж тэмдгүүдийг дүрсэлсэн бэ? Эдгээр бошиглоууд биелж байгаа ямар нотолгоог та нар харж байна вэ? Хоёр дахь Ирэлтийн өмнө болох байгалийн гай гамшигт бэлтгэхийн тулд биднийг юу хий гэж хожмын үеийн бошиглогчид зөвлөсөн бэ?
- Матай 24:14-т Хоёр дахь Ирэлтийн ямар шинж тэмдгүүдийг дүрсэлсэн бэ? Энэ бошиглол өнөөдөр хэрхэн биелж байна вэ? (Номлолын ажил өсөн нэмэгдэж, сайн мэдээг дэлхий даяарх олон олон газарт зааж мөн хүлээн зөвшөөрч байна.) Энэ бошиглолыг биелэхэд туслахын тулд бидний хүн нэг бүр юу хийж чадах вэ?
- Матай 24:24-т Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн ямар шинж тэмдгүүдийг дүрсэлсэн бэ? Энэ бошиглол биелэгдэж байгаа ямар нотолгоог та нар харж байна? Бид хуурамч бошиглогчдод хууртагдахаас хэрхэн сэргийлж чадах вэ? (Матай 7:15–20; С ба Г 45:57; 46:7–8-ыг үз.)
- Иосеф Смитийн Орчуулга Матай 24-т Есүс, хэрэв бид түүний үгийг эрхэмлэн нандигнавал сүүлчийн өдрүүдэд ирэхэд хууртагдахгүй гэжээ (Иосеф Смит—Матай 1:37). Бид Их Эзэний үгийг хэрхэн эрхэмлэн нандигнах вэ? Их Эзэний үгийг нандигнан хадгалах нь хууртагдахаас сэргийлэхэд та нарт хэрхэн тусалдаг вэ?
- Их Эзэн өөрийн дагалдагчиддаа Иерусалимд “ариун газар зогс” гэж хэлсэн (Матай 24:15) ба тэрээр одоо үед ч иймэрхүү зөвлөмжийг өгсөөр байгаа (С ба Г 87:8; 101:22). Бидний зогсох ёстой зарим ариун газар гэж юу вэ? Эдгээр газрууд нь сүүлчийн өдрүүдэд гарах хүнд хэцүү үед хэрхэн биднийг хамгаалах вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлэхдээ “Ариун эрчүүд, ариун эмэгтэйчүүд ариун газар зогсдог ба эдгээр ариун газруудад ‘шуурганаас, ямар ч хольцгүй уур хилэнг бүх дэлхий дээр асгарах үед хамгаалалт, хоргодох газар байг’ хэмээн Их Эзэний тунхагласан бидний ариун сүм, бидний цуглааны танхим, бидний гэр болон Заины гадаснууд ордог (С ба Г 115:6)” (“Prepare Yourselves for the Great Day of the Lord,” *Brigham Young University 1981 Fireside and Devotional Speeches* [1981], 68; see also *The Teachings of Ezra Taft Benson* [1988], 106).

- Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхэд бидэнд туслахын тулд Есүс дараах хэсгүүдэд юу гэж заасан бэ?
 - а. Инжрийн модны тухай сургаалт үлгэр (Матай 24:32–36).
 - б. Хоёр дахь Ирэлтийг Ноагийн үетэй харьцуулсан харьцуулалт (шүлэг 37–39).
 - в. Талбайд ажиллаж байгаа хоёр хүн ба тээрэмдэж байгаа хоёр хүний тухай бошиглол (шүлэг 40–41).

г. Сайн хүн ба хулгайчийн тухай сургаалт үлгэр (шүлэг 42–44).

д. Эзэн ба түүний боолын тухай сургаалт үлгэр (шүлэг 45–51).

- Бид Их Эзэний ирэлтийг үргэлж харж, бэлтгэх нь яагаад чухал вэ? Бид Их Эзэнтэй уулзахын тулд хэрхэн харж, бэлтгэж чадах вэ?
- Аврагчийг дахин ирэх үед зөв шударга хүмүүст юу тохиолдох вэ? (Матай 24:31, 45–47; 1 Тесалоник 4:16–18; С ба Г 88:96–98.)

Дүгнэлт

Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн тухай судар дахь бошиглолууд нь бүгд биелэгдэнэ гэдгийг гэрчил. Аврагчийн номлолуудыг суралцаж, амьд бошиглогчдын зөвлөмжийг дагаснаар бид өөрсдийгөө Христтэй уулзахад бэлтгэж чадна гэдгийг цохон тэмдэглэ. Хэрэв бид бэлтгэвэл Хоёр дахь Ирэлт нь бидний хувьд гайхамшигт сайхан өдөр байх болно.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэхүү санааг хичээлдээ хэрэглэж болно.

Хожмын өдрүүдэд илчлэгдсэн Хоёр дахь Ирэлтийн шинж тэмдгүүд

Есүсийн эртний шавь нарт өгөгдсөн бошиглолуудыг Бошиглогч Иосеф Смит дахин давтан мөн тодруулсан илчлэлт хүлээн авсан гэдгийг тайлбарла. Энэ илчлэлт нь Сургаал ба Гэрээ 45-т байдаг. Ангийн гишүүдээр Сургаал ба Гэрээ 45:15–55-ийг Матай 24-тэй харьцуулуул. (Та Сургаал ба Гэрээ 45:60–61-д илчлэлт хүлээн авч орчуулсан Шинэ Гэрээний орчуулгыг эхлэхэд Иосеф Смитэд өгсөн Их Эзэний зааварчилгаа багтсан байдаг гэдгийг цохон тэмдэглэж болно.)

“Та Нарт Бэлтгэгдсэн Хаант Улсыг Өвлөн Авсугай”

Хичээл
22

Матай 25

Зорилго Ангийн гишүүдэд зөв шударга амьдарч, өөрсдийн авьяасаа хөгжүүлэн, бусдад үйлчилснээр Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхэд нь туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 25:1–13. Есүс арван охины тухай сургаалт үлгэрээр, бид түүний Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэх ёстой гэдгийг заадаг.
 - б. Матай 25:14–30. Есүс талантын тухай сургаалт үлгэрээр, бид Бурханаас хүлээн авдаг бэлгүүдээ хөгжүүлэх хэрэгтэй гэдгийг заадаг.
 - в. Матай 25:31:46. Есүс хонь ба ямааны тухай сургаалт үлгэрээр, бид бие биендээ чин сэтгэлээсээ үйлчлэх хэрэгтэй гэдгийг заадаг.
2. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл жижигхэн шилэн сав, тостой эсвэл будагтай ус бүхий сав, мөн Хоёр дахь Ирэлт (62562; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 238) зураг байгаа бол авчир.
3. Ангийн гишүүн бүрт хуудас цаас, үзэг харандаа авчир.
4. Заахад зориулсан зөвлөмж: Ангид өрнүүлэх ярилцлагыг удирдан, тодорхой болгохын тулд, мөн Их Эзэн өнөөдөр ч өөрийн хүслээ үргэлжүүлэн илчилсээр байгааг онцлохын тулд энэ гарын авлагад болон Сүмийн сэтгүүлүүдэд буй хожмын үеийн бошиглогчдын яриаг ашигла. Энэхүү ишлэлүүдийг судрын уншлага болон ангид өрнүүлэх ярилцлагын оронд ашиглах биш харин нэмэлт дэмжлэг болгон ашигла.

**Хичээл Заах
Зөвлөмж**

**Анхаарал Татах
Ажиллагаа**

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Жижиг шилэн сав, тостой эсвэл будагтай ус бүхий сав, мөн Хоёр дахь Ирэлт зургийг үзүүл.

Энэ хичээл нь түүний Хоёр дахь Ирэлтийн тухай Төлөөлөгчдийнхөө тавьсан асуултанд хариулт болгон Аврагчийн заасан гурван сургаалт үлгэр дээр голлодог гэдгийг тайлбарла. Та шилэн сав, тостой эсвэл будагтай усыг Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэх бидний бэлтгэлийг төлөөлүүлэн ашиглах болно хэмээн ангийн гишүүдэд хэл.

**Судрын Ярилцлага
ба Ашиглалт**

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Есүс арван охины тухай сургаалт үлгэрийг өгүүлдэг.

Матай 25:1–13-ыг уншаад ярилц. Арван охины тухай сургаалт үлгэр Иудейчүүдийн хуримын ёс заншилд үндэслэсэн гэдгийг тайлбарла. Есүсийн үед шинэ хүргэн болон түүний найзууд сүйт бүсгүйгээ гэрээс нь хүргэний гэр хүртэл дагалдан явдаг байсан. Замд нь сүйт бүсгүйн найзууд тэдэнтэй нэгдэхээр хүлээдэг. Тэд хүргэний гэрт хүрч ирээд бүгд дотогш хуриманд ордог. Иймэрхүү хурим голдуу орой болдог учраас сүйт бүсгүй болон хүргэнийг хүлээж буй тэдгээр хүмүүс тостой жижиг дэнлүү барьж явдаг байсан.

- Арван охины тухай сургаалт үлгэрт хүргэн хэнийг төлөөлдөг вэ? (Аврагч.) Охид хэнийг төлөөлдөг вэ? (Сүмийн гишүүд.) Хурим юуг төлөөлдөг вэ? (Аврагчийн Хоёр дахь Ирэлт.) Дэнлүүний тос юуг төлөөлдөг вэ? (Хоёр дахь Ирэлтийн бэлтгэл.)
- Таван охин ямар мунхаг зүйл хийсэн бэ? (Матай 25:3-ыг үз.) Тэд бэлтгэлгүй байсны үр дүнд юу болсон бэ? (Матай 25:8–12-ыг үз.) Заримдаа бид мунхаг охидуудын адил хэрхэн алдаа гаргадаг вэ?
- Таван охин ямар ухаалаг зүйл хийсэн бэ? (Матай 25:4.) Тэдний бэлтгэлийн үр дүн нь юу байсан бэ? (Матай 25:10-ыг үз.) Бид ухаалаг таван охидын үйлдлээс юу сурч болох вэ? (С ба Г 45:56–57-г үз. Бид Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэх ёстой.)
- Сургаалт үлгэр дэх тос нь Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэх бэлтгэлийг төлөөлдөг гэж үзвэл бид өөрсдийн “дэнлүүндээ” “тос” нэмж болох ямар аргууд байдаг вэ? (Хариултанд, итгэлээ хөгжүүлэх, ёслолуудыг хүлээн авах, гэрээнүүдээ дагах, үйлчлэх зэрэг зөв шударга амьдралын тодорхой хэсгүүд орж болно.)

Хэрэв та шилэн сав, тос эсвэл будагтай ус хэрэглэж байгаа бол (анхаарал татах ажиллагааг үз) шилэн сав нь сургаалт үлгэр дэх дэнлүүг төлөөлж байгааг тайлбарла. Бид хэрхэн бэлтгэж болох талаар ангийн гишүүдийг саналаа хэлэх бүрт шилэн саванд тос эсвэл усаа дусаа. Та Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболлын дараах санааг хуваалцаж болно:

“Сургаалт үлгэрт тосыг зах дээрээс худалдан авч болох байсан. Бидний амьдралд бэлэн байдлын тосыг зөв шударга амьдарч дусал дуслаар хуримтлуулдаг. Ариун ёслолын цуглаанд оролцох нь жилээс жилд бидний дэнлүүд дусал дуслаар тос нэмдэг. Мацаг барих, гэр бүлийн залбирал, гэрийн багшлалт, бие махбодын дур хүслээ хянах, сайн мэдээг номлох, судраас суралцах гэсэн бүхнээ зориулах болон дуулгавартай байдлаа харуулах үйлдэл бүр нь бидний агуулахад дусал нэмдэг. Мөн сайн санааны үйлс, аравны нэгийн өргөлөө төлөх, цэвэр ариун бодол санаа ба үйлдэл, мөнх оршихуйн гэрээний дагуу гэрлэлт зэрэг нь, шөнө дунд бидний унтарч буй дэнлүүг сэлбэж чадах тосонд нэн чухал нэмэр болдог.” (*Faith Precedes the Miracle* [1972], 256)

Ангийн гишүүдээс дараах асуултыг дотроо бодохыг хүс:

- Өнгөрсөн долоо хоногт та нар дэнлүүндээ тос нэмэх ямар зүйл хийсэн бэ? Ирэх долоо хоногт дэнлүүндээ тос нэмэх ямар зүйлийг та нар хийх вэ?

2. Есүс талантын тухай сургаалт үлгэрийг өгүүлдэг.

Матай 25:14–30-ийг уншаад ярилц. Шинэ Гэрээний цаг үед талант гэдэг нь мөнгөний нэгж байсан гэдгийг тайлбарла.

- Талантын тухай сургаалт үлгэр дэх холын аянд явж буй хүн хэнийг төлөөлдөг вэ? (Их Эзэн.) Боолууд хэнийг төлөөлдөг вэ? (Бид бүгдийг.) Талант юуг төлөөлдөг вэ? (Бурханаас өгдөг бэлэг.)
- Таван талант ба хоёр талант авсан боолууд мөнгөөр юу хийсэн бэ? (Матай 25:16–17-г үз.) Тэд хоёулаа ямар шагнал хүртсэн бэ? (Матай 25:21, 23-ыг үз.) Энэ сургаалт үлгэр Тэнгэрлэг Эцэгийн биднийг адислах мөнхийн шагналын талаар юу заадаг вэ? (Хариултанд, Бурханаас цөөхөн бэлэг авч байгаа мэт санах хүмүүс өөрсдийн бэлгээ бүрэн ашиглавал бүх адислалуудыг хүлээн авах болно гэдэг нь орж болно.)

Ахлагч Жэймс И.Фауст өөрсдийгөө цөөхөн авьяастай мэт санадаг хүмүүст хэлэхдээ: “Хэрэв тэд талантаа Бурханы хаант улсыг байгуулж, бусдад үйлчлэхэд хэрэглэсэн бол тэд Аврагчийн амлалтуудыг бүрэн дүүрэн эдлэх болно. Тэд [өөрсдийн] шагналаа, бүр энэ дэлхийд амар амгалан, мөн ирэх дэлхийд мөнхийн амьдрал хүртэнэ” гэдэг нь Аврагчийн агуу амлалт юм (С ба Г 59:23)” (Conference Report, Apr. 1994, 5; or *Ensign*, May 1994, 6).

- Ганц талант авсан хүн үүнийгээ яасан бэ? (Матай 25:24–25-ыг үз.) Эзэн түүнд юу гэж хэлсэн бэ? (Матай 25:26–30-ийг үз.) Заримдаа бид Бурханы өгсөн авьяас, бэлгүүдийг хөгжүүлэхдээ яагаад бүтэлгүйтдэг вэ? Эдгээр бэлгүүдийг хөгжүүлэхийн тулд бид саадыг хэрхэн даван туулж чадах вэ?
- Ахлагч Марвин Ж. Аштон заахдаа “өөрсдийн бэлгээ хүлээн зөвшөөрч, тэднийг хуваалцах нь бидний эрх, үүрэг байдаг” гэсэн (Conference Report, Oct. 1987, 23; or *Ensign*, Nov. 1987, 20). Их Эзэний бидэнд найдан хариуцуулсан авьяас буюу бэлгийг бид хэрхэн танин мэдэж, хүлээн авах вэ? Өөрсдийн авьяас буюу бэлгээ хуваалцах нь яагаад чухал гэж та нар бодож байна вэ? Та нар авьяас буюу бэлгээ хөгжүүлэн хуваалцсанаар амьдралд тань ямар адислалууд ирсэн бэ? Бусад хүмүүс өөрсдийн авьяас буюу бэлгээ хуваалцсан учраас та хэрхэн адислагдаж байна вэ?
- Бурхан хүн болгонд ядаж нэг бэлэг өгсөн байдаг (С ба Г 46:11–12), гэвч зарим бэлгийг олж мэдэхэд бусдаасаа илүү хялбар байдаг. Олж мэдэхэд хэцүү боловч Бурханыг алдаршуулж, бусдад үйлчлэхэд хэрэглэгдэж болдог ямар бэлгүүд байдаг вэ?

Ахлагч Марвин Ж.Аштон хэлэхдээ:

“Бэлэгний талаар дурдъя. Эдгээрийн дунд та нарт байдаг бөгөөд ил тод харагддаггүй ч бодитой, мөн үнэ цэнэтэй бэлгүүд байж болно.

“Бүгдээрээ эдгээр нэг их анзаарагддаггүй бэлгүүдийн заримыг авч үзье: Үүнд асуух бэлэг; сонсох; намуун, зөөлөн дуу хоолойг сонсож, хэрэглэх; уйлах чадвартай байх; маргаанаас зайлсхийх; хүлээн зөвшөөрдөг байх; утгагүй хоосон үг давтахаас зайлсхийдэг байх; зөв шударга зүйлийг эрж хайх; шүүж, шүүмжилдэггүй байх ; Бурханы удирдамжид итгэх; шавь нь байх; бусдыг харж халамжлах; эргэцүүлэн бодож чаддаг байх; залбирал өргөх бэлэг; хүчтэй гэрчлэл хуваалцдаг бэлэг; Ариун Сүнснийг хүлээн авах бэлэг” (Conference Report, Oct. 1987, 23; or *Ensign*, Nov. 1987, 20).

Ангийн гишүүн бүрт үзэг харандаа, мөн хуудас цаас өг.

Хэрэв та шилэн сав, тостой эсвэл будагтай ус ашиглаж байгаа бол шилэн савандаа хэдэн дусал нэм. Бурханы өгсөн авьяас буюу бэлгүүдийг хөгжүүлснээр бид өөрсдийн дэнлүүндээ тос нэмдэг гэдгийг тайлбарла.

3. Есүс хонь ба ямааны тухай сургаалт үлгэрийг өгүүлдэг.

Матай 25:31–46-г уншаад ярилц.

- Есүс Хоёр дахь Ирэлт дээрээ хоньчин хонио ямаанаас тусгаарладаг шиг биднийг тусгаарлах болно гэж заадаг (Матай 25:31–32). Хонь ба ямааны тухай сургаалт үлгэр дэх хонинууд хэнийг төлөөлдөг вэ? (Матай 25:33–34-ийг үз.) Ямаанууд хэнийг төлөөлдөг вэ? (Матай 25:33, 41-ийг үз.)
- Энэ сургаалт үлгэр Хоёр дахь Ирэлт болон шүүлтийн өдөрт бэлтгэхийн тулд бидний хийх ёстой зүйлийн талаар юу заадаг вэ? (Матай 25:35–46-г үз.)

Ахлагч Марион Д.Ханкс хэлэхдээ:

“Есүс өөрийн дагалдагчиддаа болох гэж буй шүүлтийг төлөөлүүлэн хонь ба ямааны тухай сургаалт үлгэрийг заасан. Энэхүү үлгэрт, тэрээр ‘мөнхийн амьдралыг’ өвлөн авах хүмүүсийг болон ‘мөнх шийтгэлд орох’ хүмүүсийг тодорхойлсон (Матай 25:46). Түүнтэй хамт хаант улсыг өвлөн авах ёстой хүмүүс туслах зангаа хөгжүүлж, бусдад өгснөөс ирэх баяр баясгаланг, үйлчлэлээс ирэх сэтгэл хангалуун байдлыг мэдэрснээрээ гол ялгаатай байсан. Тэд өлссөн, цангасан, гэр оронгүй, нүцгэн, өвчтэй болон шоронд байгаа . . . хүмүүст хэрэгцээтэй зүйлд нь тусалсан.

“Христэд итгэгчдийн биеэ авч явах байдал болон авралд зайлшгүй хэрэгтэй зүйлийн хувьд Аврагчийн өөрийгөө үл хайрлан бусдад үйлчлэхээр зориулсан тэр агуу төлөөснөөс өөр юу ч илүү тодорхой биш санагдана. Бусдад тусалж, өгч, мөн золиослох нь өсч торнин, амьсгалахтай адил төрөлхийн байх ёстой” (Conference Report, Apr. 1992, 10; or *Ensign*, May 1992, 9).

Хэрэв та шилэн сав ба будагтай ус хэрэглэж байгаа бол шилэн сав руу хэдэн дусал нэм. Бид бусдад үйлчилснээрээ өөрийнхөө дэнлүүнд тос нэмдэг гэдгийг тайлбарла. Мөн бид дэнлүүндээ тос нэмэхэд нь бусдад тусалж болно. Та ажигласан үйлчлэлийн жишээнүүдийг хуваалц, мөн ангийн гишүүдийг өөрсдийн харсан жишээнүүдээсээ хуваалцахыг урь.

- Бид бусдад үйлчилснээр хэрхэн тэднийг адислаж чадах вэ? Өөр хүнд үйлчлэх нь та нарыг хэрхэн адисалсан бэ? Та нар үйлчилсэн хүмүүсийнхээ талаар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ? Та нарт үйлчилдэг хүмүүсийн талаар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ? Бид бусдад юу хэрэгтэй байгааг хэрхэн илүү сайн таньж мэддэг болох вэ? Бид бусдад хэрхэн илүү хичээнгүй үйлчилдэг болж чадах вэ?
- Аврагч “Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь тэр ч байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” гэж хэлэхдээ ямар утгаар хэлсэн гэж та нар бодож байна вэ? (Матай 25:40; мөн Мозая 2:17-г үз).

Дүгнэлт

Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэнд бид бэлтгэх ёстой гэдгийг гэрчил. Бид Бурханы өгсөн бэлгийг хөгжүүлж, бусдад үйлчлэх үйлчлэлд амьдралаа зориулснаар Аврагчийн жишээг дагах хэрэгтэй. Бид эдгээр бүх зүйлүүдийг нөхцөл байдлаасаа үл харгалзан хийж чадна гэдгийг цохон тэмдэглэ.

**Заах Нэмэлт
Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

Дүрс Бичлэг

Шинэ Гэрээний үеийн хуримын зарим зан үйлийг тайлбарлахын тулд *New Testament Video Presentations* (53914)-ээс сонгож “New Testament Customs”-ын тавдугаар хэсгийг ашиглаж болно.

“Би Та Нарыг Хайрласан Шиг Бие Биеэ Хайрлагтун”

Лук 22:1–38; Иохан 13–15

Зорилго

Ангийн гишүүдэд бусдыг хайрлаж, тэдэнд үйлчилснээр Есүсийн жишээг дагахад урам хайрлах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Лук 22:7–30. Есүс Дээгүүр Өнгөрөх Баяраар Арван Хоёр Төлөөлөгчидтэйгөө уулздаг. Тэрээр ариун ёслолыг тогтоож, Төлөөлөгч нартаа бусдад үйлчлэх ёстой гэж заадаг.
 - б. Иохан 13. Есүс Төлөөлөгчдийн хөлийг угааж, бие биенээ хайрлахыг тэдэнд тушаадаг.
 - в. Иохан 14:1–15; 15. Есүс “Би бол зам, үнэн, амь мөн” гэж заадаг. Тэрээр өөрийгөө усан үзмийн мод, шавь нараа усан үзмийн модны мөчиртэй зүйрлэдэг. (Тайлбар: 14 ба 15-р бүлэгт Тайтгаруулагчийн тухай өгүүлсэн шүлгүүдийн талаар 24-р хичээл дээр ярилцана.)
 2. Нэмэлт Уншлага: Матай 26:1–5, 14–35; Марк 14:1–2, 10–31.
 3. Дараах материалууд байгаа бол заримаас нь хичээлдээ хэрэглэ:
 - а. Сүүлчийн Зоог (62174; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 225) болон Есүс Төлөөлөгчдийнхөө Хөлийг Угаасан нь (62550; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 226).
 - б. Иохан 15:1–8-ыг ярилцахдаа дүрслэн үзүүлэх жижигхэн ургамал.
 4. Заахад зориулсан зөвлөмж: Хичээлийн сэдэвтэй холбоотой дуулал буюу Хүүхдийн Хэсгийн дуу дуулах буюу тоглох нь хичээлийн үеэр Сүнснийг урих нэг сайн арга юм. Их Эзэн, түүний Сүнс зүрх сэтгэлийн дуунд баярладаг; зөв шударгын дуу нь түүний хувьд залбирал мөн бөгөөд энэ нь тэдэнд хариу болгон адислалыг авчирна гэж хэлсэн (С ба Г 25:12-ыг үз; мөн Колоссай 3:16-г үз). Түүнчлэн Дуулал ба Хүүхдийн Хэсгийн дуунууд нь ангийн гишүүдийг сайн мэдээний номлолыг суралцахад тусалдаг.
-

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүдээр Иохан 13:34–35-ыг нээлгээд, хэн нэгнээс үүнийг чангаар уншихыг хүс. Эдгээр үгсийг Есүс Сүүлчийн Зоог дээр хэлснийг цохон тэмдэглэ. Уг хичээлд энэ тушаалыг, мөн Төлөөлөгчидтэйгээ хийсэн энэ цуглааны үеэр Есүсийн хэлсэн болон хийсэн өөр зүйлүүдийн тухай ярилцана.

Та дараах судрын хэсгийг заахдаа Сүүлчийн Зоогийн үеэр Аврагчийн үгс болон үйл хөдлөл Төлөөлөгчдөө мөн биднийг хайрладаг гэдгийг хэрхэн харуулж байсныг ярилц. Ангийн гишүүдэд Есүс биднээс бусдыг хайрлаж, тэдэнд үйлчлэхдээ түүний жишээг дагаасай гэж хүсдэг гэдгийг ойлгоход тусал.

1. Есүс ариун ёслолыг тогтоодог.

Лук 22:7–30-ийг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон хэсгийг чангаар уншихыг урь. Есүсийг цовдлогдохын өмнөх өдөр Есүсийн Төлөөлөгчидтэйгээ идсэн Дээгүүр Өнгөрөх баярын хоолыг ихэнхдээ Сүүлчийн Зоог гэж нэрлэдэг. Сүүлчийн Зоогийн зургийг үзүүл.

- Есүс Төлөөлөгчидтэйгээ Дээгүүр Өнгөрөх Баярын зоог барихаар уулзахдаа, ариун ёслолыг танилцуулсан. Тэр ариун ёслолын зорилгын талаар Төлөөлөгчдөд юу гэж хэлсэн бэ? (Лук 22:19–20-ийг үз. Энэ нь түүнийг, мөн түүний цагаатгалын золиослолыг дурсан санахад тэдэнд туслах байсан.) Ариун ёслолоос хүртэх нь Аврагчийг дурсан санахад та нарт хэрхэн тусалдаг вэ?

Ахлагч Жэффри Р. Холланд: “Гетсемани ба Голготагийн өмнөх үдэш дээд давхарт болсон үйл явдлаас хойш амлалтын хүүхдүүд энэ илүү шинэ, илүү дээд, илүү ариун ба хувийн замаар Христийн золиослолыг санах гэрээг байгуулжээ. . . . Хэрэв дурсан санах нь бидний өмнөх гол үүрэг даалгавар бол тэдгээр энгийн бөгөөд эрхэм бэлэгдлийг бид хүртэхэд бидний санаанд юу орж болох вэ?” гэж хэлжээ (Conference Report, Oct. 1995, 88, 90; or *Ensign*, Nov. 1995, 67, 68).

Ахлагч Холландын санал болгосон, Аврагчийн талаар бидний дурсан санах ёстой дараах зүйлсийн заримыг хамруулан түүний асуултын хариуг ярилц.

- а. Тэнгэрийн Тэргүүн Чуулган дээр түүний үзүүлсэн хайр ба хүч.
 - б. Тэр бол тэнгэр, газрыг Бүтээгч гэдгийг.
 - в. Жэховагийн хувьд мөнх бус байдлын өмнөх амьдралд түүний хийсэн бүхэн.
 - г. Түүний энгийн болоод сүр жавхлант төрөлт.
 - д. Түүний сургаалууд.
 - е. Түүний гайхамшгууд ба эдгээлт.
 - ё. Сайн сайхан бүх зүйлс Христээс ирдэг (Моронай 7:24-ийг үз).
 - ж. Түүний туулсан хатуу харьцаа, эсэргүүцэл болон шударга бус байдал.
 - з. Тэдгээрээс дээгүүр гарахын тулд тэрээр бүх зүйлд буулт хийсэн.
 - и. Тэрээр бид бүхний төлөө золиосолж, өөрийн бүх уй гашууг тэвчсэн.
- Бид ариун ёслолоос долоо хоног бүр хүртэх нь яагаад чухал вэ? Бид ариун ёслолоос хүртэхийн өмнө өөрсдийгөө хэрхэн сүнслэгээр бэлтгэж болох вэ?
 - Сүүлчийн Зоог дээр Төлөөлөгчид дахин “хэн нь хамгийн агуу нь байх” талаар маргалдсан (Лук 22:24; мөн Матай 18:1; Лук 9:46-г үз). Бид заримдаа ямар талаараа хэн нэгнээс илүү дээр гэж бодогдуулахыг хүсдэг вэ? Бид эдгээр бодлоос хэрхэн ангижирч болох вэ?
 - Их Эзэн жинхэнэ алдрын талаар юу заасан бэ? (Лук 22:25–27-г үз; мөн Матай 20: 25–28-ыг үз.) Тэр хэрхэн энэ номлолын үлгэр жишээ болдог вэ? Бид түүний жишээг хэрхэн дагаж болох вэ?

2. Тэдний хөлийг угаасны дараа Есүс Төлөөлөгчиддөө бие биенээ хайрлахыг тушаадаг.

Иохан 13-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Есүс Төлөөлөгчдийн хөлийг угаасан нь зургийг үзүүл. Есүс болон түүний Төлөөлөгчид Сүүлчийн Зоогийг идсэний дараа Есүс Төлөөлөгч болгоны хөлийг угаасан гэдгийг тайлбарла (Иохан 13:4–5). Үүнийг голдуу зочид ирэхэд зарц нар гүйцэтгэдэг байжээ. Есүс үүнийг хийсэн нэг шалтгаан нь Төлөөлөгчиддөө даруу байдал ба үйлчлэлийг заах гэсэн явдал юм.

- Есүс хөлийг нь угааж эхлэхэд Симон Петр яагаад татгалзсан гэж та нар бодож байна вэ? (Иохан 13:6, 8-ыг үз. Тэр Их Эзэн боолын хийдэг зүйлийг хийх нь буруу гэж бодсон.) Есүс юу гэж хариулсан бэ? (Иохан 13:8-г үз.)
- Есүс тэдний хөлийг яагаад угаасан тухайд Төлөөлөгчиддөө юу гэж хэлсэн бэ? (Иохан 13:12–17-г үз. Түүний үзүүлсэн үйлчлэлийн жишээг дагахыг тэр тэдэнд хэлсэн.) Бусдад үйлчлэх нь та нарт аз жаргалыг хэрхэн авчирдаг вэ?
- Есүсийн үгс болон үйлдлээс бид сайн удирдагчийн шинж чанарын талаар юу сурч болох вэ? Бид удирдах албан тушаалд байгаа үедээ түүний жишээг хэрхэн дагаж болох вэ?
- Сүүлчийн Зоогийн үеэр Есүс бие биенээ хайрлахыг шавь нартаа дахин хэлсэн. (Иохан 13:34–35; 15:12; 17). Бид Христийн хайрын жишээг дагахын тулд ямар тодорхой зүйлүүдийг хийж болох вэ?

3. Есүс “Би бол зам, үнэн, амь мөн” ба “Би бол усан үзмийн жинхэнэ мод” гэж заадаг.

Иохан 14:1–15; 15-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон хэсгийг чангаар уншихыг урь.

- Есүс Төлөөлөгчдөд “Миний явах газарт очих замыг та нар мэднэ” гэж хэлэхэд Томасын сэтгэл яагаад зовнисон бэ? (Иохан 14:4–5-ыг үз.) Есүс Томаст юу гэж хэлсэн бэ? (Иохан 14:6-г үз.) Есүс яагаад бидний Тэнгэрлэг Эцэгт очиж болох цорын ганц зам бэ?
- Есүс шавь нартаа үйлчлэлээр дамжуулан бусдад хайраа харуул гэж заасан. Түүнийг хайрладгаа харуулахын тулд тэднийг юу хий гэж тэр хэлсэн бэ? (Иохан 14:15-ыг үз.) Дуулгавартай байдал маань бидний хайрыг Их Эзэнд хэрхэн харуулдаг вэ?
- Тэрээр Төлөөлөгчиддөө заахдаа усан үзмийн модыг бэлэгдэл болгон ашигладаг (Иохан 15:1–8). Усан үзмийн модоор хэнийг бэлэгдсэн бэ? Тариалагчаар (цэцэрлэгчээр)? Мөчрөөр? (Иохан 15:1, 5-ыг үз.)

Та ангидаа ургамал авчирсан бол одоо үзүүл.

- Навч юмуу мөчрийг тайрч их биеэс нь салгахад яадаг вэ? Аврагч та нарын хоорондын холбоо ургамлын их бие нь навч эсвэл мөчиртэйгээ холбоотой байдагтай хэрхэн адил байдаг вэ?
- Аврагчийн хэрэглэсэн зүйрлэлээр тариалагч, жимс ургуулдаггүй усан үзмийн мөчрүүдийг яах вэ? (Иохан 15:2-ыг үз.) Тэр жимс ургуулдаг мөчрүүдийг яах вэ? Энэ нь бидэнд ямар хамааралтай вэ?
- Есүс, “Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал тэр хүн их жимс ургуулна. Учир нь надаас салангид байвал та нар юу ч хийж

чадахгүй” гэж заасан (Иохан 15:5). Үүнийг үнэн гэдгийг та нар хэрхэн олж мэдсэн бэ?

- Иохан 15:13-ын дагуу хайрын хамгийн агуу жишээнүүдийн нэг нь юу вэ? Энэ нь биднийг хайрладаг Аврагчийн хайрын талаар бидэнд юу хэлж байна вэ?

Дүгнэлт

Есүс Христ бидэнд хайртай бөгөөд биднээс бие биенээ хайрлаж, бие биендээ үйлчлэхийг хүсдэг гэдгийг гэрчил. Христийн Цагаатгал болон түүний биднийг хайрладаг хайрыг долоо хоног бүрийн ариун ёслолын үеэр дурсан санахыг ангийн гишүүдэд уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Христийн нэрийг өөрсөд дээрээ авах нь

Ариун ёслолын тухай ярилцахдаа та Христийн нэрийг өөр дээрээ авах талаар дараах асуултуудыг ярилцаж болно. Зарим санал болгосон хариултыг Ахлагч Даллин К. Өүксийн 1985 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр өгсөн ярианаас иш татав.

- Бид хэзээ Христийн нэрийг өөрсөд дээрээ авдаг вэ?
 - а. Бид түүний Сүмд усаар батлуулахдаа (2 Нифай 31:13; Мозая 25:23; Моронай 6:3; С ба Г 18:22–25; 20:37).
 - б. Бид ариун ёслолоос хүртэн усан баталгааныхаа гэрээг шинэчлэх үед (Моронай 4:3; 5:2; С ба Г 20:77; 79).
 - в. Бид түүнд итгэдэг гэж тунхаглах үед.
 - г. Бид өөрсөддөө түүний нэрээр үйлдэх эрх мэдлийг авч, энэ эрх мэдлээ хэрэглэх үед.
 - д. Бид ариун сүмийн нандин ёслолуудад оролцох үед.
- Бид Христийн нэрийг өөрсөд дээрээ авахдаа юу гэж амладаг вэ?
 - а. Бид түүний хаант улсын ажлыг хийх хүсэлтэйгээ болон эцсээ хүртэл түүнд үйлчлэхээр баттай шийдэхдээ илэрхийлдэг (С ба Г 20:37; Моронай 6:3).
 - б. Бид түүнд дуулгавартай байж, нүглээ наманчилснаар түүнийг шийдвэр төгс дагана гэж амладаг (2 Нифай 31:13; Мозая 5:8).
- Түүний нэрийг өөрсөд дээрээ авахад Есүс Христ бидэнд юу гэж амладаг вэ? (Бид түүний хөвгүүд, охид болж, түүний нэрээр овоглуулдаг. Түүний нэрээр дуудуулсан хүмүүс сүүлчийн өдөр өргөмжлөгдөнө. Мозая 5:7–9; 15:12; Алма 5:14; 3 Нифай 27:5–6; С ба Г 76:55, 58, 62-ыг үз).

2. Дүрс Бичлэг

New Testament Video Presentations (53914)-ээс сонгосон “New Testament Customs”-ын тав дахь хэсэгт Шинэ Гэрээний үеийн найрын тухай гардаг. Энэ хэсэг нь ангийн гишүүдэд Сүүлчийн Зоогийн орчинг дүрслэн харж, “Есүсийн цээжийг налаад сууж байсан” шавьд хэлсэн үгийг ойлгоход тусална (Иохан 13:23).

3. Ангийн гишүүний бэлтгэсэн хөтөлбөр

“Би бол усан үзмийн жинхэнэ мод” гэх мэт зүйрлэл нь зарим хүмүүст, ялангуяа өсвөр насныханд ойлгоход хэцүү байж болох юм. Биднийг хайрладаг Есүс Христийн хайрыг илүү дүрслэн үзүүлэхийн тулд нэг буюу хоёр ангийн гишүүнээс усан үзмийн мод навчис болон мөчрүүддээ хүч тэнхээ өгдөг шиг Аврагчийн хайр тэдэнд хүч тэнхээ өгч байсан явдлаасаа хуваалцахыг урь. Урилгыг ядаж долоо хоногийн өмнөөс өгч, хуваалцахад тохиромжтой явдлаа сонгохдоо Ариун Сүнсний урмыг эрэлхийлэхийг ангийн гишүүдэд уриал.

Иохан 16–17

Зорилго Ангийн гишүүдийг Ариун Сүнсний нөлөөг мэдэрч даган, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй илүү ойртоход уриалах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Иохан 16:1–15. Есүс түүний цовдлолын дараа ирэх хэцүү цаг үед Төлөөлөгчдөө бэлтгэдэг. Тэрээр Ариун Сүнсний номлолын талаар тэдэнд заадаг ба тэд Ариун Сүнсний бэлгийг хүлээн авна гэдгийг амладаг.
 - б. Иохан 16:16–33. Есүс өөрийн үхэл болон дахин амилалтын талаар урьдчилан хэлдэг ба Төлөөлөгчиддөө “зоригтой бай” гэж зөвлөдөг.
 - в. Иохан 17. Есүс Төлөөлөгчид болон түүнд итгэдэг бусад бүх хүмүүсийн өмнөөс залбирал үйлддэг.
2. Нэмэлт Уншлага: Иохан 14:16–31; 15:18–27; 3 Нифай 19:19–36; Сургаал ба Гэрээ 132:21–24.
3. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл ангидаа бэлэгний хоёр хайрцаг авчир (эсвэл самбар дээр бэлэгний хоёр хайрцаг зур). Хичээлийн үеэр хайрцагнууд дээр тавих *Ариун Сүнсний Бэлэг*, мөн *Мөнхийн Амьдрал* гэсэн хоёр үгийн хайчилбарыг бэлтгэ.
4. Заахад зориулсан зөвлөмж: Та Сүнсээр заагаасай гэж залбирахын зэрэгцээгээр ангийн гишүүд Сүнсээр сурч мөн заагдаж буй үнэнүүдийн талаарх баталгааг хүлээн аваасай гэж залбир.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Бэлэгний хоёр хайрцгийг үзүүл (эсвэл самбарт бэлэгний хоёр хайрцаг зур). Ангийн гишүүдээс авахыг хүсэж байгаа бэлэгнүүдийнхээ талаар товчхон ярихыг урь.

Таны харуулж буй бэлэгний хайрцагнуудын нэг нь энэ амьдралд бидний авч болох хамгийн агуу бэлэгнүүдийн нэгийг төлөөлж байгааг тайлбарла. Нөгөө хайрцаг нь Их Эзэний нэрлэснээр Бурханы бүх бэлэгний хамгийн агууг төлөөлж байна (С ба Г 14:7-г үз).

Энэ хичээл дээр ангийн гишүүд эдгээр хоёр бэлэг нь юу болохыг олж мэдэх бөгөөд тэдгээрийг хэрхэн хүлээн авахыг мэдэж авна гэдгийг тайлбарла.

Та дараах судрын хэсгийг заахдаа Аврагчийн Төлөөлөгчиддөө хэлсэн үг нь бид бүгдэд хэрхэн хамааралтай болохыг ярилц. Энэ хичээлтэй холбоотой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Есүс, тэд Ариун Сүнсний бэлгийг хүлээн авна гэж Төлөөлөгчиддөө амладаг.

Иохан 16:1–15-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон хэсгийг чангаар уншихыг урь.

- Өөрийн мөнх бус үйлчлэлийнхээ сүүлчийн цагуудад Есүс Төлөөлөгчиддөө зааж, тэднийг зоригжуулсан. Тэр үед Төлөөлөгчдийг зоригжуулах нь яагаад хэрэгтэй байсан бэ? (Иохан 16:1–6; мөн 15:18–20-ийг үз.)
- Аврагч Төлөөлөгчид рүүгээ Тайтгаруулагчийг (Ариун Сүнснийг) илгээнэ гэж хэлсэн (Иохан 16:7). Ариун Сүнсний номлол гэж юу вэ? (Иохан 14:26; 15:26; 16:7–14-ийг үз. Дор дурьдсан жагсаалтыг самбарт бич.)

Ариун Сүнс:

- а. Тайтгаруулагч (Иохан 14:26).
- б. Заадаг (Иохан 14:26).
- в. Бидний ой ухаанд үнэнийг авчирдаг (Иохан 14:26).
- г. Аврагчийг гэрчилдэг (Иохан 15:26).
- д. Бүх үнэн рүү удирддаг (Иохан 16:13).
- е. Болох зүйлийг бидэнд үзүүлдэг (Иохан 16:13).
- ё. Аврагчийг алдаршуулдаг (Иохан 16:14).

- Арван Хоёр Төлөөлөгчид Есүсийн мөнх бус үйлчлэлийн үеэр Ариун Сүнсний илрэлийг үзсэн боловч түүний үхэл ба дахин амилалтын дараа хүртэл тэд Ариун Сүнсний бэлгийг хүлээн аваагүй (Иохан 20:22). Ариун Сүнсний илрэл, Ариун Сүнсний бэлэг хоёрын ялгаа нь юу вэ? (Доорх ишлэлийг үз.) Ариун Сүнсний бэлгийг хүлээн авснаар та нарт хэрхэн тусалдаг вэ?

Ахлагч Даллин Х. Оакс :

“Ариун Сүнсний илрэл нь сайн мэдээний үнэнийг чин сэтгэлээсээ хайгчдыг наманчлал, усан баталгаанд итгүүлж, удирдахаар өгөгддөг. Ариун Сүнсний бэлэг нь илүү дэлгэрэнгүй юм. . . . [Энэ] нь бид ‘түүний Сүнснийг [өөрсөдтэйгөө] үргэлж байлгах’ байнгын түнштэй болох эрхийг багтаадаг (С ба Г 20:77).

“Саяхан усаар батлуулсан нэг шинэ гишүүн, тэрхүү бэлгийг хүлээн авч байхдаа юу мэдэрснээ надад ярьсан юм. Тэрээр өөрийн амьдралаа бусдад үйлчлэн зориулахаар ирсэн итгэлтэй Христэд итгэгч эмэгтэй байв. Тэр Их Эзэнийг мэддэг бөгөөд хайрладаг мөн түүний Сүнсний илрэлийг мэдэрдэг байсан. Тэр дахин сэргэсэн сайн мэдээний нэмэлт гэрлийг хүлээн аваад усаар батлуулсан бөгөөд ахлагчид түүний толгой дээр гар тавьж, түүнд Ариун Сүнсний бэлгийг өгчээ. Тэрээр эргэн дурсахдаа, ‘Миний урьд өмнө мэдэрч байснаас илүү агуу хүчтэй Ариун Сүнс надад ирэхийг би мэдэрсэн. Тэр өнгөрсөн үеүдэд намайг хөтөлж байсан, харин одоо надтай үлдэхээр ирсэн нэгэн хуучны найз шиг байсан’ гэв” хэмээн заасан (Conference Report, Oct. 1996, 80; or *Ensign*, Nov. 1996, 60).

Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэж байгаа бол *Ариун Сүнсний бэлэг* гэсэн бичигтэй хайчилбараа бэлэгний хайрцагны нэг дээр тавь.

- Бид Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсныхаа дараа Ариун Сүнсний байнгын хамтрагч байхын тулд хэрхэн зохистой байж чадах вэ? (Үйлс 54:2; С ба Г 6:14; 20:77, 79; 76:116; 121:45–46-г үз.) Бид Ариун Сүнсний нөлөөг хэрхэн танин мэдэж чадах вэ? (Галат 5:22–23; С ба Г 6:15, 23; 11:13-ыг үз.)

Ерөнхийлөгч Бойд К.Пакер заахдаа: “Ариун Сүнс *сонсохоос* чинь илүү та нарын *мэдрэх* тийм дуугаар ярьдаг. Үүнийг ‘намуун зөөлөн дуу’ гэж дүрсэлсэн байдаг. Бид Сүнсний шивнээг ‘сонсох’ талаар ярихдаа ихэвчлэн ‘Надад . . . мэдрэгдсэн’ . . . гэдгээр сүнслэг хүчтэй мэдрэмжээ дүрсэлдэг. Илчлэлт нь *сонсохоос* илүү *мэдрэх* үгсээр дамжин ирдэг” гэжээ (Conference Report, Oct. 1994, 77; or *Ensign*, Nov. 1994, 60).

Бошиглогч Жозеф Смит, Ерөнхийлөгч Бригэм Янгийн зүүдэнд “Их Эзэний Сүнс . . . тэдний зүрх сэтгэлд амар амгалан, баяр баясгаланг шивнэнэ; энэ нь хорсол, занал, маргаан болон тэдний зүрх сэтгэлээс бүх нүгэл хилэнцийг авч хаях; бөгөөд тэдний бүх л хүсэл зориг нь сайн сайхныг хийх, зөв шударгыг дэлгэрүүлэх болон Бурханы хаант улсыг барих юм” гэж Гэгээнтнүүдэд заах удирдамж өгсөн (*Manuscript History of Brigham Young, 1846–1847*, comp. Elden J. Watson [1971], 529).

2. Есүс өөрийн үхэл болон дахин амилалтын талаар урьдчилан хэлдэг.

Иохан 16:16–33-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Есүс Төлөөлөгчиддөө Ариун Сүнсний тухай ярьсныхаа дараа тэрээр удахгүй үхэх бөгөөд дахин амилна гэдгээ хэлдэг (Иохан 16:16–20). Дараа нь тэр “Миний дотор та нар амар амгалан байг гэж Би та нарт эдгээр зүйлсийг хэллээ” гэж хэлсэн (Иохан 16:33). Түүний дотор амар амгалан байна гэдэг нь юу гэсэн үг гэж та нар бодож байна вэ? Бид Иохан 16 дахь Есүсийн сургаалаас түүний дотор амар амгалан байхад туслах юу сурч болох вэ? (Түүнчлэн Филиппой 4:7–9; С ба Г 59:23-ыг үз.)
- Есүс Төлөөлөгчиддөө “Ертөнцөд та нар зовлонтой байна: гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан” гэжээ (Иохан 16:33). Есүс ертөнцийг ялсан гэдгийг мэдэх нь бидэнд зовлон тохиолдох үед зоригтой байхад хэрхэн тусалж чадах вэ? Зоригтой байх нь яагаад чухал вэ?

3. Есүс бүх хүмүүсийн өмнөөс залбирал үйлддэг.

Гетсемани Цэцэрлэгт, загалмай дээр зовж шаналахынхаа өмнөхөн Есүсийн үйлдсэн залбирлыг агуулсан Иохан 17-г уншаад ярилц. Есүс бидний авралын төлөө Тэнгэрлэг Эцэг болон бидний дунд зогсож бидний өмнөөс залбирсан учраас энэ залбирлыг ихэнхдээ өмнөөс нь үйлдсэн залбирал гэж нэрлэдэг. Уншиж, ярилцах шүлгүүдийг сонгохдоо Сүнсний удирдамжийг эрэлхийл.

- Есүс залбирлаа эхлэхдээ дэлхий дээрх номлолоо хэрхэн дүрсэлсэн бэ? (Иохан 17:1–2-ыг үз. Мөн Мосе 1:39-ийг үз.) Тэр энэ номлолоо хэрхэн гүйцэтгэсэн бэ?
- Аврагч залбирахдаа “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” гэжээ (Иохан 17:3). Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нарыг мэдэх нь зөвхөн тэдний *талаар* өнгөцхөн мэдэхээс

юугаараа ялгаатай вэ? Бид тэднийг хэрхэн мэдэж чадах вэ? (1 Иохан 4:7–8; Мозая 5:10–13; Алма 22:18; С ба Г 18: 33–36; 132:21–24-ийг үз.)

Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэж байгаа бол *Мөнхийн Амьдрал* гэж бичсэн хайчилбараа хоёр дахь бэлэгний хайрцган дээр тавь (С ба Г 14:7-г үз).

- Залбирлын эхний хэсэгт Есүс номлолоо бүрэн гүйцэтгэхийн тулд хийсэн зүйлээ өгүүлсэн (Иохан 17:4–8). Бид Тэнгэрлэг Эцэгт өөрсдийн хүч чармайлтаа хэрхэн танилцуулдаг вэ? Тухайн өдрийн туршид түүнд үйлчлэхээр гаргасан чармайлтынхаа мэдээг орой болгон залбиралдаа багтаавал энэ нь бидний үйлд хэрхэн нөлөөлж болох вэ?
- Хэдийгээр Есүс маш их зовж шаналах гэж байгаагаа мэдэж байсан ч гэсэн тэр хэний төлөө залбирсан бэ? (Иохан 17:6–9, 20-ийг үз.) Үүнээс бид юу сурч болох вэ?
- Бид хэрхэн Есүс болон түүний Төлөөлөгчид шиг дэлхий дээр “ертөнцийнх биш” амьдарч чадах вэ? (Иохан 17:14; мөн 15–16-р шүлгүүдийг үз).

Ахлагч М.Рассел Баллард хэлэхдээ:

“Сүмд бид ‘Ертөнцийнх биш, харин ертөнцөд бай’ гэсэн холбоо үгсийг үе үе хэлдэг. Бид хараал, хүчирхийлэл болон буруу санаа төрүүлсэн хэрнээ улиг болсон үл итгэх зүйлийг үзүүлдэг телевизийн нэвтрүүлгийг үзэхдээ зарим талаар дэлхийгээс ангид байж, энэ бүгдээс өөрсдийн гэр бүлээ тусгаарлахыг үе үе хүсдэг билээ. . . .

“Бид дээр дурьдсан холбоо үгийг хоёр тусдаа сануулгаар нь хэлэх хэрэгтэй байх аа. Нэгдүгээрт, *‘Ертөнцөд байх’*. Оролцох; мэдлэгтэй байх. Өөр өөр үзэл бодолтой хүмүүсийг ойлгож, хүлцэнгүй тэвчээртэй байж мөн хүндэтгэхийг хичээх. Үйлчлэл болон оролцоогоороо нийгэмд ач холбогдолтой хувь нэмэр оруулах. Хоёрдугаарт, *‘Ертөнцийнх биш байх’*. Зөв биш зүйлийг дэмжих буюу хүлээн зөвшөөрөхийн тулд буруу замыг бүү дага эсвэл бүү бууж өг.

“Бидний гэр орныг доромжлон гутаасан зүйлүүдийг дарснаар телевизээр болон нийгэмд гарч буй гуйвуулсан, мөн ёс суртахуунгүй чиг хандлагыг өөрчлөхийг бид хичээх ёстой. Дэлхий дээрх бүх гэм нүглийг үл харгалзан хаа сайгүй сайны эсрэг байдаг бүх зүйлийг үл ойшоон, бид өөрсдийгөө болон хүүхдүүдээ дэлхийгээс *ангид* байлгахыг хичээх ёсгүй. Есүс ‘Тэнгэрийн хаант улс бол исгэгчтэй төстэй’ буюу хөрөнгөтэй төстэй гэжээ. Бид эргэн тойрондоо байдаг бусармаг явдлаас ангижирч дэлхийг хөгжүүлэх ёстой. Аврагч Эцэгтээ хандан залбирахдаа:

“Би Танаас тэднийг ертөнцөөс аваач гэж гуйхгүй, харин тэднийг нүгэл хилэнцээс хамгаалаач гэж залбирч байна” гэсэн (Иохан 17:15) (Conference Report, Apr. 1989, 101; or *Ensign*, May 1989, 80).

- Иохан 17:21–22-т хэлсэнчлэн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр хэрхэн “нэг” вэ?

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон Ариун Сүнсний талаар Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Тэд салангид боловч зорилго, зүтгэлээрээ нэг юм. Тэд Бурханы хүүхдүүдийн аврал, өргөмжлөлийн төлөө сүр жавхланг авчрах тэнгэрлэг төлөвлөгөөнд нэг мэт нэгдсэн. . . . Эцэг, Хүү ба Ариун

Сүнс гурвыг тэнгэрлэг Бурхан Тэргүүтэн болгон нэгтгэдэг төгс нэгдэл байдаг” гэжээ (Conference Report, Oct. 1986, 69; or *Ensign*, Nov. 1986, 51).

- Төлөөлөгчид нэг юм шиг байх нь яагаад чухал байсан бэ? (Иохан 17:22–23-ыг үз.) Бид яагаад Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нартай нэгдмэл байх хэрэгтэй вэ? Мөн Сүмийн бусад гишүүдтэй? Гэр бүлийнхэнтэйгээ? Бид эдгээр харьцаанд эв нэгдлийг хэрхэн батжуулж чадах вэ?

Дүгнэлт

Ангийн гишүүдээс хэн нэг нь тэдний төлөө залбирч байгааг мэдэхэд ямар санагддаг талаар бодохыг хүс. Есүсийг хүмүүсийн өмнөөс залбирал үйлдэх үед нь түүнтэй хамт байсан бол ямар сэтгэгдэлтэй байх байсныг эргэцүүлэн бодохыг тэднээс хүс. Хүмүүсийн өмнөөс залбирах нь Аврагчийн бидэнд санал болгодог мөнхийн амьдралын үнэт бэлгийг талархан хүлээж авахад бидэнд тусалж чадна гэдгийг тайлбарла. Ариун Сүнсний хүчтэй мэдрэмжийг дагаснаар, мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй нэг болохыг хичээснээр бид адислагдана гэдгийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Сүнсийг Урих

Ариун Сүнсний нөлөөг мэдэрч, танихад ангийн гишүүдэд туслахын тулд тэдний заримтай нь урьдчилан уулзаж, дараах танилцуулгуудын нэгийг хичээлийн хэсэг болгон сонгоход тэд нараас урь:

- Дуртай судрын хэсгээ унших.
- Гэрчлэлээ хуваалцах.
- Аврагчийн тухай дуулал буюу Хүүхдийн Хэсгийн дууг дуулах.
- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг хайрладаг хайраа илэрхийлэх.
- (тохиромжтой бол) Сүнслэг явдлаасаа хуваалцах.

Танилцуулгыг хийсний дараа ангийн гишүүдийг танилцуулгын үеэр юу мэдэрснээ хэлэхийг урь. 99–100 хуудсан дахь Ерөнхийлөгч Боид К. Пакерын мэдэгдлийг уншаад, Ариун Сүнснээс ирдэг мэдрэмжийг танихад ангийн гишүүдэд тусал. Ариун Сүнснээс удирдамж хүлээн авах үедээ та юу мэдэрдэг тухайгаа ярь.

“Миний Хүсэл Бус, Харин Таны Хүсэл Биелэгдэг”

Матай 26:36–46; Марк 14:32–42; Лук 22:39–46

Зорилго

Есүс Христийн Цагаатгалын ачаар тэд өршөөл, амар амгалан болон мөнхийн амьдралыг хүлээн авч чадна гэсэн ангийн гишүүдийн гэрчлэлийг батжуулах болно.

Бэлтгэл

1. Гетсемани Цэцэрлэгт Аврагчид тохиолдсон явдлын талаарх дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир: Матай 26:36–46, Марк 14:32–42 ба Лук 22:39–46.
2. Нэмэлт Уншлага: 2 Нифай 2:5–8; Алма 7:11–14; 34:8–16; 42:1–31; Сургаал ба Гэрээ 19:15–24.
3. Есүс Гетсеманид Залбирсан нь (62175; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 227) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэ.
4. Цагаатгалын тухай судрын дуртай хэсгээ эсвэл ариун ёслолын дуртай дуулаасаа хэдэн мөр хэлж Есүс Христийн Цагаатгалын талаарх өөрсдийн бодлоо товчхон илэрхийлэхэд бэлтгэж ирэхийг ангийн хэдэн гишүүнээс урь.
5. Заахад зориулсан зөвлөмж: Их Эзэн биднийг түүний үгийг тунхаглахын тулд эрэлхийлэх биш, харин эхлээд түүний үгийг мэдэж авахыг хичээ гэж хэлжээ (С ба Г 11:21-ийг үз). Судраас үр дүнтэй заахын тулд та тэдгээрийг өдөр бүр судалж эргэцүүлэн бодох хэрэгтэй. Тэдгээрийн хүч, үнэн байдлын талаарх гэрчлэлээ үргэлж өсгө.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ахлагч Орсон Ф. Витний Төлөөлөгчөөр томилогдохоосоо хэдэн жилийн өмнө Гетсемани Цэцэрлэг дэх Аврагчийн тухай үзэгдлийг хүлээн авсан. Ахлагч Витний үзэгдлээ тайлбарласан тухай дараах ишлэлийг унш:

“Би Гетсемани Цэцэрлэгт Аврагчийн зовж шаналж байгааг гэрчилж байх шиг санагдсан. Би Түүнийг хэн нэгнийг энгийнээр харж байгаа шигээ тод харсан. Наад талд нь байсан модны ард зогсоод би Есүсийг Петр, Иаков, Иохан нарын хамт миний баруун талд байсан жижигхэн . . . хаалгыг өнгөрөөд ирж байхыг харсан. Тэднийг сөхрөөд залбир гэж хэлснийхээ дараа гурван Төлөөлөгчийг тэнд үлдээгээд, Бурханы Хүү цэцэрлэгийн нөгөө тал руу очиж, Тэрээр бас сөхрөн залбирсан. Энэ нь Библи уншигч бүгдийн танил тэрхүү залбирал байсан: ‘Эцэг минь, Хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч миний хүслээр биш, харин Таны хүслээр болог’.

“Түүнийг залбирч эхлэхэд нулимс нь хацрыг нь даган урссан нь надад хүрсэн. Үүнийг хараад сэтгэл минь ихэд догдолж, би бас агуу их хайраар

уйлсан. Бүхий л зүрх сэтгэл минь түүн рүү чиглэж; би түүнийг бүх сэтгэл зүрхээрээ хайрлаж, өөр юуг ч тэгж хүсэж байгаагүй тийм ихээр түүнтэй хамт байхыг хүссэн.

“Удалгүй Тэрээр босож, сөхрөөд бөх унтаж байсан Төлөөлөгчид рүүгээ очив. Тэр тэднийг зөөлөн нударч сэрээгээд, зэмлэнгүйгээр, уур, тэвчээргүй байдлыг огтхон ч үзүүлэхгүйгээр тэднээс өөртэй нь хамт ганцхан цаг ч сэргэг байж чадсангүй юу гэж гуниглангуй асуусан. Тэрээр мэдрэмтгий сэтгэл зүрхийг нь зүсэх эрэгтэй хүн, эмэгтэй хүн, хүүхэд нэг бүрийн өмнөөс шаналан, дэлхийн аймшигт их нүглийг мөрөндөө үүрэн зогсож байхад тэд түүнийг ердөө ганц цаг л харж сэргэг байж чадаагүй!

“Тэрээр буцаж ирээд өмнөхтэйгөө адил залбирал үйлдсэн; дараа нь буцаж очоод тэднийг унтаж байхыг дахин харсан. Тэрээр тэднийг дахин сэрээж, залбирахыг тэдэнд дахин сануулаад, дахин эргэж очоод залбирсан. Энэ нь гурван удаа давтагдсан”(Through Memory's Halls [1930], 82).

Есүс Гетсеманид Залбирсан нь зургийг үзүүл. Ангийн гишүүдээс Аврагчийг хайрладаг хайрынх нь талаар, мөн түүнийг цовдлогдохын өмнөх шөнө Гетсемани цэцэрлэгт залбирч байгааг нь тэд харсан бол ямар сэтгэгдэлтэй байх байсан талаар бодож үзэхийг хүс. Ангийн хэдэн гишүүнийг өөрсдийн бодлоосоо хуваалцахыг урь.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Энэ хичээл болон 26-р хичээл нь Есүс Христийн Цагаатгалын бүх хүн төрөлхтний үхэл, нүгэл, сул дорой байдлыг өөр дээрээ авсан сайн дурын үйлийн тухай юм. 26-р хичээл дээр түүний Цовдлолыг ярилцах бол энэ хичээл Гетсемани Цэцэрлэгт Аврагчид тохиолдсон явдлыг голлон анхаарна. Цагаатгал нь Аврагчийн цэцэрлэгт болон загалмай дээр, аль алиных нь зовлон шаналлыг агуулдаг гэдгийг санах нь чухал юм.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон заахдаа: “Гетсеманид болон Калварид тэрээр хязгааргүй мөнхийн цагаатгалыг үзүүлсэн. Энэ нь түүхэнд тэмдэглэгдсэн хайрын хамгийн агуу үйлдэл байсан юм. Тиймээс Тэр бид бүгдийг бие махбодийн үхлээс гэтэлгэж мөн бидний дундаас хуулиудыг болон сайн мэдээний ёслолуудыг дуулгавартай дагах хүмүүсийг гэтэлгэж, бидний Гэтэлгэгч болсон” гэжээ (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 14).

1. Аврагч бидний нүгэл, сул дорой байдлыг өөр дээрээ авдаг.

Матай 26:36–46; Марк 14:32–42 ба Лук 22:39–46-г ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Гетсемани Цэцэрлэгт Есүс Төлөөлөгчдөөсөө юу хийхийг хүссэн бэ? (Лук 22:39–40-ийг үз.) Есүс яагаад Төлөөлөгчдөө залбирахыг хүссэн бэ? (Лук 22:40-ийг үз.) Залбирал биднийг хэрхэн уруу таталтын эсрэг хүчтэй болгодог вэ?
- Гетсемани Цэцэрлэгт Есүс Петр, Иаков, Иохан нараас юу хийхийг хүссэн бэ? (Матай 26:38; 41-ийг үз. Энд хэлсэн *харах* гэдэг үг нь *сэрүүн бай* гэсэн утгатай гэдгийг цохон тэмдэглэ.) Хар буюу сэрүүн бай гэсэн тушаал нь сайн мэдээний дагуу амьдрахыг хичээхэд бидэнд ямар хамаатай байдаг вэ? (2 Нифай 4:28; Алма 7:22; 32:26–27-г үз.)

- Есүс Гетсемани Цэцэрлэгт агуу ихээр шаналж зовно гэдгээ мэдсээр байж яагаад үүнийг гүйцэтгэхэд бэлэн байсан бэ? (Матай 26:39, 42, 44-ийг үз.) Гетсемани дахь Аврагчийн залбирлаас бид юу сурч болох вэ? Тэнгэрлэг Эцэгийн хүслийг биелүүлснээр та нар хэрхэн адислагдаж байсан бэ?
- Есүсийг Тэнгэрлэг Эцэгийн хүслийг биелүүлнэ гэж хэлсний дараа “тэнгэрээс тэнгэрийн элч Түүнд үзэгдэн, Түүнийг тэнхрүүлж байлаа.” (Лук 22:43.) Энэ нь Тэнгэрлэг Эцэгийн маань талаар бидэнд юу зааж байна вэ? (Хариултанд, биднийг хүлцэнгүйгээр түүний хүслийг биелүүлбэл тэрээр биднийг тэнхрүүлнэ гэж орж болно.)
- Гетсеманид Есүс юуг туулсан бэ? (С ба Г 19:16–19; Лук 22:44; Мозая 3:7; Алма 7:11–13-ыг үз.)

Ахлагч Жэймс И.Талмаж: “Цэцэрлэгт Христийн зовж шаналсныг сэтгэл зүйн болон учир шалтгааны талаас хоёулангаас нь бодоход төсөөлөхийн аргагүй юм. . . . Тэрээр газар дэлхий дээр амьдардаг өөр ямар ч хүн төсөөлөхийн аргагүй тийм ачаа үүрч тэмцэж, зовж шаналсан. Энэ нь нүх сүв бүрээс нь цус гарч түүнийг зовоход нөлөөлсөн бие махбодын болоод сэтгэл санааны шаналал биш; харин зөвхөн Бурхан л даван туулах чадвартай зүрх сэтгэлийн сүнслэг зовлон байсан юм. . . . Зовж шаналах тэр мөчдөө Христ ‘ертөнцийн захирагч’ Сатаны учруулж чадах бүх муу муухай зүйлтэй тулгарч, даван туулсан. . . . Зарим талаараа хүний төсөөлшгүй үнэн бөгөөд сүрдмээр бодит байдалд Адамаас эхлээд дэлхийн төгсгөл хүртэлх бүх хүн төрөлхтний нүглийн ачааг Аврагч Өөр дээрээ үүрсэн билээ” гэжээ (*Jesus the Christ*, 3rd ed. [1916], 613).

Ахлагч Нил А.Максвелл хэлэхдээ: “Хязгааргүй цагаатгалынхаа нэг хэсгийн хувьд Есүс ‘махбодийн хувьд’ бидний туулж өнгөрөөх бүгдийг туулж өнгөрөөнө гэдгээ мэддэг (Алма 7:11–12). Тэрээр эрэгтэй эмэгтэй хүн, хүүхэд болгоны нүгэл, уй гашуу, эмгэнэл болон . . . өвчин шаналлыг авсан (2 Нифай 9:21-ийг үз.)” гэжээ (Conference Report, Apr. 1987, 89; or *Ensign*, May 1987, 72).

2. Бидэнд Есүс Христийн Цагаатгал хэрэгтэй.

- Бидэнд яагаад Есүс Христийн Цагаатгал хэрэгтэй вэ? (Алма 34:9-ийг үз.)
 - а. Адам, Ева хоёрын Уналтаас болж бид бие болон сүнсний салалт болох бие махбодын үхлийн харьяат юм (Мосе 6:48).
 - б. Бид нүгэл үйлдэхдээ өөрсдийгөө Бурханаас тусгаарладаг учраас өөрсөд дээрээ сүнсний үхлийг авдаг. Нүгэл маань биднийг Бурхантай оршиход цэвэр бус, мөн боломжгүй болгодог (1 Нифай 10:21).
 - в. Бид бие махбодийн болоод сүнсний үхлийг өөрсдөө давж чадахгүй учраас Тэнгэрлэг Эцэг өөрийн Цорын Ганц Хүүгээ Цагаатгал хийлгэхээр илгээсэн (Иохан 3:16; 2 Нифай 2:5–9).
- Аврагчийн цагаатгалын золиослолын улмаас бид ямар адислал хүртэх боломжтой болдог вэ? Бид эдгээр адислалуудыг хэрхэн хүлээн авч болох вэ?
 - а. Аврагч үхлийг даван туулж, дахин амилсан учраас бид бүгд бие махбодын үхлийг даван туулж дахин амилах болно (Мозая 16:7–8).
 - б. Тэр бидний гэм нүглийг өөр дээрээ авсан учраас бид нүглээ наманчлан өршөөгдөж болох ба биднийг Бурхантай оршин байхад цэвэр болоод зохистой болгодог (Алма 7:13–14; Итгэлийн Тунхаг 1:3).

в. Бидний сул дорой байдлыг өөр дээрээ авсан учраас тэр бидний зовлон бэрхшээлийг ойлгодог бөгөөд бидэнд хэрхэн туслахаа мэддэг (Алма 7:11–12). Бид түүнийг хүлцэнгүйгээр дагавал түүн дотор амар амгаланг хүлээн авна (С ба Г 19:23).

Ахлагч Марион Г.Ромни Цагаатгалаар дамжуулан бүх хүмүүс бие махбодийн үхлээс аврагдах бөгөөд наманчилж, дуулгавартай байдаг хүмүүс нь бас нүглээс аврагддаг гэдгийг тайлбарласан:

“Дахин амилалтаар хүмүүний бие махбод болон сүнснийг дахин нэгтгэхийн тулд Есүс Христ Цагаатгал үзүүлэх болсон юм. Тиймээс бүх дэлхий, итгэгчид болон үл итгэгчид өөрсдийн тодорхой дахин амилалтынхаа төлөө Гэтэлгэгчид талархах ёстой, учир нь дахин амилалт хүн бүрийг үхэлд хүргэсэн Уналттай адил өргөн хүрээтэй байх болно.

“Намайг Аврагчийг улам илүү хайрлахад хүргэдэг, мөн үгээр илэрхийлшгүй талархлаар зүрх сэтгэлийг минь дүүргэдэг цагаатгалын өөр нэгэн үе шат байдаг. Энэ нь Адамын гэмийг цагаатгахаас гадна, дахин амилалтыг авчирсан, Аврагч зовж шаналснаараа миний нүглийн төлөөсийг төлсөн явдал юм. Тэрээр та нарын нүглийг болоод дэлхий дээр амьдарч байсан буюу дэлхий дээр мөнх бус байдалд амьдрах бүх хүний нүглийн төлөөсийг төлсөн. Гэвч тэрээр үүнийг болзолтойгоор хийсэн. Бид бүгдийн гэмийн төлөө зовон шаналсны ашиг тус нь бидний юу хийхээс үл хамааран ирдэг дахин амилалттай адил бидэнд зүгээр ирэхгүй. Бид цагаатгалын адислалуудыг хүртэхийг хүсвэл өөрсдийн гэмээ анхаарч, хуулийг дуулгавартай дагах ёстой.

“Бид нүгэл үйлдэхдээ Бурханаас холдож, түүний оршихуйд орох боломжгүй болдог. Ямар ч бохир зүйл түүний оршихуйд орж чадахгүй. Бид яаж ч хичээсэн өөрсдийн гэмийн үр дүн болох бидэн дээр буй тэр толбоос өөрсдөө салж чадахгүй. Тэрхүү толбо нь Гэтэлгэгчийн цусаар угаагдаж арилах ёстой бөгөөд тэрээр толбыг арилгах замыг бий болгосон. Тэр зам нь Есүс Христийн сайн мэдээ юм. Сайн мэдээ нь биднээс Гэтэлгэгчид итгэж, түүний цагаатгалыг хүлээн зөвшөөрч, нүглээ наманчлан, нүглээ цайруулахын тулд усанд умбуулсан баталгаа хийлгэн, толгой дээрээ гар тавиулан Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах болоод өөрсдийн амьдралын бүх л өдрүүдэд үргэлжлүүлэн сайн мэдээний зарчмуудыг итгэлтэйгээр мөрдөх буюу мөрдөхийн тулд хамаг хүчээрээ ажиллахыг шаарддаг” (Conference Report, Oct. 1953, 35–36).

Урьдчилан томилсон ангийн гишүүдээс бэлтгэсэн танилцуулгаа хуваалцахыг урь (“Бэлтгэл” хэсгийг үз).

Дүгнэлт

Есүс Христийг гэрчилж, түүний Цагаатгалд талархлаа илэрхийл. Мөн тохиромжтой байвал ангийн гишүүдээс талархлаа илэрхийлэхийг хүс.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг нь эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. Дүрс Бичлэг

New Testament Video Presentations (53914)-ээс сонгосон “New Testament Customs”-ын тав дахь хэсэгт *Гетсемани* гэдэг нь “чидун жимс шахах” гэсэн үг гэдгийг тайлбарладаг. Хэрэв та энэ хэсгийг үзүүлбэл Аврагчийн бидний нүглийг үүрч гарсан цэцэрлэгт *Гетсемани* гэдэг нь ямар тохирсон нэр болохыг ярилц.

2. “Зуучлагч”

Ахлагч Бойд К.Пакер, биднийг наманчилж, тушаалуудыг дуулгавартай дагах үед Есүс Христийн Цагаатгал нүглээс хэрхэн чөлөөлдөг талаар заахын тулд сургаалт үлгэр ашигласан. Та ангийн гишүүдэд Цагаатгалын хэрэгцээг ойлгоход туслахын тулд энэ сургаалт үлгэрийг хуваалцаж болно. Уг сургаалт үлгэрийг дараах материалаас олж болно:

Сайн Мэдээний Зарчмууд [1997], 75–77 хуудас.

Матай 26:47–27:66; Марк 14:43–15:39; Лук 22:47–23:56; Иохан 18–19

Зорилго

Ангийн гишүүд Аврагчийн хайрыг мэдэрч, түүнийг хайрлах хайраа болон түүний цагаатгалын золиослолд талархах талархлаа нэмэгдүүлэхэд туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Матай 26:47–75; Марк 14:43–72; Лук 22:47–71; Иохан 18:1–27.
Гетсеманид шаналан тарчилсных нь дараахан Иудас тэргүүн прист, Фарисайчууд болон цэргүүдийн хамт ирж Есүсийг барьж өгдөг. Есүс, Түүнийг цэцэрлэгээс авч явж, Иудейчүүдийн гарт барьж өгч зовоосон хүмүүст өөрийгөө тушаадаг. Эхлээд тэргүүн прист байсан Аннас, дараа нь Аннасын өв залгамжлагч, хүргэн хүү Каиаф түүнээс асуулт асуудаг. Тэнд байсан тэргүүн прист болон ахлагч нар Есүс рүү нулимж, түүнийг дооглон, хүлж, харааж зүхэн буруушааж, үхэх шийтгэл хүлээх болно гэдэг. Каиафын өргөөний гадаа Петр Есүсийг мэддэг гэдгээ үгүйсгэдэг.
 - б. Матай 27:1–26; Марк 15:1–15; Лук 23:1–25; Иохан 18:28–19:16. Тэргүүн прист болон ахлагч нар Есүст үхэх ял оноох хүч чадалгүй тул тэд Иудей дэх Ромын захирагч Понтиус Пилатаар шүүлгэхээр түүнийг илгээдэг. Пилатын өмнө Есүсийг Цезарийн дайсан байсных нь төлөө буруушаадаг. Есүсийг Галилынх гэдгийг олж мэдээд Пилат түүнийг Галилын захирагч Херод руу явуулдаг. Херод Есүсийг шүүхээс татгалзаж, түүнийг буцааж, Есүсийг нь цовдлохыг шаардсан олон түмэнд бууж өгсөн Пилат уруу илгээдэг.
 - в. Матай 27:27–66; Марк 15:16–39; Лук 23:26–56; Иохан 19:17–42. Есүсийг ташуурдаж, цовдолдог. Тэрээр загалмай дээр хүн төрөлхтний төлөө өөрийгөө золиослол болгон өргөхдөө их тарчлалыг амсдаг.
2. Нэмэлт Уншлага: Исаиа 53; Марк 15:39–47; Иохан 3:16; 15:13; 1 Нифай 11:32–33; 19:7–9; 2 Нифай 9:21–22.
3. 110 хуудсанд үзүүлсэн долоон үгийн хайчилбарыг бэлтгэ (эсвэл самбарт өгүүлбэрүүдийг бичихээр бэлтгэ).
4. Дараах материалууд байгаа бол хичээлдээ хэрэглэ:
 - а. Есүсээс Урвасан нь (62468; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 228); Петр Үгүйсгэсэн нь (62177; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 229) ба Цовдолт (62505; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 230)
 - б. *New Testament Video Presentations* (53914)-ээс “To This End Was I Born” арван зургаан минутын бичлэг.
5. Заахад зориулсан зөвлөмж: Багш болон ангийн гишүүд бишрэнгүй байснаар ангид Сүнсийг урьдаг. Ангийн гишүүд “чөлөөтэй ярилцаж, чөлөөтэй ярьж, ангийн ажилд чөлөөтэй оролцох ёстой, харин ангийн гишүүн өрсөлдөж эсвэл хөнгөн хийсвэр тайлбар хэлж бусад оюутнуудад

саад болох эрхгүй (David O. McKay, *Gospel Ideals* [1954], 224). Бурханд бишрэнгүй хандаж, ангийн гишүүн бүрийг хүндэтгэн үлгэржишээ үзүүл.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Энэ хичээл Аврагчийн Цовдлолт болон үүнээс нэг цагийн өмнө болсон үйл явдалд төвлөрнө гэдгийг тайлбарла. Эдгээр үйл явдлууд дараах газруудад болсон: (1) Гетсеманий цэцэрлэг, (2) Каиафын гэрт, (3) Харь үндэстнүүдийн шүүхэд (4) Антониягийн харшид (Пилатын гэрт) ба (5) Голготагийн толгод (Калварид).

Есүс Голготагийн толгод дээр цовдлогдсон гэдгийг тайлбарла. Цовдлолтын зургийг үзүүл. Ангийн гишүүдээс бяцхан хүүхэд энэ зургийг хараад “Есүс яагаад үхэх хэрэгтэй байсан юм бэ?” гэж асууж байгааг төсөөлөхийг хүс. Ангийн гишүүдийг хичээлийн үеэр хүүхдэд юу гэж хариулахаа эргэцүүлэн бодох цаг гаргахыг урь. Хичээлийн төгсгөлд энэ асуултын талаар ярилцана гэж хэл.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгийг заахдаа мөрдөж, хавчин, цовдлохыг зөвшөөрсөн Аврагчийн тэдэнд зориулсан хайрыг ойлгоход ангийн гишүүдэд тусал.

1. Есүсийг барьж өгч, хорьж, харааж зүхэн буруушаадаг; Петр Есүсийг гурван удаа үгүйсгэдэг.

Матай 26:47–75; Марк 14:43–72; Лук 22:47–71; Иохан 18:1–27-г ярилц. Ангийн гишүүдээс сонгосон хэсгүүдийг чангаар уншихыг урь. Та энэ хэсгийг “Бэлтгэл” хэсгийн 1а- д заасны дагуу дүгнэн хэлж болно. Есүсийг Гетсеманид барьж өгч байгаа зургийг үзүүл.

- Гетсеманий Цэцэрлэгт Есүсийг авч явахаар ирсэн эрчүүдийг Петр яасан бэ? (Иохан 18:10-ыг үз.) Есүс эдгээр хүмүүсийг яасан бэ? (Лук 22:51–53; Иохан 18:11–12-ыг үз.) Есүс өөрийг нь авч явахыг яагаад зөвшөөрсөн бэ? (Матай 26:53–54; Иохан 10:17–18-ыг үз. Есүс бидний төлөө амьдралаа өгөх нь Тэнгэрлэг Эцэгийн хүсэл байсан гэдгийг тайлбарла.)
- Иудейн тэргүүн прист, ахлагч нар Есүсийг харааж зүхэн буруушааж, хэргийн шийтгэл нь үхэл байна гэдэг (Марк 14:64). Харааж зүхэх гэдэг нь юу гэсэн үг вэ? (Бурханд бишрэлгүй хандах буюу Бурхантай эн тэнцүү болохыг санаархах.) Тэргүүн прист, ахлагчид бодол санаандаа харааж зүхэхэд Есүс юу гэж хэлсэн бэ? (Марк 14:60–63-ыг үз.)
- Есүсийг цэцэрлэгээс явахад шавь нарын ихэнх нь “түүнийг орхин зугтдаг” (Матай 26:56). Хэдий тийм ч Петр, Иохан нар түүнийг дагасаар байв. (Матай 26:58; Иохан 18:15; Иохан 18:15 дээр үл нэрлэгдсэн шавь нь Иохан байдаг гэж таамагладаг.) Каиафын ордны гадаа байсан хүмүүс түүнийг Есүсийг мэддэг гэж хэлэхэд Петр яасан бэ? (Матай 26:69–74-ийг үз.) Петр Есүсийг гурван удаа үгүйсгэсэнэ ойлгоод юу хийсэн бэ? (Матай 26:75; мөн шүлэг 33–35-ыг үз.)

Петр Есүсийг үгүйсгэж байгаа зургийг үзүүл.

- Бидний зарим нь Петр шиг заримдаа итгэлээ хэрхэн үгүйсгэдэг вэ? Их Эзэнийг үгүйсгэсний дараах Петрийн амьдралаас бид юу сурч болох вэ?

Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли хэлэхдээ:

“Би зүрх сэтгэлдээ Петрийг өрөвдөж байна. Бидний олонх түүнтэй маш их төстэй байдаг. Бид шударга байдлаа барьцаанд тавьдаг; бид зоригтой сайн байхын тулд шийдэмгий байдлаа бататгадаг; бид заримдаа бүр олон түмэнд юу ч боллоо гэсэн зөвийг хийж, зөв учир шалтгааны төлөө зогсож, өөртөө болон бусдад үнэнч байна гэж тунхагладаг.

“Дараа нь дарамтанд орж эхэлдэг. Эдгээр нь заримдаа нийгмийн дарамт байдаг. Зарим үед эдгээр нь хувийн дур сонирхол байдаг. Заримдаа хуурамч хүсэл байдаг. Хүсэл сонирхол буурах явдал гэж байдаг. Дэг журам суларна гэж байдаг. Бууж өгөх явдал гэж бий. Тэгээд гэмшиж, дараа нь өөрийгөө буруутгаж, харууслын гашуун нулимс асгардаг. . . .

“. . . Сүм даяар үг хэлээрээ, үйлдлээрээ итгэлээ үгүйсгэсэн хүмүүс бий бол та нар Есүстэй өдөр бүр хамт байдаг, байсан ч гэсэн нэн чухал үед нь Их Эзэнийг, мөн зүрх сэтгэлдээ хадгалж явсан гэрчлэлээ үгүйсгэсэн Петрийн жишээнээс тайтгарал, шийдвэрийг олж аваг хэмээн би залбирч байна. Гэхдээ тэр үүнийг давж гарч, агуу хамгаалагч, хүчирхэг өмгөөлөгч болдог. Тиймээс үүний адил ямар ч хүнд Бурханы хаант улсыг байгуулахын төлөө бусдын итгэл, хүч чадалд хүч тэнхээ, итгэл нэмэхээр эргэж хийх арга зам гэж бий” гэжээ (“And Peter Went Out and Wept Bitterly,” *Ensign*, Mar. 1995, 2–4, 6).

2. Есүст цовдлох ял оноодог.

Матай 27:1–26; Марк 15:1–15; Лук 23:1–25; ба Иохан 18:28–19:16-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Та энэ үйл явдлыг “Бэлтгэл” хэсгийн 16-д дурьдсаны дагуу дүгнэж болно.

- Пилат Есүсийг Галилаас ирснийг мэдээд Галилын захирагч Херод рүү илгээдэг (Лук 23:6–7). Херод Есүсийг хараад яагаад “ихэд баярласан” бэ? (Лук 23:8-ыг үз.) Херодын асуултанд Аврагч хэрхэн хариулсан бэ? (Лук 23:9-ийг үз; энэ шүлгийг Исаиа 53:7 дээрх бошиглолтой харьцуул.)
- Херод болон түүний хүмүүс Есүсийг буруушааж, доог тохуу хийснийхээ дараа тэд түүнийг Пилат уруу буцаан илгээдэг (Лук 23:11). Есүсийг шүүсэн Пилатын шүүлт юу байсан бэ? (Лук 23:13–17-г үз; мөн Лук 23:4-ийг үз.) Пилат яагаад Есүсийг цовдлох ял оноосон бэ? (Матай 27:15–24; Марк 15:6–15; Лук 23:18–25; Иохан 19:1–16-г үз.) Бид заримдаа Пилат шиг хэцүү зүйлд шийдвэр гаргах хариуцлагаас хэрхэн зайлсхийхийг оролддог вэ?
- Есүсийг хаан мөн эсэхийг асуусан Пилатын асуултуудын нэгэнд Есүс “Би үнэний тухай гэрчлэхээр төрсөн бөгөөд үүний тулд л ертөнцөд ирсэн” гэж хариулсан (Иохан 18:37). Есүс ямар байдлаараа Хаан бэ? (Дуулал 24:10; Исаиа 44:6; Илчлэлт 11:15; 15:3; 2 Нифай 10:14-ийг үз.) “Түүний хаант улс энэ ертөнцөд байхгүй” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Иохан 18:36).

3. Есүсийг ташуурдаад, цовдолдог.

Матай 27:27–66; Марк 15:16–39; Лук 23:26–56 ба Иохан 19:17–42-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Цовдолтын зургийг толилуул.

- Есүсийг цовдлох ял оноосны дараа хүмүүс түүнийг яасан бэ? (Матай 27:27–44; Лук 23:34–39-ийг үз.) Түүнийг мөрдөн хавчихыг Есүс хүмүүст яагаад зөвшөөрсөн бэ? (1 Нифай 19:9-ийг үз.)

Загалмай дээр байхдаа Есүсийн хэлсэн долоон мэдэгдлийг сударт бичсэн байдаг. Дор дурьдсан шүлгүүдийг уншаад ярилц. Тэдгээрийг ярилцахдаа мэдэгдлийг бичсэн үгийн хайчилбарыг үзүүл эсвэл самбарт бич.

1. Лук 23:34. *“Аав аа, тэднийг уучлаач; Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна.”*

- Бид Иосеф Смитийн Орчуулгаас, Есүс өөрийг нь цовдолсон Ромын цэргүүдийн төлөө залбирахдаа үүнийг хэлсэн гэдгийг сурч авдаг. Энэ нь түүний талаар юуг илчилдэг вэ? Биднийг хохироосон эсвэл гомдоосон хүмүүст хандах дэлхийн арга юу вэ? Бид Есүсийн жишээг дагаснаар хэрхэн адислагддаг вэ?

2. Лук 23:43. *Гэмшсэн гэмт хэрэгтэнд хандан: “Үнэнээр би чамд хэлье. Өнөөдөр чи надтай хамт диваажинд байх болно” гэжээ.*

3. Иохан 19:26–27. *Өөрийн эх Мариад хандан: “Эмэгтэй энэ бол таны хүү!” Иоханд хандан “Энэ бол чиний эх” гэжээ.*

- Зовлонг сорилтынхоо үеэр Есүс хэний хэрэгцээ шаардлагын талаар бодож байсан бэ? (Лук 23:43; Иохан 19:26–27-г үз.) Үүнээс бид юу сурч болох вэ? (Лук 23:43-г байгаа Есүсийн мэдэгдлийн талаар асуулт гарч ирвэл гурав дахь заах нэмэлт санааг үз.)

4. Матай 27:46; Марк 15:34. *“Миний Бурхан, Миний Бурхан, юунд Та намайг орхив?”*

- Ганцаардсан үед биднийг ойлгож туслах боломжийг түүнд өгсөн ямар зүйл Есүсийг загалмай дээр байхад тохиолдсон бэ? Аврагч бидний нүглийг үүрээд зогсоогүй мөн бидний ганцаардмал байдал, гуниг зовлон, айдсыг авдаг гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ?

Ахлагч Жэффри Р.Холланд хэлэхдээ: “Тэр хэнээс ч тусламж авах аргагүй энэ гэтэлгэлийн усан үзмийн шахуургыг гарцаагүй гишгэх ёстой учраас хамгийн харанхуй муухай мөч бүгдийг, агуу их өвчин шаналлыг нь тэвчин гарч чадах уу? Энэ нь өргөс, хадааснаас биш, харин цор ганцаараа байгаа мэт аймшигт мэдрэмжээс ирдэг юм: . . . ‘Миний бурхан, миний Бурхан, юунд та намайг орхив?’ (Марк 15:34). Тэр бас бидний бүх гэм нүгэл, ганцаардлын айдсыг үүрч чадах уу? Тэр үүрсэн, үүрж ч байгаа, мөн үүрэх ч болно” гэсэн (Conference Report, Oct. 1989, 32; or *Ensign*, Nov. 1989, 26).

5. Иохан 19:28. *“Би цангаж байна.”*

- Есүс бүхий л байдлаар зовж шаналснаас гадна бие махбод нь таагүй байсан тухайгаа илэрхийлсэн ганц тохиолдол нь энэ байсан. Түүнийг цангаж байна гэхэд түүнд юу өгсөн бэ? (Иохан 19:29-ийг үз.)

6. Иохан 19:30. *“Энэ нь төгслөө.”*

- Иосеф Смитийн Орчуулгын дагууд бол Есүс, энэ нь төгслөө гэж хэлсэн; түүний Эцэгийн хүсэл биелсэн. (Иосеф Смитийн Орчуулга, Матай 27:54-ийг үз.) Тэнгэрлэг Эцэгийн хүслийг биелүүлэхийн тулд Аврагч яагаад үхэх ёстой байсан бэ? (2 Нифай 9:5; 3 Нифай 27:13–16-г үз. Та анхаарал татах

ажиллагааг хэрэглэсэн бол ангийн гишүүдийг хүүхдийн асуултанд хариулахаар өөрсдийн санаа бодлоо хуваалцахыг урь.)

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл хэлэхдээ: “Түүний булшийг онгойлгосон байсан шиг тэрээр бүх хүмүүний булшийг онгойлгохын тулд үхэх хэрэгтэй байсан. Цовдлолтын үеэр болсон гүн харанхуй үе болоогүй бол булшнаас гарч ирэх үр удам гэж байхгүй байх байсан” гэсэн (Conference Report, Apr. 1975, 4; or *Ensign*, May 1975, 4).

7. Лук 23:46. “Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая.”

Та “To This End Was I Born” дүрс бичлэгийг хэрэглэж байгаа бол одоо үзүүл.

Дүгнэлт

Мөнх бус байдлын өмнөх амьдралд хэлсэн Аврагчийн анхны үг нь тэрээр Аавдаа, би дэлхий рүү Аврагч болон илгээгдэхийг дуртайяа хүсэж байна гэж бичигдсэн байдаг гэдгийг тайлбарла. (Абрахам 3:27-г үз.) Түүний анхны мөнх бус үг нь “Би Эцэгийнхээ үйл хэргийг хийх ёстой” (Лук 2:49) гэж бичигдсэн байдаг. Мөнх бус байдалд хэлсэн сүүлчийн үгс нь Ажил тань дууслаа; Эцэгийн хүсэл биелсэн хэмээн Эцэгтээ хэлсэн үгс байсан. (Иосеф Смитийн Орчуулга, Матай 27:54-ийг үз.) Есүс номлолдоо байхдаа хэзээ ч Эцэгийнхээ хүслийг умартаагүй юм. Тэрээр тоо томшгүй олон тэнгэр элч нарыг өөрийгөө аврахаар дуудаж болох байсан, гэвч тэр дуудаагүй (Матай 26:53–54). Тэр ихэд зовж шаналж байсан хэдий ч цорын ганц Цагаатгалыг гүйцэлдүүлэх хүсэл болон нигүүлслээсээ хэзээ ч буцаагүй.

Хичээл дээр ярилцсан үнэнүүдийн тухай гэрчил. Боломжтой бол ангийн гишүүдийг гэрчлэлээ хуваалцахыг урь.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Хүнд хэцүү цаг үед Аврагчийн жишээг дагах нь

Мөнх бус амьдралынхаа сүүлчийн өдрүүдэд Аврагчийн хийсэн зүйлүүд түүний зан чанарын нэн чухал ач холбогдлыг харуулдаг. Тэр өдөр Есүсийн туулсан хүнд сорилтыг дүгнэж үз. Дараа нь доорх асуултуудыг тавь:

- Энэ хүнд хэцүү цаг үед Есүсийн ямар зан чанар нь нотлогдсон бэ? (Хариултанд, тэр өөрөөсөө илүү бусдын төлөө анхаарал тавьж байсан, тэр өршөөнгүй хандсан, Тэнгэрлэг Эцэгийнхээ хүсэл дуулгавартай байсан, тэр бусдын сул дорой байдлыг шүүмжлээгүй, мөн тэр гомдоллоогүй гэх зэрэг нь орж болно. Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич. Тэр зан чанарыг нь батлан харуулж байгаа тодорхой жишээг гаргахыг ангийн гишүүдээс хүс.)
- Хамгийн хүнд хэцүү цаг үед маань биднээс ямар зан чанарууд харагддаг вэ? Хүнд хэцүү цаг үед бид Аврагчийн жишээг хэрхэн дагаж болох вэ?

2. “Би гэм зэмгүй цуснаас урвасан” (Матай 27:4)

- Иудас Аврагчаас урваснаа наманчлахаар оролдож юу хийсэн бэ? (Матай 27:3–5-ыг үз.) Бидний нүгэлд хариу болгон дэлхийгээс өгдөг “төлөөсийн” тухай түүнд тохиолдсон явдлаас бид юу сурч болох вэ?

3. “Өнөөдөр чи надтай хамт диваажинд байх болно” (Лук 23:43)

Лук 23:43 дээрх Аврагчийн үгийг тайлбарлах хэрэгтэй бол дараах мэдээллийг хэрэглэнэ үү.

Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ, Есүс хулгайчид, “Энэ өдөр чи надтай хамт сүнсний дэлхийд байх болно” гэсэн (*Teachings of the Prophet Joseph Smith*, ed. Joseph Fielding Smith [1976], 309).

Бид Сургаал ба Гэрээ 138:36–37-гоос Есүс үхээд, Дахин Амилах хүртлээ сүнснүүдийн дэлхий рүү очиж, тэрээр түүний сайн мэдээг дэлхийд байхдаа хүлээн авч чадаагүй сүнснүүдэд заахад нь итгэлтэй сүнснүүдийг бэлтгэсэн гэдгийг сурч авдаг.

“Тэр Энд Байхгүй, Учир нь Тэр Амилсан”

Хичээл
27

Матай 28; Лук 24; Иохан 20–21

Зорилго Ангийн гишүүдийг Аврагчийн Дахин Амилалт, үүнээс ирдэг адислалуудад талархахад туслах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - a. Матай 28:1–5; Лук 24:1–12; Иохан 20:1–10. Магдалын Мариа болон бусад эмэгтэйчүүд Есүсийн булш уруу эргэж ирээд хоосон байхыг нь олдог. Тэнгэр элчүүд Есүсийг дахин амилсан гэж зарладаг. Петр, Иохан нар хоосон булшийг үзэхээр ирдэг. Амилсан Их Эзэн эмэгтэйчүүдэд үзэгддэг.
 - б. Лук 24:13–35. Есүс Еммау хүрэх замд хоёр шавьтайгаа хамт явж, ярьдаг. Тэд түүнийг талх хуваагаад өгөх хүртэл нь таньдаггүй.
 - в. Матай 28:16–20; Лук 24:33–53; Иохан 20:19–31. Есүс шавь нартаа үзэгдэж, дахин амилснаа үзүүлж, сайн мэдээг бүх үндэстэнд заахыг тушаадаг. Томас Есүсийн гар, хөл, хажуу тал дахь шархны сорвийг тэмтэрч үздэг.
 - г. Иохан 21. Есүс Тибер Тэнгисийн дэргэд зарим Төлөөлөгч нарт дахин үзэгддэг. (Галил Тэнгис.) Тэр Петрт “хонийг минь тэжээ” гэж тушаадаг.
 2. Нэмэлт Уншлага: Марк 16.
 3. Ангийн нэг гишүүнээс Еммаугийн зам дээрх Есүс болон хоёр шавийнх нь тухай явдлыг дүгнэж ярихаар бэлтгэхийг хүс (Лук 24:13–32).
 4. Дараах зургууд байгаа бол хичээлдээ хэрэглэ: Есүсийг Оршуулсан нь (62180; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 231); Есүсийн Булш (62111; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 232) эсвэл Хоосон Булш (Ариун Сургаалийн Уран Зургийн Цуглуулга 245); Мариа ба Дахин Амилсан Их Эзэн (62186; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 233); Есүс Шархаа Үзүүлсэн нь (62503; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 234); Дахин Амилсан Есүс Христ (62187; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 239).
 5. Заахад зориулсан зөвлөмж: Их Эзэний “Хонийг минь тэжээ” (Иохан 21:16–17) гэж Петрт хэлсэн тушаал нь бүх багш нарт хамаатай юм. Судрын сүнслэг хоолыг ангийн гишүүдэд үзүүлэх арга замыг залбирч хай, тэгснээр тэд үүнийг шимтэн судлах хүсэлтэй болно (See *Teaching—No Greater Call*, 3).

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ахлагч Жэймс М.Парамоорын ярьсан дараах түүхийг өгүүл:

“Олон жилийн өмнө . . . нэгэн сонины сэтгүүлчээс ‘Дэлхийд түгээх хамгийн чухал мэдээ юу байж болох бол?’ гэж асуужээ.”

- Та энэ асуултанд юу гэж хариулах вэ?

Ахлагч Парамоор үргэлжлүүлэн: “[Зохиолч] энэ асуултын тухай дахин дахин бодож, олон хүмүүстэй ярилцаж, өөртөө хариулт олохыг оролдон бүх чадлынхаа хэрээр уншиж хайжээ. Эцэст нь тэрээр хариултаа, ‘Есүс Христ өнөөдөр амьд гэдгийг мэдэх нь дэлхийд түгээх хамгийн чухал мэдээ юм. Үнэндээ тэр өнөөдөр амьдардаг, түүнчлэн Түүний хэлсний дагуу бид ч мөн мөнхөд амьдарна’ гэж хэвлэн гаргажээ” гэв (Conference Report, Oct. 1990, 80; or *Ensign*, Nov. 1990, 64).

“Бэлтгэл” хэсэгт бичсэн зургуудыг үзүүл. Христийг үхэхэд шавь нарын гуниглаж байсан явдал нь түүнийг Дахин Амилахад үгээр өгүүлшгүй их баяр баясгалангаар солигдсон гэдгийг тайлбарла. Мөн бид Христийг дахин амилсан явдалд баярлан баясдаг.

Зургийг тавиастай хэвээр нь орхи. Зохих үед нь тэдгээрийг хичээлдээ хэрэглэ.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Дараах судрын хэсгүүдийг ярилцахдаа Дахин Амилалтын тухай мэддэг байх нь тэдний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлдөг тухай ангийн гишүүдтэй ярилц. Дахин Амилалтын үеэр болсон тодорхой үйл явдлыг (Сайн мэдээг бичсэн хүн болгон ялихгүй ялгаатай мэдээллийг өгсөн байдаг) тодорхойлон ярих гэж оролдохын оронд Сайн мэдээний түүх болгонд өгөгдсөн Дахин Амилалтын тухай гэрчлэлээ хуваалцахад голлон анхаар.

1. Магдалын Мариа болон бусад эмэгтэйчүүд дахин амилсан Их Эзэнийг гэрчилдэг.

Матай 28:1–15; Лук 24:1–12 ба Иохан 20:1–10-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг уншихыг урь. Есүсийг цовдлуулсны дараа түүний биеийг цэвэр маалинган даавуунд ороож, Есүсийн шавь нарын нэг Ариматын Иосефийн эзэмшил дэх булшны газарт тавьсан гэдгийг тайлбарла (Матай 27:57–60; Лук 23:50–53; Иохан 19:38–42). Хүндэтгэлийн Өдөр болох гэж байсан учир үүнийг яаралтай хийсэн. Магдалын Мариа болон бусад эмэгтэйчүүд булш уруу эргэж ирээд анхилуун үнэртэн болон үнэрт тосоор Есүсийг тосолж, биеийг нь занданшуулсан.

- Магдалын Мариа болон бусад эмэгтэйчүүд Есүсийн булш уруу очоод юу олсон бэ? (Матай 28:1–4; Лук 24:1–4-ийг үз. Матай 28-ын Иосеф Смитийн Орчуулгад Лукийн хэлсэнчлэн тэнд хоёр тэнгэр элч байсан гэснийг тайлбарла.) Тэнгэр элчүүд эмэгтэйчүүдэд юу гэж хэлсэн бэ? (Матай 28:5–7; Лук 24:5–8-ыг үз.)
- Тэнгэр элчүүд “Тэр амилсан” гэж хэлэхдээ ямар утга санааг илэрхийлсэн бэ? (Есүс дахин амилсан.) Дахин амилах гэдэг нь юу гэсэн үг вэ? (Алма 11:42–45-ыг үз.) Есүсийн Дахин Амилалтаас бид ямар адислал хүртэх вэ? (1 Коринт 15:22, 50–58; Алма 11:42–45-ыг үз. Бид бүгд дахин амилж, үхэшгүй биетэй болно.)
- Ерөнхийлөгч Ховард В.Хантэр хэлэхдээ, “Тэр энд байхгүй, тэр амилсан” (Лук 24:6) гэсэн үгс “бүхий л итгэл найдвар, баталгаа, саад тотгор, зарим

үед зовлонгоор дүүрсэн амьдралд маань биднийг дэмжихэд шаардлагатай итгэлийг агуулдаг” гэсэн (Conference Report, Apr. 1986, 18; or *Ensign*, May 1986, 15–16). Цагаатгал, Дахин Амилалтын талаарх таны гэрчлэл хүнд хэцүү үед тань хэрхэн тусалсан бэ?

- Тэнгэр элч нарыг ярьж дуусахад эмэгтэйчүүд юу хийсэн бэ? (Матай 28:8; Лук 24:8–9-ийг үз.) Тэдний жишээнээс бид юу сурч болох вэ?
- Мариа болон бусад эмэгтэйчүүд Есүс Христийг дахин амилсных нь дараа харсан олон хүмүүсийн анхны хэдэн хүмүүс нь байсан. (Мөн хоёр, гуравдугаар заах нэмэлт санааг үз.) Дахин амилсан Их Эзэн дэлхийн гэрчүүдэд үзэгдсэн нь яагаад чухал байсан гэж та нар бодож байна вэ? (2 Коринт 13:1-ийг үз.)

2. Еммаус орох замд явсан хоёр шавь нь дахин амилсан Их Эзэний гэрчүүд юм.

Лук 24:13–35-ыг ярилц. Урьдчилан даалгасан ангийн гишүүнээр судрын хэсгийг дүгнэн яриул.

- Еммау орох замд алхаж байхдаа Клеоп болон түүний хамтрагч хоёр яагаад гунигтай байсан бэ? (Лук 24:13–24-ийг үз.) Тэднийг алхаж явахад дахин амилсан Их Эзэн тэдэнд юу заасан бэ? (Лук 24:25–27-г үз.)
- Есүсийг тэдэнд заахад хоёр шавь нь ямар мэдрэмжтэй байсан бэ? (Лук 24:32-ыг үз.) Тэдэнд энэ мэдрэмжийг юу төрүүлсэн бэ? (Ариун Сүнсний нөлөө) Ангийн гишүүдийг сайн мэдээнээс суралцаж эсвэл хэн нэгний заахыг сонсож байхдаа Сүнсний гэрчлэлийг хүлээн авсан тохиолдлоосоо ярихыг урь.

3. Төлөөлөгчид бол дахин амилсан Их Эзэний гэрчүүд мөн.

Матай 28:16–20; Лук 24:33–53 ба Иохан 20:19–31-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Аврагчийг дахин амилсан өдрийнхөө үдэш үзэгдэхэд Төлөөлөгчид нь юу харж байна гэж бодсон бэ? (Лук 24:36–37-г үз.) Есүс өөрийгөө сүнс биш харин дахин амилсан биеэрээ байна гэдгээ хэрхэн баталсан бэ? (Лук 24:38–43-ыг үз.)
- Их Эзэн дахин амилжээ гэж бусад Төлөөлөгчдийг гэрчлэхэд Томас юу гэж хариулсан бэ? (Иохан 20:24–25-ыг үз.) Их Эзэнийг дахин амилсан гэдэгт тэр яаж итгэсэн бэ? (Иохан 20:26–29-ийг үз.) Бид заримдаа Томасын адил сул дорой байдлаа хэрхэн харуулдаг вэ?

Ахлагч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“Бусад хүмүүс Томасын адилаар ярьж байхыг та нар сонсоогүй гэж үү? Тэд ‘бидэнд туршилтанд тулгуурласан нотолгоо үзүүл. Бидний нүд, чих, гарын өмнө батал үгүй бол бид итгэхгүй’ гэж хэлдэг. Энэ бол бидний амьдарч буй цаг үеийн хэл юм. Эргэлзэгч Томас хайр, итгэл, тэр ч бүү хэл цахилгаан шиг физикийн гоц үзэгдлийг баталдаг шиг бодитойгоор батлахгүй л юм бол хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг аль ч үеийн хүний жишээ болсон. . . .

“Миний дуу хоолойг сонсож байгаа эргэлзэгч бүх хүмүүст би Их Эзэний шархтай гарыг тэмтэрч үзээд Томасын хэлсэн үгийг давтан хэлье: “Итгэлгүй бус, харин итгэлтэй бай” гэсэн” (Conference Report, Apr. 1978, 90; or *Ensign*, May 1978, 59).

- Бид “итгэлгүй бус, харин итгэлтэй бай” гэсэн Их Эзэний сануулгыг хэрхэн илүү бүрэн дүүрэн дагаж чадах вэ?

4. Зарим Төлөөлөгчид нь Есүсийг Тиберийн Тэнгисийн ойролцоо дахин хардаг.

Иохан 21-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Дахин амилсан Их Эзэн долоон Төлөөлөгчиддөө загасчилж байхад нь үзэгддэг. Эрэг дээр Есүсийг байна гэж тэд хэрхэн ойлгосон бэ? (Иохан 21:4–7-г үз.) Тэднийг идэж дууссаны дараа Есүс, Петр болон бусад Төлөөлөгчдийг юу хийхийг хүссэн бэ? (Иохан 21:15–17-г үз.) Их Эзэний хонийг бид хэрхэн гэжээж чадах вэ?
- Дахин амилсан Есүсийн хэлж, хийсэн зүйлүүдийн заримыг Иохан ямар учир шалтгаанаар бичиж үлдээсэн бэ? (Иохан 20:30–31-ийг үз.) Есүсийн Дахин Амилалтын тухай судраас суралцсанаар та ямар ач тусыг олж авсан бэ?

Дүгнэлт

Есүс Христ дахин амилсан бөгөөд үүний учир бид бас дахин амилна гэдгийг гэрчил. Дахин амилалтын тухай мэддэг явдал нь танд хүч тэнхээ, тайтгарлыг авчирдаг гэсэн гэрчлэлээ хуваалц.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Тэр амилсан” (Матай 28:6)

Жижигхэн хамтлагийг “Тэр Амилсан” (*Hymns*, no. 199) эсвэл “Христ, Их Эзэн Өнөөдөр Амилсан Байгаа” (*Hymns*, no. 200) дууг хичээлийн төгсгөлд дуулуулахаар төлөвлө. Эсвэл хэсэг хүүхдүүдээр “Есүс Үнэхээр Дахин Амьдарсан Гэж үү?” дууг дуулуул.

2. “Эмэгтэй, та юунд уйлна вэ?” (Иохан 20:15)

Иоханы Сайн Мэдээнд л зөвхөн Дахин амилсныхаа дараа Их Эзэн Магдалын Мариад үзэгдсэн талаар өгүүлдэг гэдгийг цохон тэмдэглэ. Энэ тухай Иохан 20:11–18 дээрээс ангийн гишүүнээр чангаар уншуул. Энэ үйл явдлын талаар өөрсдийн сэтгэгдэл, бодлоо хуваалцахыг ангийн гишүүдээс урь.

3. Дахин амилсан Их Эзэний бусад гэрчүүд

- Сайн мэдээнд дурьдсан олон гэрчүүдээс өөр хэн дахин амилсан Их Эзэнийг харсан бэ? (Зарим хариултыг дор жагсаав.)

Стефан (Үйлс 7:55)

500 гаруй ах нар (1 Коринт 15:6)

Төлөөлөгч Иаков (1 Коринт 15:7)

Төлөөлөгч Паул (1 Коринт 15:8)

Эртний Америк дахь 2500 Гэгээнтнүүд (3 Нифай 11:8–15; 17:25)
 Бошиглогч Иосеф Смит (Иосеф Смитийн Түүх 1:17; С ба Г 76:22–24)
 Сидней Ригдон (С ба Г 76:22–24)

4. Судрууд Дахин Амилалтын тухай

Мормоны Ном, Сургаал ба Гэрээний хэд хэдэн хэсэг Дахин Амилалтын тухай бидний ойлголтыг нэмэгдүүлдэг. Дараах санаануудаас цагтаа багтааж аль болох олныг нь ярилц:

- а. Есүс дахин амилсан анхны хүн байсан (2 Нифай 2:8) бөгөөд тэр Дахин Амилсан учраас бүх хүн дахин амилах болно (2 Нифай 9:22; Алма 11:42, 44).
- б. Есүс Христийн дараа, эхлээд сэлэсчел алдрыг хүртэх хүмүүс дахин амилж, дараа нь тэррэстрил алдрыг хүртэх нь, мөн тэлэсчел алдрыг хүртэх нь, эцэст нь мөхлийн хөвгүүд амилна (С ба Г 88:96–102).
- в. Биднийг дахин амилахад бидний сүнс төгс биетэй маань нэгдэж, дахин хэзээ ч салахгүй болдог (Алма 11:43, 45).
- г. Дэлхийд бидний олж авдаг оюуны мэдлэг маань дахин амилахад биднийх хэвээрээ байна. (С ба Г 130:18–19-ийг үз.)
- д. Нас барсан хүний сүнс салсан биеэ хүлээс адилаар хардаг; дахин амилалт биднийг баяр баясгалангийн бүрэн дүүрэнг мэдрэх боломжтой болгодог (С ба Г 138:12–17, 50).

Зорилго	Ангийн гишүүдэд Есүс Христийн гэрч байх үүргийг нь сануулж, мөн Ариун Сүнсний бэлэг үүнийг хийхэд тэдэнд хэрхэн тусалдгийг харахад туслах болно.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none"> 1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир: <ol style="list-style-type: none"> а. Үйлс 1. Шавь нарынхаа дунд 40 хоногийн турш үйлчилснийхээ дараа дахин амилсан Их Эзэн тэнгэр өөд өргөгддөг. Маттиа нь Иудасын оронд Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгад ордог. б. Үйлс 2. Пентекостын өдөр Төлөөлөгчид Ариун Сүнсээр дүүрч, олон хэлээр ярьдаг. Тэднийг сонссон олон хүмүүс өөрчлөгддөг. в. Үйлс 3–4. Петр, Иохан хоёр доголлон хүнийг эдгээж, уг хүн Есүс Христийн хүч чадлаар эдгэрсэн гэж гэрчилдэг. Төлөөлөгчид агуу хүч чадлын төлөө залбирч, Ариун Сүнсээр дамжуулан үүнийг хүлээн авдаг. г. Үйлс 5:12–42. Төлөөлөгчид агуу хүч чадлаар номлож, анагаасаар байдаг. Тэднийг баривчилж, шоронд хийдэг боловч тэнгэрийн элч тэднийг шоронгоос сулладаг. Тэд тэргүүн прист нарт хүмүүсийг дагахын оронд Бурханыг дуулгавартай дага хэмээн тунхагладаг. Гамалиел Фарисайчуудад, Төлөөлөгчдийг бүү ал гэж зөвлөдөг. 2. Нэмэлт Уншлага: Марк 16:19–20; Лук 24:49–53; Иосеф Смитийн Түүх 1:21–25. 3. Есүс Тэнгэрт Өргөгдсөн нь (62497; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 236) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэ. 4. Та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл хичээл эхлэхээс өмнө ангийнхныг суудлаа эзэлж байх зуур ангид хоёр хүнийг оруулж ирүүлэхээр товлло. (Боломжтой бол эдгээр хүмүүс танай ангийн хүмүүс биш байх ёстой.) Тэд орж ирээд хурдхан шиг ямар нэгэн зүйл хийгээд (жишээ нь, тантай ярих эсвэл өрөөнд ямар нэг юм оруулж ирэх) дараа нь гарч явна. Тэд ангийн гишүүдтэй ярьж эсвэл өөрсөд рүүгээ тэдний анхаарлыг татах ёсгүй. 5. Заахад зориулсан зөвлөмж: Багш нар зааж байгаа зүйл нь үнэн гэдгийг гэрчлэх ёстой. Есүс Христ болон түүний сайн мэдээний тухай зөвхөн хичээлийн төгсгөлд биш, харин Сүнсний хүчтэй мэдрэмжийг мэдрэх бүрдээ гэрчил.

**Хичээл Заах
Зөвлөмж**Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Хичээлээ эхлэхийн өмнө ангид орж ирээд гарсан хоёр хүнийг анзаарсан эсэхийг ангийн гишүүдээс асуу. (“Бэлтгэл” хэсгийг үз.) Хэрэв ангийн

гишүүдийн аль нэг нь анзаарсан бол тэд хэн байсан, ямар хувцас өмсөж байсан болон тэд юу хийсэн гэх мэтээр тэдний юу анзаарсныг нь хэлүүл. Тэр ирсэн хүмүүсийг харсан ангийн гишүүд бол гэрчүүд юм гэдгийг цохон тэмдэглэ.) Үйл явдлыг харж эсвэл үүнд оролцоод энэ тухайгаа бусдад хэлдэг хүн нь гэрчлэгч юм.

Ирээд явсан хүмүүсийг хараагүй ангийн гишүүдээс:

- Эдгээр гэрчүүдийн хэлсэн зүйлд та нар итгэж байна уу? Яагаад эсвэл яагаад үгүй гэж? хэмээн асуу.

Өнөөдрийн хичээлд дахин амилсан Есүс Христийг гэрчилж байсан эртний Төлөөлөгчдийн тухай гарна гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага ба Ашиглалт

Та дараах судрын хэсгийг заахдаа дахин амилсан Их Эзэнийг Төлөөлөгчид итгэл, хүч чадлаар гэрчилж байсан гэдгийг онцлон тэмдэглэ. Мөн ангийн гишүүдтэй, тэд хэрхэн Есүс Христийн гэрч байж болох тухай ярилц.

Үйлсийн ном нь Есүс Христийн мөнх бус амьдралын дараах 30 орчим жилийн турш Сүмд болсон чухал үйл явдлын тухай Лукийн бичсэн мэдээлэл юм гэдгийг тайлбарла. Лук дахин амилсан Их Эзэний 40 өдрийн үйлчлэлийн мөн түүний Өргөгдөлтийн тухай ярьдаг. Түүнчлэн тэр Пентекостын өдөр болсон агуу сүнслэг асгаралт, Петр Сүмийг удирдсан тухай, Төлөөлөгчдийн номлолын эхэн үеийн хичээл зүтгэл, Паулын эмгэнэлт өөрчлөгдөлтийн тухай дүрсэлдэг. Энэ номын хоёр дахь хагаст Паулын Харь Үндэстнүүдийн дунд үйлчилсэн номлолын ажлын тухай голлон гардаг.

1. Их Эзэн тэнгэрт өргөгддөг. Маттиа Төлөөлөгчөөр дуудагддаг.

Үйлс 1-ийг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь. Өргөгдөлтийн зургийг үзүүл.

- Есүс дахин амилсныхаа дараа шавь нартайгаа 40 хоног “Бурханы хаант улсын талаарх зүйлсийн тухай ярьж” хамт үлдсэн (Үйлс 1:3). Тэр Тэнгэр дэх Эцэг рүүгээ буцахын өмнөхөн Төлөөлөгчиддөө, тэд удахгүй юу хүлээн авна гэж амласан бэ? (Үйлс 1:4–5-ыг үз. Мөн Лук 24:49-ийг үз. Хэдийгээр Төлөөлөгчид Ариун Сүнсний *илрэлийг* мэдэрсэн ч гэсэн тэд Ариун Сүнсний бэлгийг арай хүлээн аваагүй байсан гэдгийг цохон тэмдэглэ.)
- Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсныхаа дараа тэд юу хийх ёстой гэж Есүс Төлөөлөгчиддөө хэлсэн бэ? (Үйлс 1:8-ыг үз.) Энэ зааварчилгааг өнөөдрийн Төлөөлөгчдөд өгөгдсөн үүрэг хариуцлагатай хэрхэн харьцуулах вэ? (С ба Г 107:23, 35-ыг үз.) Төлөөлөгчид энэ үүрэг хариуцлагыг Есүсийг Дахин Амилсны дараахан хэрхэн биелүүлсэн бэ? (Жишээ нь, Үйлс 2–5 дээр зарим хүчтэй гэрчлэлүүдийг бичсэн байдгийг тайлбарла.) Төлөөлөгчид өнөөдөр энэ үүргийг хэрхэн биелүүлж байна вэ?
- Есүс Христийн гэрч байх Төлөөлөгчдийн үүрэгт Ариун Сүнсний бэлэг хэрхэн тусалсан бэ? (Иохан 15:26–27; 1 Коринт 12:3-ыг үз. Сайн мэдээг заах хичээл зүтгэлд маань Ариун Сүнс ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? (2 Нифай 33:1; С ба Г 42:14-ийг үз.)
- Есүсийг тэнгэрт өргөгдөхөд цагаан хувцастай хоёр хүн дэргэд нь зогсож байсныг Төлөөлөгчид харсан. Эдгээр хүмүүс Төлөөлөгчдөд юу гэж хэлсэн бэ? (Үйлс 1:10–11-ийг үз.) Христийн Хоёр дахь Ирэлт бодит үйл явдал байх

болно гэдгийг гэрчил. Христ Мянган Жилийн эхлэлийг тавьж, дэлхийг удирдан захирахаар дэлхийд буцаж ирнэ.

- Их Эзэнийг өргөгдсөний дараа Иудасын үлдээсэн Чуулга дахь хоосон зайг бүрэн болгохоор шинэ Төлөөлөгчийг сонгодог. Маттиа шинэ Төлөөлөгчөөр хэрхэн сонгогдсон бэ? (Үйлс 1:21–26-г үз.) Өнөөдөр Төлөөлөгчид болон Сүмийн бусад удирдагчид хэрхэн сонгогддог вэ? (Итгэлийн Тунхаг 1:5-ыг үз.)

2. Пентекостын өдөр Төлөөлөгчид Ариун Сүнсээр дүүрдэг.

Үйлс 2-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Дээгүүр Өнгөрөх баярын дараа ургацын ойг тэмдэглэдэг Пентекостын баярыг 50 өдрийн турш хийдгийг тайлбарла. Газар газрын Иудейчүүд Иерусалимд энэ баярт ирсэн.

- Аврагчийн өргөгдсөнөөс долоо хоногийн дараа Пентекостын өдрөөр ямар чухал үйл явдал болсон бэ? (Үйлс 2:1–4-ийг үз. Иохан 14:26, 15:26 ба 16:7–14, Үйлс 1:5 дээрх Их Эзэний амлалтыг энэ нь биелүүлсэн тухай цохон тэмдэглэ.)
- Төлөөлөгчид Ариун Сүнсийг хүлээн аваад юу хийсэн бэ? (Үйлс 2:4-ийг үз.) Төлөөлөгчдийг янз бүрийн хэлээр ярихад хүмүүс яасан бэ? (Үйлс 25:13-ыг үз.) Өнөөдөр сайн мэдээг номлодог байдал нь Пентекостын өдөр номлосонтой хэрхэн төстэй байдаг вэ? (С ба Г 90:11; 100:5–8-ыг үз.)
- Төлөөлөгчдийг хэлээр ярихад доог тохуу хийсэн хүмүүст Петр юу гэж хариулсан бэ? (Үйлс 2:14–24, 36-г үз.) Петрийн хариултын юу нь таны сэтгэлийг хөдөлгөдөг вэ? Есүс Христийн болон түүний тэнгэрлэг номлолын тухай гэрчлэлтэй болох нь яагаад чухал вэ? Гэрчлэлээ хуваалцахад Ариун Сүнс бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Петрийн гэрчлэлийг сонссон хүмүүст энэ нь хэрхэн нөлөөлсөн бэ? (Үйлс 2:37-г үз.) Гэрчлэлд нь итгэсэн хүмүүст Петр юу заасан бэ? (Үйлс 2:28-ыг үз.) Үйлс 2:38-ыг итгэлийн дөрөвдүгээр тунхаг, 3 Нифай 27:19–20-той ангийн гишүүдээр харьцуулуул. Сайн мэдээний үндсэн зарчмууд ба ёслолууд нь бүхий л эрин үед нэгэн адил байдаг гэдгийг цохон тэмдэглэ.
- 3000 орчим хүн Петрийн үгэнд итгэж, усаар батлуулдаг. Эдгээр хүмүүс Есүс Христийн сайн мэдээгээр өөрчлөгдсөнөө хэрхэн харуулсан бэ? (Үйлс 2:41–47-г үз. Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич.) Тэдний жишээнээс бид юу сурч болох вэ?

3. Петр, Иохан хоёр Есүс Христийн хүч чадлаар доголлон хүнийг эдгээдэг.

Үйлс 3–4-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Та ангийн гишүүнээр Үйлс 3:1–11-ийг чангаар уншуулж болно.

- Ариун Сүмийн хаалганы дэргэд байсан доголлон хүнд өгөх мөнгө Петр, Иохан нарт байгаагүй ч гэсэн тэд түүнд юуг санал болгосон бэ? Ямар хүч чадлаар тэр хүн эрүүл болсон бэ? (Үйлс 3:6, 12–13, 16; 4:10-ыг үз.) Та амьдралдаа Есүс Христийн анагаах хүчийг хэрхэн мэдэрсэн бэ?
- Петр энэ гайхамшгийг Есүс Христийг гэрчлэх сайхан завшаан болгон хэрэглэдэг (Үйлс 3:12–26; 4:5–12). Христийг гэрчлэх ямар боломж бидэнд

бий вэ? Есүс Христийн гэрч байснаараа эсвэл бусад гэрчүүдийг сонсоод та нар хэрхэн адислагдсан бэ?

- Пристүүд болон Садукайчууд Петрийн номлолыг хэрхэн хүлээн авсан бэ? (Үйлс 4:1–3-ыг үз. Тэд Петр, Иохан хоёрыг баривчлуулдаг.) Олон түмэн номлолыг хэрхэн хүлээн авсан бэ? (Үйлс 4:4-ийг үз.) Энэ хоёр бүлэг хүмүүс нэг ижил номлолыг яагаад эрс өөрөөр хүлээн авсан гэж та нар бодож байна вэ? Сүмийн удирдагчдын үгсийг хүлээн авч байгаа маань бидний зүрх сэтгэлийн байдлын талаар юуг илчилдэг вэ?
- Эдгэрсэн хүнийг хажууд нь зогсож байгааг хараад пристүүд болон Садукайчууд гайхамшиг тохиосон гэдгийг эсэргүүцэж чадахгүй байсан (Үйлс 4:13–14, 16). Петр, Иохан нарыг шоронд хийх шалтгаан нэгэнт байхгүй байсан тул тэд оронд нь юу хийсэн бэ? (Үйлс 4:15–18-ыг үз. Иудейчүүдийн шашны удирдагчид цовдлолтын дараа Есүс болон түүний сургаал мартагдана гэж найдаж байсныг цохон тэмдэглэ. Төлөөлөгчдийг Есүс Христийн сайн мэдээг үргэлжлүүлэн номлоход Иудейчүүдийн удирдагч нар тэднийг зогсоохыг оролдсон.)
- Сайн мэдээг номлохоо зогсоохыг шаардахад Петр, Иохан нар пристүүд, Садукайчуудад юу гэж хариулсан бэ? (Үйлс 4:19–20-ийг үз.) Есүс Христийн гэрч байхад үүнтэй адил эр зориг шаардагдаж болох ямар байдал амьдралд чинь гардаг вэ?
- Петр, Иохан нар суллагдсаныхаа дараа Сүмийн гишүүд дээр эргэн ирж тэдэнтэй хамт залбирдаг (Үйлс 4:23–30). Тэд залбиралдаа юу хүссэн бэ? (Үйлс 4:29–30-ийг үз.) Энэ залбирлын болон Төлөөлөгчдийн удаа дараагийн үйл хэргийн үр дүнд юу тохиолдсон бэ? (Үйлс 4:31–35; 5:12–16-г үз.)

4. Төлөөлөгчид агуу хүч чадлаар номлож, анагаасаар байдаг.

Үйлс 5:12–42-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Төлөөлөгчдийг үргэлжлүүлэн номлож, гайхамшигийг үйлдсээр байтал пристүүд болон Садукайчууд тэднийг шоронд хийдэг (Үйлс 5:17–18). Тэд шоронгоос хэрхэн суллагдсан бэ? (Үйлс 5:19–20-ийг үз.) Тэд суллагдсаныхаа дараа юу хийсэн бэ? (Үйлс 5:21, 25-ыг үз.) Төлөөлөгчид яагаад шоронгоос гарсныхаа дараа ч сайн мэдээг номлосоор байсан бэ?
- Төлөөлөгчдийг алахыг хүссэн Иудейчүүдийн удирдагчдад Гамалиел юу гэж зөвлөсөн бэ? (Үйлс 5:33–39-ийг үз.) Гамалиелын үгсийн үнэн байдлыг та ямар тохиолдлуудаар харсан бэ?
- Ариун Сүнсний бэлэг Төлөөлөгчдөд ямар өөрчлөлтийг авчирсан бэ? (Матай 26:47–56, 69–75-ийг Үйлс 4:5–21; 5:17–18, 26–42-той харьцуул.) Төлөөлөгчдийн жишээ биднийг үнэний гэрчүүд байхад хэрхэн урамшуулж чадах вэ?

Дүгнэлт

Төлөөлөгчид Ариун Сүнсний бэлгийг хүртсэнийхээ дараа Есүс Христийн хүчирхэг гэрчүүд болсон гэдгийг тайлбарла. Төлөөлөгчид Христийг гэрчлэх онцгой дуудлагыг авсан байхад Сүмийн гишүүн бүр бас түүнийг гэрчлэх үүрэгтэй байдаг. Ариун Сүнс бидэнд Христийг хэзээ, яаж гэрчлэхээ мэдэхэд тусалдаг гэсэн гэрчлэлээ хэл. Сүнсний хүчтэй нөлөөг дагавал итгэл

маань өсч, Сүнснийг мэдрэх чадвар маань дээшилж, бид Их Эзэн Есүс Христийн илүү үр нөлөөтэй гэрчүүд болно.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Көртландын Ариун Сүмийг онцгойлон адислах үед үзэгдсэн Ариун Сүнс

Үйлс 2:1–4 дээр гарсантай төстэй Ариун Сүнсээр дүүрэх байдал Көртландын Ариун Сүмийг онцгойлон адислах үеэр 1836 оны 3 сарын 27-нд болсон. (С ба Г 109:36–37, Бошиглогч Иосеф Смитийн тийм ихээр мэдрэхийг хүссэнээ илэрхийлсэн онцгойлох адислалын хэсгийг үз.) Дараа нь ангийн өөр нэг гишүүнээр хүсэлтээ хэрхэн илэрхийлснийг нь үзүүлэх дараах мэдэгдлийг уншуул:

Көртландын Ариун Сүмийг онцгойлон адисласан өдрийн цуглааны үдэш Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ, “Ариун Сүм дотор хүчит салхи салхилах мэт чимээгээр дүүрэхийг сонсоод Жорж А.Смит ах босоод бошиглож эхэлсэн бөгөөд цугларагсад бүгдээрээ үл үзэгдэх хүчээр түлхүүлэн нэгэн зэрэг босч; ихэнх нь олон хэлээр ярьж, бошиглож эхэлсэн; бусад нь гайхамшигт үзэгдэл үзэж; би Ариун Сүмийг тэнгэрийн элч нараар дүүрсэн байхыг хараад үүнийг цугларагсдад хэлсэн. Ойр зэргэлдээ байсан хүмүүс хамтдаа (Ариун Сүм дотор гарсан ер бусын дуу чимээг сонсож, мөн Ариун Сүмийн дээр гарч байгаа галан баганан хурц гэрлийг хараад) гүйлдэн ирж, юу болж байгааг хараад гайхаж хоцорсон” (*History of the Church*, 2:428).

2. “Бүхнийг сэргээх үе” (Үйлс 3:21)

Ангийн гишүүнээр Үйлс 3:20–21-ийг уншуул.

- Петр “бүхнийг сэргээх” талаар бошиглохдоо юуг урьдчилан хэлсэн бэ? (Тэр Бошиглогч Иосеф Смитээр дамжин ирэх Есүс Христийн сайн мэдээний хожмын үеийн дахин сэргээлтийг урьдчилан хэлсэн.)

3. “Тэдний бүх юм нь нийтийнх байв” (Үйлс 4:32)

Үйлс 4:32–5:11-ийг ярилц. Эртний Сүмийн гишүүдийн “бүх юм нь нийтийнх байсан” гэдгийг тайлбарла. (Үйлс 2:44; мөн Үйлс 4:32, 34–37-г үз.) Тэд хүн нэг бүрийн хэрэгцээг хангахын тулд байсан бүхнээ ариулдаг байв. (Та үүнийг Инохын хоттой [Мосе 7:18], Лихайн үр удамтай [4 Нифай 1:1–3], энэ эрин үеийн эртний Сүмийн гишүүдтэй [С ба Г 42:30–34] харьцуулж болно.)

- Эд хөрөнгөө ариулах энэ тогтолцоог Барнаб хэрхэн хүлээн авсан бэ? (Үйлс 4:36–37-г үз.) Энэ тогтолцоог Ананиа, Сапфир нар хэрхэн зөрчсөн бэ? (Үйлс 5:1–2-ыг үз.) Тэдний хийсэн зүйлийн талаар Петр Ананиа, Сапфир нарт юу гэж хэлсэн бэ? (Үйлс 5:3–4, 8–9-ийг үз.) Бид Бурханд шударга ханддаг гэдгээ хэрхэн баталж чадах вэ?
- Хэдийгээр бид албан ёсны ариулах тогтолцоог дагаж амьдардаггүй ч гэсэн биднийг Бурхантай болон бусад хүмүүстэй юугаа хуваалцахыг хүсдэг вэ? (Омнай 1:26; Мозая 4:16; С ба Г 4:2; 119:4-өөс зарим жишээг үз.) Бид заримдаа хэрхэн “өөртөө авч үлддэг” вэ?

Ахлагч Нил А.Максвэлл тайлбарлахдаа:

“Ананиа, Сапфир хоёр бүх зүйлээ өгч ариулахын оронд ‘заримыг нь өөрсөддөө үлдээдэг.’ (Үйлс 5:1–11-ийг үз.) Зарим нь Есүсийг гучин зоосоор хэзээ ч зарахгүй боловч, тэд бас Түүнд бүхнээ өгдөггүй!

“ . . . Ариулах явдлын талаар бодохдоо бид зөвхөн эд хөрөнгө, мөнгийг боддог. Гэвч өөртөө үлдээдэг олон янзын юмнууд байдаг. Цаг хугацаа, мөнгөө өгдөг нэг нь өөрийнхөө зориулах ёстой чухал зүйлээ өгдөггүй байж болно. Олны өмнө авъяасаа хуваалцдаг нэг нь дотроо тодорхой хэмжээний бардам сэтгэлийг хөгжүүлж байж болох юм. Бурханы сэнтийн өмнө өвдөг сөгддөггүй нэг нь харин дээд язгууртан хүний өмнө бөхийдөг байж болно. Сүмийн дуудлагыг хүлээн авдаг нэг нь дэлхий дээр тодорхой нэг үүрэг гүйцэтгэхэд зүрх сэтгэлээ өгдөг байж болох юм” гэжээ (Conference Report, Oct. 1992, 90; or *Ensign*, Nov. 1992, 66).

- “Өөртөө үлдээдэг” байдлаасаа бид хэрхэн салж чадах вэ? Өөртөө байгаа бүхнээ Их Эзэнд өгснөөр ямар адислалууд ирдэг вэ?

4. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Өсвөр насныханд заадаг багш нар “Асууж лавласан сургалтын” үйл явцыг хичээлийнхээ нэг хэсэг болгон хэрэглэж болно. Жишээлбэл, та “тийм”, “үгүй” гэж хариулах асуултуудыг ангийн гишүүдээр тавиулж хичээлийн сэдвийг тодорхойлохоор оролдуулж болно.

Зорилго

Ангийн гишүүд Сүмийн ажил хэргийг олон хүмүүс гүйцэтгэдэг бөгөөд тэд авъяас чадвар, гэрчлэлээ Сүмийг бэхжүүлэхэд хувь нэмэр болгон оруулдаг хэмээн ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Үйлс 6:1–7. Арван хоёр Төлөөлөгчид Сүмийн эд зүйлийг хариуцах ажлыг удирдан зохицуулах долоон хүнийг томилдог.
 - б. Үйлс 6:8–7:60. Уг долоогийн нэг Стефан Иудейчүүдийн дээд зөвлөлийн өмнө гэрчилдэг. Түүний үгсийг сонссон хүмүүс уурлаж, түүнийг хотоос гаргаж хаян, чулуу шиддэг.
 - в. Үйлс 8:4–40. Уг долоогийн бас нэг нь Филип гэгч Самарийн хотод номлож, гайхамшгийг үзүүлдэг. Тэрээр Етиопын тайган амбанд зааж, усаар баталдаг.
 - г. Үйлс 8:1–3; 9:1–31. Есүс Христийн тухай үзэгдэл үзэх хүртлээ Саул Сүмийг хавчдаг. Саул өөрчлөгдөж усаар батлуулан, сайн мэдээг номлож эхэлдэг.
 2. Нэмэлт Уншлага: Үйлс 22:1–16; 26:1–5, 9–18.
 3. Заахад зориулсан зөвлөмж: Та хувь хүн нэг бүрээс бүрдсэн ангид зааж байна гэдгээ сана. Тэд амьдралын туршлага, Сүмийн гишүүн болоод хэр удаж байгаа, сайн мэдээний номлол, зарчмуудыг ойлгох байдал, авъяас, чадвар, боловсрол эзэмших бололцоо байдлаараа их ялгаатай байж болно. Ангийн гишүүдийн ялгаатай талыг ойлгохыг хичээж, заагдаж байгаа үнэнийг хүн нэг бүрийг ойлгоход туслаарай.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүдээс асуу:

- Та нарын биеийн аль хэсэг нь хамгийн чухал гэж та нар бодож байна вэ? Яагаад?

Ангийн хэдэн гишүүнийг хариулсны дараа, асуу:

- Сүмийн аль гишүүн нь хамгийн чухал вэ? Яагаад?

Дахиад хэдэн гишүүний хариултыг сонс. Дараа нь ангийн гишүүнээр 1 Коринт 12:14–21-ийг уншуулж, өөр нэг гишүүнээр 1 Коринт 12:12–13-ыг уншуул. Эдгээр шүлэгт Төлөөлөгч Паул Сүмийн гишүүдийг биеийн хэсгүүдтэй харьцуулсан гэдгийг тайлбарла. Хөл, гар, чих, нүд гээд бүгд тус

тусын үүргээрээ ялгаатай ч чухал байдаг шиг Сүмийн бүх гишүүд өөр өөр ур чадвар, авъяасаараа чухал байдаг.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Сүмийн эд зүйлийг хариуцах ажлыг удирдан зохицуулах долоон хүнийг томилдог.

Үйлс 6:1–7-г уншаад ярилц. Төлөөлөгчдийн удирдлаган дор олон үндэстнүүд Сүмд шинээр элсэж, Сүм хурдацтай өссөн гэдгийг тайлбарла. Энэ нь агуу их баяр баясгаланг авчирсан хэдий ч, мөн зарим сорилтуудыг бий болгосон. Сүм өсөхийн зэрэгцээгээр Төлөөлөгчдөд Сүмийг удирдаж, Бурханы хаант улсыг байгуулахад туслах гишүүд хэрэгтэй болсон.

- Сүм өсөхийн зэрэгцээгээр заримдаа сүм доторх бүлгүүд хоорондоо санал зөрөлдөж байв. Зарим Грек гишүүд яагаад Еврей гишүүдийн эсрэг гомдол мэдүүлж байсан бэ? (Үйлс 6:1-ийг үз.) Сүмийн гишүүдийн хувьд бид үндэс угсаа, эдийн засаг, соёл эсвэл өөр бусад ялгаатай зүйлийн талаар хоорондоо байгаа санал зөрөлдөх байдал, хагарлыг хэрхэн үгүй хийж чадах вэ? Иймэрхүү хагарлыг үгүй болгох нь яагаад чухал вэ? (2 Нифай 26:33; С ба Г 38:26–27-г үз.)

Ерөнхийлөгч Ховард В.Хантэр хэлэхдээ: “Энэ нь Бурхан бол дэлхий ертөнцийн эцэг бөгөөд бүх хүн төрөлхтөн, тэднийг болон хоорондын харьцааг нь халамжлан анхаарах Бурханы анхаарал халамжинд маш их талархаж чадна гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрөх явдал юм. Энэ бол үндэс гарал, хэл, эдийн засаг буюу улс төрийн байр суурь, боловсрол, соёлын түвшин зэргээс үүссэн хавчигдмал уламжлалын эсрэг баттай зогсдог амьдрал, хайрын тухай захиас бичиг юм. Учир нь бид бүгдээрээ нэг л сүнслэг удамтай билээ. Бидэнд тэнгэрлэг удмын бичиг бий бөгөөд хүн нэг бүр Бурханы сүнсэн хүүхэд юм” гэсэн (Conference Report, Oct. 1991, 22; or *Ensign*, Nov. 1991, 18).

- Олон янзын гаралтай гишүүд нь Сүмийг хэрхэн баяжуулж, бэхжүүлдэг вэ? Бид нэг нэгнээсээ ялгаатай байвч, хэрхэн нэгдмэл байж болох вэ?
- Төлөөлөгчид сайн мэдээг заах цагаа маргааныг зохицуулж, өөр бусад цаг зуурын ажил хэрэгт зарцуулах ёсгүй гэж үзсэн (Үйлс 6:2). Тэд энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ? (Үйлс 6:3–6-г үз.) Сүмийн ажил хэргийг олон хүмүүст хуваалцах нь яагаад чухал вэ? Та нар Сүмд үйлчлэх боломжоор хэрхэн адислагдсан бэ?
- Сүм өсөхийн зэрэгцээгээр Их Эзэн бүтцийн ямар өөрчлөлт хийхийг хожмын үеийн Сүмийн удирдагч нарт илчилсэн бэ? (Хариултанд, Далын Чуулгыг нэмсэн эсвэл Сүмийг орон нутагт байгуулж, Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс ерөнхийлөн удирддаг болсон зэрэг орж болно.) Эдгээр өөрчлөлтүүд нь дэлхий даяарх Сүмийн гишүүдийн хэрэгцээг хангахад хэрхэн тусалсан бэ?

2. Стефан Иудейчүүдийн дээд зөвлөлийн өмнө гэрчилж, чулуугаар шидүүлж үхдэг.

Үйлс 6:8–7:60-ийг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь.

- Арван хоёр Төлөөлөгчдөд туслахаар дуудагдсан долоогийн нэг Стефаныг ариун нандин зүйлийг харааж зүхсэн хэмээн худал ял оноон баривчилж, Иудейчүүдийн дээд зөвлөлийн өмнө авчирдаг. (Үйлс 6:11–15; шаардлагатай бол нандин зүйлийг хараах гэдэг нь Бурхан эсвэл нандин зүйлүүдийг үл хүндэтгэх гэсэн үг гэдгийг тайлбарла.) Иудейчүүдийн дээд зөвлөлийн өмнө ирээд Стефан юу хийсэн бэ? (Үйлс 7:1–53-ыг үз. Тэр Израилчуудын түүхийн нэг хэсгийг ярьж өгдөг.)
- Израильчуудын түүхэнд Их Эзэний хийсэн агуу үйлийн талаар Стефан яагаад онцлон тэмдэглэсэн гэж та нар бодож байна вэ? Бид амьдралдаа Их Эзэний ажил хэргийг мартахгүй байхыг хэрхэн анхаарч болох вэ? Их Эзэнээс урьд өмнө нь авч байсан адислалаа санаж байх нь биднийг одоо итгэлтэй байхад хэрхэн тусалдаг вэ?
- Мөн Стефан яагаад Израильчууд Бурханыг удаа дараа мартаж, дуулгаваргүй байгаа тухай онцлон тэмдэглэсэн гэж та нар бодож байна вэ? Стефан өөрийг нь сонсож байгаа хүмүүсийг эртний дуулгаваргүй Израильчуудтай хэрхэн харьцуулсан бэ? (Үйлс 7:51–53-ыг үз.) Хүмүүс энэ хариуцлагыг хэрхэн хүлээн авсан бэ? (Үйлс 7:54-ийг үз.)
- Стефан ярьж дууссаныхаа дараа ямар үзэгдэл үзсэн бэ? (Үйлс 7:55–56-г үз.) Үзэгдлийнхээ тухай хүмүүст хэлтэл хүмүүс юу хийсэн бэ? (Үйлс 7:57–58-ыг үз.) Стефаны сүүлчийн үгс түүний шавь байх талаар нь юуг илчилдэг вэ? (Үйлс 7:59–60-ыг үз.)

3. Филип Самарийн хотод номлож, гайхамшгийг үзүүлдэг.

Үйлс 8:4–40-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Төлөөлөгчдөд туслахаар сонгогдсон долоогийн нэг нь болох Филип гэгч Самарийн хотод номлож, гайхамшгийг үзүүлдэг. Филипийн мэдээг сонсоод Самарийн хүмүүс хэрхэн хүлээж авсан бэ? (Үйлс 8:6–8, 12-ыг үз.) Эдгээр хүмүүс Ариун Сүнсний бэлгийг хэрхэн хүлээн авсан бэ? (Үйлс 8:14–17-г үз.)
- Самаричуудаас шинээр элсэгчийн нэг нь Симон гэгч илбэчин байсан. Илбийн аргаар үйлдэж байгаа зүйлсээ Симон хэний ач гэж үзсэн бэ? (Үйлс 8:9–11-ийг үз.) Төлөөлөгчид үйлдсэн гайхамшгаа хэний ач гэж үзсэн бэ? (Үйлс 4:7–10-ыг үз.) Энэ ялгаа нь яагаад чухал ач холбогдолтой вэ? (Бидний анхаарлыг татаж, шударга ёсны төлөө тэмцэлддэг хүмүүс олон байдаг бөгөөд үүнийг тэд өөрсдөдөө алдар хүнд олох гэж хийдэг гэдгийг цохон тэмдэглэ. Харин үүний эсрэгээр, Бурханы үйлчлэгчид алдар хүндийг Бурхандаа өгдөг. Энэ ялгааг ойлгох нь бидний амьдрал дахь олон нөлөөллийг дүгнэж үзэхэд бидэнд тусалдаг.)
- Төлөөлөгчдийг Ариун Сүнсний бэлэг хүртэж байгааг хараад Симон юу хийсэн бэ? (Үйлс 8:18–19-ийг үз.) Симоны хүсэлтийг Петр хэрхэн хариулсан бэ? (Үйлс 8:20–23-ыг үз.) Пристийн зэргийн хүч чадлыг хүлээн авах шаардлагыг хүн хэрхэн хангадаг вэ? (Еврей 5:4; С ба Г 121:36-г үз.)

Ерөнхийлөгч Жэймс И. Фауст хэлэхдээ: “Бүх хүч чадлаас хамгийн агуу нь болох энэ пристийн зэргийн хүч чадал бол дэлхий дээр хэрэглэгддэг хүч чадалтай адил замаар ирдэггүй. Үүнийг худалдан авч эсвэл худалдаж болдоггүй. . . . Дэлхийн хүч чадлыг ихэвчлэн хайр найргүйгээр хэрэглэдэг. Харин пристийн зэргийн хүч чадал нь зөвхөн пристийн зэрэгтний удирдлаган доорх зөв шударга байдлын зарчмуудаас ирдэг юм” гэсэн (Conference Report, Apr. 1997, 59–60; or *Ensign*, May 1997, 43).

- Филип Етиопын амбантай яаж тааралдсан бэ? (Үйлс 8:25–26-г үз.) Филип Сүнсийг дагасан учраас Филип болон Етиоп хүн хоёрт ямар адислалууд ирсэн бэ? (Үйлс 8:30–38-ыг үз.) Сүнсийг дагасны чинь хариуд танд (эсвэл таны мэддэг хэн нэгэн хүнд) ямар адислалууд ирсэн бэ?
- Етиопын тайган амбан нигүүлслийг хэрхэн үзүүлсэн бэ? (Үйлс 8:30–39-ийг үз.) Бурханы үгийг ойлгон хүлээн зөвшөөрөхөд нигүүлсэл бидэнд хэрхэн тусалдаг вэ?

4. Саул өөрчлөгдөн усаар батлуулж, сайн мэдээг номлож эхэлдэг.

Үйлс 8:1–3 ба 9:1–31-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Саул эртний Гэгээнтнүүдийг ямагт хавчин гадуурхаж байсан Фарисай хүн байсан гэдгийг тайлбарла. Тэрээр Стефаныг чулуугаар шидүүлж байхыг харсан (Үйлс 7:58) бөгөөд Сүмийн олон гишүүдийн үхэл, шоронд хоригдох явдлыг хариуцаж байсан (Үйлс 8:3; 22:4). Гэсэн ч тэр гайхалтайгаар өөрчлөгдөж, агуу номлогч болсон.

- Саулыг Гэгээнтнүүдийг хавчигч байхаас нь өөрчилж Их Эзэний агуу үйлчлэгч болоход юу нөлөөлсөн бэ? (Үйлс 9:1–9, 17-г үз.) Саул ИХ Эзэний дуу хоолойг сонсоод өөрчлөгдсөн гэдгийг цохон тэмдэглэ. Бид ИХ Эзэний дуу хоолойг хэрхэн сонсож чадах вэ? (С ба Г 1:38; 6:23; 8:2; 18:34–36-г үз.) Түүний дуу хоолойг сонсох нь биднийг өөрчлөгдөхөд хэрхэн тусалдаг вэ?

Ангийн гишүүдэд өөрчлөгдөлт нь Саулынх шиг гэнэтийн гайхалтай явдал бус ихэвчлэн чимээгүй аажмаар болдог явдал юм гэдгийг сануул. Ахлагч Роберт Д. Хэйлз хэлэхдээ, “Тохиолдлоор хувь хүмүүст [Саулд тохиолдсонтой адил явдал] тохиолдож болдог, гэхдээ өөрчлөгдөлт нь ихэнхдээ суралцах явдал, залбирал, туршлага, итгэл нь гэрчлэлийг маань болон өөрчлөгдөлтөө нэмэгдүүлэхэд бидэнд тусалдаг шиг цаг хугацаа шаарддаг” гэсэн (Conference Report, Apr. 1997, 111; or *Ensign*, May 1997, 80).

- Ахлагч Эзра Тафт Бэнсон, Паулын “Их Эзэн минь, та надаар юу хийлгэх вэ?” гэсэн асуулт нь энэ амьдралдаа бидний асууж болох хамгийн чухал асуулт юм гэж хэлсэн (Conference Report, Oct. 1972, 53; or *Ensign*, Jan. 1973, 57). Бид энэ асуултыг тавих нь яагаад чухал вэ? Өөрийнхөө төлөө Бурханы хүслийг биелүүлснээр та нар хэрхэн адислагдсан бэ?
- Ананиа Саултай уулзахаас яагаад цааргалсан бэ? Үйлс 9:10–14-ийг үз.) Түүний урьдчилан хэлснийг Ананиа яагаад үл тоомсорлон явсан бэ? (Үйлс 9:15–16-г үз.) Бид Ананиагийн үйлдлээс юу сурч болох вэ? (Хариултанд, Бурханы хүссэн ямар ч зүйлийг хийх эр зоригийг тэр бидэнд өгдөг бөгөөд хэдийгээр сэтгэл санааны дэмжлэгээс илүү зүйл хэрэгтэй байсан ч бид хүнд туслахаас хэзээ ч шантрах ёсгүй гэдэг нь орж болно.)
- Ананиа Саулын төлөө юу хийсэн бэ? (Үйлс 9:17–18-ыг үз.) Саул усаар батлуулсныхаа дараа юу хийсэн бэ? (Үйлс 9:19–22, 26–29-ийг үз.) Нэгэнт

Есүс Христийн сайн мэдээгээр өөрчлөгдсөн бол бид ямар үүрэг хариуцлагыг хүлээдэг вэ? (Лук 22:32; Иохан 8:31; Мозая 18:8–10; С ба Г 88:81-ийг үз.)

Дүгнэлт

Бид Стефан, Филип, Саул нарын адил Сүм хурдацтай хөгжиж байгаа цаг үед амьдарч байгаа гэдгийг цохон тэмдэглэ. Их Эзэн бид бүгдийг түүний хаант улсыг цэцэглэн хөгжихөд нь үйлчлэхийг хүсдэг гэдгийг гэрчил. Хэсэг буюу салбар бүрийн гишүүдийн Их Эзэний үйлчлэлд хувь нэмэр оруулдаг янз бүрийн чадвар, авъяас, тохиолдлуудыг ойлгож хүндэтгэхэд ангийн гишүүдийг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Бурантаглуулахгүйн тулд тийрэх нь хэцүү байдаг” (Үйлс 9:5)

- Үйлс 9:5-ыг ангийн гишүүнээр уншуул. “Бурантаглуулахгүйн тулд тийрэх нь хэцүү байдаг” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Чиглэл буюу зааврыг эсэргүүцэх. Амьтдыг хурдан эсвэл тодорхой нэг чиглэлд хөдөлгөхийн тулд зарим үед шовх үзүүртэй саваагаар хатгадаг. Хэрэв амьтан энэ саваа уруу тийрвэл энэ нь уг амьтныг улам илүү өвтгөдөг.) Саулын үзэгдэл үзэхээс өмнөх үйлдэл нь хэрхэн хор нөлөөтэй байсан бэ? Бид үнэний эсрэг тэмцсэнээр өөрсдийгөө хэрхэн өвтгөдөг вэ?

2. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Дараах үгсийг үгийн хайчилбар эсвэл самбарт бич: *Ананиа, эрх мэдэл, нүгэл хилэнц, нүд, Ариун Сүнс, гэрэл, номлох, хайрс, дүүгүй байх, чичрэх, сав, дуу хоолой.*

Үйлс 9:1–22-ыг ангийн гишүүдээр суралцуулж, Саулын өөрчлөгдөлтийн түүхэнд гардаг эдгээр үгсийн чухал ач холбогдол, дарааллыг тодорхойл. Дараа нь бүх үгийг хэрэглэн тэд нараар түүхийг яриул.

“Бурхан Нүүр Тал Хардаггүй”

Хичээл
30

Үйлс 10–14; 15:1–35

Зорилго

Ангийн гишүүд сайн мэдээ нь бүх хүмүүст зориулагдсан бөгөөд Сүм нь үргэлж илчлэлтээр удирдуулдаг гэдгийг таньж мэдэхэд туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Үйлс 10:1–11:18. Корнел үзэгдэл үзэж тэнгэр элчийг хардаг бөгөөд Талөөлөгч Петрийг авчруулахаар хүн илгээхийг түүнд хэлдэг. Петр үзэгдлээс Харь үндэстнүүдэд (Иудей бус хүмүүс) сайн мэдээг номлох ёстойгоо мэддэг. Тэрээр Корнел болон түүний гэр бүлийнхэн, найз нөхдөд заахаар Кайсари уруу явдаг. Ариун Сүнс Корнел болон бусад хүмүүс дээр ирж, тэд усаар батлуулдаг. Сүмийн зарим гишүүд Петрийг Харь үндэстнүүдэд заалаа гэж шүүмжилдэг боловч тэрээр үзсэн үзэгдлийнхээ тухай ярьж, тэд үүнийг нь Сүмийн илчлэлт хэмээн хүлээн зөвшөөрдөг.
 - б. Үйлс 12. Херод Хаан Иаковыг алуулж Петрийг шоронд хийдэг. Гэгээнтнүүд Петрийг суллуулахын төлөө залбирдаг бөгөөд Их Эзэний тэнгэр элч түүнийг чөлөөлдөг. Херодыг Их Эзэний тэнгэр элч цохиж, тэрээр үхдэг.
 - в. Үйлс 13–14. Саул (одоо Паул гэгддэг), Барнаб хоёр анхныхаа номлолын ажилд явж, Харь үндэстнүүдийн хэд хэдэн хотод Сүмийг байгуулдаг.
 - г. Үйлс 15:1–35. Зарим Иудей Гэгээнтнүүд Сүмд нэгдсэн Харь үндэстнүүд Мосегийн хуулийг мөн хөвч хөндөх ёслолыг мөрдөх ёстой гэж заадаг. Төлөөлөгчид Их Эзэн үүнийг шаардаагүй гэж тодорхойлдог.
2. Паулын анхны номлолын ажлыг харуулсан газрын зураг байгаа бол хичээлдээ хэрэглэж болно.
3. Заахад зориулсан зөвлөмж: Ахлагч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Танай оюутнуудад таны мэддэгээс илүү зүйл хэрэгтэй. Тэд таны сүнслэг урмаар өлсөж, энэ л тэдэнд хэрэгтэй байдаг. Тэд халуун дотно харьцааг хүсдэг. Энэ нь үргэлжид агуу багш хүний шинж байсан” гэсэн (Conference Report, Oct. 1965, 52; or *Improvement Era*, Dec. 1965, 1124). Ангийн гишүүн бүрийг хайрлах хайраа хэрхэн хөгжүүлж, тэдэнд харуулж чадах талаар залбирч, бодож үз.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Дараах түлхүүр үгсийг нэг нэгээр нь өгч ангийн гишүүдийг эдгээр нь Сүмийн түүхэн дэх ямар чухал ач холбогдолтой үйл явдалд холбоотой болохыг нь тодорхойлохыг хүс:

1. Илчлэлт
2. 1978 оны 6-р сарын 8
3. Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл
4. Пристийн Зэрэг
5. Албан Ёсны Тунхаг 2

Албан Ёсны Тунхаг 2 (Сургаал ба Гэрээний төгсгөлд бий)-т Сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүдэд пристийн зэргийг өгөх болсон илчлэлтийг бичиж тэмдэглэсэн байдаг.

Ангийн гишүүдээс илчлэлтийг тунхагласан үеийг санаж байвал энэ тухай сонсоод ямар сэтгэгдэлтэй байснаа тайлбарлахыг урь.

- Сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүдэд пристийн зэрэг авах боломжийг хэн бий болгосон бэ? (Их Эзэн.) Их Эзэн өөрийн хүслээ яаж Сүмийнхэнд мэдэгдсэн бэ? (Тэр бошиглогчдоо илчилж, бошиглогч нь дараа нь Сүмийн гишүүдэд зарласан.) Энэ илчлэлт Сүмд яаж нөлөөлсөн бэ?

Энэ илчлэлт нь Их Эзэн хэрхэн Сүмээ илчлэлтээр дамжуулан удирдсаар байгаагийн жишээ юм. Энэ хичээлд Есүс Христийн Дахин Амилалтын дараахан Сүмийн гишүүдэд өгөгдсөнтэй адил төстэй илчлэлтийн талаар ярилцана.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судруудыг заахдаа Их Эзэний Сүмдээ өгч байгаа илчлэлтийн чухал ач холбогдлыг онцлон тэмдэглэ. Үргэлжлэн ирсээр байгаа илчлэлтийн тухай гэрчлэлээ хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Петр үзэгдлээс Харь үндэстнүүдэд сайн мэдээг номлох ёстойг мэддэг.

Үйлс 10:1–11:18-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг уншихыг урь.

- Корнел ямар хүн байсан бэ? (Үйлс 10:1–2, 30–31-ийг үз.) Тэр Бурханд итгэдэг зөв шударга хүн байсан боловч Харь үндэстэн, өөрөөр хэлбэл Иудей хүн биш байсан.) Тэнгэр элчийн Корнелд авчирсан мэдээ нь юу байсан бэ? (Үйлс 10:3–6-г үз.) Энэ мэдээг сонсоод Корнел яасан бэ? (Үйлс 10:7–8, 33-ыг үз.) Бурханы заавар эсвэл удирдамжийг аваад тэр дор нь ёсоор болгох нь яагаад чухал вэ?
- Корнелийн явуулсан хүмүүсийг Иоппа руу явж байхад Петр үзэгдэл үздэг (Үйлс 10:9–16). Петр энэ үзэгдэлдээ юу харсан бэ? (Үйлс 10:11–12-ыг үз.) Петрийг юу хий гэж хэлсэн бэ? (Үйлс 10:13-ыг үз.) Петр яагаад татгалзсан бэ? (Үйлс 10:14-ийг үз. Тэр Мосегийн хуулийн дагуу бузар гэж тооцогдох амьтдыг идэхийг хүсээгүй.) Петрийн сэтгэлийг зовоосон зүйлд Их Эзэн юу гэж хариулсан бэ? (Үйлс 10:15–16-г үз.)
- Петр Корнелтой уулзаад зүүдээ ойлгов. Энэ нь ямар утгатай вэ? (Үйлс 10:28, 34–35-ыг үз.) Сайн мэдээ нь зөвхөн Иудейчүүдэд бус бүх хүмүүст зориулагдсан. “Бурхан нүүр тал хардаггүй” гэдэг нь Бурхан хүн бүрт авралын төлөвлөгөөний дагуу адислалуудыг хүлээн авах боломжийг олгоно гэсэн утгатайг тайлбарла. Зүүдэнд харь үндэстнүүдийг яагаад бузар амьтдаар төлөөлүүлсэн бэ? (Иудейчүүд Харь үндэстнүүдийг

Мосегийн хуульд Иудейчүүдийн идэхийг хориглосон амьтадтай адил сүнсээрээ зохистой бус буюу ариун бус гэж боддог байсан. Зүүдэнд гарсан амьтад одоо “цэвэр” болсон гэж Их Эзэн Петрт хэлэхдээ тэрээр сайн мэдээг бүх хүмүүст номлох ёстой тухай хэлж байсан.)

- Петр зүүднийхээ тухай тайлбарлаж дуусаад Корнел болон түүний найзуудад зааж эхэлдэг. Тэдэнд заасан анхны номлолдоо тэр юу заасан бэ? (Үйлс 10:36–43-ыг үз.) Петрийг номлож байхад юу болсон бэ? (Үйлс 10:44, 46-г үз.) Энэ нь Корнел болон түүний найзууд усаар батлуулах ёстой гэдгийг яагаад Петрт итгүүлсэн бэ? (Үйлс 10:47–48; мөн Үйлс 11:15–17-г үз.)
- Петрийг Харь үндэстнүүдэд сайн мэдээнээс зааж байгааг Сүмийн зарим гишүүд сонсоод яасан бэ? (Үйлс 11:1–3-ыг үз.) Эдгээр гишүүд яагаад сэтгэлээр унасан бэ? (Тэд Харь үндэстнүүдийг Бурханы сонгосон хүмүүсийн нэг хэсэг байхыг хүлээн зөвшөөрөөгүй.)
- Петрийн үзэгдэл болон Корнелд тохиолдсон явдлыг Петр хэлэхэд Сүмийн гишүүдийн бодол санаа яаж өөрчлөгдсөн бэ? (Үйлс 11:4–18-ыг үз.) Бид Сүмийн удирдагчдаас шинэ зааварчилгаа аваад хэдийгээр зааварт нь дургүй эсвэл тэдгээрийг ойлгоход хэцүү байсан ч юу хийх ёстой вэ? (Иохан 7:17; 2 Нифай 28:30; С ба Г 6:11, 14–15.)
- Яагаад Петр Харь үндэстнүүдэд сайн мэдээг заах илчлэлтийг авах болсон бэ? (Тэр үед Петр Сүмийн удирдагч байсан.) Өнөөдөр Сүмд хэн илчлэлт хүлээн авдаг вэ? Сүмд илчлэлт хүлээн авдаг ганц л хүн байх нь яагаад чухал вэ? (С ба Г 43:2–6-г үз.)

2. Петр гайхалтайгаар шоронгоос суллагддаг.

Үйлс 12-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Херод Хаан Төлөөлөгч Иаковыг агуулж, Петрийг шоронд хийж, хатуу чанд хорионд оруулав (Үйлс 12:1–4). Петрийг шоронд хориход Сүмийн гишүүд яасан бэ? (Үйлс 12:5) Залбирал маань бошиглогч, Сүмийн бусад удирдагчдад өнөө үед хэрхэн тусалж чадах вэ? (С ба Г 43:12; 93:51, 107:22-ыг үз.)

Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит мэдэгдэхдээ, “Сүмийн бүх хүмүүс түүний үйлчлэгчдийг дэмжин Их Эзэнд дуу хоолойгоо өргөн залбирахгүй нэг ч өдрийг өнгөрөөх ёсгүй” гэжээ (*Gospel Doctrine* 5th ed. [1939], 223).

- Петр шоронгоос яаж зугтсан бэ? (Үйлс 12:6–10-ыг үз.) Өөр ямар үед Их Эзэн хэн нэгний амьдралыг газар дэлхий дээрх номлолоо дуустал нь гайхалтайгаар хамгаалсан бэ? (Сударт гардаг жишээнд Даниел; Шадрах, Мешах, Абеднего гурав; Абинадай; Алма ба Амюлек; мөн Иосеф Смит нар ордог.)
- Петрийг зугтсаны дараа Херод Хаанд юу тохиолдсон бэ? (Үйлс 12:21–23-ыг үз.) Дараагийнх нь шүлэгт тайлбарласнаар Херодод тохиолдсон зүйлийг Сүмд тохиолдсон явдалтай харьцуул (Үйлс 12:24). Сүмийг устгахыг хичээж буй хүмүүсээс үл хамааран Сүмийг цэцэглэн хөгжихийг та хэрхэн харсан бэ?

3. Саул (одоо Паул гэгддэг), Барнаб хоёр Харь үндэстнүүдэд сайн мэдээг номлодог.

Үйлс 13–14-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Та газрын зураг хэрэглэж байгаа бол Паул, Барнаб хоёрын тухай ярихдаа тэдний очсон газрыг заа.

- Саул, Барнаб хоёрыг дуудсан нь Сүмийн гишүүдийг Бурханы үйлчлэлд хэрхэн дууддаг талаар юуг харуулж байна вэ? (Үйлс 13:1–3-ыг үз. Сүмд үйлчлэх гишүүдийг дуудахад залбирал, мацаг барилт, илчлэлт ба пристийн зэргийн эрх мэдэл хэрэгтэй байдаг тухай ярилц.) Сүмийн дуудлагат ажлууд нь Сүнсний илчлэлтээр ирдгийг мэдэхэд танд ямар явдал тусалсан бэ?
- Антиох дахь сүмийн захирагчид Паулыг Хүндэтгэлийн өдрийн үйлчлэл дээрээ ярихыг урив (Үйлс 13:14–15). Паулын ярьсан зүйлийн гол мэдээ нь юу байсан бэ? (Үйлс 13:23–31, 38–41-ийг үз.) Антиохын Харь үндэстнүүд номлогч нар болон тэдний мэдээнд юу гэж хариулсан бэ? (Үйлс 13:42–44-ийг үз.) Зарим Иудейчүүд яагаад Паул, Барнаб хоёрыг хавчиж байсан бэ? (Үйлс 13:45–47-г үз.)
- Паулыг төрөлхийн хөл нь мэдээгүй хүнийг эдгээхэд Лустрын хүмүүс яасан бэ? (Үйлс 14:8–13-ыг үз. Зевс, Хермес хоёр нь хүмүүсийн шүтдэг байсан хуурамч бурхад юм гэдгийг тайлбарла.) Паул Барнаб хоёрыг ийн магтаж, анхаарал тавьж байгааг тэд хэрхэн хүлээн авсан бэ? (Үйлс 14:14–18-ыг үз.) Бурханы үгийг заадаг жинхэнэ багш нар нь Бурханыг алдаршуулахад бүх анхаарлаа тавьж, өөрсдийгөө мартдаг гэдгийг цохон тэмдэглэ. Өнөөдрийн Сүмийн удирдагчид энэ чанарыг хэрхэн хадгалдгийг та нар яаж харсан бэ?
- Паул, Барнаб хоёрын зочилсон хот бүрт хүмүүс сайн мэдээг сонсохыг тэсэн ядан хүлээж байгааг тэд харсан боловч бас тэднийг хавчин гадуурхаж, бусдыг Сүмийн эсрэг босгон хутган үймүүлж байгаа хүмүүсийг харсан (Үйлс 13:43–45; 50; 14:1–6, 19). Хэдийгээр тэднийг хавчин гадуурхаж байсан ч гэсэн Паул, Барнаб хоёр яагаад тэдгээр хотууд уруу буцаж очсон бэ? (Үйлс 14:21–23-ыг үз. Тэд Сүмийн салбарыг хотуудад нээсэн байсан бөгөөд эдгээр салбаруудын шинэ гишүүдийг урамшуулж, зааварлахаар буцаж очдог байсан.) Бид салбар юмуу хэсгийнхээ шинэ гишүүдийг тэтгэж, дэмжихийн тулд юу хийж болох вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сануулахдаа: “Шинэ гишүүдийн тоо тогтмол өсч байгаа энэ үед бид тэднийг замаа олоход нь туслах гол зүтгэл чармайлтаа өсгөсөөр ёстой. Тэдэнд хүн нэг бүрт гурван зүйл хэрэгтэй байдаг: найз нөхөд, үүрэг хариуцлага, ‘Бурханы сайн үгээр’ тэжээгдэх юм (Моронай 6:4). Эдгээр зүйлүүдээр хангах нь бидний үүрэг мөн” гэжээ (Conference Report, Apr. 1997, 66; or *Ensign*, May 1997, 47).

4. Харь үндэстнүүд Мосегийн хуулийг дагах хэрэггүй гэж Төлөөлөгчид тодорхойлдог.

Үйлс 15:1–35-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Паул, Барнаб хоёр Иерусалим уруу ямар маргааныг шийдвэрлэхээр явсан бэ? (Үйлс 15:1–2-ыг үз. Хөвч хөндөх ёслол нь Мосегийн хуулийг бүхэлд нь бэлэгддэг байсан гэдгийг тайлбарла. Хөвч хөндүүлсэн эрэгтэй хүн уг хуулийг сахидаг байв. Хэдийгээр Есүс Христ Мосегийн хуулийг гүйцэлдүүлсэн ч, Иудейн зарим Христэд итгэгчид энэ хуулийг дагасаар

л байсан бөгөөд Харь үндэстэн шинээр элсэгчдийг мөн энэ хуулийг дагахыг хүсэж байсан.) Маргааныг хэрхэн шийдвэрлэсэн бэ? (Нухацтай ярилцсаны дараа Төлөөлөгчид илчлэлт авч ховч хөндөх шаардлагагүй гэж шийдсэн.)

- Үйлс 15:6–31-д гардаг үйл явдал Сүмийн бодлого, мөрддөг зүйлүүдийг яаж шийдвэрлэдгийг хэрхэн харуулсан бэ?
 - а. Сүмийн удирдагчид асуудлыг хэлэлцэхээр цуглардаг (шүлэг 6).
 - б. Тэд асуудлыг нухацтай ярилцдаг (шүлэг 7–21).
 - в. Тэд Их Эзэний хүсэлд нийцүүлэн шийдвэр гаргадаг (шүлэг 19–21).
 - г. Ариун Сүнс шийдвэрийг зөв болохыг нь баталдаг (шүлэг 28).
 - д. Шийдвэрийг Гэгээнтнүүдээр батлуулахын тулд тэдэнд зарладаг (шүлэг 22–31).

Дүгнэлт

Сүмийг үргэлж тэнгэрлэг илчлэлтээр удирдаж ирсэн бөгөөд тэр илчлэлт өнөөдөр ч бий гэдгийг гэрчил. Ангийн гишүүдийг амьд бошиглогч болон Сүмийн бусад удирдагчдын зөвлөгөөг дагахыг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэхүү санааг хичээлдээ хэрэглэж болно.

Дэлхийг хамарсан Сүм

Сүмийн хэрхэн хөгжиж байгааг ангийн гишүүдэд үзүүлэхийн тулд дэлхийн газрын зургийг үзүүл. Корнелийн цаг үеийн Сүмийн гишүүдийн амьдарч байсан газрыг заа (Одоогийн Израиль, Турк, Грек болон ойр орчмынх нь газрууд). Дараа нь Сүмийн гишүүдийн өнөөдөр амьдардаг газрыг ангийн гишүүдээр заалгуул. 1998 оны эхээр Сүм 162 улс орон болон бүс нутагт 10 сая гаруй гишүүдтэй байсныг тайлбарла. 57000 гаруй номлогч 116 улсад үндсэн 45 хэлээр болон өөр олон янзын нутгийн аялгуугаар ярьж ажиллаж байсан. (Саяхан хэвлэгдсэн Сүмийн сэтгүүлүүдээс шинэ тоо мэдээг олж авч болно.)

“Тийнхүү Сүм Итгэл Дээр Байгуулагдсан”

Үйлс 15:36–18:22; 1 ба 2 Тесалоник

Зорилго

Ангийн гишүүдэд сайн мэдээг хэрхэн хуваалцаж, Гэгээнтнүүдийн адилаар хэрхэн амьдрах тухай Паулын номлолоос сурч авахад туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Үйлс 15:36–41; 16; 17:1–15; 18:1–22. Харь үндэстэн шинээр элсэгчдийн талаарх маргаан намдаж, Мосегийн хуулийг шийдвэрлэсний дараа Паул, Барнаб хоёр удаах номлолын ажилдаа бэлтгэдэг. Тэд номлолын хамтрагч нар байх явдалтай санал зөрөлдөж салж явахаар болдог. Паул, Силас, Тимот хоёрын хамт номлолын ажлаа Македон, Грект эхэлдэг. Тэднийг байнга хавчиж мөрдөж байсан ч тэд олон хүмүүсийг элсүүлдэг.
 - б. Үйлс 17:16–34. Паул Афинд очиж, хотыг бүхэлдээ шүтээнээр дүүрснийг нь хардаг. Тэр Афины гүн ухаантнуудад гэрчилж, Арейпагийн дунд зогсож Бурханы мөн чанар, Бурханы үр удмын хувьд хүмүүс нэгдмэл байх болон Дахин Амилалтын тухай номлодог.
 - в. 1 ба 2 Тесалоник. Паул Македоны Тесалоник хотын Гэгээтнүүдэд хоёр захидал бичдэг. Тэрээр сайн мэдээг хуваалцаж, Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэн, Гэгээнтнүүдийн адилаар амьдрах талаар тэдэнд зөвлөдөг.
2. Нэмэлт Уншлага: 1 Коринт 2:4–5, 10–13.
3. Дараах материалууд байгаа бол хичээлдээ хэрэглэ:
 - а. Паулын хоёр дахь номлолын ажлын газрын зураг.
 - б. *New Testament Video Presentations* (53914)-ээс “The Second Coming” гурван минутын бичлэг.
4. Заахад зориулсан зөвлөмж: Ангийн гишүүд асуулт асууж, санал оруулж, туршлагаа хуваалцаж, гэрчлэлээ хуваалцах бэлтгэлтэйгээр ангидаа ирэх үүрэгтэй байдаг. Ангийн гишүүдийг судраасаа суралцан, өдөр бүр залбирч хичээлд бэлтгэхэд уриал. Ангийн гишүүдийн хичээлд оролцох оролцоог нь сонирхон анхаарч, талархсанаа илэрхийл.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Дараах түүхийг ярь:

1800-д оны сүүлчээр Солт Лэйк Ситид Хэйвүүдийн гэр бүлийнхэнтэй хамт амьдарч байхдаа Жон Морган нэгэн шөнө Жоржиагийн замаар аялж явна гэж зүүдлэв. Нэгдсэн Улсын Иргэний Дайны үед цэрэгт байхдаа энэ замаар үргэлж явдаг байсан болохоор зам нь танил байлаа. Тэрээр салаа замын уулзвар дээр ирж, тэнд Бригэм Янгийг зогсож байхыг харав. Баруун талын жим нь хот руу орж байсан ч Ерөнхийлөгч Янг түүнийг зүүн тал руу нь яв гэж хэлжээ.

Тэр үед Сүмийн гишүүн биш байсан Ноён Морган зүүднийхээ тухай Хэйвүүд эгчид хэлж, юу бодож байгааг нь асуув. Тэрээр түүнийг Сүмд орж, өрнөдийн муж улсад номлолд үйлчилж, нэгэн өдөр тэр зүүдэндээ үзсэн зам дээрээ зогсож байх болно гэдэгт нь итгэлтэй байгаагаа хэлэв. Мөн энэ явдлыг тохиолдоход тэр Бригэм Янгийн зөвлөснөөр зүүн тал руу нь явахаа санах ёстой байв.

Олон жилийн дараа Жон Морган усаар батлуулсныхаа дараа өрнөдийн муж улсад номлолд дуудагдаад, зүүдэндээ үзсэн тэр салаа зам дээр ирэв. Тэрээр зүүн талын замыг нь сонгох зөвлөгөөг санаж тийшээ явав. Цагийн дараа тэр олон жилийн өмнө тэр зүүдийг зүүдлэхдээ хамт амьдарч байсан гэр бүлийнхний нэрээр нэрлэгдсэн үзэсгэлэнт сайхан Хэйвүүдийн Хөндийн захад очсон байлаа.

Тэрээр хөндийг туулан сургаалыг номлохдоо хүмүүс нь сайн мэдээг сонсож хүлээн авахад сайн бэлтгэгдсэнийг олж мэдсэн. Түүний заахыг сонсоод хэд хэдэн гэр бүлүүд арван хоногийн өмнө нэгэн үл таних хүн тэр хөндийгөөр явж өнгөрөхдөө Библийн номон дээр чинь тэмдэглэгээ хийж болох уу гэж зөвшөөрөл эрж байсныг хэлэв. Тэр үл таних хүн өөр нэгэн элч ирж тэр тэмдэглэсэн хэсгүүдийг тайлбарлаж өгнө гэж хэлжээ. Жон Морган сайн мэдээг тэдэнд заахдаа тэдгээр тэмдэглэсэн хэсгүүдийг тайлбарлаж өгөв. Дараа долоо хоногт нь Ахлагч Морган хөндийд амьдардаг хорин гурван гэр бүлийн гурваас бусдад нь зааж, усаар баталсан. (Bryant S. Hinckley, *The Faith of Our Pioneer Fathers* [1956], 242–44.)

- Жон Морганыг номлолдоо амжилт олоход нь юу тус нэмэр болсон бэ? (Хариултанд, тэр шаргуу ажиллах хүсэлтэй байсан, тэр Сүнсний шивнээг сонссон, хүмүүсийн зүрх сэтгэл сайн мэдээг хүлээн авахад бэлтгэгдсэн байсан зэрэг нь орж болно.)

Энэ хичээл нь Жон Морган шиг Сүнсний шивнээг сонсож, номлолдоо амжилт олсон Төлөөлөгч Паулын тухай юм гэдгийг тайлбарла. Хоёр дахь номлолдоо байхдаа Паул олон янзын хавчлаганд орж байсан ч Есүс Христийн сайн мэдээг хүлээж авахаар бэлтгэгдсэн олон хүмүүсийг олдог.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Паулын хоёр дахь номлолын ажлын тухай заахдаа сайн мэдээг заах, сайн мэдээг сурахад өөрсдийгөө бэлтгэх, мөн гэрчлэлээ батжуулах талаар Паулаас юуг сурч болох талаар ярилц.

1. Паул, Силас, Тимот хоёртой хамт Македон, Грект номлодог.

Үйлс 15:36–41; 16; 17:1–15; 18:1–22-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг уншихыг урь. Та ангийнхандаа Үйлс номыг Лук бичсэн гэдгийг сануулж болно. Лук Паулын номлолын зарим нэг ажилд хамт явж байсан бололтой. Яагаад гэвэл тэр Паулын болон түүний номлолын хамтрагчийн тухай ярихдаа *бид* гэсэн үгийг үе үе хэрэглэсэн байдаг (Үйлс 16:10).

- Хоёр дахь номлолдоо Паул Филиппой, Тесалоник, Берой, Коринт, Афин зэрэг Македон, Грекийн олон хотуудаар явж номложээ. (Эдгээр хотуудыг газрын зураг дээр заа.) Сүнс Паул болон түүний хамтрагч нарыг аян замд нь хэрхэн удирдаж байсан бэ? (Үйлс 16:6–10; 18:9–11-ийг үз.) Их Эзэнд үйлчлэх зүтгэл чармайлтыг чинь Сүнс хэрхэн удирдсан бэ?

- Их Эзэн Лудиагийн зүрх сэтгэлийг нээсэн тул тэр Паулын үгийг сонсоод итгэсэн гэж сударт бичсэн байдаг (Үйлс 16:14–15). Сайн мэдээг хүлээн авахад “нээлтэй зүрх сэтгэл” яагаад хэрэгтэй байдаг вэ? (Мозая 2:9; С ба Г 64:34-ийг үз.) Их Эзэн сайн мэдээг хүлээж авахад тэдний зүрх сэтгэлийг (эсвэл тэдний таньдаг хэн нэгний зүрх сэтгэлийг) нээсэн тухай явдлаасаа ярихыг ангийн гишүүдээс урь.
- Паул болон түүний хамтрагч нар яагаад Туатэйрт шоронд орсон бэ? (Үйлс 16:16–24-ийг үз.) Тэд яаж суллагдсан бэ? (Үйлс 16:25–26-г үз.) Тэд номлолынхоо ажилд энэ тохиолдлыг хэрхэн сайхан завшаан болгосон бэ? (Үйлс 16:27–34-ийг үз.) Сүмийн түүхэнд эсвэл таны амьдралд хавчлага гадуурхлаас сайн зүйл ирсэн өөр ямар жишээ байгаа вэ?
- Паул Хүндэтгэлийн гурван өдрийг сүмд өнгөрөөхдөө Тесалоникийн хүмүүст юу заасан бэ? (Үйлс 17:1–3-ыг үз.) Паул Тесалоникт зааснаар ямар үр дүнд хүрсэн бэ? (Үйлс 17:4–10-ыг үз.)
- Беройн сүмийн хүмүүс Паулын номлолыг хэрхэн хүлээн авсан бэ? (Үйлс 17:10–12-ыг үз.) Бид сайн мэдээг сурахдаа хэрхэн “уужим сэтгэлтэй” байж чадах вэ?

2. Паул Арейпагийн дунд зогсож Афины гүн ухаантнуудад номлодог.

Үйлс 17:16–34-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Паул Беройгоос явсныхаа дараа тэр үедээ дэлхийн соёлын төв байсан Афинд ирсэн. Гүн ухаантнууд Бурханыг бидний сүнсний Эцэг гэхээсээ илүү хийсвэр биет юмуу хүч гэж үздэг байв. Тэд Бурханы бүтээлүүдийг Бурханаас өөрөөс нь илүүтэйгээр шүтэж байсан. Тэд илчлэлтийг учир шалтгаан, маргаанаар сольж, хүний мэргэн ухааныг Бурханы үнэнээс дээгүүр тавьдаг байв.

- Афины гүн ухаантнууд “цагаа юунд ч биш, харин ямар нэг шинэ зүйл ярьж эсвэл сонсоход зориулдаг” байв (Үйлс 17:21). Энэ байдал өнөөдөр яаж илэрхий харагддаг вэ? Үргэлж “ямар нэгэн шинэ зүйлийг” эрэлхийлэхийн аюул юу байж болох вэ?
- Паул Афинчуудад Бурханы тухай юу гэж заасан бэ? (Үйлс 17:22–31-ийг үз.) “Бид Бурханы үр удам” гэдгээ мэдэх нь яагаад чухал вэ? (Үйлс 17:28). Бурханы жинхэнэ мөн чанар болон бидний Эцэг болох түүний үүргийг ойлгох нь түүнийг хайрлаж, шүтэхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Паул гүн ухаантнуудын учир шалтгаанд бидний Эцэг, Бурханыг чин сэтгэлээсээ гэрчилж хариу өгдөг. Сайн мэдээг заахад учир шалтгааныг нь тайлбарлаж хэлснээс чин сэтгэлээсээ гэрчилсэн нь илүү их итгэл үнэмшлийг яагаад төрүүлдэг вэ? (1 Коринт 2:4–5, 10–13-ыг үз.)
- Гүн ухаантнууд яагаад Паулыг сонссон бэ? (Үйлс 17:18–21-ийг үз.) Энэ шалтгаан нь Паулын мэдээлэлд хариу үзүүлсэн тэдний хандлагад хэрхэн нөлөөлсөн гэж та нар бодож байна вэ? (Үйлс 17:32–33-ыг үз.) Сүмийн удирдагчдын үгийг сонсож, ойлгоход бид өөрсдийгөө хэрхэн бэлтгэж чадах вэ?

3. Паул Тесалоникийн Гэгээнтнүүдэд зөвлөн захидал бичдэг.

1 ба 2 Тесалоникоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Тесалоникийн Гэгээнтнүүдийн төлөө Паулын санаа зовж байсан боловч тэдэн рүү буцаж очин зочлох боломжгүй байсан учраас тэр Тимотыг тэдэн рүү явуулдаг (1 Тесалоник 2:17–18; 3:1–2, 5–7-г үз.) Тимотыг буцаж ирсний дараа Паул Тесалоникийн Гэгээнтнүүдэд зөвлөж, урамшуулсан хоёр захидлыг бичсэн. Сүмийн шинэ гишүүдийн төлөө Паулын зориулсан хичээл зүтгэлээс бид юу сурч болох вэ?
- 1 Тесалоник 1:5 ба 2:2–12 дээр Паул сайн мэдээг бусдад хэрхэн заах тухай юу заадаг вэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич.) Эдгээр зарчмуудыг дагах нь таныг сайн мэдээг заахад яаж тусалсан бэ?
- Тесалоникийн Гэгээнтнүүдийн ямар эргэлзээ нь Хоёр дахь Ирэлтийн тухай Паулын тайлбарласанд нөлөөлсөн бэ? (Тесалоник 4:13–18; 5:1–3-ыг үз.) Хоёр дахь Ирэлтээс өмнө юу болно гэж Паул Тесалоникчуудад хэлсэн бэ? (2 Тесалоник 2:1–4-ийг үз.) Энэ бошиг хэрхэн биеллээ олсон бэ? (С ба Г 1:15–16; 112:23; Иосеф Смитийн Түүх 1:19-ийг үз.)
- Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхийн тулд юу хийх ёстой гэж Паул Тесалоникийн Гэгээнтнүүдэд хэлсэн бэ? (1 Тесалоник 5:4–8-ыг үз.) Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхийн тулд бид юу хийх ёстой вэ?

Хэрэв та дүрс бичлэг хэрэглэж байгаа бол “The Second Coming” -ийг одоо үзүүл. Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхэд зориулсан Ахлагч Пакер, Ахлагч Максвелл нарын зөвлөгөөг товч ярилц, харин энэ нь хэзээ болох бол гэж бүү санаа зов.

- Гэгээнтнүүдийн адилаар амьдрах талаар Паул Тесалоникчуудад ямар зөвлөгөө өгсөн бэ? (1 Тесалоник 4:9–12; 5:11–22-ыг үз.) Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич. Бичсэн зарим зөвлөгөөнийхөө талаар Сүнсний удирдсаны дагуу ярилц. Ярилцлагандаа, бид зөвлөгөөг хэрхэн бүрэн дүүрэн дагаж чадах мөн үүнийг хийвэл бид хэрхэн адислагддаг тухай оруулж болно.

Дүгнэлт

Паулын заасан сайн номлогч, Хожмын Үеийн энэрэнгүй Гэгээнтнүүдэд байх ёстой шинж чанарын тухай үнэнийг гэрчил. Ангийн гишүүдийг эдгээр шинжүүдийг хөгжүүлэхээр эрэлхийлэхэд уриал. Тэгвэл тэд өөрсдийгөө болон бусдыг Их Эзэний Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхэд тусалж чадна.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэхүү санааг хичээлдээ хэрэглэж болно.

Сайн мэдээг зөв санаа өвөрлөн заах нь

Ангийн гишүүдээр 1 Тесалоник 2:2–3-ыг уншуул. Паул хэлэхдээ сайн мэдээг зоригтойгоор ов мэх хэрэглэхгүйгээр заах ёстой гэж хэлснийг цохон тэмдэглэ. Ахлагч Жэймс И. Талмаж бид бусад хүмүүсийн итгэл бишрэлийг шүүмжилж эсвэл дарамтлахгүйгээр үнэнийг зоригтой заах ёстой гэж нэмж хэлсэн. Үүнийг дүрслэн үзүүлэхийн тулд дараах түүхийг хуваалц.

Ахлагч Талмаж оюутан байхдаа нэг удаа сайн чанарын зул зарахыг санал болгох нэгэн эртэй тааралджээ. Ахлагч Талмаж өөрөө зултай байсан хэдий ч тэр худалдагчийг өрөөндөө оруулж зулаа асааж үзүүлэхийг зөвшөөрчээ.

“Бид миний өрөөнд ороод би үзүүрийг нь сайн засаж тэгшилсэн зуландаа шүдэнз зуран асаав. Зочин зулыг маань ихэд магтаж ийм төрлийн зулнаас хамгийн сайн нь бөгөөд ийм сайн засаж тэгшилсэн үзүүртэй зул хэзээ ч хараагүй гэж хэлэв. Тэрээр зулын голыг нааш цааш хөдөлгөж үзсэнээ маш төгс сайн хийгдсэнийг нь зарлан хэлэв.

Тэрээр “Одоо танаас зөвшөөрөл авч ‘Би өөрийнхөө зулыг асаая’ гээд зулаа цүнхнээсээ гаргаж ирэв. . . . Зул нь миний өрөөний хамгийн захын буланг ч гэсэн гэрэлтүүлж байлаа. Үүний хурц дөл миний зулын дөлийг сүүмийсэн мэт харагдуулж байв. Үүнийг надад үзүүлэх хүртэл би тийм гүн харанхуйд амьдарч, ажиллаж, суралцаж, тэмцэж байснаа мэдээгүй явсан юм.”

Ахлагч Талмаж шинэ зулыг худалдан авч, хожим нь тэрээр, бид сайн мэдээг заахдаа тэр зул худалдсан хүнээс юу сурч болох талаар зөвлөсөн юм. Тэрээр: “Зулаа зарж байсан хүн миний зулыг голоогүй. Тэрээр өөрийн хурц гэрлээ миний бүдэг гэрлийн дэргэд тавьж, би түүнийг нь авахаар яаравчилсан.

“Есүс Христийн Сүмийн номлогч үйлчлэгчид өнөөдөр хүмүүсийн итгэл бишрэлд халдан, доог тохуу хийх гэж явдаггүй, харин дэлхий ертөнцөд хүмүүсийн бүтээсэн сүсэг бишрэлийн дөлний сүүмэлзсэн бүдэг мананг харуулахын тулд агуу гэрлийг зэрэгцүүлэн асаахаар илгээгддэг” гэв (Albert L. Zobell Jr., *Story Gems* [1953], 45–48; мөн *The Parables of James E. Talmage*, comp. Albert L. Zobell Jr. [1973], 1–6-г үз.)

Үйлс 18:23–20:38; Галат

Зорилго Ангийн гишүүдэд Ариун Сүнсний хүчтэй мэдрэмжийг эрэлхийлж, энэхүү мэдрэмжийг хүлээн авахад нь саад хийх зан байдал, үйлдлээс зайлсхийхийг уриалах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Үйлс 18:23–19:41. Паул гурав дахь номлолын ажлаа эхэлдэг. Акул, Прискила хоёр сайн мэдээг Аполд заадаг. Паул Ефесийн итгэгчдэд зааж, усаар батлан Ариун Сүнсний бэлгийг хүртээдэг. Деметр болон бусад төмрийн дархчууд Ефесийн хүмүүсийг Паулын эсрэг босгодог.
 - б. Үйлс 20. Паул Ефесээс явж, Македон, Грект очиж заадаг. Тэрээр Иерусалим орохоор буцах замдаа Ефесээс ирсэн Сүмийн удирдагчидтай урвалт болохыг сэрэмжлүүлэн салах ёс гүйцэтгэх яриа өгдөг.
 - в. Галат. Паул Галатчуудыг Мосегийн хуулийг дахин мөрддөг болоход нь зэмлэсэн захидал бичдэг. Тэрээр Есүс Христэд итгэх итгэлийн чухлыг сануулж, тэднийг Сүнсний үр жимсийг эрэлхийлэхийг уриалдаг.
2. Паулын гурав дахь номлолын газрын зураг байгаа бол та хичээлдээ хэрэглэж болно.
3. Заахад зориулсан зөвлөмж: Таны амьдралд тохиолдсон явдлууд нь хамгийн сайн жишээ, түүхүүд байдаг. Танд тохиолдсон явдлуудаас алийг нь ангийн гишүүдтэй хуваалцахад зохицсон мөн хэрэгтэй байхыг мэдэхдээ тусламж эрж Сүнсэнд найд.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Өмнө нь хөгжүүлсэн боловч удаан хугацаагаар үүнийгээ Ашиглалтгүй байгаа хөгжмийн зэмсгээр тоглох, оёх, бичих эсвэл спортоор хичээллэх зэрэг авъяас, чадварынхаа талаар бодож үзэхийг ангийн гишүүдээс хүс. Тэднээс дараах зүйлүүдийг асуу.

- Та нар энэ авъяас, чадвараа өнөөдөр хэрэглэвэл дургүйцэх үү? Таны авъяас, чадвар хэр их сайн байгаа бол? Өмнөх шигээ энэ авъяас, чадвараа ашиглахын тулд та юу хийх хэрэгтэй вэ? (Ангийн гишүүд ямар ч авъяас, чадвараа бодож олж чадахгүй бол та өөрийн амьдралын жишээнээс ярилц.)

Ариун Сүнсний хүчтэй мэдрэмжийг таньж мэдэх нь сүнслэг авъяас, чадвар болж болох юм гэдгийг цохон тэмдэглэ. Энэ авъяасаа хэрэглэх тусам бид

үүндээ улам сайн болдог.

- Ариун Сүнсний хүчтэй мэдрэмжийг таньж мэдэх чадвараа бид хэрхэн хөгжүүлж чадах вэ? (Хариултанд, зөв шударгаар амьдарч, Ариун Сүнсний урамшууллыг эрэлхийлж, хүчтэй мэдрэмжийг мэдрэхдээ түүнийг дуулгавартай дагах зэрэг орж болно.) Энэ чадварыг бид өөрсөддөө хөгжүүлчихээд дараа нь үл ойшоож орхивол юу болох вэ?

Паулын гурав дахь номлолын ажил болон түүний Галатчуудад илгээсэн захидлын талаарх өнөөдрийн ярилцлаганд Ариун Сүнсний хүчтэй мэдрэмжийг дагах хэрэгтэй байдаг тохиолдлууд мөн ийн хийснээр бид хэрхэн адислагдах талаар ярилцлага орсон гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Ангийн гишүүдэд хэрэгтэй судрын хэсгүүд болон асуултуудыг залбиран сонго. Эдгээр судруудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Паул Ефесийн итгэгчдэд зааж, усаар баталж, мөн Ариун Сүнсийг хүртээдэг.

Үйлс 18:23–19:41-ийг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг уншихыг урь. Паул хоёр дахь номлолоос буцаж ирснийхээ дараа Антиохт хэсэг хугацааг өнгөрүүлээд дараа нь гурав дахь номлолдоо явдаг (Үйлс 18:22–23). Гурав дахь номлолынхоо үеэр тэр ихэнх хугацаагаа буюу бараг гурван жилийг Ефесчүүдэд номлож өнгөрүүлдэг. (Та газрын зураг хэрэглэж байгаа бол түүний гурав дахь номлолын ажлын тухай ярилцахдаа Паулын тухайн цагт явж байсан газруудыг заа.)

- Апол нь Баптисм хүртээгч Иоханаар усан баталгааны тухай заалгаж мэдсэн Иудей хүн байсан хэдий ч Ариун Сүнсний бэлэгний тухай мэддэггүй байв. Ефест байсан Акул, Прискила гэгч сүмийн хоёр гишүүн Аполын номлолыг сонсоод Аполд “Бурханы замыг улам зөвөөр” зааж өгсөн (Үйлс 18:26). Аполын ямар зан чанар нь түүнд заахад хялбар болгосон бэ? (Үйлс 18:24–28-ыг үз.) Эдгээр зан чанар нь түүнийг хэрхэн сайн багш болгосон бэ? Бид ийм чанарыг өөртөө хэрхэн хөгжүүлж чадах вэ?
- Зарим Ефесчүүдийг Ариун Сүнсний бэлгийг хүлээж авахад ямар сүнслэг үзэгдэл үзэгдсэн бэ? (Үйлс 19:6-г үз.) Өөр ямар үед иймэрхүү үзэгдлүүд үзэгдсэн байдаг вэ? (Үйлс 2:1–4; 10:44–46-г үз.) Төлөөлөгчид Пентекостын өдөр Ариун Сүнсний бэлгийг хүлээн аваад харийн хэлээр ярьж эхэлсэн. Кайсарид Паулыг Харь үндэстнүүдэд сайн мэдээг заах ёстой гэсэн үзэгдлийг хүлээн авсны дараа хэдэн Харь үндэстнүүд бас харийн хэлээр ярьсан. Өнөө үед Ариун Сүнс байнга ямар байдлаар үзэгддэг вэ? (Зарим жишээг С ба Г 6:15, 23; 8:2-оос үз; мөн Хаадын дээд 19:12-ыг үз.)
- Паул яагаад Ефес дэх сүмээс явж, Туранны сургуульд зааж эхэлсэн бэ? (Үйлс 19:8–9-ийг үз.) Эдгээр шүлэгт гарч байгаа *сургамжлан* гэдэг үг нь номлох эсвэл учир шалтгааныг нь тайлбарлах гэсэн утгатайг тайлбарла.) Сайн мэдээг шүүмжилж эсвэл эсэргүүцдэг хүмүүст бид яаж хандах ёстой вэ? (3 Нифай 11:29–30-ийг үз.)

Ахлагч Марвин Ж.Аштон заахдаа: “Бусдыг бидний байдалтай санал зөрөлдөхөд бид маргаж, зөрөлдөж эсвэл тэдэнтэй тэмцэх ёсгүй. . . . Харин

бид өөрсдийн энэ байдлаа учир шалтгааныг нь хэлж, нөхөрсгөөр ятган, үнэн зөв баримт ашиглан тайлбарлах ёстой. Мөн бид өнөөгийн маьдралын ёс суртахууны асуудлууд болон сайн мэдээний мөнхийн зарчмуудын талаар гуйвшгүй бат бэх үзэлтэй байх ёстой. Харин ямар ч хувь хүн, байгууллагатай бүү тэмцэлд. Маргаан нь хүмүүсийн дунд хана хэрэм, саад тотгор үүсгэдэг. Хайр үүдийг нээдэг. . . . Маргаан нь хэзээ ч хөгжил дэвшилд хүргэж байгаагүй, хүргэх ч үгүй” гэжээ (Conference Report, Apr. 1978, 10; or *Ensign*, May 1978, 7–8).

- Деметр болон бусад төмрийн дархчууд Паулын номлохыг сонсоод яагаад сэтгэлээр унасан бэ? (Үйлс 19:23–28-ыг үз. Тэд Арметисын сүм, хиймэл бурхад урлан зардаг байсан бөгөөд Паулыг хүмүүст Есүс Христийн сайн мэдээг заан өөрчилж, тэд үйлчлүүлэгчдээ алдаж байгаад санаа зовж байсан.) Эд баялаг эсвэл дэлхийн дур сонирхолдоо санаа тавих нь биднийг Бурханд үнэнч байхад хэрхэн нөлөөлдөг вэ? Ийм зүйлд санаа зовох байдал нь Сүнсний хүчтэй мэдрэмжийг мэдрэхэд бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Деметр болон мөнгөний дархчуудын зан байдлыг Есүс Христийг дагаж амьдарч эхлэхдээ ид шид үзүүлэхдээ хэрэглэдэг номоо хаясан Ефесчүүдийн зан байдалтай харьцуул (Үйлс 19:18–19). Дэлхийн эд хөрөнгөө хэрхэн зүй зохистойгоор хэрэглэж чадах вэ?

2. Паул Ефесээс ирсэн Сүмийн удирдагчдад салах ёс гүйцэтгэн яриа өгдөг.

Үйлс 20-иос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Паул Ефесээс явж, Македон, Грекээр аялан сайн мэдээг номлодог гэдгийг тайлбарла. Тэрээр Пентекостын Өдрөөр Иерусалимд буцаж очихоор төлөвлөдөг. Иерусалим уруу буцаж байхдаа тэр Сүмийн удирдагчдыг Милетэд ирж түүнтэй уулзахыг хүсэхээр Ефес рүү элч илгээдэг. Тэрээр сэтгэл хөдөлгөм яриа өгч салах ёс гүйцэтгээд, аянаа үргэлжлүүлдэг.

- Ефесийн ахлагч нартай сүүлчийн удаа уулзаж байгаага мэдээд Паул салах ёс гүйцэтгэхдээ юуг онцгойлон захисан бэ? (Үйлс 20:28–35-ыг үз.) Паулын сэрэмжлүүлэн хэлсэн “догшин чононууд” нь хэн байсан бэ? (Үйлс 20:29-ийг үз. Сүмийн эсрэг дайснууд.) Паул өөр хэний талаар сэрэмжлүүлсэн бэ? (Үйлс 20:30-ийг үз. Сүмээс урваж, бусад гишүүдийг уруу татахыг оролдож байгаа гишүүд.) Бид амьдралдаа урвалтаас хэрхэн хол байж чадах вэ?
- Паул Ефесийн ахлагч нарт Сүмийн гишүүдийг Сүмээс холдуулан уруу татахыг оролдох хүмүүсээс хамгаалахад туслахын тулд юу хийх ёстой гэж хэлсэн бэ? (Үйлс 20:28; мөн Иохан 21:15–17-г үз.) Бид Бурханы сүргийг хэрхэн “догшин чононуудаас” хамгаалах вэ?
- Ефесийн ах нарт өгсөн яриагаа өндөрлөхдөө Паул тэдэнд Их Эзэний “авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй” гэж заасныг сануулсан (Үйлс 20:35). Та амьдралдаа үүнийг үнэн болохыг нь яаж мэдсэн бэ?

3. Паул Галатын Гэгээнтнүүдийг зэмлэж, зөвлөдөг.

Галатчуудад бичсэн Паулын захидлаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Паул гурав дахь номлолдоо байхдаа Мосегийн хуулийг дахин дагаж эхэлсэн Галатын олон Гэгээнтнүүдэд захидал бичсэн. Их Эзэн, Есүс Христэд итгэх итгэлийн оронд Мосегийн хуульд заасан үйлдлүүдийг хийснээр авралд хүрч

чадна гэдэгт итгэсэн тэдгээр хүмүүсийг зэмлэсэн.

- Мосегийн хууль ямар зорилгоор өгөгдсөн бэ? (Галат 3:23–26; Жэкоб 4:4–5; Мозая 13:29–30-ийг үз.) Их Эзэн Израильчуудад түүнийг дурсан санахад тусалж, түүний Цагаатгалаар дамжуулан авралыг хүлээн авахдаа бэлтгэг хэмээн энэ хуулийг өгсөн.) Мосегийн хуулийг хэрхэн гүйцэлдүүлсэн бэ? (3 Нифай 15:2–5; Алма 34:10; 3 Нифай 9:19-ийг үз.) Есүс олон хуулийн ёслолуудын бэлэгдэл болсон Цагаатгалаараа Мосегийн хуулийг гүйцэлдүүлсэн.
- Галатын Гэгээнтнүүд ЕсүсХристийн сайн мэдээг суралцсан дороо Мосегийн хуулийг дахин дагаж эхэлсэнд Паул гайхсан (Галат 1:6; 4:9). Мосегийн хуулийг ингэж дахин шүтсэн нь Их Эзэнд итгэх итгэл нь сул байгааг яаж харуулдаг вэ? (Галат 2:16; 3:1–5; 5:1–6-г үз.)
- Паулын цаг үед зарим хүмүүс Есүс Христийн сайн мэдээг өөрчилж, гажуудуулахыг оролддог байсан (Галат 1:7–8). Орчин үед үүний ямар баримт байна вэ? Сайн мэдээг гажуудуулахыг оролдож байгаа явдалд бид яаж хандах ёстой вэ?
- Галат 1:11–12-оос бид сайн мэдээний гэрчлэлийг хэрхэн олж авах талаар юу сурч болох вэ? Гэрчлэл маань Есүс Христээс ирдэг илчлэлтэнд тулгуурласан байх нь яагаад чухал вэ? (Та олон нийтийн харьцаа эсвэл оюун ухааны судалгаа шинжилгээ, итгэлийн сорилтыг давж чадахгүй байх зэрэг өөр суурин дээр тулгуурласан гэрчлэлийн тухай ярилцаж болно.)
- Паул Галатчуудад “махан биеийн үйлсийг” хийхгүй байхыг сэрэмжлүүлсэн. (Галат 5:19) Махан биеийн үйлс гэж юу вэ? (Галат 5:19–21-ийг үз.) Эдгээр үйлсийг хийснээс ирэх сөрөг үр дагавар нь юу вэ? (Галат 5:21-ийг үз.) Өнөөдрийн дэлхийд махан биеийн үйлс давамгайлж байгааг үл харгалзан амьдарч байгаа орчиндоо сүнслэг байдлыг улам илүү бий болгохын тулд та нар энэ долоо хоногт юу хийж болох вэ?
- Паул Сүнсний удирдамжаар амьдарч үр жимс, үр дүнг нь үзэхийг Галатчуудад уриалсан (Галат 5:16, 25). Эдгээр үр жимс нь юу вэ? (Галат 5:22–23-ыг үз.) Эдгээр үр жимс нь таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ? Эдгээр үр жимсийг амьдралдаа байхгүй байгааг мэдэрвэл бид юу хийх ёстой вэ?
- Хөршдөө хэрхэн хандах талаар Галатын Гэгээнтнүүдэд Паул юу гэж заасан бэ? (Галат 5:14; 6:2; мөн Мозая 18:8–10-ыг үз.) Бид хэрхэн “нэг нэгнийхээ ачаанаас үүрэлцэж” чадах вэ? Үүнийг хийх нь биднийг Есүс Христэд хэрхэн улам ойртуулах вэ?
- Паул “Бурхан элэг доог болохгүй” гэж хэлснээрээ ямар утга санааг илэрхийлсэн бэ? (Галат 6:7; мөн С ба Г 63:58-ыг үз.) Нэг утга нь Бурханыг дуулгавартай дагадаггүй, нүглээ наманчилдаггүй хүмүүс түүнийг тохуурхаж байгаа бөгөөд тэд шийтгүүлэх болно.) Өнөөдөр хүмүүс Бурханыг яаж элэг доог хийдэг вэ?
- “Хүн юу тарина түүнийгээ хурааж авна” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Галат 6:7–9-ийг үз.) Энэ зарчим Ариун Сүнсний хүчтэй мэдрэмжийг мэдэрч, дагах бидний чадвартай яаж холбогддог вэ? Энэ нь бусад хүмүүстэй харьцах бидний харьцаанд яаж хэрэглэгддэг вэ? Энэ нь бидний амьдралд өөр бусад нөхцөл байдалд хэрхэн хэрэглэгддэг вэ?

Дүгнэлт

Маргаан, ертөнцийн юмст санаа тавих, урвалт зэрэг зөв шударга бус чиг хандлага, үйлдлүүд нь биднийг Ариун Сүнсний хүчтэй мэдрэмжийг хүлээн авахаас холдуулна гэдгийг гэрчил. Гэхдээ бид хүлээн авдаг хүчтэй мэдрэмжүүдээ дагаж, зөв шударгаар амьдрахыг хичээвэл тэр хүчтэй мэдрэмжийг таньж мэдэж, дагах чадвараа хөгжүүлнэ. Ангийн гишүүдийг Ариун Сүнсний хүчтэй мэдрэмжийг эрэлхийлж, дагахад уриал.

Заах Нэмэлт**Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэхүү санааг хичээлдээ хэрэглэж болно.

Паулын адилаар сайн мэдээг заах нь

- Сайн мэдээг заах талаар бид Паулаас юу сурч болох вэ? (Үйлс 19:8–10, 21; 20:7–12, 18–24, 27, 31, 35–36-г үз. Мөн 31-р хичээлийн 1 Тесалоник 1:5 ба 2:2–12-ын ярилцлагыг үз.)

Ангийн гишүүдийн хариултыг самбарт бичээд, сургаалыг заахдаа бид Паулын жишээг хэрхэн дагаж чадах талаар ярилц.

Зорилго

Ангийн гишүүдэд Христийн дотор нэгдмэл байж, Сүнсний даган, ёс суртахуунаар цэвэр байхаас ирдэг адислалыг эрэлхийлэх урам хайрлах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад, эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 1 Коринт 1:10–13; 3:1–11. Паул Гэгээнтнүүдийг маргаанаас зайлсхийж, нэгэн сэтгэл, нэгэн шүүлттэй байхыг уриалдаг.
 - б. 1 Коринт 1:17–31; 2:1–16. Паул Гэгээнтнүүдэд мэргэн ухаан, дэлхийн гүн ухаанаас илүү Сүнсэнд найдахыг зөвлөдөг.
 - в. 1 Коринт 3:16–17; 5; 6:9–20. Паул Гэгээнтнүүдэд ёс суртахуунаар цэвэр байхыг уриалдаг.
2. Нэмэлт Уншлага: 1 Коринт 7–10.
3. Заахад зориулсан зөвлөмж: Ахлагч Боид К.Пакер зөвлөхдөө: “Хүн болгон сайн зан чанартай байдаг гэдгийг багш нар ойлгох нь нэн чухал юм. Мөн тэд зөв зүйлийг хийх хүсэлтэй байдгийг мэдэх нь чухал. Ийм өөдрөг бодолтой байх нь итгэлийг бэхжүүлдэг. Өөрсдийн хүүхдүүдийн өмнө зогсох нь залуу хүмүүсийн өмнө заахаар зогсохоос огт өөр зүйл байдаг” гэсэн (*Teach Ye Diligently* [1975], 73).

**Хичээл Заах
Зөвлөмж**

**Анхаарал Татах
Ажиллагаа**

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Самбарт зам зураад, энэ зам дээрээ машин юмуу тээврийн хэрэгсэл зур. Тэгээд Ахлагч Иосеф Б.Ворфлингийн өгүүлсэн дараах явдлыг хуваалц:

“Тэнгэр дуугарч, цахилгаан цахилсан ширүүн бороотой нэгэн үдэш Ворфлин эгч бид хоёр уулын замаар явж байхдаа замынхаа урд, баруун, зүүн талуудыг арай гэж харж байв. Бид зам дээрх хоёр цагаан шугамыг урьд урьдаас илүү анхааралтай харж явав. Шугамыг дагах нь биднийг замаасаа гарахгүй байж, нэг талд байгаа гүн хавцал уруу унахаас, мөн нөгөөтэйгүүр урдах машинтайгаа мөргөлдчихгүй явахад тусалж байлаа. Хоёр талын шугамнаас гарвал аюулд өртөх байв. Дараа нь би, ‘Зөв бодолтой хүн аюул тулгарна гэдгийг мэдсэн бол замын шугамны хоёр тал уруу хазайж орох болов уу? Хэрэв тэр мөнх бус амьдралаа үнэ цэнэтгэйд тооцдог бол мэдээж энэ хоёр шугамны хооронд л үлдэнэ’ гэж бодлоо.

“Энэ уулын замаар аялсан явдал нь яг л амьдралтай адил юм. Хэрэв бид Бурханы зурсан шугамнуудын хооронд үлдвэл тэр биднийг хамгаалж, бид зорьсон газартаа аюулгүй хүрнэ” (*Conference Report*, Oct. 1990, 80; or *Ensign*, Nov. 1990, 64).

Паулыг Коринтын Гэгээнтнүүдэд анхны захидлаа бичих үед тэдний зарим нь сайн мэдээний шугамнаас хазайж эхэлсэн байсан. Энэ хичээлд Паул Гэгээнтнүүдийг замаасаа хазайхад хүргэсэн гурван зүйлээ наманчлахыг уриалсан тухай ярилцана. Самбарт тээврийн хэрэгслийг замаасаа хазайн явж байгааг харуулсан гурван шугам зур. Эхний шугамны төгсгөлд *Маргаан ба нэгдмэл бус байдал* гэж бич. Хоёрдугаар шугамны төгсгөлд *Ертөнцийн мэргэн ухаанд найдах* гэж бич. Гуравдугаар шугамны төгсгөлд *Үхэшгүй байдал* гэж бич.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгийг заахдаа Паулын зөвлөгөө өнөө үед яаж хэрэглэгддэг мөн бид энэ сургаалыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар ярилц.

1. Маргаанаас зайлсхийж, нэгдмэл бай.

1 Коринт 1:10–13; 3:1–11-ийг уншаад ярилц.

- 1 Коринт 1:10–13-г Паул ямар асуудлын талаар ярьсан бэ? Гэгээнтнүүдийн зарим нь “Паулынх,” зарим нь “Аполлынх,” зарим нь “Сефасынх (Петр),” зарим нь “Христийнх” гэгдэхийг оролдсон нь ямар утгатай вэ? (Есүс Христийн дагалдагч нарын хувьд нэгдмэл байхын оронд зарим Гэгээнтнүүд Сүм дотроо хэсэг, бүлэг болж хуваагдсан.) Бид заримдаа үүнтэй адил алдаа яаж гаргадаг вэ? Иймэрхүү байдлаар хуваагдах нь ямар сөрөг үр дагавартай вэ? Христийн шавь нарын хувьд бидний нөхөрлөлд хуваагдан, маргах нь ямар нөлөө үзүүлдэг вэ? (Мозая 18:21–22; 3 Нифай 11:29–30; С ба Г 38:27-г үз.)
- Улам нэгдмэл байхын тулд Гэгээнтнүүд юу хийх ёстой гэж Паул зөвлөсөн бэ? (1 Коринт 1:10-ыг үз. Ангийн гишүүн энэ шүлгийг уншихад Паулын зөвлөсөн болгоныг дор үзүүлснээр самбарт жагсааж бич.) Бид энэ зөвлөгөөг гэртээ болон Сүм дээр хэрхэн хэрэгжүүлж чадах вэ?
 - а. “Адилхан юм ярих.”
 - б. “Хоорондоо хагарал гаргахгүй” бай.
 - в. “Адил бодол, адил шүүлт дотор нягт нэгдэх.”
- Коринтын Гэгээнтнүүд яагаад зөвхөн сайн мэдээний “сүүг” нь авсан бэ? (1 Коринт 3:1–4-ийг үз.) Маргаан яагаад биднийг сайн мэдээний “махыг” авахад саад болдог вэ? Бид сайн мэдээний “махаар” тэжээлгэхийн тулд өөрсдийгөө хэрхэн бэлгэх вэ?
- Паул сайн мэдээний үйлдэгчид (үйлчлэгчид) олон байгаа хэдий ч Есүс Христ бол цорын ганц найдвартай суурь юм хэмээн заасан (1 Коринт 3:5–11). Аврагчийг итгэлийн сууриа болгох нь яагаад чухал вэ? (Хиламан 5:12-ыг үз.)

2. Ертөнцийн мэргэн ухаанд найдсанаас Сүнсэнд найд.

1 Коринт 1:17–31; 2:1–16-г ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг уншихыг урь.

- Паул, Бурханы мэргэн ухаан ертөнцийн мэргэн ухааныг “мунхаг болгодог” гэж заасан (1 Коринт 1:18–21). Бурханы мэргэн ухаан ертөнцийн мэргэн ухаанаас ямар ялгаатай вэ? (Исаиа 55:8–9; С ба Г 38:1–2-ыг үз.)

Бурханы мэргэн ухаан ертөнцийн мэргэн ухааныг мунхаг болгодог зарим ямар жишээ байдаг вэ?

- Шашны бус зүйлийг сурах нь ямар замаар биднийг адисладаг вэ? (Шаардлагатай бол *шашны бус* гэдэг нь шашингүй гэсэн үг гэдгийг тайлбарла.) Бид шашны бус зүйл болон сүнслэг зүйлүүдийг сурахаа яаж тэнцвэржүүлэх вэ? (2 Нифай 9:28–29-ийг үз.)

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл заахдаа: “шашны бус болон сүнслэг зүйлүүдийг хамтад нь сурах боломж бий. Хэрэв бид мөнх бус амьдралын өдрүүдээ сүнслэг зүйлүүдийг үл харгалзан шашны бус мэдлэгийг цуглуулахад зариулбал та хожим нь гарах гарцгүй болох тул энэ нь хүн Бурхантай уулзахдаа бэлтгэх цаг юм, мөн итгэлтэй болж, усан баталгааны үр дүн гарч, Ариун Сүнсийг хүлээн авч ёслолуудыг гүйцэтгэх цаг юм. Энэ хөтөлбөрийн зэрэгцээгээр шашны бус мэдлэгийг үхлийн дараа сүнслий дэлхийд ч гэсэн сүнснүүд маань суралцсаар байх болно” гэжээ (*The Teachings of Spencer W. Kimball*, ed. Edward L. Kimball [1982], 390).

- Паул Бурхан “мэргэдийг ичээхийн тулд ертөнцийн мунхаг юмсыг” сонгож, “хүчит юмсыг ичээхийн тулд ертөнцийн мөхөс юмсыг сонгожээ” гэж хэлэхдээ ямар утгаар хэлсэн бэ? (1 Коринт 1:27). Бурхан зорилгоо биелүүлэхийн тулд яагаад “ертөнцийн мөхөс юмсыг” сонгодог вэ?
- Паул сайн мэдээг заахдаа ямар мөхөс байдалтай тулгарч байсан бэ? (1 Коринт 2:1–3-ыг үз.) Түүний мөхөс байдал нь хэрхэн хүчирхэгжсэн бэ? (1 Коринт 2:2, 4–5-ыг үз.) Түүний ажлыг хийхэд тохирохгүй эсвэл хийхээс айж байсан үед Их Эзэн та нарт хэрхэн тусалсан бэ?
- Паулын хэлсний дагуу бид хэрхэн “Бурханы юмсыг” мэдэж чадах вэ? (1 Коринт 2:10–13-ыг үз.) Бид яагаад заримдаа Сүнснээс илчлэлт авахын оронд өөрсдийнхөө мэргэн санаа, оюун ухаанд илүү найддаг вэ? Сүнслий хүчээр сурч мэдэх, зөвхөн оюун ухааныхаа хүчээр мэдэж авах хоёрын хооронд ямар ялгааг та ажигласан бэ?

Ахлагч Брүс Р.МакКонки заахдаа: “Цэвэр шашин гэдэг бол ганц оюун ухааны зүйл бус, Сүнслий зүйл бөгөөд үүний үнэнийг Сүнслий хүч чадлаар сонсогч хүний сэтгэлд хүрдэг, үгүй бол хүмүүний бие сэтгэл өөрчлөгдөхгүй . . . ба авралыг эрэгч Христийн дотор амьд болдоггүй” гэжээ (*Doctrinal New Testament commentary*, 3 vols. [1966–73], 2:318).

- Паул “төрөлх хүн” Бурханы юмсыг хүлээн авахад боломжгүй байдаг гэж заасан (1 Коринт 2:14). Энэ нь яагаад ийм байдаг вэ? Төрөлхийн хүний байдлыг даван туулахын тулд бид юу хийх ёстой вэ? (Мозая 3:19-ийг үз.)

3. Ёс суртахуунаар цэвэр бай.

1 Коринт 3:16–17; 5; 6:9–20-иос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Паул бидний бие махбодыг юутай харьцуулсан бэ? (1 Коринт 3:16–17; 6:19–20-ийг үз.) Энэ нь яагаад зохих харьцуулалт мөн гэж та нар бодож байна вэ? Ямар зүйлүүд бидний бие махбодыг гэмтээдэг вэ? Бид бие махбоддоо ариун сүм мэт хандахын тулд юу хийх ёстой вэ?
- Паул тэр үеийнхээ маш ноцтой гэм нүглээс сэрэмжлүүлэхдээ хэд хэдэн бэлгийн харьцааны гэм нүглийн талаар дурьддаг. (1 Коринт 6:9-ийг үз.) Бэлгийн харьцааны ёс суртахууны талаар Бурхан ямар хууль өгсөн бэ? (С ба Г 42:23; 59:6-г үз.)

Ахлагч Ричард Г.Скотт хэлэхдээ: “Гэрлэлтийн холбооноос гадуурх бэлгийн харьцаа нь, өөрөөр хэлбэл, хувцастай ба хувцасгүй бусад хүний биеийн нандин болон хувийн хэсгүүдэд санаатайгаар хүрэх нь гэм нүгэл бөгөөд Бурхан үүнийг хориглосон байдаг. Мөн ийм сэтгэлийн хөдөлгөөнийг өөрийн биедээ санаатайгаар агуулбал гэм болно” гэжээ (Conference Report, Oct. 1994, 51; or *Ensign*, Nov. 1994, 38).

- Бэлгийн харьцааны гэм нүгэл нь яагаад маш ноцтой байдаг вэ? (Дараах ишлэлийг үз.) Ёс суртахуунаараа цэвэр байснаар ямар адислалууд ирдэг вэ?

Ахлагч Иосеф Б.Ворфлин заахдаа: “Сүүлийн жилүүдэд хамгийн хурдан тархдаг хууран мэхлэх явдлуудын нэг нь ёс суртахуунгүй байдал бол энгийн бөгөөд боломжийн зүйл ба үүнд ямар ч сөрөг үр дагавар байхгүй гэх ойлголт юм. Үнэндээ бол ёс суртахуунгүй байдал нь далд байгаа маш их зовлон болон эмчилгээгүй өвчин, үр хөндөлт, салсан гэр бүлүүд, эцэггүй өрх гэр, дэндүү залуухан ээжүүд зэрэг өнөө үед зонхилох өөр бусад асуудлуудаас шалтгаалдаг юм” гэсэн (Conference Report, Oct. 1994, 100–101; or *Ensign* Nov. 1994, 76).

Ахлагч Бойд К.Пакер заахдаа: “[Сатан] амьдрал бүтээх энэ хүч нь төлөвлөгөөнд зүгээр л тохиолдлоор орчихсон зүйл бус, харин гол түлхүүр нь юм гэдгийг мэддэг. Тэрээр таныг энэ хүчийг зуурдын зүйлд, хэт эрт эсвэл ямар нэгэн байдлаар зүй бусаар хэрэглэхэд уруу татаж чадвал та мөнхийн хөгжил дэвшлийг олох боломжоо шууд алдана гэдгийг мэддэг” гэжээ (Conference Report, Apr. 1972, 137; or *Ensign*, July 1972, 112).

- Паул Гэгээнтнүүдэд “садар самуун хүмүүстэй бүү нийл, [холбогд]” (1 Коринт 5:9) гэж зөвлөсөн. Энэ зөвлөгөөг бид хэрхэн хэрэглэж болох вэ? (Бидний сонгосон найз нөхөд болон зугаа цэнгэлдээ хэрэглэдэг зүйлүүдийн төрлүүд нь ёс суртахуунаар цэвэр байх хүсэл сонирхол, чадварт маань хэрхэн нөлөөлөх талаар ярилц.) Бид ёс суртахуунгүй зүйлийн нөлөөнөөс хэрхэн зайлсхийж чадах вэ?
- Сатан Бурханы хуулиудад өөр бас дагалдах зүйл бий хэмээн биднийг ятгахыг оролдохдоо ямар арга хэрэглэдэг вэ? (Доорх ишлэлийг үз.) Бид хэрхэн уруу таталтын эсрэг зогсох вэ? Биднийг бэлгийн харьцааны гэм нүгэл үйлдүүлэх уруу таталтыг эсэргүүцэхийг хичээхэд 1 Коринт 10:13 ямар нотлох зүйл өгдөг вэ? Уруу таталтыг эсэргүүцэхэд Их Эзэнээс тусламж эрснээрээ та хэрхэн адислагдсан бэ?

Ахлагч Ричард Г.Скотт хэлэхдээ: “Сатан, сэтгэлийн хөдөлгөөнөөс үүсэх хүчтэй сонирхлыг хайгч хувь хүмүүс хоорондоо зөвшилцсөнөөр бие махбодын харьцаанд орох боломжийн хэр хэмжээ гэж бий, мөн хэрэв хэмжээ хязгаараас хэтрэхгүй бол ямар ч муу нөлөө үзүүлэхгүй гэж хэн нэгнийг уруу татдаг. Есүс Христийн гэрчийн зүгээс би энэ нь үнэхээр худал зүйл мөн гэж гэрчилж байна. . . .Та нар юуг хийх, юуг хийхгүйгээ шийд. Уруу таталттай тулгарсан үедээ өөрийн байр сууриа бүү өөрчил” гэсэн (Conference Report, Oct. 1994, 51; or *Ensign*, Nov. 1994, 38).

- Бэлгийн харьцааны гэм нүглээ наманчилдаг хүмүүст Есүс Христийн Цагаатгал ямар амлалтыг санал болгосон байдаг вэ? (1 Коринт 6:11; Исаиа 1:18; С ба Г 58:42- ыг үз.)

Дүгнэлт

Манай үеийн төлөөлөгчид болон бошиглогчид Паулын адилаар Их Эзэний заасан хэмжээ хязгаарын хүрээнд байхын тулд юу хийх ёстойг бидэнд заасаар байна. Та саяхан болсон чуулганд Паулын Коринтчуудад бичсэн захидлуудтай холбоотой маргаанаас зайлсхийх, Сүнсэнд найдах эсвэл ёс суртахуунаар цэвэр байх зэрэг сэдвээр ярьсан бошиглогч эсвэл төлөөлөгчдийн хэн нэгний ярианы талаар товч ярилцаж болно. Боломжтой үед нь Паулын эсвэл хожмын үеийн төлөөлөгч эсвэл бошиглогчдын нэгний зөвлөгөөг хэрэгжүүлснээр хэрхэн адислагдсан талаар хуваалц.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Бурхан өөрийг нь хайрладаг хүмүүст бэлдсэн зүйл” (1 Коринт 2:9)

- Танд хэзээ нэгэн цагт тохиолдсон хамгийн гайхамшигтай эсвэл сайхан зүйл юу ву?

Ангийн гишүүнээр 1 Коринт 2:9-ийг уншуул. Бид Бурханыг хайрлаж, зарлигуудыг нь дагахад түүний бидэнд зориулан бэлдсэн адислалууд нь бидний төсөөлдөг ямар ч зүйлээс илүү гайхамшигтай гэдгийг гэрчил.

2. “Ах нь дүүтэйгээ хуулийн дагуу байх” (1 Коринт 6:6)

1 Коринт 6:1–8-ыг уншаад ярилц.

- Коринтын олон Гэгээнтнүүд маргаанаа хэрхэн шийдвэрлэсэн бэ? (1 Коринт 6:1–8-ыг үз.) Энэ нь хэрхэн улам нэгдмэл бус болох шалтаг болсон бэ? Өнөөдөр энэ асуудал хэрхэн илэрхий харагддаг вэ? Паулын зөвлөгөөнөөс бид юу сурч болох вэ?

“Та Нарт Дамжуулж Өгсөнчлөн Ёслолуудыг Сахь”

Хичээл
34

1 Коринт 11–16

Зорилго

Ангийн гишүүдийг сайн мэдээний номлолын дагуу амьдарч, пристийн зэргийн ёслолуудыг хүлээн авахын чухлыг таньж мэдэхэд туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - 1 Коринт 11:1–3, 11–12. Паул эхнэр нөхрийн хоорондын болон Их Эзэнтэй харьцах харьцааны талаар заадаг.
 - 1 Коринт 11:17–29. Паул ариун ёслол бол Аврагчийн золиослолын бэлэг тэмдэг бөгөөд Түүнийг дурсан санахын тулд хүртэх ёстой гэж заадаг.
 - 1 Коринт 12–14. Паул олон сүнслэг бэлгүүд байдаг бөгөөд бүгд Сүмд чухал байдаг гэж заадаг. Энэрэл нь өөр бусад бэлгүүд эсвэл зан чанаруудаас илүү чухал гэж тэр заадаг. Тэрээр сүнслэг бэлгүүдийг бүхний эрх ашгийн төлөө зориулах ёстой гэж заадаг.
 - 1 Коринт 15. Паул, Есүс Христийн ачаар бид дахин амилах болно гэдгийг заадаг. Тэрээр мөн нас барагсдын төлөө хийдэг усан баталгаа, алдар хүндийн гурван зэргийн талаар заадаг.
2. Нэмэлт Уншлага: 3 Нифай 18:1–14; Моронай 7:44–48; 10:8–18; Сургаал ба Гэрээнүүд 46:1–26; 76:50–119; 88:27–32, 95–102.
3. Дараах зургууд байгаа бол энэрлийн тухай ярихдаа заримыг нь хичээлдээ хэрэглэ. Өөрсдийнхөө Ээлжийг Хүлээсэн нь (62316); Гурван Дугуйтаа Унуулсан нь (62317); Гэр Бүлийн Зугаа Цэнгэл (62384); Өвчтөнд Үйлчлэл Үзүүлэх нь (62342); Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 613); Гэрийн Багшлалт (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 614); Бие Биедээ Үйлчлэх нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 615).
4. Заахад зориулсан зөвлөмж: Сайн мэдээг үр дүнтэй сайн заахын тулд багш нарт зүрх сэтгэлийг ойлгох бэлэг авъяас хэрэгтэй байдаг. Ангийн гишүүдийн хэрэгцээг илүү сайн ойлгохын тулд багш энэрэх сэтгэлтэй байж, мөн Ариун Сүнсээр удирдуулах ёстой. Багш нар ангийн гишүүн нэг бүрийн хэрэгцээг мэдэрч, тэдгээрийг хангахад хэрхэн туслах талаар залбирч, анхаарч үзэх ёстой.


Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүдээс галт тэрэгний сумны шилжүүлэг гэдгийг мэдэх эсэхийг асуу. Самбарт сумны шилжүүлэг (дор үзүүлсэн шиг) зураад, сумны шилжүүлэг гэдэг нь галт тэрэгний замыг нэгээс нөгөө чиглэлд шүлжүүлэхэд хэрэглэдэг зүйл гэдгийг тайлбарла.



Ахлагч Гордон Б.Хинклигийн өгүүлсэн дараах түүхийг хуваалц.

“Олон жилийн өмнө би төмөр замын удирдах газарт ажилладаг байлаа. Нэг өдөр би Нью Жэрсигийн Ньюарк дахь ажил нэгт нөхрөөсөө суудлын галт тэрэг ирэхдээ ачаатай вагон нь ирсэнгүй гэсэн дуудлага утсаар авав. Үйлчлүүлэгчид ууртай байлаа.

“Бид, Калифорнийн Оукландад галт тэрэгний бүх зүйлс зохих ёсоороо байсан бөгөөд зүүн хязгаар луу явах галт тэрэг хөдлөх буудал болох Сэинт Луйс руу мөн зохих ёсоороо илгээгдсэнийг олж тогтоов. Гэтэл Сэинт Луйст нэгэн сум шилжүүлэгч бодлогогүйгээр төмөр замыг гуравхан инчийн зөрүүтэй шилжүүлсэн байлаа. Энэ нь сумны шилжүүлгийн хэсэг байсан бөгөөд Нью Жэрсигийн Ньюаркт байх ёстой байсан вагон Луизианагийн Нью Орлийнзд, 1300 милийн хол очсон байжээ” (Conference Report, Oct. 1972, 106–7; or *Ensign*, Jan. 1973, 91).

Түүхийг ярьж дуусаад та самбар дахь сумны шилжүүлэгтэй холбоотой дараах асуултуудыг тавь:

- Энэ яльгүй жаахан өөрчлөлт галт тэрэгний чиглэлд яаж тийм том нөлөө үзүүлсэн бэ? Бидний амьдралд байж болох сумны шилжүүлгүүд нь юу вэ? (Хариултанд, үйл явдлууд, шийдвэрүүд, шинэ мэдлэг эсвэл бидний амьдралын чигийг өөрчилдөг аливаа зүйлүүд орж болно. Сумны шилжүүлэг нь биднийг үнэнээс өөр зүгт хөтөлбөл сөрөг талтай, харин биднийг зөв зам дээр буцааж гаргавал эерэг талтай байдаг.)

Паулын Коринтчуудад бичсэн нэгдүгээр захидлын сүүлчийн бүлэгт Коринтчуудыг үнэнээс хазайхад нөлөөлсөн сургаалын дөрвөн сумны шилжүүлгийг авч үзсэн байдаг. Эдгээр бүлгээс Паулын номлолыг уншсанаар бид Тэнгэр дэх Эцэг рүү маань хөтөлдөг зөв шударгын замыг дагах амлалтаа бэхжүүлж чаддаг.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Эхнэр, нөхрийн хоорондын болон Их Эзэнтэй харьцах харьцаа

1 Коринт 11:1–3, 11–12.

- 1 Коринт 11:3-т Паул ямар гурван холбооны тухай ярьдаг вэ? Паул яагаад энэ бүх холбоог хамтад нь авч үзсэн гэж та нар бодож байна вэ? Есүс Христ, түүний Эцэг хоёрын хоорондын харьцаанд ямар чанар байдаг вэ? (Иохан 5:20; 8:29; 17:21–22-ыг үз.) Бид хэрхэн эдгээр чанаруудыг Есүс Христтэй харьцах харьцаандаа хөгжүүлж чадах вэ? Эхнэр нөхрүүд энэ чанарыг хоорондын харьцаандаа яаж хөгжүүлж чадах вэ?

- “Их Эзэн дотор эр хүнгүйгээр эмэгтэй хүн гэж үгүй бөгөөд эмэгтэй хүнгүйгээр эр хүн гэж үгүй” гэдэг юу гэсэн утгатай вэ? (1 Коринт 11:11). Эхнэр нөхрийн хоорондын харьцаа Бурханы хаант улсад яагаад чухал вэ? Эхнэр нөхөр бие биендээ яаж хандах талаар энэ нь бидэнд юуг заадаг вэ?

Ерөнхийлөгч Марион Г.Ромни заахдаа: “[Нөхөр, эхнэр] хоёр нийцэл, хүндэтгэл, харилцан ойлголцох чадвараараа нэг байх ёстой. Хувь хувьдаа үйл ажиллагаа явуулах ёсгүй. Тэд зөвлөлдөж, залбирч, хамтран шийдэх ёстой. . . . Эхнэр нөхрийн хэн нь ч нэг нэгнийхээ боол биш гэдгийг сана. Эхнэр нөхрүүд эн тэгш хамтрагч нар юм” гэжээ (“In the Image of God,” *Ensign*, Mar. 1978, 2, 4).

Та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол эдгээр харьцаа нь бидний амьдралд хэрхэн эерэг болон сөрөг нөлөөтэй сумны шилжүүлэг болохыг ярилц.

2. Ариун ёслолын зорилго

1 Коринт 11:17–29-ийг уншаад ярилц. Коринтын олон Гэгээнтнүүд ариун ёслолын үйл ажиллагааны зорилгыг анхаардаггүй байсан. Ариун ёслолд анхаарлаа хандуулахын оронд тэд нэг нэгэнтэйгээ марган, хэт их ууж, идэж байсан (1 Коринт 11:18–22).

- Ариун ёслолын цуглааны үндсэн зорилго юу вэ? (1 Коринт 11:20-ийн Иосеф Смитийн Орчуулгаас Их Эзэний зоогийг идэхийн тулд юм гэснийг үз.)

Ахлагч Жэффри Р.Холланд заахдаа: “Маш олон зүйлийг алдаж мөн олж болох учраас [ариун ёслолоос] бид заримдаа илүү бодлоготойгоор хүртэх ёстой. Энэ нь хүчтэй бишрэнгүй, мөн эргэцүүлэн бодох мөч байх ёстой. Үүний зэрэгцээгээр үүнийг яарч хийх ёсгүй. Энэ нь ариун ёслолын цуглааны жинхэнэ зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд зүгээр нэг ‘хийгээд өнгөрөх’ ёстой зүйл биш. Энэ бол жинхэнэ цуглааны зорилго юм” гэжээ (Conference Report, Oct. 1995, 89; or *Ensign*, Nov. 1995, 68).

- Паулын хэлсний дагуу ариун ёслолын зорилго нь юу вэ? (1 Коринт 11:23–26; мөн Лук 22:19–20-ийг үз.) Бид ариун ёслолыг хүртэхдээ бодол санаа, зүрх сэтгэлээ Есүст хэрхэн төвлөрүүлж чадах вэ?
- Ариун ёслолоос зохистойгоор хүртэхийн чухлын талаар Паул юу заасан бэ? (1 Коринт 11:27–29-ийг үз.) Ариун ёслолоос зохисгүйгээр хүртэх гэдэг нь юу гэсэн үг вэ? Зохистой байдлаа дүгнэх нь яагаад ариун ёслолын чухал хэсэг болдог вэ?
- Ариун ёслолоос хүртэх нь таныг хэрхэн адисласан бэ? Бид энэ ёслолыг амьдралдаа хэрхэн илүү утга учиртай болгох вэ?

Та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол ариун ёслолд хандах бидний хандлага хэрхэн сумны шилжүүлэг болдгийг ярилц.

3. Бүх сүнслэг бэлгүүдийн чухал ач холбогдол

1 Коринт 12–14-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон хэсгүүдийг чангаар уншихыг урь. Паулын захидалд Коринтын Гэгээнтнүүд хэлээр ярих бэлгийг хэт их чухалчилж байгааг нь сануулдгийг тайлбарла (1 Коринт 14:2–14, 27–28). 12–14-р бүлэг бүрт Паул Сүнсний бүх бэлгүүд нь чухал харин Гэрээнтнүүд бүх хүмүүсийн тусын тулд байх бэлгийг эрэлхийлэх ёстой гэж тайлбарласан байдаг.

- Сүнслэг бэлэг гэж юу вэ? (Сүнслэг адислал эсвэл чадварыг Ариун Сүнс өгдөг. 1 Коринт 12:7–11; С ба Г 46:11). Бурхан яагаад сүнслэг бэлгийг өгдөг вэ? (С ба Г 46:26-г үз.)
- Та Сүнсний ямар бэлгүүдийг хүлээж авсан эсвэл харсан бэ? (Та 1 Коринт 12:8–10, Моронай 10:8–17 ба С ба Г 46:13–25-д илчилсэнчлэн сүнслэг бэлгүүдийг жагсааж бичээд ярилцаж болно.) Эдгээр бэлгүүд таныг буюу бусдыг хэрхэн адисласан бэ?
- Паул сүмийн гишүүдийг биеийн өөр өөр хэсгүүдтэй яагаад харьцуулсан гэж та нар бодож байна вэ? (1 Коринт 12:12–25. Гишүүн бүр чухал гэдгийг бусад гишүүд, Сүмд бүхэлд нь үзүүлэхийн тулд.) Энэ харьцуулалтыг бид Сүнсний янз янзын бэлгүүдтэй хэрхэн харьцуулах вэ?
- Сударт биднийг сүнслэг бэлгүүдийг эрэлхийлэхийг зөвлөсөн байдаг (1 Коринт 12:31; С ба Г 46:8). Сүнслэг бэлгийг эрэх бидний шалтгаан юу байх ёстой вэ? (1 Коринт 14:12; С ба Г 46:9-ийг үз. Шаардлагатай бол гэгээрэх гэдэг босгох, зааварлах, дээшлүүлэх, гэгээрүүлэх гэсэн утгатайг тайлбарла.)
- Паул бүх сүнслэг бэлгүүдээс агуу юуг заасан бэ? (1 Коринт 13-ыг үз. 4–7-р шүлгүүдэд дурьдсан энэрлийн шинж чанар бүрийн талаар тодорхойлж, тэдгээрийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар ярилц.) Та шинжүүдийг самбарт бичиж болно. Энэрэл нь бусад сүнслэг бэлгүүдээс яагаад илүү чухал вэ? (1 Коринт 13:1–3, 8–13.)
- Танд энэрэл үзүүлсэн хүн таныг хэрхэн адисласан бэ? Энэрлийг хэрхэн илүү их хөгжүүлж чадах вэ? (Моронай 7:44–48-ыг үз.)

Та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол энэрэл нь хэрхэн сумны шилжүүлэг болдгийг ярилц.

4. Дахин амилалт ба алдар хүндийн зэргүүд

1 Коринт 15-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Олон Коринтчууд Дахин амилалтын мөн чанарын талаар маргаж эхэлснийг тайлбарла (1 Коринт 15:12).

- Паул Дахин амилалтын ямар жишээг иш татсан бэ? (1 Коринт 15:5–8-ыг үз.) Паул яагаад Дахин амилалтын талаар тийм олон жишээ татсан гэж та нар бодож байна вэ? (2 Коринт 13:1-ийг үз.) Дахин амилалтын жишээнүүд танд яагаад чухал вэ?
- Паул Адамын Уналт, Дахин амилалт хоёрын хоорондын харьцааны талаар юу гэж заасан бэ? (1 Коринт 15:20–23-ыг үз.)
- Паул нас барагсдын төлөө хийх усан баталгааны номлолыг Дахин амилалтын тухай заахдаа яаж хэрэглэсэн бэ? (1 Коринт 15:29-ийг үз.)

Нас барагсдын төлөө хийдэг усан баталгааны ёслол нь Дахин амилалтгүйгээр утгагүй болдог.)

- Паул алдар хүндийн хаант улсуудын талаар юу заасан бэ? (1 Коринт 15:35–44-ийг үз. Бид дахин амилж сэлэсчел, тэврэстрил эсвэл тэлэсчел гэсэн алдар хүндийн хаант улсуудыг хүртэх болдог. Мөн С ба Г 88:27–32-ыг үз.) Дахин амилалт, алдар хүндийн хаант улсуудын тухай мэдлэг чинь таны амьдралд яаж нөлөөлдөг вэ?

Дүгнэлт

Биднийг Тэнгэр дэх Эцэг рүү буцаж очиход хөтлөх номлолуудыг дагахын чухлын талаар гэрчил. Анхаарал татах ажиллагааг та хэрэглэсэн бол ангийн гишүүдийг өөрсдийн амьдрал дахь юманд хандах байдал, үйлдэл болох сумны шилжүүлгийг дүгнэж үзэхийг урь. Тэдний амьдралд эергээр нөлөөлөх замыг сонгохыг тэдэнд уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Бурхан бол самуурал үүсгэгч бус” (1 Коринт 14:33).

Ангийн гишүүдээр 1 Коринт 14:33-ыг уншуул. Тэгээд дараах асуултуудыг тавь:

- Дэлхий дээр их маргаан, төөрөгдөлтэй зарим зүйлүүд нь юу вэ? Дэлхийд яагаад ийм их төөрөгдөл байна гэж та нар бодож байна вэ? Бурхан хэрхэн “амар амгалан үүсгэгч” байдаг вэ?

2. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Хичээлийн өмнө өсвөр насныхан амьдралдаа энэрлийг үзүүлэх боломжтой байх (жишээлбэл, сургууль дээрээ тусламж хэрэгтэй хүнтэй уулзах, ах эгч нартайгаа санал нийлэхгүй байх эсвэл ганцаардмал, мөн зохих ёсоороо үнэлэгдээгүй хүнтэй нөхөрлөх) хэд хэдэн нөхцөлүүдийг бод. Эдгээр нөхцөлүүдийг өсвөр насныханд танилцуулж, 1 Коринт 13-т Паулын заасан энэрлийн шинж чанарыг уг нөхцөл байдлыг сайжруулахын тулд хэрхэн хэрэглэж болохыг асуу.

Зорилго

Ангийн гишүүдийг 2 Коринтод Паулын өгсөн зөвлөгөөг хэрэгжүүлж, Есүс Христийн шавь нар байхад уриалах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 2 Коринт 1:3–11; 4; 6:1–10; 11:21–33; 12:1–10. Паул зовлон зүдгүүрийг давж туулах тухай заадаг.
 - б. 2 Коринт 2:5–11. Паул Гэгээнтнүүдэд нэг нэгнийгээ уучлахыг сануулдаг.
 - в. 2 Коринт 7:8–10. Паул нүглийнхээ төлөө Бурханы хүслийн дагуу гашуудах тухай заадаг.
 - г. 2 Коринт 5:17–21. Паул Гэгээнтнүүдийг Бурхантай эвлэрэхийг уриалдаг.
2. *New Testament Video Presentations* (53914) байгаа бол “Godly Sorrow” 11 минутын бичлэгийг хичээл дээрээ үзүүл.
3. Та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл ангидаа бага зэрэг элс авчир.
4. Заахад зориулсан зөвлөмж: Хичээлийн төгсгөлд юу зааснаа дүгнэж ярих хугацаа үлдээ. Няхуур сайн төлөвлөсөн дүгнэлт ангийн гишүүдийг юу сурснаа цэгцэлж, ойлгомжтой болгож, амьдралдаа яаж хэрэгжүүлэхээ бодож үзэхэд нь тусалж чадна.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Авчирсан элсээ ангийн гишүүдэд үзүүл.

- Та нарын итгэж явдаг хүн энд алт байгаа гэж амлаад гарт чинь элс атгуулвал та яах вэ?

Ангийн гишүүдэд хариулт өгөх боломж олго. Дараа нь Ахлагч Хэнри Б. Айрингийн бошиглогчдын зөвлөгөөг дагах талаар өгсөн дараах мэдэгдлийг унш.

“Зөвлөгөөг бүү хэрэгсэхгүй орхи, харин үүнийг чангахан атга. Хэрэв таны итгэж явдаг хүн чинь элснээс өөр юу ч биш юм шиг харагдах зүйлийг энд алт бий гэж амлалт өгөн байж атгуулбал та үүнийг ухаалгаар гартаа хэсэг зуур бариад, зөөлөн сэгсэрч үзнэ байх. Бошиглогчийн зөвлөгөөг дагах бүрт хэсэг хугацааны дараа алтан ялтсууд ил гарч ирж эхэлдэг бөгөөд би үүнд талархдаг байсан” гэжээ (Conference Report, Apr. 1997, 35; or *Ensign*, May 1997, 26).

- Ахлагч Айрингийн мэдэгдэл ямар утгатай вэ?

2 Коринтын ном бидний үед хамаатай бошиглогчийн зөвлөгөөг агуулдаг гэдгийг тайлбарла. Энэ захидалд байгаа Паулын сургаалууд нь ерөнхий

чуулган дээр бидний байнга сонсдог сургаалуудтай адил төстэй байдаг. Ахлагч Айринг ажиглахдаа, “Бошиглогчдын үгс давтагдаад байх шиг санагдах үед энэ нь бидний анхаарлыг [тэдгээр] үгс татах ёстой юм (Conference Report, Apr. 1997, 32; or *Ensign*, May 1997, 25). Ангийн гишүүдийг энэ хичээлд гарах зөвлөгөөг дагаж, “үүнийг чангахан атгахыг” уриал” гэж хэлжээ.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Энэ хичээл 2 Коринтын чухал сэдвүүдийг голлон анхаарсан дөрвөн хэсэгт хуваагддаг. Эдгээрийн аль нэгийг ангийн гишүүдтэй ярилцахаар залбирч сонго.

1. Зовлон зүдгүүрийг давж туулах нь

2 Коринт 1:3–11; 4; 6:1–10; 11:21–33; 12:1–10-ыг уншаад ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь.

- Паул Коринтчуудад бичсэн захидлаа Паул, Тимот хоёрыг ихэд хавчиж, “амьд үлдэх ч горьдлого тасарсан” үеийн дараа бичжээ (2 Коринт 1:8). Паул, Тимот хоёр яагаад зовж, тэвдэж, хавчигдаж, гадагш шидэгдэж байхын оронд горьдлого тасарсан байдлаас зайлсхийх боломжтой байсан бэ? (2 Коринт 1:3–5; 4:5–15-ыг үз.) Яагаад Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр тайтгарал олж авах хамгийн сайн эх сурвалж байдаг вэ?

Ахлагч Нил А.Максвэлл Есүс Христ биднийг зовж шаналах үед тусалдаг гэдгийг баталсан.

“Есүсийн буулгыг өөрсөд дээрээ авахад энэ нь аажимдаа биднийг Паулын нэрлэсэн “[Христийн] зовлонгийн нөхөр” болгодог (Филиппой 3:10). Хэрэв бид номхон дөлгөөн байвал өвчин эсвэл ганцаардал, шударга бус байдал эсвэл эсэргүүцэл, . . . бидний харьцангуй бага зовлон ч бай, эдгээр нь бидний бие сэтгэлийн гүнд шингэдэг. Бид дараа нь бидний төлөө зовсон Есүст зөвхөн талархаад зогсохгүй, мөн түүний юутай ч зүйрлэшгүй тэр зан чанар бидэнд улам их бишрэл, тэр ч бүү хэл үүнийг даган дууриах сэтгэлийг төрүүлдэг.

“Алма Есүс бидний уй гашуу, өвчин зовлонд яг яаж туслахаа мэддэг, учир нь Есүс аль хэдийнэ бидний уй гашуу, өвчин зовлонг үүрсэн юм гэж илчилсэн. (Алма 7:11–12-ыг үз.) Тэр үүнийг анхнаас нь мэддэг байсан. Тиймээс ч тэр хайрлаж, энэрэхийг олж авсан юм. Мэдээж бид тэр мөнх бус нүглүүдийг өөртөө үүрсэн гэдгийг ойлгодгоос өөр зүйлийг бүрэн дүүрэн ойлгодоггүй, харин Түүний Цагаатгал үнэнийг аварч, нотлохоор үлддэг” (Conference Report, Apr. 1997, 13; or *Ensign*, May 1997, 12).

- Саад тотгор тулгарсан үед Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр та нарт яаж тусалсан бэ?
- Паул Бурханаас авсан тайтгаралтай адил зүйлийг бусдыг ч гэсэн аваасай гэсэн хүслээ илэрхийлсэн (2 Коринт 1:4). Бид бусдыг Бурханаас тайтгарал хүлээн авахад нь хэрхэн тусалж чадах вэ?
- Паул, Тимот тэр хоёрт саад тотгор учирсан үед тэдний төлөө залбирсан Гэгээнтнүүдэд талархсан (2 Коринт 1:11). Нэг нэгнийхээ төлөө залбирах нь яагаад чухал вэ? Бусдын залбирал таныг эсвэл таны мэддэг хэн нэгэн хүнийг хэрхэн адисласан бэ? Бид бусдын төлөө залбирснаараа хэрхэн адислагддаг вэ?
- 2 Коринт 4:17–18-ын номлолууд зовлон зүдгүүртэй үед бидэнд хэрхэн

тусалж чадах вэ? (Мөн С ба Г 121:7–8-ыг үз.) Бид зовлон бэрхшээлээ мөнхийн зорилгын үүднээс харах нь яагаад тустай вэ? Бид яаж зовлон бэрхшээлээ мөнхийн зорилгын үүднээс харж сурах вэ?

- Паул Коринтчуудад зовлон бэрхшээлийнх нь талаар хэлэхдээ өөрөө болон олон Гэгээнтнүүд үүнийг Есүс Христэд итгэх итгэлээрээ давсан гэж хэлсэн (2 Коринт 6:4–5; 11:23–33). Зовлон бэрхшээлийг давахад бидэнд туслахын тулд бидний хөгжүүлэх ёстой ямар шинж чанарыг Паул заасан бэ? (2 Коринт 6:4, 6–7-г үз.) Эдгээр шинж чанарууд нь зовлон бэрхшээлтэй үед танд хэрхэн тусалсан бэ?
- Их Эзэн “махан биед минь өргөс” доройтлыг өгсөн гэж Паул хэлсэн (2 Коринт 12:7). Их Эзэн яагаад энэ доройтлыг Паулд өгсөн бэ? (2 Коринт 12:7-г үз.) Их Эзэн түүний “махан биен дэх өргөсийг” гуйсных нь дагуу аваагүйгээс Паул юу сурсан бэ? (2 Коринт 12:8–10-ыг үз.) Бидний сул тал Есүс Христээс эрч хүч авахад бидэнд хэрхэн тусалдаг вэ? (Ифэр 12:27-г үз.) Паулын “би хэзээ мөхөс байна, тэр үед хүчтэй байдаг” гэж мэдэгдсэний үнэнийг та яаж харсан бэ?

2. Бусдыг уучлах нь

2 Коринт 2:5–11-ийг уншаад ярилц.

- Паул Гэгээнтнүүдэд нэг нэгнээ уучлахыг сануулсан (2 Коринт 2:5–8). Бид бусдыг уучлах нь яагаад чухал вэ? (Матай 6:14–15; 2 Коринт 2:7–8; С ба Г 64:9–10-ыг үз. Бид уучилж байхад бидэнд болон бусад хүмүүст энэ нь хэрхэн нөлөөлдөг вэ?)

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“Бид довын чинээ жижиг үл ойлголцлыг уулын чинээ том маргаан болгодог хүмүүсийн гэрт [уучилж] сурах хэрэгцээг олж хардаг. Бид ялихгүй ялгааг мөнхийн атаа хорсол болгодог хөршүүдийнхээ дунд үүнийг хардаг. Хэрэв зэрэгцэж суугаад бие биетэйгээ намуухан ярилцах хүсэлтэй байсан бол бүгдийг адислах явдлаар асуудлыг шийдэж болохоор байхад хэрэлдэж зөвшилцөл, уучлалаас татгалздаг ажил хэрэгч хүмүүсийг бид ихэнх тохиолдолд хардаг. Ингэхийн оронд тэд бүх өдрөө атаархалд автан, шийтгэл оноох явдлаа төлөвлөхөд зарцуулдаг. . . .

“Өөр нэгэнд дайсагнаж зүрх сэтгэлээ хорт шар айргаар тэтгэдэг хэн нэгэн байвал би та нарыг Их Эзэнээс уучлах хүчийг эрж гуйхыг хүсэж байна. Энэхүү хүслийн илэрхийлэлт нь таны наманчлалын гол зүйл байх болно. Энэ нь хялбар биш байж болно. Гэхдээ та үүнийг чин сэтгэлээсээ эрэлхийлж, тордож арчилбал энэ нь бий болох болно. . . .

“. . . Хуучин шархны хөндүүрийг мэдрэхэд амар амгалан байдал мэдрэгддэггүй. Зөвхөн наманчлал, өршөөлөөс л амар амгалан ирдэг. ‘Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно’ гэж хэлсэн Христийн гайхалтай сайхан амар амгалан бий (Мат. 5:9)” гэжээ (“Of You It Is Required to Forgive,” *Ensign*, June 1991, 2, 5).

- Илүү өршөөнгүй сэтгэлтэй болохын тулд бид юу хийж болох вэ?

3. Нүглийнхээ төлөө Бурханы хүслийн дагуу гашуудах нь

2 Коринт 7:8–10-ыг уншаад ярилц.

- Захидлуудынх нь нэг нь [Коринтчуудыг] гэмшихэд хүргэснийг сонсоод

Паул баярласан (2 Коринт 7:8–9). Коринтчуудын гунигласанд Паул яагаад ийм байдлаар хариу өгсөн бэ? (2 Коринт 7:9–10-ыг үз.) Нүглийнхээ төлөө “Бурханы хүслийн дагуу гашуудах” гэдэг нь юу гэсэн үг вэ?

Та “Бурханы Хүслийн дагуу Гашуудал” бичлэгийг хэрэглэх гэж байгаа бол одоо үзүүл.

- Бурханы хүслийн дагуу гашуудах, “дэлхийн уй гашуу” хоёрын ялгаа нь юу вэ? Бурханы хүслийн дагуу гашуудах нь яагаад наманчлалын чухал хэсэг вэ?

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл тайлбарлахдаа: “Нүглийг нь хэн нэгэн олж мэдсэн учраас гэмшиж байгаа бол түүний наманчлал бүрэн дүүрэн бус юм. Бурханы хүслийн дагуу гашуудах нь хүнийг бусдад баригдаагүй ч гэсэн наманчлах хүсэлтэй болгож, юу ч тохиолдсон зөвийг хийхээр шулуудуулдаг. Иймэрхүү гашуудал нь зөв шударгыг авчирч, өршөөлд хүрэхэд тусална” гэжээ (*Repentance Brings Forgiveness* [pamphlet, 1984], 8).

4. Бурхантай эвлэрэх нь

2 Коринт 5:17–21-ийг уншаад ярилц.

- Паул, Тимот хоёр Коринтчуудад “Бурхантай эвлэрэхийг” зөвлөсөн (2 Коринт 5:20). Бурхантай эвлэрэх гэдэг нь юу гэсэн үг вэ?

Ахлагч Брүс Р.МакКонки заахдаа: “Эвлэрэл нь хүнийг нүгэл болон сүнслэг харанхуйгаас чөлөөлж, түүнд нийцэл болон Агуу Дээдтэй нэгдэх байдлыг сэргээх үйл явц юм. . . . Урьд нь тачаангуй, нүгэлтэй махан биеийн байдлын дагуу амьдардаг байсан хүн Ариун Сүнсний шинэ бүтээл болж; тэрээр дахин төрж; тэр жаахан хүүхэд шиг Христэд амьд болдог” гэжээ (*Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [1965–73], 2:422–23).

- Бид Бурхантай хэрхэн эвлэрч чадах вэ? (2 Коринт 5:17–19, 21; 2 Нифай 25:23; Жэкоб 4:10–11-ийг үз.)

Дүгнэлт

Ярилцсан үнэнийхээ тухай гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Гаднах хүн” ба “доторх хүн” (2 Коринт 4:16).

- Паул “гаднах хүн” ба “доторх хүний” тухай ярьсан (2 Коринт 4:16). Энэ хоёр хэллэг ямар утгатай байж болох вэ? “Доторх хүн өдөр өдөрт яаж шинэчлэгдэж” болох вэ? (2 Коринт 4:16).

2. “Христийн төлөөх Элчин сайд нар” (2 Коринт 5:20)

- Тимот тэр хоёр “Христийн төлөөх элчин сайд нар” гэж Паул хэлсэн (2 Коринт 5:20). Элчин сайд гэж юу вэ? (Элчин сайд нь улс орон эсвэл байгууллагын удирдлагыг төлөөлж ярьдаг албан ёсны төлөөлөгч юм. Элчин сайд нь төлөөлж байгаа хүмүүс, бусад хүмүүс хоёрын хооронд сайн харилцаа холбоо тогтоохоор ажилладаг.) Паул, Тимот хоёр хэрхэн Еүс Христийн элчин сайд нар байсан бэ? Хүн нэг бүр хэрхэн Еүс Христийн элчин сайд нар байж болох вэ?

“Гэгээнтнүүд Байхаар Дуудагдсан Бурханы Хайртай Хүмүүс”

Ром

Зорилго

Ангийн гишүүдэд тэд Бурханы хүүхдүүд гэдгийг сануулж, өөрсдийн тэнгэрлэг өвийг авахаар зохистой амьдрахад нь уриалах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Ром 2–5. Паул бүх хүмүүс зөв шударга үйлсээ харуулснаар Есүс Христэд итгэх итгэлээрээ зөвтгөгддөг гэж заадаг.
 - б. Ром 6:8. Паул Бурханы хүүхдүүд дахин төрж болдог ба Христтэй хамт өв залгамжлагчид болдог гэж заадаг.
 - в. Ром 12–13; 15:1–7. Паул Ромчуудад Гэгээнтнүүдийн адил амьдрахыг зөвлөдөг.
 2. Та гоцлол дуучин эсвэл жижиг хамтлагаар “Би Бурханы Хүүхэд” дууг дуулуул эсвэл аяыг нь тоглохыг урь (Дууллаууд ба Хүүхдийн Дуунууд, х. 58). Хэрэв үүнийг хийх боломжгүй бол та энэ дууг ангийн гишүүдтэй хамт дуулахад бэлтгэ.
 3. Заахад зориулсан зөвлөмж: Паул Ромчуудад бичсэн захидалдаа багш нарт заадаг зарчмуудаа амьдралдаа хэрэгжүүлэхийн чухлыг сануулсан (Ром 2:21–22). Таны үлгэр жишээ таны хэлэх үгсээс илүү зүйлийг ангийн гишүүдэд зааж чадна. Сайн мэдээний зарчмуудыг өдөр бүр дагаж амьдарснаас үүний тухай гэрчлэлтэй болдог гэдгийг ангийн гишүүдэд харуул (Иохан 7:17).
-

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүнээр Ром 3:10-ыг уншуул. Энэ шүлэгт Паул хэн ч хэзээ ч зөв шударга үйлсийг хийдэггүй; харин үүний оронд тэр ертөнц дээр төгс зөв шударга хэн ч үгүй гэдгийг онцлон тэмдэглэж байсан гэж зөвлөж байсныг тайлбарла. Христ огт нүгэлгүй амьдралаар амьдарсан цорын ганц хүн байсан. Бусад хүн бүр гэм нүгэл үйлдсэн. (Мөн Ром 3:23-ыг үз.)

- Бид гэм нүгэл хийсэн үедээ үүнээсээ салж цэвэр болохын тулд юу хийх ёстой вэ? (Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, нүглээ наманчлах ёстой ингэснээр бид түүний Цагаатгалын цэвэрлэх хүчийг хүлээн авч болно.)

Бид нэгэнт гэм нүгэл үйлдсэн бол өөрсдөө нүглээсээ бүрэн дүүрэн салж чаддаггүй. Энэ хичээлд бид хэрхэн Паулын зөвтгөл хэмээн нэрлэсэн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан цэвэр болж болох талаар ярилцана.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд тохирсон судрын хэсгүүд болон асуултуудыг залбирч сонго. Энэ хичээлд ярилцсан сургаал ба зарчмуудын тухай гэрчлэлээ хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Бид Есүс Христэд итгэх итгэлээр зөвтөгддөг.

Ром 2–5-ыг уншаад ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь. Паул уг хуулийн хатуу чанд мөрдлөг нь авралыг авахад шаардлагатай гэдэгт итгэн Мосегийн хуулийг эргэн дагадаг болсон хэд хэдэн газарт байсан Сүмийн гишүүдэд бичдэг байсныг тайлбарла. Хэдийгээр Ромын Гэгээнтнүүд сайн мэдээнд хүчтэй итгэж дагадаг байсан ч (Ром 7:8), Ромчуудад зөвтгөл ба аврал нь Мосегийн хуулийг дагаснаас биш Христэд итгэх итгэлээс ирдэг гэдгийг онцлон тэмдэглэх гэж энэ захидлыг бичсэн.

- Паул захидалдаа Ромын Гэгээнтнүүдэд зөвтгөлийн номлолыг ойлгоход туслахыг оролдсон. Зөвтөгдөх гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Бурхантай эвлэрэх, нүглийнхээ шийтгэлээс өршөөгдөх ба зөв шударга, буруугүй хэмээн тунхаглах.)
- Бид яагаад зөвтөгдөх хэрэгтэй вэ? (Ром 3:10–12, 23; мөн Алма 7:21-ийг үз. Бид бүгд Бурханыг гомдоож, нүгэл үйлдсэнээр бузар болдог. Бурхантай цэвэр бус зүйл хамт байж үл болох тул бид түүнтэй хамт үлдэхийн тулд зөвтөгдөх ёстой.)
- Бид хэрхэн зөвтөгддөг тухай Паул юу заасан бэ? (Ром 3:24, 28; 5:1–2; мөн 2 Нифай 2:6-г үз. Бид Есүс Христийн ивээлээр мөн түүнд итгэх итгэлээрээ зөвтөгддөг.) Ивээл гэж юу вэ? (Тэнгэрлэг тусалцаа буюу хүч.) Энэ тэнгэрлэг тусалцааг бид хэрхэн авах боломжтой болсон вэ? (Ром 5:8–11; 2 Нифай 2:7–8-ыг үз. Есүс Христийн ивээл нь үүнийг түүний Цагаатгалаар дамжуулан боломжтой болгодог.) Аврагчийн ивээлийг бүрэн дүүрэн хүртэхийн тулд бид яагаад итгэлтэй байх хэрэгтэй байдаг вэ?
- Зөвтгөл нь “хуулийн үйлсээр” бус Есүс Христийн ивээлээс ирдэг гэж Паул тайлбарласан (Ром 3:20, 24, 28). Бид яагаад зөвтгөл, аврал хоёрыг зөвхөн өөрсдийнхөө үйлсээр олж авч чаддаггүй вэ? (Мозая 2:20–21; Алма 22:14-ийг үз.)
- Олон хүмүүс Паулын бичсэнийг бид сайн үйлсгүйгээр ганцхан итгэлээр зөвтөгдөж болно гэсэн утгаар тайлбарладаг. Бидний үйлс (эсвэл хөдөлмөр), Христийн ивээлээс ирдэг зөвтгөл хоёрын хоорондын харьцаа юу вэ? (Ром 3:31; Иаков 2:14–18, 24; 2 Нифай 25:23; С ба Г 88:38–39-ийг үз.)

Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ: “Бурханы өмнө зөвтөгдөхийн тулд бид бие биенээ хайрлах ёстой: бид нүгэл хилэнцийг даван туулах ёстой; бид зовж зүдрэх цагт нь эцэггүй, бэлбэсэн нэгнийг эргэж тойрч, дэлхийн бохирдлоос өөрсдийгөө хамгаалах ёстой: ийм сэтгэл нь цэвэр шашны агуу булгаас ундрэн гарч, адислагдсан Есүсийн хүүхдүүдийг хүндэтгэх сайн зан чанар бүрийг нэмж итгэлээ батжуулснаар ирдэг. Бид залбирлын цаг үед залбирч; бид ийм зүйлийн шагнал нь тэнгэрийн хаант улсад илүү агуу байдгийг мэдэн хөршүүдээ өөр шигээ хайрлаж, гай гамшгийн эсрэг итгэлтэй зогсож чадна. Ямар их тайтгарал! Ямар их баяр баясгалан юм бэ!” гэжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 76).

2. Бид дахин төрж, Христтэй хамт өв залгамжлагчид болж чадна.

Ром 6 ба 8-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Паул усан баталгааг үхэл, оршуулга, дахин амилалттай харьцуулсан. Усан баталгаа хэрхэн үхэл, оршуулга, дахин амилалтыг (шинэ төрөлт) төлөөлдөг вэ? (Ром 6:3–4; С ба Г 76:50–52-ыг үз.) Усан баталгаа нь таны хувьд яаж шинэ төрөлт болдог вэ?

Усанд умбуулсан усан баталгаа нь бидний оюун санааны дахин төрөлтийн бэлэгдэл юм гэдгийг тайлбарла. Бид усан дотор орохдоо энэ нь бид хуучин амьдралаа булшинд оршуулж байгаагийн бэлэгдэл юм. Бид уснаас гарч ирэхдээ угаагдаж цэвэр боллоо гэдгийг бэлэгддэг. Бид Христийг дагах гэрээ байгуулсан шинэ хүн болдог.

- Бид усан баталгаагаараа олж авсан “шинэ амьдрал” (Ром 6:4) цэвэр байдлаа хэрхэн хадгалж чадах вэ? (Хариултанд, долоо хоног бүр ариун ёслолоос хүртэн усан баталгааны гэрээгээ шинэчилснээр, наманчилж, Их Эзэнээс өршөөл гуйснаар, өдөр бүрийг Бурханд үйлчлэх шинэ эрмэлзэлтэйгээр эхлэх зэрэг орж болно.)
- “Махан биеийн доторх санаа”-тай байх гэж юу гэсэн үг вэ? (Ром 8:5–6-г үз.) Махан бие доторх санааны үр дагавар нь юу вэ? (Ром 8:6–8, 13-ыг үз.) Бид бодол санаа зүрх сэтгэлээсээ махан биеийн байдлаа хэрхэн багасгаж чадах вэ? Сүнслэг бодолтой байхыг сонгоод та хэрхэн адислагдсан бэ?
- “Бид Бурханы хүүхдүүд” гэж Паул гэрчилсэн (Ром 8:16). Бид Бурханы хүүхэд гэдгээ мэдэх явдал танд хэрхэн нөлөөлсөн бэ? Энэ таны боломж, чадварын талаар юуг харуулдаг вэ?

Ахлагч Даллин Х.Өүкс хэлэхдээ: “Бидний хайртай ‘Би Бурханы Хүүхэд’ (Дуулмууд ба Хүүхдийн Дуунууд, х. 58) дуунд заадаг үзэл санааны хүч чадлыг бодож үз. . . . Тэнд ‘Би хэн бэ?’ гэсэн амьдралын агуу асуултуудын нэгэнд Би тэнгэрлэг эцэг эхийнхээ сүнсэн удамтай Бурханы хүүхэд хэмээсэн хариулт байдаг. Энэхүү эцэг эхийн холбоо нь бидний мөнхийн боломжийг тодорхойлдог. Энэ агуу ойлголт нь сэтгэлийн дарамтын эсрэг хүчирхэг зүйл юм. Энэ нь хүн бүрийг зөв шударга сонголт хийж, өөрсдийнхөө хамгийн сайнаар хийх явдлыг хайхад зоригжуулдаг. Залуу хүний бодол санаанд тэр бол Бурханы хүүхэд гэсэн хүчирхэг бодлыг төрүүлж мөн тэднийг өөрсдийгөө хүндэлж, амьдралын асуудлын эсрэг зогсоход нь урам оруулдаг” гэсэн (Conference Report, Oct. 1995, 31; or *Ensign*, Nov. 1995, 25).

Та тусгай хөгжмийн үзүүлбэр болгон “Би Бурханы Хүүхэд” дууг дуулуулах эсвэл тоглуулахаар төлөвлөсөн бол гоцлол дуучин эсвэл жижиг хамтлагийг одоо дуулуул. Эсвэл үүнийг ангийн гишүүдийн хамт дуул. (“Бэлтгэл” хэсгийг үз.)

- Бурханы хүүхдүүд ямар агуу адислалуудыг хүлээн авна гэж Паул агуу амлалтыг өгсөн бэ? (Ром 8:17-г үз.) Христтэй хамт өв залгамжлагч байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (С ба Г 76:50, 54–70-ыг үз.) Энэ агуу өвийг хүлээн авахын тулд бид юу хийх ёстой вэ? (С ба Г 76:51–53-ыг үз.)
- Бид Бурханы хүүхэд ба Христтэй хамт өв залгамжлагчид байх боломжтой гэдгийг мэдэх нь энэ дэлхийн саад тотгорыг даван туулахад бидэнд хэрхэн

тусалдаг вэ? (Ром 8:18, 28, 31; мөн Ром 5:3–5-ыг үз.) “Бурханыг хайрладаг хүмүүст бүх зүйлс сайнаар эргэдгийг” та хэрхэн харсан бэ? (Ром 8:28.)

- Ром 8:35–39-д Паул Есүс Христийн хайрын талаар юу гэж заасан бэ? Та амьдралдаа Аврагчийн хайрыг хэрхэн мэдэрсэн бэ? Түүний хайр таны амьдралыг хэрхэн өөрчилсөн бэ?

3. Бид Гэгээнтнүүд болохоор амьдрах ёстой.

Ром 12–13; 15:1–7-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Паул Ромын Гэгээнтнүүдэд өөрсдийгөө “Бурханд тааламжит, амьд, ариун тахил болгон” өргөхийг уриалсан (Ром 12:1). Бид өөрсдийгөө хэрхэн Бурханд амьд тахил болгон өргөж чадах вэ? (3 Нифай 9:20; С ба Г 59:8-ыг үз.)

Ахлагч Брүс Р.МакКонки тайлбарлахдаа, “Өөрсдийгөө амьд тахил болгон өргөх гэдэг нь дуулгавартайгаар даруу зүрх, наманчлагч сэтгэлээр хүрч ирэх гэсэн үг юм” гэжээ (*Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [1966–73], 2:292).

- Паул Ромын Гэгээнтнүүдэд “энэ дэлхийн явдалд бүү нийцэгтүн” гэж зөвлөсөн (Ром 12:2). Өнөөдөр бид ямар замаар энэ дэлхийн явдалд нийцэхээр хичээж байна вэ? Бид энэ байдлаа хэрхэн таслан зогсоож чадах вэ? (Ром 12:2.)
- Ром 12 ба 13-т жинхэнэ Гэгээнтнүүдийн олон янзын зан чанаруудыг дурьдсан байдаг. Ангийн гишүүдээр эдгээр зан чанаруудыг тодорхойлуулж, тэдгээрийг самбарт бич. (Та ангийнхныг хэсэг бүлэг болгон хувааж, хэсэг бүрт номын бүлгийн хэсгүүдээс өгч эрж хайлгуулж болно.) Дараа нь эдгээр зан чанаруудын хэд хэдийнх нь талаар дараах асуултуудыг ярилц: Энэ зан чанарыг хөгжүүлэх яагаад чухал вэ? Бид энэ зан чанарыг цаашид хөгжүүлэхийн тулд энэ долоо хоногт юу хийж болох вэ?
- Дайснууддаа хэрхэн хандах талаар Паул бидэнд ямар заавар өгсөн бэ? (Ром 12:19–21-ийг үз.) Бид энэ байдлаар дайснууддаа хандвал үүнээс ямар адислалууд ирдэг вэ? Хэн нэгэн нь нүгэлт эсвэл эрүүл бус хүслийг ялан дийлэхийн тулд эелдэг зан байдлыг хэрэглэсэн ямар жишээг та харсан бэ?
- Бусад бүх зарлигуудыг хамруулдаг ямар зарлигийг Паул хэлсэн бэ? (Ром 13:8–9-ийг үз.) Энэ зарлиг бусдыг нь хэрхэн хамруулдаг вэ? (Ром 13:10-ыг үз.)
- Бат бэх итгэлтэй гишүүд итгэл султай гишүүдэд яаж хандах ёстой гэж Паул заасан бэ? (Ром 15:1–7.) Бат бэх итгэлтэй хүн итгэл султай хүнд хэрхэн тусалж чадах вэ?

Дүгнэлт

Есүс Христэд итгэх итгэл, зөв шударга амьдралаар дамжуулан бид зөвтгөгдөж—зөв шударга гэдгээ тогтоолгон, Бурхантай эвлэрдэг. Бид Бурханы хүүхдүүд бөгөөд хэрэв түүнд итгэж, тушаасных нь дагуу амьдарвал Христтэй хамт өв залгамжлагчид байж болох боломжтой гэдгийг гэрчил.

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг нь эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Би Есүс Христийн сайн мэдээнээс ичихгүй” (Ром 1:16.)

Ангийн гишүүнээр Ром 1:16-г уншуул.

- Бид Есүс Христийн сайн мэдээнээс ичихгүйгээ хэрхэн үзүүлж чадах вэ? (1 Петр 3:15-аас нэг зөвлөгөө авахаар үз. Ангийн гишүүдийн хариултыг самбарт бичиж, ангийн гишүүн бүрийг эдгээр зүйлүүдээс ядаж нэгийг нь ирэх долоо хоногт хийхийг уриал.)

2. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Ангийн гишүүдэд хуудас цаас, харандаа эсвэл бал өг. Ангийн гишүүдээр Ром 8:31-ээс дараах асуултыг цаасан дээр нь бичүүл. “Хэрэв Бурхан бидний талд байвал хэн бидний эсрэг байх вэ?” (Та Иосеф Смитийн Орчуулгаас хэн биднийг ялж чадах вэ гэсэн өгүүлбэрийн хэсгийг хэрэглэж болно.)

Ангийн гишүүдийн өдөр тутмын амьдралд энэ мэдэгдэл тэднийг хэрхэн зоригжуулах тухай ярилц. Ангийн гишүүдийг энэ бичгээ үргэлж харж байхаар газар тавихыг уриал.

Есүс Христ “Бидний Итгэлийн Зохиогч Бөгөөд Төгсгөгч”

Хичээл
37

Еврей

Зорилго

Ангийн гишүүдэд аврал нь Есүс Христэд итгэх итгэл болон түүний зарлигуудад дуулгавартай байснаас ирдэг гэдгийг сануулах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Еврей 1–4. Паул Есүс Христийг Тэнгэрлэг Эцэгийн Заяасан Ганц Хүү, бидний Аврагч хэмээн гэрчилдэг.
 - б. Еврей 5; 6:20; 7. Паул Мелкизэдэк Пристийн Зэрэг нь сайн мэдээний бүрэн дүүрэн байдлын нэг хэсэг нь гэж тайлбарладаг.
 - в. Еврей 8:1–10:18. Паул Есүс Христийн сайн мэдээ нь шинэ гэрээ юм бол Мосегийн хууль нь Бурхан, түүний хүүхдүүд хоёрын хооронд байгуулсан хуучин гэрээ байсан хэмээн заадаг.
 - г. Еврей 10:19–11:40. Паул Гэгээнтнүүдийг Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, тэгснээрээ тэд Бурханы хаант улсад орших газрыг өвлөн авна гэж уриалдаг.
2. Нэмэлт Уншлага: Еврей 6; 12–13.
3. Заахад зориулсан зөвлөмж: Үргэлж яриад байхаас зайлсхий. Заримдаа та мэдээлэл өгөхийн тулд ярих хэрэгтэй болж болно, гэвч дан ганц ярихыг заах аргаа болговол энэ нь үр нөлөөгөө алддаг. Мэдээлэл өгөх болон зарчмыг тайлбарласны дараа ангийн гишүүдэд хариулах, саналаа хэлэх боломж олгоход анхаар.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Дараах нөхцөл байдлуудыг тайлбарлаад, ангийн гишүүдээс эдгээрийн нэгэнд нь хэрэглэж болох судрыг хайж олохыг хүс. (Хаалтанд хэд хэдэн судрын хэсгийг санал болгон өгөв.)

1. Таны таньдаг хүүхэд хүүхдийн хэсгийн хичээл дээр Есүс Христ дэлхийг бүтээсэн гэдгийг дөнгөж сая мэдэж авсан бөгөөд энэ тухай аль сударт тайлбарласан байдгийг мэдэхийг хүсчээ (Еврей 1:2; Иохан 1:1–3, 10; Ефес 3:9; Мозая 3:8).
2. Найзад чинь хувийн зарим асуудал гарсан бөгөөд тэрээр Аврагч түүнийг анхаарч үзэж эсвэл юуг туулж байгааг нь ойлгодог болов уу хэмээн гайхаж байна (Еврей 2:6–8, 18; 2 Нифай 1:15; Алма 7:11–12).
3. Гишүүн бус найз чинь пристийн зэрэгтэй хүн усан баталгаа болон бусад ёслолуудыг гүйцэтгэх нь үнэхээр шаардлагатай юм байх даа гэж гайхаж байна (Еврей 5:1–4; Египетээс гарсан нь 28:41; Иохан 15:16).

Ангийн нэг юмуу хоёр гишүүнээс нөхцөл бүрт сонгосон шүлгүүдийг уншихыг урь. Паулын Еврейчүүдэд бичсэн захидалд гурван нөхцөлд гурвууланд нь хэрэглэгдэж болох судрууд бий гэдгийг цохон тэмдэглэ. Ангийн гишүүдийг Еврейн номны тухай ярилцахдаа эдгээр судруудыг сонсохыг урь.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

Паул номлолынхоо ажлын турш Сүмийн гишүүдийг Мосегийн хуулийг дахин дагах ёсгүй гэдэгт итгүүлэхийг чармайсан гэдгийг тайлбарла. Иудейчүүдийн Христэд итгэгчид Есүс Христэд итгэх итгэлээр аврал ирдэг гэдгийг заалгасан ч гэсэн тэдний олонх нь Мосегийн хуулийг дуулгавартай дагах нь тэдний авралд нэн чухал гэдэгт итгэсээр байв. Паул Мосегийн хуулийг Христээр гүйцэлдүүлсэн гэдгийг дахин онцлон тэмдэглэхийн тулд Еврейчүүдэд захидал бичсэн.

1. Есүс Христ, Тэнгэрлэг Эцэгийн Заяасан Ганц Хүү бол Бидний Аврагч.

Еврей 1–4-ийг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг уншихыг урь.

- Еврей 1-ээс бид Есүс Христийн тухай юу сурдаг вэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбарт жагсааж бич. Дор бичсэн зүйл нь хариултанд орж болно.)
 - а. Тэр дэлхийг бүтээсэн (шүлэг 2, 10).
 - б. Тэр Бурхан Эцэгийн дүрээр бүтээгдсэн (шүлэг 3).
 - в. Тэр бидний нүглийг цагаатгасан (шүлэг 3).
 - г. Тэр Бурхан Эцэгийн Ууган Хүү (шүлэг 5–6).
 - д. Түүний алдар, хүч бол мөнхийн ба өөрчлөгдөшгүй (шүлэг 8, 12).
- Паул, “тэнгэр элч нараас илүү ихийг өвлөсөн” (Еврей 1:4). Бурханы Хүү нь мөн “тэнгэр элч нараас арай дорд болгогдсон” гэж хэлсэн (Еврей 2:9). Есүс ямар байдлаар “тэнгэр элч нараас арай дорд болгогдсон” бэ? (Мозая 13:34–35-ыг үз. Тэрээр дэлхийд мөнх бусаар ирсэн бөгөөд өвдөлт, үхлийн хараанд байсан.) Энэ нь яагаад шаардлагатай байсан бэ? (Еврей 2:9–10, 16–18; 4:15–16; мөн Матай 23:10–11-ийг үз.)
- Паул Гэгээнтнүүдийг зөв шударга амьдар, тэгснээрээ тэд Бурханы амралтад орно гэж уриалсан (Еврей 3:7–19; 4:1–11). Бурханы амралтад орох гэдэг нь юу гэсэн үг вэ? (С ба Г 84:23–24; 3 Нифай 27:19-ийг үз.) Паул Мосегийн үед Израилийн зарим хүүхдүүд яагаад Бурханы амралтад орох боломжгүй байсныг тайлбарладаг. (Еврей 3:7–11, 16–19; 4:1–2-ыг үз.) Бид Бурханы амралтад ороход зохистой болохын тулд хэрхэн нэг нэгэндээ тусалж чадах вэ? (Еврей 3:13–14; 4:11; Алма 13:12–13, 16-г үз.)

2. Мелкизэдэк Пристийн Зэрэг нь сайн мэдээний бүрэн дүүрэн байдлын нэг хэсэг.

Еврей 5; 6:20; 7-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Паул эрэгтэй хүн пристийн зэргийн эрх мэдлийг хэрхэн хүлээн авч, хэрэглэх талаар юу заасан бэ? (Еврей 5:1–4-ийг үз.) Пристийн зэрэгтэн “өөртөө энэ хүндлэлийг авчихын” оронд яагаад Бурханаар дуудагдсан байх ёстой вэ?

- Мосегийн хуулинд пристийн зэргийн ямар эрх мэдэл орсон бэ? (Аароны пристийн зэрэг мөн Левийн арай бага, эсвэл пристийн зэргийн бэлтгэл гэж нэрлэгддэг. С ба Г 84:25–27-г үз.) Есүс Христ пристийн зэргийн ямар эрх мэдлийг атгадаг вэ? (Еврей 5:5–6; 6:20-ийг үз.) Есүс ирж Мосегийн хуулийг гүйцэлдүүлэхдээ тэр мөн Мелкизэдэк Пристийн Зэргийг дахин сэргээсэн гэдгийг тайлбарла. Энэ нь яагаад шаардлагатай вэ? (Еврей 7:11-ийг үз.) Аароны Пристийн Зэрэг нь авралд шаардлагатай бүх ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлгүй.)

“Мосегийн хууль, Аароны Пристийн Зэргийн аль нь ч Бурханы хүүхдүүдэд төгс төгөлдрийг авчрах бололцоогүй байсан. Аароны Пристийн зэрэг нь арай бага эрх мэдэл бөгөөд зөвхөн сайн мэдээний бэлтгэлийг үйлддэг. Мелкизэдэк Пристийн Зэрэг, нөгөө талаас нь илүү дээд пристийн зэрэг ба сайн мэдээний ёслолуудыг бүрэн дүүрнээр үйлдэх, бидний амьдралыг цэвэрлэн ариутгах, ингэснээр бид Их Эзэний дэргэд дахин очиж чадах үүрэгтэй” (*The Life and Teachings of Jesus and His Apostles* [Church Educational System manual, 1979], 385–86; see also D&C 107:18–20).

- Бид яагаад Мелкизэдэк Пристийн Зэргийг илүү дээд пристийн зэрэг гэж нэрлэдэг вэ? (С ба Г 107:2–4-ийг үз.) Өнөөдөр Сүмийн гишүүд Мелкизэдэк Пристийн Зэрэг мөн Аароны Пристийн зэрэгтэй байснаар хэрхэн адислагдаж байна вэ? Пристийн Зэрэг таны амьдралыг хэрхэн адисласан бэ?

3. Есүс Христийн сайн мэдээ бол Бурхан түүний хүүхдүүд хоёрын хоорондох шинэ гэрээ юм.

Еврей 8:1–10:18-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Паул Сүмийн гишүүдэд Мосегийн хуулийн дор шүтэж байсан шүтлэг нь Их Эзэн, Есүс Христийг илэрхийлж байсныг сануулсан гэдгийг тайлбарла.

- Еврей 8:5-д заасны дагуу Израильчууд бишрэл шүтлэгээ хийх газар болгон табернэклийг барьж байхад Мосед юу хий гэж Их Эзэн хэлсэн бэ? (Табернэклд үйлддэг байсан ёслолууд нь дор үзүүлсэнтэй адил “тэнгэрлэг зүйлсийг” бэлэгдэж байсныг тайлбарла.)

Табернэкл дэх ёслолууд:	Юуг бэлэгдсэн бэ:
а. Пристүүд Бурханд золиослол болгон амьтдыг өргөдөг байсан (Еврей 10:1–4, 11).	Есүс өөрийгөө бидний нүглийн төлөө золиослол болгон өгсөн (Еврей 9:26–28; 10:4–12).
б. Пристүүд золиосолсон амьтны цусыг хүмүүсийг цэвэр ариун болгох байдлыг бэлэгдэн тахилын ширээн дээр тавьдаг байсан (Еврей 9:6–7, 19–23).	Цагаатгалын үед асгарсан Есүсийн цус биднийг нүглээс цэвэрлэн, ариусгадаг (Еврей 9:11–15).
в. Дээд прист нь Ариунаас Ариун өрөөнд хөшгөөр нэвтрэн ордог байсан (Еврей 9:1–7).	Агуу, дээд прист Есүс хөшгөөр дамжин тэнгэр лүү явсан (Еврей 9:24).

- Паул Мосегийн хууль нь Бурхан түүний хүмүүс хоёрын хоорондын хуучин гэрээ байсан гэж тайлбарласан. (Еврей 8:9; мөн Галат 3:24–25-ыг үз.) Есүс Христийн авчирсан шинэ гэрээ нь юу вэ? (Еврей 8:6–8, 10–13-ыг үз. Сайн мэдээний бүрэн дүүрэн байдал). Хуучин гэрээг Библийн Хуучин Гэрээнд, шинэ гэрээг Шинэ Гэрээ номонд тайлбарласныг цохон тэмдэглэ.
- Хуучин гэрээ яагаад үүнийг дагадаг хүмүүсийг төгс болгох боломжгүй байсан бэ? (Еврей 10:1–4-ийг үз.) Шинэ гэрээ яагаад бидэнд төгс төгөлдрийг хүртэхэд илүү их найдлага төрүүлдэг бэ? (Еврей 10:9–18-ыг үз.)

4. Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлдэг хүмүүс Бурханы хаант улсад орох газрыг өвлөнө.

Еврей 10:19–11:40-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Паул Мосегийн хуулийг орлох сайн мэдээний бүрэн дүүрэн байдлыг илүү дээд, илүү бүрэн гүйцэд хууль болохыг нь тайлбарласан ба Гэгээнтнүүдийг Есүс Христэд итгэн энэ “шинэ, амьд замыг” дагахыг уриалсан гэдгийг цохон тэмдэглэ.

- Сүмийн анхны буюу хамгийн үндсэн зарчмууд юу вэ? (Итгэлийн тунхаг 1:4-ийг үз.) Итгэл гэж юу вэ? (Еврей 11:1; Алма 32:21; Эфэр 12:6-г үз.) Итгэл нь найдахаас хэрхэн илүү байдаг вэ? Есүс Христэд итгэх итгэл яагаад бидний авралд нэн чухал вэ?
- Паул Есүс Христэд итгэх итгэлээрээ агуу зүйлүүдийг гүйцэтгэсэн хүмүүсийн олон жишээг дурьдсан. Тэр хэний тухай дурьдсан бэ? (Еврей 11:4–12, 17:34-ийг үз.) Тэдгээр дурьдагдсан хүмүүсийн нэрсийг самбарт бичээд, хүн нэг бүрийн үйл хэрэгт итгэл хэрхэн шаардагдсаныг ярилц.
Та ангийн гишүүдийг хэсэг бүлэг болгон хувааж энэ ярилцлагыг явуулж болно. Хэсэг бүрт Еврей 11-т гарсан хэдэн хүмүүсийн талаар ярилцуулахаар даалган өг. Тэдгээр хүмүүсийн үйл хэрэгт итгэл хэрхэн шаардлагатай байсныг ярилцуулахын тулд хэсгүүдэд хэдэн минутын хугацаа өгөөд дараа нь хэсэг бүрийн дүгнэлтийг ангийнханд товч танилцуул.
- Түүнчлэн Паул итгэл нь саад тотгор юмуу эсэргүүцлийн үед бидэнд тусалдаг гэж заасан (Еврей 11:32–38). Саад тотгорыг давахад итгэл танд хэрхэн тусалсан бэ? Та эсвэл таны мэддэг хэн нэгэн Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлснээр өөр ямар адислалуудыг хүлээн авсан бэ?

Дүгнэлт

Бид сайн мэдээний бүрэн дүүрэн байдал боломжтой болсон цаг үед амьдрахаар адислагдсан гэдгийг цохон тэмдэглэ. Аврал нь Есүс Христэд итгэх итгэл, түүний зарлигуудыг дуулгавартай дагаснаар ирдэг гэдгийг гэрчил. Ангийн гишүүдэд дахин сэргээгдсэн сайн мэдээний гэрээг сахин, зарлигуудыг дагахыг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. Бурхан амлалтаа биелүүлнэ.

- Еврей 6:10–19-т Бурхан хүүхдүүддээ амласан амлалтын талаар юу заадаг вэ? 15-р шүлэгт саад тотгорыг давах, Бурханаас амласныг нь хүлээн авах хоёрын холбооны талаар юу гэж заадаг вэ? (Мөн С ба Г 82:10-ыг үз.) Бурхан танд амласнаа биелүүлсэн ямар явдал танд тохиолдсон бэ?

2. “Их Эзэн хайрладаг хүнээ сахилгажуулдаг” (Еврей 12:6)

Еврей 12:5–11-ийг ангийн гишүүдээр уншуул.

- Их Эзэн биднийг хэрхэн сахилгажуулдаг вэ? Их Эзэний сахилгажуулалт хэрхэн бидний төлөө байдаг вэ? (Еврей 12:10; С ба Г 61:8; 95:1; 101:5-ыг үз.) Бид сахилгажуулалтыг хэрхэн сурч мэдэх, өсч хөгжих боломж болгон ашиглаж болох вэ? Ангийн гишүүдээс Их Эзэн тэднийг сахилгажуулсан үеийн тухай, энэ явдлаас юу сурснаа ярихыг урь.

Зорилго

Ангийн гишүүдийг саад тотгор, гай гамшгийн дунд Паулын үлгэр жишээг дагаж, Есүс Христийн итгэлтэй гэрчүүд байхад уриалах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Үйлс 21:1–22:21. Амьдралаа алдана гэж айж эсэргүүцсэн хамтрагч нараа эс харгалзан Паул Иерусалим руу явдаг. Тэр номлолын ажлынхаа тухай тэнд байсан ах нарт мэдэгддэг. Тэрээр ариун сүмд очиж, уурласан дээрэмчдэд баригддаг. Мянгатын дарга түүнийг баривчилсан боловч хүмүүст үг хэлэхийг зөвшөөрдөг. Паул хүмүүст Есүс Христийн сайн мэдээг сонсож өөрчлөгдсөн тухайгаа ярьдаг.
 - б. Үйлс 22:22–23:35. Дээрэмчид Паулыг эсэргүүцэж, түүний амийг авахыг эрдэг, Мянгатын дарга Паулыг дээрэмчдийг гараас авч, түүнийг хуаранд аваачдаг. Дараагийн өдөр мянгатын дарга Паулыг ахлах тахилчийн өмнө авчрав. Өөр нэгэн их маргаан болж, мянгатын дарга Паулыг дахин хуаранд авчирдаг. Шөнө нь Их Эзэн Паул дээр ирж Иерусалимд түүнийг гэрчилсэн шиг Ромд түүнийг гэрчлэхээр дуудагдсан гэж хэлэв. 40 гаруй хүн Паулыг алахаар хуйвалддаг бөгөөд түүнийг хамгаалахын тулд ахлах тахилч руу аваачдаг.
 - в. Үйлс 26. Хэдэн жилийн мөрдлөгө хавчлага, хорионыхоо дараа Паул Агрийп Хаанд гэрчлэхээр ирдэг. Агрийп Паулын гэрчлэлийг эсэргүүцдэг ба түүнийг Ром руу Цезарьтай уулзуулахаар илгээдэг.
 - г. Үйлс 27–28. Усан онгоцны ахмад Паулын зөвлөгөөг үл ойшоосны дараа усан онгоц Ром орох замдаа сүйрдэг. Эцэст нь тэрээр Ромд ирээд шоронд хоригддог ч сонсох бүх хүмүүст номлодог.
2. Дараах материалууд байгаа бол заримаас нь хичээлдээ хэрэглэ:
 - а. *New Testament Video Presentations* (53914)-ийн “Paul—A Chosen Vessel” 11 минутын бичлэг. Боломжтой бол энэ бичлэгийг урьдчилж үз, ингэснээр ярилцахын тулд та бичлэгийг хэзээ зогсоохоо мэднэ.
 - б. Паулын Ром руу аялсан газрын зураг.
3. Заахад зориулсан зөвлөмж: “Таны зааж байгаа хүмүүс ямар нэгэн зүйл сурч тэжээгдэх хэрэгтэй байдаг. Тэд хичээлд ирэх бүрт дор хаяж нэг санаа, нэг бодол, нэг урам олж мэдэж авах ёстой. Энэ нь ердийн л нэг бяцхан бодол байж болно, үнэндээ та хэр их үндсэн зүйлийг заана төдий чинээ үр дүнд хүрнэ” (Boyd K. Packer, *Teach Ye Diligently* [1975], 154).

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

- Адил төстэй бодол санаа, туршлага, нөхцөл байдлаас шалтгаалж таны тодорхойлж хэлж чадна гэж боддог хүн сударт бий юу? Та чухам яагаад энэ хүнтэй ойролцоо гэж боддог вэ?

Ангийн хэдэн гишүүнийг саналаа хэлэх боломж олго. Дараа нь Бошиглогч Иосеф Смит өөртөө тохиолдсоноо эргэн бодоод түүнд тохиолдсон явдал нь Төлөөлөгч Паулд тохиолдсонтой адил мэт сэтгэгдэл төрсөн гэдгийг цохон тэмдэглэ. (Иосеф Смитийн Түүх 1:23–25-ыг үз.)

Төлөөлөгч Паулын Агрийп Хааны өмнө ирсэн явдал нь энэ хичээлд ярилцах үйл явдлуудын нэг гэдгийг тайлбарла. Энэ тохиолдолд болон түүний номлолын ажлын туршид Паул эсэргүүцэл мөрдлөг хавчлагыг эс харгалзан итгэлдээ баттай зогсож, Есүс Христийг зоригтойгоор гэрчилсэн.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа Паулын адил хүчтэй итгэл, зоригоо хэрхэн хөгжүүлж болох тухай ярилц. Ангийн гишүүдийг үг яриа болон үйлдлээрээ гэрчлэлээ зоригтойгоор гэрчилсэн үеийнхээ тухай ярихыг уриал.

1. Паул ажлынхаа тухай мэдэгдэж, уурласан дээрэмчидтэй Иерусалимд тааралддаг.

Хэрэв та “Paul—A Chosen Vessel” дүрс бичлэгийг хэрэглэх гэж байгаа бол эхний хэсгийг одоо үзүүл. “Түүний нэрийг хаад, удирдагчдын өмнө гэрчилнэ хэмээсэн Их Эзэний үгсийг биелүүлсэн” гэж өгүүлэгчийг хэлсний дараа бичлэгээ зогсоо. (Эдгээр үгсийг хэлж байхад Паулыг хэдэн цэргүүд үүдний өрөөнд манаад зогсож байдаг.)

Үйлс 21:1–22:21-ийг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон хэсгүүдийг уншихыг урь. Паул Ромын хаант улсыг нийтэд нь туулсан амжилттай гурван номлолын ажлынхаа дараа ингэх нь аюултай гэж мэдэж байсан ч Иерусалимд буцаж ирсэн.

- Паулын найзууд яагаад түүнийг Иерусалимд буцаж ирэхийг нь болиулах гэж оролдсон бэ? (Үйлс 21:10–12-ыг үз.) Паул найзуудынхаа сэтгэл зовсон байдалд юу гэж хариулсан бэ? (Үйлс 21:13-ыг үз.) Энэ нь Паулын Христэд өгсөн амлалтыг хэрхэн харуулсан бэ?
- Иерусалимд очсон өдрийнхөө маргааш Паул юу хийсэн бэ? (Үйлс 21:17–19-ийг үз.) Энэ нь өнөөдөр номлогч нар номлолоосоо эргэж ирснийхээ дараа хийдэг зүйлтэй хэрхэн адил байна вэ? (Тэд номлолоосоо сурсан зүйлээ гадасны ерөнхийлөгч ба дээд зөвлөлд, мөн үе үе хэсэг, салбарын гишүүдэд ариун ёслолын цуглаан дээр мэдээлдэг.) Бусдын номлолын туршлагаас сонсох нь танд ач тусаа хэрхэн өгсөн бэ?
- Христэд итгэгч олон Иудей хүмүүст аврал нь Мосегийн хуулиар бус Есүс Христээр ирдэг гэдгийг заахаар Паул дахин дахин тэдэн дээр очсон (Үйлс 15:1–35). Эдгээр хүмүүсийн хүсэлд нийцүүлэх гэж Иерусалим дахь ах нар Паулыг ариун сүмд очиж, цэвэршүүлэх ёсыг үйлдэж, тэр ч хуулийг дагадаг гэдгийг үзүүлэхийг хүссэн (Үйлс 21:20–25). Паул ариун сүмд байхад юу тохиолдсон бэ? (Үйлс 21:26–30-ийг үз.) Түүнийг Мосегийн хуулийг эсэргүүцэн зааж, ариун сүмд Иудей биш хүн авчран бохирдуулсан хэмээн буруушааж дээрэмчид барьсан. Паул эдгээр дээрэмчдээс хэрхэн зугтсан бэ? (Үйлс 21:31–36-г үз.) Мянгатын дарга Паулыг хүмүүст үг хэлэхийг зөвшөөрөхөд тэр юу хийсэн бэ? (Үйлс 21:37–22:21-ийг үз.) Үүнд яагаад эр зориг шаардагдсан бэ?

Та Үйлс 21–28 дээрээс Паул Есүс Христийн гэрч байж агуу эр зориггоо үзүүлсэн үеүдийг самбарт бичиж эхэлж болно. Хичээлийн явцад зохих үед нь жагсаалтандаа нэмж бич.

- Та эр зориг шаардагдсан ямар үед гэрчлэлээ хуваалцсан бэ? Үүнийг хийх эр зоригийг та хэрхэн олсон бэ? Паулын үйлсийг сурч авах нь биднийг гэрчлэлээ бусдад хуваалцах илүү зоригтой байхад хэрхэн туслах вэ?

2. Паулыг Дээд Зөвлөлийн өмнө аваачдаг.

Үйлс 22:22–23:35-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Ариун сүмийн гадна байсан олон түмэн Паулын өөрчлөгдсөн түүхийг сонсоод юу гэж хариулсан бэ? (Үйлс 22:22-ыг үз.) Паулыг дээрэмчдээс холдуулсан мянгатын даргын зорилго юу байсан бэ? (Үйлс 22:24-ийг үз.) Ташуурдуулахаас Паул яаж зайлсхийж чадсан бэ? (Үйлс 22:25–26-г үз. Тэр өөрийгөө Ром хүн гэж хэлсэн. Энэ нь Иерусалимын нэг хэсэг байсан Ромын хаант улсад багтах онцгой эрх, завшааныг түүнд өгсөн.)
- Паулыг Дээд Зөвлөлийн (Иудейн зөвлөл) өмнө авчрахад түүний хамгийн түрүүнд хэлсэн зүйл юу байсан бэ? (Үйлс 23:1; мөн Үйлс 24:16-г үз. С ба Г 135:4-өөс Иосеф Смитийн мэдэгдсэнтэй адил зүйлийг олохоор үз.) Паулын “Бурханы талаарх зөв мэдрэмж” энэ үед түүнд хэрхэн тусалсан гэж та бодож байна вэ? Ангийн гишүүдээс “Бурханы талаар зөв мэдрэмжтэй” байхын тулд өөрсдийн амьдралдаа ямар өөрчлөлт хийх хэрэгтэйгээ бодохыг урь.
- Дээд зөвлөлийг шалгасны дараа Паулд Их Эзэн харагдахдаа юу гэж хэлсэн бэ? (Үйлс 23:11-ийг үз.) Таныг хүнд хэцүү цагт “сайныг дэмжигч байхад” Их Эзэн яаж тусалсан бэ?
- Их Эзэнийг Паулд үзэгдсэн өдрийн маргааш нь зорьсондоо хүртлээ идэж, уухгүй гэж ам тангараг өгөн 40 гаруй Иудейчүүд Паулыг алахаар хуйвалддаг (Үйлс 23:12–15). Тэдний төлөвлөгөөнөөс Паулыг хэрхэн хамгаалсан бэ? (Үйлс 23:16–35-ыг үз. Энэ нь нэг өдөр гурав дахь удаагаа Паул үхлээс хамгаалуулсан явдал байсан гэдгийг та цохон тэмдэглэж болно.)

3. Паул Агрийпт гэрчилдэг ч, түүний гэрчлэлийг эсэргүүцдэг.

Үйлс 26-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Та Үйлс 24–25-аас дараах мэдээллийг дүгнэн ярьж болно. Паул захирагч Фелик дээр ирж, түүний өмнө зоригтойгоор гэрчилдэг. Фелик түүнийг чөлөөлөөд мөнгө авна гэж найдаж байсан ч Паул шоронд хоёр жил суусан. Фелик захирагч Фестээр солигдож Иудейчүүд Фестээс Паулыг Иерусалим руу явуулж, замд нь саад тотгор учруулахаар гуйсан. Паул тийшээ сайнаар явахгүй гэдгээ мэдэж байсан тул явахаас татгалзсан. Харин тэр Ромынх тул өөрт байсан эрхээрээ Цезарьт давж заалдсан. Фест Паулыг Ром руу илгээхийг зөвшөөрсөн ч Паул эхлээд Иудейн газрын удирдагч хэмээн Ромчуудын томилсон Херодийн Агрийптэй уулзсан.

Та дүрс бичлэг хэрэглэж байгаа бол хоёрдугаар хэсгийг үзүүл. Паулын “Зөвхөн та ч биш, харин өнөөдөр энд намайг сонсогсод бүгдээрээ энэхүү гинжнээс бусдаар надтай адил болоосой гэж би Бурханд залбирмаар байна” гэж мэдэгдсэний дараа бичлэгээ зогсоо. (Агрийп хааны шүүлтээс харуул

хамгаалалттай гарч явахын яг өмнө.)

- Паулын Агрийп хаанд хэлсэн үгний юу нь таны сэтгэлийг хөдөлгөсөн бэ? (Үйлс 26:2–27-г үз.) Агрийп Паулын үгст юу гэж хариулсан бэ? (Үйлс 26:28-ыг үз. Агрийпийг Христэд итгэгч болоход юу саад болсон бэ? Өнөөдөр хүмүүсийг Есүс Христийн сайн мэдээг хүлээн зөвшөөрөхөд ямар зан байдал эсвэл өөр бусад асуудлууд тэдэнд саад болдог вэ?)
- Паулд өгсөн Фест, Агрийп нарын хариултууд ямар ялгаатай байсан бэ? Тэд юугаараа адил байсан бэ? (Үйлс 26:24, 28-ыг үз. Их Эзэн бүрэн гүйцэт сэтгэл зүрхээ зориулахаас өөр юуг ч хүлээн зөвшөөрдөггүйг цохон тэмдэглэ. Хэдийгээр Агрийп Паулын мэдээнд бараг итгэсэн ч Фест түүнийг шууд эсэргүүцсэн, хоёулаа Паулын тэдэнд санал болгосон итгэлийн шалгуурыг даваагүй.)

4. Паул Ром руу явж байгаад усан онгоцны сүйрэлд өртдөг.

Үйлс 27–28-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Агрийп Паулыг чөлөөлөх хүсэлтэй байсан (Үйлс 26:32), харин Паул Цезарьт давж заалддаг тул Ром руу явдаг. Паулын Ром орох аяллын тухай ярилцахдаа газрын зураг үзүүлж холбогдох газруудыг заа. Үүнд, өвлийг өнгөртөл явалгүй үлдэхийг Паул нэгэн эрд зөвлөж байсан газар болох Үзэсгэлэнт Боомт, усан онгоцны сүйрэлд өртсөн зорчигчид эрэг рүү сэлж гарсан газар болох Малта (Мальт) гэх зэрэг газрууд.

- Усан онгоцны ахмад Үзэсгэлэнт Боомтоос далайд гарч явах нь хэтэрхий аюултай гэж Паулын сэрэмжлүүлснийг эсэргүүцэхэд юу тохиолдсон бэ? (Үйлс 27:7–20-ийг үз.) Паулын зөвлөгөөг үл тоомсорлоход зуутын даргыг юу өдөөсөн бэ? (Үйлс 27:11–12-ыг үз.) Бидний зарим нь яагаад тохиолдлоор сүмийн удирдагчдынхаа зөвлөгөөг эс тоодог вэ?
- Паул унсан онгоц шуурганд сүйрсэн ч гэсэн бүх зорчигчдыг газар дээр аюулгүй хүрнэ гэдгийг яаж мэдэж байсан вэ? (Үйлс 27:21–26-г үз.) Бошиглол хэрхэн биелсэн бэ? (Үйлс 27:27–44-ийг үз.)
- Мальтын арал дээр байхдаа Паул пристийн зэргийн хүчээ хэрхэн хэрэглэсэн бэ? (Үйлс 28:7–9-ийг үз.) Энэ явдал пристийн зэргийн хүч чадлын тухай юу зөвлөдөг вэ? Пристийн зэргийг дээдлэх нь биднийг Христийн гэрчээр үйлчлэхэд хэрхэн тусалдаг вэ?
- Хэдэн сарын дараа Паул эцэст нь Ромд ирж дахин шоронд ордог. Тэр энэ саадыг хэрхэн өөртөө сайнаар ашигласан бэ? (Үйлс 28:16–31-ийг үз. Тэр тодорхой нэг эрх чөлөөтэй болсон бөгөөд энэ үедээ сайн мэдээг зааж, Христийг гэрчилсэн. Есүс Христийн итгэлтэй гэрч байх талаар бид Паулаас юу сурч болох вэ? (Та Паулын итгэлтэй гэрч байх эр зориггоо харуулсан үеүдийг нь самбарт бичсэн бол түүнийгээ хэрэглэ.)

Та дүрс бичлэг үзүүлж байгаа бол үлдсэн хэсгийг одоо үзүүл.

Дүгнэлт

Түүхчдийн нотолгоогоор Паул МЭ 65 оны үед Ромд алуулж нас барсан гэдгийг тайлбарла. Амьдралынхаа туршид тэр Төлөөлөгчийн хувьд “явж бүх үндэстэнд заах” үүргээ гүйцэтгэсэн (Матай 28:19). Мөн тэр сайн мэдээг “харь үндэстнүүд, хаадад, Израилийн хүүхдүүдэд” заана гэсэн Их Эзэний бошиглолыг биелүүлсэн (Үйлс 9:15). Тэр аман болон бие махбодын

хандлага, шударга бус хорио, байгалын гамшгийг эс харгалзан Христийн итгэлтэй гэрч байсан.

Бид Паулын жишээг бүхий л нөхцөлд Есүс Христийн итгэлтэй гэрч байснаар дагахад тэр бидэнд саад тотгорыг давж туулах эрч хүчийг өгдөг гэдгийг гэрчил.

Заах Нэмэлт

Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэхүү санааг хичээлдээ хэрэглэж болно.

Паулын амьдралыг дүгнэх нь

Паул, Христийг гэрчлэх амьдралын номлолоо хэрхэн биелүүлснийг хүндэтгэн үнэлэхэд ангийн гишүүдэд туслахын тулд гишүүн бүрийг Паулын амьдралд Христийг гэрчилсэн нэг нэг явдлыг сонгуул. Сонгосноо ангийнхантайгаа хуваалцахад гишүүн бүрийг урьж, бүх үйл явдлыг самбарт бич. Хэрэв үйл явдлын болсон газрыг тогтоох шаардлагатай бол ангийн гишүүдийг зохих судруудыг нягтлан үзэхэд тусал.

“Гэгээнтнүүдийг Төгс Төгөлдөр Болгохын Тулд”

Хичээл
39

Ефес

Зорилго

Ангийн гишүүдийг “Гэгээнтнүүдийг . . . төгс төгөлдөржүүлэх” (Ефес 4:12) үйл явц нь биднээс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, төлөөлөгч, бошиглогчдын сургаалыг дагаж, мөн өөрсдийгөө дэлхийн бусармаг явдлаас хамгаалахыг шаарддаг хэмээн ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Ефес 1:9–10. Паул цаг хугацааны бүрдлийн эрин үеийн зорилго нь “бүх зүйлүүдийг Христэд нэг болгон цуглуулах” явдал юм гэж заадаг.
 - б. Ефес 2:12–22; 4:1–16. Паул Есүс Христ бол бидний тулгын чулуу хэмээн заадаг. Тэр Их Эзэн биднийг төгс төгөлдөр болоход тусалж, “итгэлийн нэгдэлд” хүрэхэд туслуулахаар төлөөлөгч, бошиглогчдыг өгсөн гэж заадаг.
 - в. Ефес 5:22–29; 6:1–4. Паул эхнэр нөхөр, эцэг эх хүүхдийн хоорондын нэгдлийн тухай заадаг.
 - г. Ефес 4:21–32; 6:10–18. Паул бид өөрсдийгөө дэлхийн бусармаг явдлаас хамгаалахын тулд)
2. Нэмэлт Уншлага: Иохан 17:11; Мозая 18:21–22; Сургаал ба Гэрээ 27:15–18; 38:25–27.
3. Та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл ангидаа (ойролцоогоор 30–90см урт) утас мөн адил урттай олс авчир.
4. Заахад зориулсан зөвлөмж: Сударт тэмдэглэгээ хийх нь багш болон ангийн гишүүдийг чухал үгс, санаа, хүмүүс, үйл явдал зэргийг тэмдэглэхэд тусалдаг. Та ангийн гишүүдэд чухал зарчмуудыг цохон тэмдэглэж, харьцуулалт шүлэг өгч эсвэл өөрийн судрын захад юу бичсэнээ хэлж судартаа тэмдэглэгээ хийхийг уриалж болно.

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Ангийн гишүүдэд утас, олсоо үзүүл. (“Бэлтгэл” хэсгийг үз.)

- Утас, олс хоёрт адил тал юу байдаг вэ? (Хоёулаа утас, хялгасаар хийгдсэн.) Тэдний ялгаа нь юу вэ? (Утас нь нэг хялгаснаас бүрдэж байхад, олс нь олон хялгаснуудыг сүлжиж хийсэн байдаг.) Энэ хоёрын аль нь илүү хүчтэй вэ?

Бид өөрсөддөө найдсан үедээ утас шиг сул дорой хүчгүй байдаг. Хэдий тийм ч итгэл, зөв шударга байдлаараа нэгдмэл байвал бид олс мэт илүү хүчтэй байдаг. Ефесчүүдэд бичсэн захидалдаа Паул “гэгээнтнүүдийг . . . төгөлдөржүүлж,” “итгэлээрээ” нэгдмэл байхын чухлыг онцлон тэмдэглэсэн

(Ефес 4:12–13). Энэ хичээлд бид гэр бүл, Сүмээрээ хэрхэн төгс төгөлдөр болж, төлөөлөгч, бошиглогчдыг даган, бат бэх холбоотой гэр бүлүүдийг хөгжүүлж, Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөж Аврагчдаа итгэн нэгдмэл болж болох талаар ярилцана.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Ангийн гишүүдийн хэрэгцээнд нийцэх судрын хэсгүүд асуултуудыг залбирч сонго. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Цаг хугацааны бүрдлийн эрин үе

Ефес 1:9–10-ыг уншаад ярилц.

- Ефесийн нэгдүгээр бүлэгт Паул “цаг хугацааны бүрдлийн эрин үеийн” тухай ярьдаг (Ефес 1:10). Сайн мэдээний эрин үе гэж юу вэ? (Их Эзэн дэлхий дээр дор хаяж нэг хүнд пристийн зэргийн түлхүүрүүдийг атгуулж, сайн мэдээг удирдах эрх мэдэлтэй хүнийг байлгах цаг үе.)

- Цаг хугацааны бүрдлийн эрин үе гэж юу вэ? (Иосеф Смитээр дамжин дахин сэргэсэн сайн мэдээ ба Сүмийн байгуулалтын эхэлсэн эрин үе.) Манай эрин үеийг яагаад цаг хугацааны бүрдэлтэй хамааруулдаг вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли заахдаа: “Та бид нар цаг хугацааны бүрдлийн эрин үеийн агуу их, гайхамшигтай адислалуудыг хүртэцгээж байна. Энэ өдөр, энэ цаг үед дэлхий дээр өмнөх бүх эрин үеийн зарчмууд, хүч чадал, адислалууд болон түлхүүрүүд дахин сэргээгдсэн” гэжээ (Conference Report, Apr. 1992, 98; or *Ensign*, May 1992, 70).

- Тэнгэр дэх Эцэг маань энэ эрин үед юу хийнэ гэж Паул хэлсэн бэ? (Ефес 1:9–10-ыг үз.) “Бүх юмсыг Христ дотор нэгтгэх” гэж юу гэсэн утгатай гэж та нар бодож байна вэ? Өнөө үед нэгдэн нэгтгэгдсэн зарим ямар зүйлүүд байдаг вэ? (Хариултанд, судрууд, Сүмийн гишүүд, нас барагсдын бичиг баримтууд, ариун сүмд холбогдсон гэр бүлүүд зэрэг орж болно.) Энэхүү цугларалтын үйл явцад бид хэрхэн тус нэмрээ оруулж чадах вэ?

2. Есүс Христ бидний булангийн чулуу

Ефес 2:12–22 ба 4:1–16-гаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Ефес 2:12 ба 2:19-ийг хооронд нь харьцуул. Аврагчийг хүлээн зөвшөөрч, дагасан тэдгээр хүмүүст гарсан өөрчлөлтүүдийг Паул хэрхэн тайлбарласан бэ? Та үүний адил өөрчлөлтийг өөртөө болон бусдад гарахыг хэрхэн харсан бэ? “Нутгийн иргэдийн” хувьд Сүмийн бусад гишүүдтэй сайн мэдээний дагуух таны харьцаа таны амьдралыг хэрхэн адисалсан бэ?
- Есүс Христ бол Сүмийн “булангийн чулуу” гэж заахдаа Паул ямар утга санааг илэрхийлсэн бэ? (Ефес 2:20.) (Хэрэв шаардлагатай бол булангийн чулуу гэдэг нь хоёр ханын уулзвар дахь буланд байдаг суурь чулуу юм гэдгийг тайлбарла. Булангийн чулуу нь бүтцийг бэхжүүлж, нэгтгэн барьж байхад чухал хэрэгтэй байдаг.) Есүс Христ хэрхэн таны итгэлийн булангийн чулуу болсон бэ?
- Ефес 2:20 ба 4:11–14 дээр Паул төлөөлөгч, бошиглогчдын чухлын талаар юу заасан бэ? Үнэн Сүмд амьд төлөөлөгч, бошиглогчид байх нь яагаад нэн чухал вэ? Биднийг төгс төгөлдөр, нэгдмэл байдал уруу өсч хөгжихөд

тусалдаг хожмын үеийн төлөөлөгч, бошиглогчдын зарим ямар сургаалууд бий вэ? (Та ангийн гишүүдийн хариултуудыг самбарт бичиж болно.)

Ерөнхийлөгч Боид К.Пакер заахдаа: “Бошиглогч, төлөөлөгчдийн үйлчлэл нь тэднийг үргэлж айл өрх, гэр бүлүүд рүү хөтөлдөг. . . . Бидний заадаг бүхний туйлын зорилго нь эцэг эх, хүүхдүүдийг Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр нэгдүүлж, гэртээ аз жаргалтай байх, мөнхийн гэрлэлтээр холбогдон, өөрсдийн үе удамтайгаа холбогдон, Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд өргөмжлөлийг хүртэх баталгаа юм” (Conference Report, Apr. 1995, 8; or *Ensign*, May 1995, 8).

- “Нэг Их Эзэн, нэг итгэл, нэг усан баталгаа” бий гэдгээр Паул ямар утга санааг илэрхийлсэн бэ? (Ефес 4:5.) Сүмийн үндсэн сургаалуудыг ойлгож, заахдаа бид нэгдмэл байх нь яагаад чухал вэ?

3. Эхнэр нөхөр, эцэг эх хүүхдүүдийн хоорондын эв нэгдэл

Ефес 5:22–29; 6:1–4-ийг уншаад ярилц.

- Эхнэр нөхрийн хоорондын харьцааны тухай тайлбарлахдаа Паул юутай харьцуулсан бэ? (Ефес 5:22–29.) Эхнэр нөхрүүд гэрлэлтээ улам их хайр, эв нэгдэлтэй болгохын тулд энэ харьцуулалтаас юу сурч болох вэ? (Есүс Сүмийг хайрладаг байсан тодорхой нэг арга зам, мөн зам бүрийг гэрлэлттэй хэрхэн холбож авч үзэж болох тухай ярилц. Та ангийн гишүүдийн хариултыг самбарт бичиж болно.)

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл заахдаа: “Та нар бүх л ариун судруудаас Их Эзэн, Есүс Христ өөрийн сүмээ хэзээ нэгэн цагт унагаж, доройтуулсан тухай олж чадах уу? . . . Тэр итгэлтэй байсан уу? Тэр үнэнч байсан уу? Түүний өгөөгүй ямар нэгэн сайн, зохистой зүйл бий юу? Тэгвэл тэр нөхрүүдээс юу асуусан, үүнийг л бид асууж байна. . . .

“ . . . Та нар түүнийг хэрхэн Сүмийг хайрласныг бодож чадах уу? Сүмийн амьсгал болгон түүнд чухал байсан. Сүмийн өсөлт болгон, сүмийн хүн нэг бүр түүнд үнэтэй зүйл байсан. Тэрээр тэдгээр бүх хүмүүст бүх хүч чадал, эрч хүч, бүхий л хүсэл сонирхлоо өгсөн юм. Тэрээр мөн өөрийн амьдралаа өгсөн. Үүнээс өөр юу өгч чадах билээ дээ.” (*Men of Example* [address delivered to religious educators, 12 Sept. 1975], 4–5.)

- Ефес 6:1–3-т хүүхдүүдэд Паул ямар зөвлөгөө өгсөн бэ? Энэ зөвлөгөө өнөөдөр яагаад чухал вэ? Та нар эцэг эхээ хүндэтгэснээр хэрхэн адислагдсан бэ?
- Паул эцэг эхчүүдэд хүүхдээ “Их Эзэний дэг журам болон сургамж дотор” хүмүүжүүлэхийг зөвлөхдөө ямар утга санааг илэрхийлсэн бэ? (Ефес 6:4.) Эцэг эхчүүд хүүхдээ хэрхэн сүнсээр нь хүмүүжүүлж чадах вэ? Эцэг эхчүүд хүүхдүүддээ сургамжилж байхдаа хэрхэн Их Эзэний жишээг дагаж болох вэ?
- Паулын эцэг эх, хүүхдүүдэд өгсөн зөвлөгөө гэр бүлийн холбоог хэрхэн бэхжүүлж, айл гэрт эв нэгдлийг бий болгож чадах вэ? Гэр бүлийн талаар ямар зөвлөгөөг хожмын үеийн төлөөлөгчид, бошиглогчид бидэнд өгсөн бэ? Ангийн гишүүдийг саяхон болсон ерөнхий чуулган дээр, өөр бусад цуглаан эсвэл галын дэргэдэх ярилцлага болон Сүмийн сэтгүүлийн нийтлэлд өгсөн зөвлөгөөг ярилцахыг урь.

“Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхагт” Тэргүүн Зөвлөл, Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгынхан “Их Эзэн Есүс Христийн сургаалд үндсэлсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин амьдарна” гэж заасан (*Ensign*, Nov. 1995, 102).

4. “Шинэ хүнийг” мөн “Бурханы бүрэн хуяг дуулгыг” өмсөх нь

Ефес 4:21–32 ба 6:10–18-ыг уншаад ярилц.

- Паул Ефесчүүдийг “шинэ хүнийг өмсөхийг” уриалахдаа ямар утга санааг илэрхийлсэн бэ? (Ефес 4:24.) Есүс Христийн Цагаатгалаар “шинэ” болсон хүмүүсийн зарим зан чанар нь юу вэ? (Ефес 4:21–32-ыг үз.)
- Гэгээнтнүүдийг Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөхийг уриалахдаа Паул тэднийг олон янзын нүгэл нилэнцийн нөлөөнөөс хол байхыг сэрэмжлүүлсэн (Ефес 6:10–12). Энэ амьдралд нүгэл хилэнцийн ямар зарим нэг нөлөө байдаг вэ?
- Паул Бурханы хуяг дуулгыг нэрлэсэн ямар ялгаатай хэсгүүд байдаг вэ? Хэсэг бүр юуг төлөөлдөг вэ? (Ефес 6:13–18; С ба Г 27:15–18-ыг үз. Та *Хуяг дуулга* болон *Бэлэгдэл* гэсэн гарчгийн дор хариултыг самбарт жагсаан бичиж болно.) Бурханы хуяг дуулгын хэсэг нэг бүр биднийг Сатаны нөлөөнөөс хэрхэн хамгаалж чадах вэ? Түүний хуяг дуулгыг өдөр бүр өмсөхийн тулд бид юу хийж болох вэ?

Дүгнэлт

Их Эзэн биднийг түүнтэй адил болж, түүнтэй хамт амьдрахаар эргэн очиход туслахын тулд өөрийн Сүмээ төлөөлөгч, бошиглогчдын хамт байгуулсан гэдгийг гэрчил. Ангийн гишүүдийг хамтдаа Ефес дэх Паулын сургаалыг даган “Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэхийн” төлөө чармайхыг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Бурханы бүрэн хуяг дуулгыг өмс” (Ефес 6:11)

New Testament Video Presentations (53914)-ээс “The Whole Armor of God” арван гурван минутын дүрс бичлэгийг үзүүл. Дараа нь дараах асуултуудыг тавь.

- Дүрс бичлэгт цэргүүд ямар аюултай тулгарсан бэ? Залуучууд ямар аюултай тулгарсан бэ? Хоёр хэсэгт гарч байгаа хүн нэг бүр хуяг дуулгаа өмссөнөөрөө хэрхэн адислагдсан бэ?

2. Сүмийн удирдагчдын төлөө залбирах нь

- Ефес 6:18–20-ийг унш. Паул Ефесчүүдийг түүний төлөө залбирахыг яагаад хүссэн гэж та нар бодож байна вэ? Бусдын залбирал таныг хэзээ зоригжуулж байсан бэ? Бид нэг нэгнийхээ, мөн Сүмийн удирдагчдын төлөө залбирах нь яагаад чухал вэ?

3. “Нигүүлслээр та нар итгэлээрээ дамжуулан аврагдсан” (Ефес 2:8)

- Ефес 2:8–9 дээр Паул хүн хэрхэн аврал хүртдэг тухай юу гэж заасан бэ? Бид өөрсдийгөө үйлсээрээ аврах нь яагаад боломжгүй зүйл вэ? (Ром 3:23; Мозая 3:17; Алма 22:12-ийг үз. Паул Мосегийн хуулийн дагуу хийж байгаа үйлс нь тэднийг аврахгүй гэж Иудей Гэгээнтнүүдэд үе үе сануулах ёстой болдог байсныг та цохон тэмдэглэ. Нигүүлсэл, үйлс хоёрын талаар илүү дэлгэрэнгүй ярилцахын тулд хичээл 36-г үз.)

“Би Христээр Дамжуулан Бүгдийг Хийж Чадна”

Филиппой; Колоссай; Филемон

Зорилго

Ангийн гишүүдэд Есүс Христийн жинхэнэ дагалдагчийн зан чанарыг хөгжүүлэхийг уриалах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Филиппой. Паул Филиппойн Гэгээнтнүүдэд түүнд илгээсэн тусламжинд талархлаа илэрхийлж, тэднийг Христийн нэгдмэл, итгэлтэй дагалдагчид байхыг уриалдаг.
 - б. Колоссай 1. Паул Колоссайн Гэгээнтнүүдэд аврал зөвхөн Есүс Христээр ирдэг гэдгийг сануулдаг.
 - в. Колоссай 2:1–8, 16–23; 3; 4. Паул Колоссайн Гэгээнтнүүдэд тэдний хийх ёстой зүйлс, мөн Бурханаар сонгогдогсдын хувьд хөгжүүлэх ёстой шинж чанаруудын тухай заадаг.
 - г. Филемон. Паул зугтсан хоригдол болох Онесимд өршөөнгүй хандахыг Филемонд уриалдаг.
2. Заахад зориулсан зөвлөмж: Хичээлд гарах зүйлс буюу судрын хэсгүүд нь таны ангид зарцуулах цагт багтахгүй их зүйлийг агуулсан байж болох юм. Та хичээл бүрд бэлтгэхдээ ангийнхандаа аль сургаал, зарчмууд тэдэнд хамгийн их хэрэглэгдэхийг залбирч шийдвэрлэ. Үүнээсээ эхэлж, цаг гарвал хичээлийн бусад хэсгийг заахаар төлөвлө. Хэдий тийм ч та заахдаа Сүнснийг мэдэрч, хэрэв хүчтэй мэдрэмж төрсөн бол төлөвлөснөө өөрчилж, уян хатан бай.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Самбарт итгэлийн арван гуравдугаар тунхгаас *үнэнч, шударга, ач буянтай, бахархууштай* зэрэг хэдэн түлхүүр үгсийг бич.

- Итгэлийн хэддүгээр тунхагт эдгээр үгс байдаг вэ? (Ангийн гишүүд үүнийг мэдэхгүй бол тэд нараар Агуу Их Үнэт Сувдын дараа байгаа Итгэлийн Тунхагийг харуул.)

Ангийн гишүүдийг зөв хариулсны дараа нэг гишүүнээс итгэлийн арван гуравдугаар тунхагийг цээжээр хэлэхийг эсвэл уншихыг хүс. Дараа нь ангийн уг гишүүнээр итгэлийн тунхагийн тал хэсгийг нь “Паулын сануулга” гэдэг хүртэл дахин хэлүүл.

- “Паулын сануулга” нь юу вэ? Энэ нь хаана байдаг вэ?

Ангийн гишүүдийг Филиппой 4:8 руу хандуулж, үүнийг итгэлийн тунхагтай харьцуулуул. Иосеф Смитийн итгэлийн арван гуравдугаар тунхагт Паулын сануулгын тухай дурдахдаа Филиппойн Гэгээнтнүүдэд Паулын бичсэн

захианы хэсэг Филиппой 4:8-ын талаар ярьж байсан гэдгийг тайлбарла. Өнөөдрийн хичээлд Паул Ромд шоронд байхдаа бүгдийг нь бичсэн энэ захидлын, мөн Паулын Колоссай, Филемонд бичсэн захидлуудын тухай гарна. Эдгээр захидалд Есүс Христийн итгэлтэй дагалдагч нарын хувьд бидний хөгжүүлэх ёстой шинж чанарын тухай өгүүлдэг.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа эдгээрийг Паулын цаг үед Гэгээнтнүүд хэрэгжүүлж байсан шиг бид өнөөдөр хэрхэн хэрэгжүүлдэг тухай ярилц. Ангийн гишүүдэд судрын зарчмуудтай холбоотой тохиолдлоосоо хуваалцахыг уриал.

1. Паул Филиппойн Гэгээнтнүүдэд Есүс Христийг дагахыг уриалдаг.

Филиппойчуудад бичсэн Паулын захидлын талаар ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь.

- Паул Филиппойчуудад бичих үедээ Ромд шоронд байсан. Паулыг шоронд орсонд Сүмийн бусад гишүүд яаж хандаж байсан бэ? (Филиппой 1:12–18-ыг үз.) Их Эзэнд урам зоригтойгоор үйлчилж байсан бусад хүмүүсийг харж эсвэл тэдний тухай сонсоод та ямар туслалцаа авч байсан бэ?
- Филиппой 2:2–3-т Паул Сүмийг гишүүдийг юу хийхийг уриалсан бэ? Сүмийн гишүүд ямар замаар “нэгэн бодолтой” байх ёстой вэ? (Филиппой 1:27; 2:14–15-ыг үз.) Бид яагаад заримдаа юмыг “бардам зангаар” хийдэг вэ? Паул яагаад үүнийг хориглохыг зөвлөсөн гэж та нар бодож байна вэ? (С ба Г 38:24–26-г үз.)
- Филиппой 2:5–8 дээр Паул Есүсийн тухай юу гэж заасан бэ? Есүс Эцэгийнхээ хүсэлд номхон, даруу байхын төгс жишээ хэрхэн болсон бэ? (Иохан 8:29-ийг үз.) Бид Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд хэрхэн улам даруу, номхон хүлцэнгүй байж чадах вэ?
- Паул Филиппойчуудад “өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр биелүүлэгтүн” гэж хэлэхдээ ямар утга санааг илэрхийлсэн гэж та нар бодож байна вэ? (Филиппой 2:12.)

Ерөнхийлөгч Давид О.МакКэй тайлбарлахдаа: “Өөрсдийн авралаа авчрах нь үйл ажиллагаагаар итгэлийг жинхнээр бий болгох гэсэн бодлоготой, дуулгавартай чармайлтаар харуулах уриалга юм. Гэхдээ үүнийг хийхдээ өөртөө бүрэн найдах нь уналтанд хүргэх бардамнал ба сул байдлыг үүсгэж болох юм гэдгийг ухамсарлах ёстой. Бид айдас болон чичрэлтэйгээр эцсийн ялалтыг олох урмын төлөө Бурханы хүч чадал, нигүүлслийг эрэх ёстой” гэжээ. (Conference Report, Apr. 1957, 7.)

- Паул “Их Эзэний дотор баярлахыг” (Филиппой 3:1; 4:4). Филиппойчуудад дахин давтан зөвлөсөн. Бид Их Эзэний дотор хэрхэн баярлаж чадах вэ?
- Паул Филиппойчуудад тэрээр Христийн төлөө бүх зүйлээ золиосолсон гэж хэлсэн (Филиппой 3:7–8). Паул юугаа золиосолсон бэ? Христийн төлөө бид золиослох нь яагаад чухал вэ? (Филиппой 3:9–12-ыг үз.)

Бошиглогч Иосеф Смит заахдаа: “Бүхий л зүйлсийг золиослохыг шаарддаггүй шүтлэг хэзээ ч амьдрал, авралд шаардлагатай хүрэлцэхүйц итгэлийг бий болгох хүчтэй байдаггүй; учир нь анх хүн оршин тогтносноос эхлээд амьдрал, авралын таатай байдалд шаардагддаг

итгэлийг дэлхийн бүх зүйлсээс золиослохгүйгээр хэзээ ч бий болгож болохгүй” гэсэн (*Lectures on Faith* [1985], 69).

- Филиппой 4:7-д дурьдсан “Бурханы амар амгаланг” бид хэрхэн олж авч чадах вэ? (Филиппой 4:6–7-г үз.) Та хэзээ Бурханы амар амгаланг мэдэрсэн бэ?
- Филиппой 4:8 дээр Паулын зөвлөснийг бид хэрхэн хэрэгжүүлж болох вэ? (мөн Итгэлийн Тунхаг 1:13-ыг үз.) Бид энэ сануулгыг дагаснаар хэрхэн адислагддаг вэ?
- Паул “надад хүч өгөгч Христээр би бүгдийг хийж чадна” гэж гэрчилсэн (Филиппой 4:13). Христийн тухай энэ гэрчлэлийг Паул яаж олж авсан гэж та нар бодож байна вэ? Та “бүх зүйлсийг Христээр дамжуулан” хийж чадна гэдгээ хэрхэн харсан бэ?

2. Паул Колоссайчуудад аврал зөвхөн Христээр ирдэг гэдгийг сануулдаг.

Колоссай 1-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдээс чангаар уншихыг урь. Ефесээс зүүнтээд орших жижиг хот Колоссайн Гэгээнтнүүд Аврагчийн чухал ач холбогдлыг хэт багасгаж, ёслолуудыг үйлдэж, тэнгэр элчүүдийг шүтсэнээр төгс төгөлдөр болно гэдэгт гол анхаарлаа хандуулсан сургаалын нөлөөнд автагдсан байсан. Колоссайчуудад бичсэн захидалдаа Паул Гэгээнтнүүдийг аврал нь зөвхөн Есүс Христээр дамжин ирдэг гэдэг мэдлэгтээ “суурилагдсан бөгөөд бат тогтсон” (Колоссай 1:23; мөн Колоссай 2:5–7-г үз.) хэвээр байхыг уриалж эдгээр сургаалуудаас сэрэмжлүүлсэн.

- Паул Колоссайчуудад Есүс Христийн тухай ямар үнэнүүдийг заасан бэ? (Колоссай 1:12–22-ыг үз. Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич.) Эдгээр үнэнүүдийг ойлгох нь Колоссайчуудад яагаад чухал байсан бэ? Есүс Христийн тухай таны мэдлэг, гэрчлэл таны амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Тэнгэр дэх Эцэгээсээ бидний хүлээн авч болох “гэгээнтнүүдийн өв” гэж юу вэ? (Колоссай 1:12; 2 Нифай 9:18; С ба Г 50:5-ыг үз.) Энэ өвийг өвлөх боломжийг хэн бий болгодог вэ? (Колоссай 1:12–14-ийг үз.) Энэ өвийг өвлөхийн тулд бид юу хийх ёстой вэ? (Колоссай 1:10–12; 2 Нифай 9:18; Алма 5:51; С ба Г 50:5-ыг үз.)
- Паул Колоссайчуудад сайн мэдээн дотор “суурилагдсан бөгөөд бат тогтсон” байхыг уриалахдаа ямар утга санааг илэрхийлсэн бэ? (Колоссай 1:23-ыг үз.) Зарим хүмүүсийг “сайн мэдээнд найдах найдлагаас нь” юу холдуулдаг вэ? (Колоссай 1:23.) Бид гэрчлэлээ бэхжүүлэхийн тулд юу хийж болох вэ?

3. Паул Колоссайчуудад Бурханы сонгогдогсдын хувьд юу хийх ёстойг заадаг.

Колоссай 2:1–8, 16–23; 3; 4-ийг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь.

- Паул Гэгээнтнүүдийг зүрх сэтгэлээ “хайрын дотор” мөн Бурхан Эцэг, Есүс Христийн мэдлэг дотор холбохыг хүссэн (Колоссай 2:2–3). Бид үүнийг өөрсдийн хэсэг буюу салбартаа хэрхэн хэрэгжүүлж чадах вэ?

- Христэд “үндэслэгдэн байгуулагдах” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Колоссай 2:7.) Бид Христэд хэрхэн үндэслэж болох вэ? Христэд “үндэслэгдэж, байгуулагдсан” байх нь саад тотгор тулгарах үед бидэнд хэрхэн тусалж чадах вэ? (Та богинохон тачир үндэстэй модыг урт, гүн суусан үндэстэй модтой харьцуулж болно. Шуурга, үер зэрэг гамшиг тулгарахад аль мод нь арай илүү давж гарч чадах талаар ярилц.)
- Колоссай 3:12–15 дээр “Бурханы сонгогдогсдын” ямар шинж чанарууд гардаг вэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич.) Эдгээр чанаруудын жишээг Есүс Христ хэрхэн харуулсан бэ? (Шинж чанар нэг бүр дээр Есүсийн харуулсан тодорхой жишээг бодож олохыг ангийн гишүүдээс хүс.) Бид эдгээр жишээнүүдийг хэрхэн илүү бүрэн дүүрэн хөгжүүлж чадах вэ?
- Паулын сануулсны дагуу бид Христийн үгийг хэрхэн өөрсөд дотроо байлгаж болох вэ? (Колоссай 3:16–17-г үз; мөн С ба Г 1:37; 18:34–36-г үз.) Дууллууд нь Христийн үгийн тухай бидний ойлголт болон гэрчлэлийг хэрхэн батжуулдаг вэ? Бид дуулал болон нандин хөгжмүүдийг хэрхэн илүү сайн ашиглаж болох вэ?

Ахлагч Даллин Х.Өүкс хэлэхдээ: “Бид Их Эзэний Сүнстэй нэгэн хэмнэлд байж, нэгдмэл болж, сургаалуудаа зааж, сурч мэдэж авахад өөрсөддөө туслахын тулд дууллуудыг илүү их хэрэглэх хэрэгтэй байдаг. Номлогчид зааж байхад, сургаалыг заах хичээл дээр, чуулгын цуглаан дээр, гэр бүлийн үдшийн үеэр, гэрийн багшлалтын айлчлалын үеэр бид дууллыг илүү сайн ашиглах хэрэгтэй байдаг. Хөгжим нь Тэнгэрлэг Эцэг, түүний Хүү Есүс Христийг шүтэх үр ашигтай арга зам болдог. Бид сүнслэг хүч зориг, илчлэлт хэрэгтэй үедээ дууллыг хэрэглэх ёстой” гэжээ (Conference Report, Oct. 1994, 13; or *Ensign*, Nov. 1994, 12).

- Паул талархахын чухлын талаар дахин давтан цохон тэмдэглэсэн (Колоссай 2:7; 3:15, 17). Талархах нь яагаад чухал вэ? Бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд бүхий л зүйлд талархлаа хэрхэн илэрхийлж чадах вэ?

4. Паул Филемонд Онесимийг уучлахыг уриалдаг.

Паулын Филемонд бичсэн захидлын тухай ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь. Паул Колоссай дахь Сүмийн гишүүн Филемонд түүний боол Онесимийн талаар хувьд нь захидал бичсэн гэдгийг тайлбарла. Онесим Филемоноос хулгай хийгээд Ром руу зугтсан бөгөөд тэнд Паултай тааралдаж Сүмд элсэн ордог. Паул Филемоноос Онесимийг уучилж, түүнийг сайн мэдээний доторх ах шиг үзэхийг хүсдэг.

- Филемонд бичсэн захидлаас нь бид Паулын талаар юуг сурч болох вэ?
- Филемоны чөлөөтэй сонгох эрхийг Паул хэрхэн хүндэтгэсэн бэ? (Филемон 1:14-ийг үз.) Онесимийн сайн сайхны төлөө амласнаа Паул хэрхэн харуулсан бэ?
- Хүний хоорондох харилцааг өөрчлөх сайн мэдээний хүч чадлын тухай энэ захидлаас бид юу сурч болох вэ? (Филемон 1:16-г үз.) Эргэн тойрныхоо хүмүүстэй харьцах харьцаанд чинь сайн мэдээ хэрхэн нөлөөлдөг вэ?

Дүгнэлт

Биднийг Есүс Христтэй илүү адил болоход тусалдаг Паулын Филиппойчууд, Колоссайчууд, Филемонд бичсэн захидлуудад дурьдсан шинж чанаруудыг хөгжүүлэхийн чухлыг гэрчил. Ангийн гишүүдийг Филиппой 4:8 ба Колоссай 3:12–15-ыг уншиж, тэдгээрээс нэг шинж чанарыг нь энэ долоо хоногт хөгжүүлэхээр сонгохыг урь.

Заах Нэмэлт

Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Эцэг эх, хүүхдүүдийн хоорондын харьцаа

Колоссай 3:20–21-ийг ангийн гишүүнээр уншуул.

- Паулынхаар бол хүүхэд эцэг эхийнхээ өмнө ямар хариуцлага хүлээдэг вэ? Эцэг эх нь хүүхдийнхээ өмнө ямар хариуцлагатай вэ? Та гэртээ эцэг эх, хүүхдүүдийн харьцааг хэрхэн сайжруулж чадах вэ?

2. “Та нар Их Эзэн, Есүс Христэд үйлчил” (Колоссай 3:24)

Ангийн гишүүнээр Колоссай 3:23–24-ийг уншуул.

- Эдгээр шүлгүүд дэх Паулын зааварчилгааг бид хэрхэн дагаж чадах вэ? (мөн Матай 25:34–40-ийг үз.) Ингэж хандах нь бидний үйлчлэлд ямар өөрчлөлт гаргах вэ?

1 ба 2 Тимот; Тит

Зорилго Ангийн гишүүдийг үнэн сургаалыг сурч, заахад мөн бусдад зөв шударгаар үлгэр жишээ үзүүлэхэд уриалах болно.

Бэлтгэл

- Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - 1 Тимот 4; 2 Тимот 1–4; Тит 1. Паул урвалтын шинж тэмдгийн тухай дүрсэлдэг. Үнэн сургаалыг суралцаж, заах нь урвалтын эсрэг хамгаалалтанд зогсоход тусалдаг гэж тэр заадаг.
 - 1 Тимот 4:12. Паул, бид “итгэгчдийн жишээ” байх ёстой гэж заадаг.
 - 1 Тимот 6; Тит 2–3. Паул, бид “зөв шударга байдлыг дагаж,” бурханлаг бус байдлыг эсэргүүцэх ёстой гэж заадаг.
- Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл дараах өгүүлбэрүүдийг бичсэн үгийн хайчилбар бэлтгэ эсвэл тэдгээрийг самбарт бичихээр бэлтгэ.

*Би замаа дуусгахын тулд:
Үнэн сургаалыг сурч, заан
Итгэгчдийн жишээ байж
Зөв шударга байдлыг даган, бурханлаг бус зүйлсийг эсэргүүцэх ёстой.*
- Заахад зориулсан зөвлөмж: Та заахдаа янз бүрийн материал, арга барилыг хэрэглэ. Жишээ нь, та зураг, дуу бичлэгийн материал, янз янзын ярилцлагын арга барил хэрэглэж эсвэл суудлыг нь өөр өөр болгож болно. Олон янзын байх нь ангийн гишүүдийн хичээл дэх сонирхлыг татдаг.

Хичээл Заах Зөвлөмж

**Анхаарал Татах
Ажиллагаа** Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

- Таны хамгийн сүүлд үзсэн эсвэл уралдсан уралдаан чинь юу вэ? Өрсөлдөөнтэй уралдаанд *ялах, дуусгах* хоёрын ялгаа нь юу вэ? Ердийн уралдаанд хэдэн ялагч байдаг вэ? Ялахын тулд та юу хийх ёстой байдаг вэ?
- Бидний амьдралын зам уралдаантай хэрхэн адил байдаг вэ? (Бүх хүмүүс амьдралын “уралдаанд” ялж болдог.) Амьдралын уралдааныг амжилттай дуусгахын тулд бид юу хийх ёстой вэ?

Ангийн гишүүнээс 2 Тимот 4:7-г уншихыг хүс. (Та “уралдаан” гэдэг нь мөн “зам” гэж нэрлэгдэж болно гэдгийг онцлон зааж болно.) Төлөөлөгч Паул амьдралынхаа төгсгөлд ийнхүү тунхаглаж чадахаар амьдарсан гэдгийг тайлбарла. Энэ хичээлд замаа амжилттайгаар дуусгахыг хичээхэд бидэнд туслах Паулын хэд хэдэн сургаалын тухай ярилцдаг.

Би замаа дуусгахын тулд гэсэн үгийн хайчилбарыг үзүүл.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

Тимот, Тит хоёр Паулыг сайн мэдээг номлоход тусалсан итгэлт хамтран зүтгэгчид байсан гэдгийг тайлбарла. Паул Ромд анхны удаа шоронд орсныхоо дараа номлолын аянаа түр завсарладаг. Тэр Тимотыг Ефест Сүмийг удирдуулахаар орхиж, Кретэд, Титэд мөн адил даалгавар өгч үлдээдэг. Паул аяллаа үргэлжүүлэхдээ эдгээр ах нарыг зоригжуулж, тэдэнд Гэгээнтнүүдийн пастор буюу хоньчдын хувьд үүрэг хариуцлагынх нь талаар зөвлөхөөр захидал бичсэн. Тиймээс эдгээр захидлуудыг багшид зориулсан захидал гэж үргэлж нэрлэдэг.

1. Үнэн сургаалыг сураад заа.

1 Тимот 4; 2 Тимот 1–4; Тит 1-ийг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь.

- Тимот, Тит нар бичсэн захидалдаа Паул урвалтын ямар шинж тэмдгийн талаар дүрсэлсэн бэ? (1 Тимот 4:1–3; 2 Тимот 3:1–7, 13; 4:3–4; Тит 1:10–11-ийг үз.) Урвалтын эдгээр шинж тэмдгүүд өнөөдөр яаж батлагдаж байна вэ? (2 Нифай 28:3–9; С ба Г 1:15–16-г үз.) Бид эдгээр нүгэл хилэнцээс өөрсдийгөө хэрхэн хамгаалж чадах вэ?
- Зарим хүмүүс яагаад “Үргэлж суралцавч, үнэний мэдлэгт хэзээ ч хүрдэггүй” вэ? (2 Тимот 3:7). Бидний сурч байгаа явдал нь үнэний мэдлэгийг авчирдаг гэдгийг бид хэрхэн баталж чадах вэ?
- Сайн мэдээг заадаг хүмүүсийн үүргийн талаар Паул Тимотод юу заасан бэ? (1 Тимот 4:6–7, 13–16; 2 Тимот 2:16, 23–25; 3:14–17; 4:2, 5-ыг үз. Та эдгээр үүргийг самбарт бичиж болно.) Сайн мэдээг заах ямар боломж бидэнд байдаг вэ? (Хариултанд, гэр бүлийнхэндээ заах, Сүмийн дуудлагаа биелүүлэх, сайн мэдээг найзууд, танилуудтайгаа ярилцах зэрэг орж болно. Бид бүгдээрээ зарим нэг байдлаар сайн мэдээний багш байдаг гэдгийг цохон тэмдэглэ.) Бид сайн мэдээг хэрхэн илүү үр ашигтайгаар зааж болох вэ?
- Үнэн сургаалыг зааж, суралцахын чухлыг Паул онцлон тэмдэглэсэн (1 Тимот 1:3; 4:6, 13; Тит 2:1). Үнэн сургаалыг сурах нь биднийг урвалтын эсрэг зогсоход хэрхэн тусалдаг вэ? Худал сургаалын зарим сөрөг тал нь юу вэ? Сайн мэдээний үнэн сургаалыг суралцсан нь таны амьдралыг хэрхэн адисалсан бэ?

Ахлагч Бойд К.Пакер үнэн сургаалын хүч чадлын талаар ярихдаа: “Ойлгож авсан үнэн сургаал нь зан авир, чиг хандлагыг өөрчилдөг. Сайн мэдээний сургаалаас суралцах нь зан авирыг, үүний талаар суралцаж сайжруулснаас илүү хурдан хөгжүүлдэг. . . . Тийм болохоор л бид сайн мэдээний сургаалыг суралцах явдлыг тэгтэл нь их шахаж шавдуулдаг юм” гэж хэлсэн (Conference Report, Oct. 1986, 20; or *Ensign*, Nov. 1986, 17).

- Бидний зааж байгаа нь үнэн сургаал мөн гэдэгт бид хэрхэн баттай байж чадах вэ? (Мозая 18:19–20; С ба Г 52:9-ийг үз.)

Ахлагч Иосеф Б.Вертлин зөвлөхдөө: “Бурхан бидний авралд зайлшгүй шаардлагатай бүх зүйлийг илчилсэн. Бид илчлэгдсэн зүйлүүдийг зааж,

үүний дагуу амьдрах ёстой бөгөөд оньсого нууц гэгддэг зүйлүүдийг эрэлхийлэхээс зайлсхийх ёстой. Сүмийн хэсэг, гадас, Сүмийн дээд боловсрол олгох байгууллага, шашны институт, семинар эсвэл бүр гэртээ эцэг эхийн зүгээс зааж сургадаг ч бай багш нарт өгөх миний зөвлөгөө бол заахдаа судруудад болон хожмын үеийн бошиглогчдын үгст төвлөрөх явдал юм” гэсэн (Conference Report, Oct. 1994, 101; or *Ensign*, Nov. 1994, 77).

- Бид нэгэнт дуут сургаалыг хүлээн авсан тул Паул биднийг юу хий гэж зөвлөсөн бэ? (2 Тимот 1:13; Тит 1:9-ийг үз.) “Чанга атгах” гэж юу гэсэн үг гэж та нар бодож байна вэ? (1 Нифай 15:23–24-ийг үз.)

Та анхаарал татах ажиллагааг хэрэглэж байгаа бол *Үнэн сургаалыг сурч, заа* гэсэн үгийн хайчилбарыг үзүүл.

2. “Итгэгчийн . . . жишээ бай.”

1 Тимот 4:12-ыг уншаад ярилц.

- “Итгэгчийн жишээ” байх гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? (1 Тимот 4:12.) “Итгэгчийн жишээ” байсан хүн танд хэрхэн нөлөөлсөн бэ?

Паул Тимогод жишээ болохыг сануулсан тэр арга зам бүрийг бич. Ангийн гишүүдээс, бид хэрхэн эдгээр арга зам бүрийн жишээ болж болох тухай тайлбарлахыг хүс.

Үг

Харилцан яриа (мөн биеэ авч явах байдал буюу зан авир байж болно)

Энэрэл

Сүнс

Итгэл

Цэвэр ариун байдал

Та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол *Итгэгчийн жишээг үзүүл* гэсэн үгийн хайчилбарыг үзүүл.

3. “Зөв шударга байдлыг дагах” ба бурханлаг бус байдлыг эсэргүүцэх

1 Тимот 6 ба Тит 2–3-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Мөнгөнд хайртай байх явдлын талаар Паул юу заасан бэ? (1 Тимот 6:7–10-ыг үз.) Мөнгөнд хайртай байх нь ямар талаараа “нүгэл хилэнц бүхний үндэс” байдаг вэ? Бид мөнгө болон бусад эд материаллаг баялагт хэт их анхаарлаа хандуулахгүй байхад хэрхэн анхаарах вэ? (1 Тимот 6:17–19; Жэкоб 2:18–19-ийг үз.)

Ахлагч Даллин Х.Өүкс заахдаа: “Мөнгө нь угаасаа л нүгэл хилэнц юм гэх хэрэггүй. Сайн санаат Самари хүн нөхөртөө туслахдаа, Эзэнийг барьж өгсөн Иудасын хэрэглэсэнтэй адил зоосыг л хэрэглэсэн. ‘Мөнгөнд хайртай байх [нь] бүхий л нүгэл хилэнцийн үндэс’ юм. (1 Тимот 6:10; бичмэлээр бичсэн нь нэмэгдсэн.) Гол ялгаа нь энэ дэлхийн юмсыг дүгнэж, үнэлэн, хэрэглэх сүнслэг байдлын маань хэм хэмжээ юм” гэжээ (Conference Report, Oct. 1985, 78; or *Ensign*, Nov. 1985, 63).

- Тимот, Тит нарт бичсэн захидалдаа Паул зөв шударга амьдрах талаар олон олон зааварчилгаа өгсөн. Дараах шүлгүүдэд: 1 Тимот 6:11–12; 2 Тимот 2:22; Тит 2:1–8, 12; 3:1–2, 8-д Паул ямар зөвлөгөөг өгсөн бэ? (Ангийн гишүүдийн хариултыг дүгнэж самбарт бич. Эдгээр зааварчилгаа

нь ямар утгатай, мөн бид тэдгээрийг амьдралдаа хэрхэн хэрэглэж болох тухай ярилц.)

Та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол *Зөв шударга байдлыг дагах ба бурханлаг бус зүйлсийг эсэргүүцэх* гэсэн үгийн хайчилбарыг үзүүл.

Дүгнэлт

Есүс Христийг гэрчилснээсээ болоод удахгүй алуулна гэдгээ Паул мэдэж байсан гэдгийг тайлбарла. Гэхдээ тэр сайн мэдээний дагуу амьдарсан тул “түүнд зөв шударга байдлын титмийг зэхсэн” гэдгийг бас мэдэж байсан (2 Тимот 4:8). Өдөр бүр зөв зүйлийг хийж, зам дээрээ зогсож үлдсэнээр бид Паулын хамтаар “Би сайн тэмцлээр тэмцсэн. Би замаа дуусгасан, итгэлээ сахисан” (2 Тимот 4:7.) гэж хэлж чадна хэмээхийн чухлын талаар гэрчлэлээ хуваалц.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. 1 Тимотын тухай нэмэлт ярилцлага

- 1 Тимот 2:1–3 дээрх залбирлын талаар Паул ямар зөвлөгөө өгсөн бэ? Бид яагаад бүх хүмүүсийн төлөө залбирах ёстой вэ? Бид үүнийг хэрхэн илүү утга учиртай хийж чадах вэ? Бид чухам яагаад үндэстнүүдийн удирдагчдын төлөө залбирах ёстой вэ?
- 1 Тимот 3:1–7 дээр Паул бишопын шинж байдлыг тодорхойлсон. Бишопт эдгээр чанар нь яагаад чухал вэ?
- Паул 1 Тимот 5:8 дээр гэр бүлүүдээ халамжлах талаар юу заасан бэ? Энэ хариуцлагаа биелүүлдэггүй хүмүүсийн талаар Паул яагаад ингэж ноцтойгоор ярьсан гэж та нар бодож байна вэ?

2. “Бурхан бидэнд айдсын сүнсийг өгөөгүй” (2 Тимот 1:7)

2 Тимот 1:7-г уншихыг ангийн гишүүнээс хүс.

- Өнөөдөр дэлхий дээр хүмүүс ямар зүйлүүдээс айдаг вэ? “Айдсын сүнсний” талаар Паул Тимотод ямар баталгаа өгсөн бэ? Та өөрийнхөө амьдралд энэ баталгаа нь үнэн гэдгийг хэрхэн олж харсан бэ?

3. Сайн албан хаагчид байх

Тит 2:9–10-ыг уншаад ярилц.

- Эдгээр шүлэгт боолуудад өгсөн Паулын зөвлөгөө нь албан хаагчдад хэрхэн хамаарах вэ? (*Хумслах* гэдэг үг нь хулгайлах буюу завших гэсэн утгатай цохон тэмдэглэ.) Албан хаагчид заримдаа ажил олгогчоосоо хэрхэн хулгайлдаг вэ? (Хариултанд, шамшигдуулах, хангамжнаас хувьдаа хэрэглэхээр авах эсвэл бүтэн өдөр ажиллахгүй байх зэрэг орж болно.)
- Бид хумслахын оронд юу хийх ёстой гэж Паул хэлсэн бэ? (“Сайн итгэлийг” харуул эсвэл итгэлтэй, үнэнч бай.) Ажлын талбартаа “сайн итгэлийг” харуулснаар та ямар үр дүнг үзсэн бэ?

Иаков

Зорилго Ангийн гишүүд шашнаа илүү бүрэн дүүрэн шүтэхэд өөрсдөдөө хөгжүүлэх ёстой шинжүүдийг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Иаков 1:1–4; 5:10–11. Бид зовлон бэрхшээлийг тэвчээртэйгээр давах ёстой гэж Иаков заадаг.
 - б. Иаков 1:5–7; 4:8. Бид Бурханд итгэлтэйгээр залбирах ёстой гэж Иаков заадаг.
 - в. Иаков 1:19–20, 26; 3:2–18. Иаков бидэнд хэл яриагаа цэгнэж, уур хилэндээ хойрго байхыг заадаг.
 - г. Иаков 1:22–25, 27; 2:14–26; 4:17. Иаков биднийг өөрсдийн үйлсээрээ итгэлээ харуулж “үгийг хэрэгжүүлэгчид” байх ёстой гэж заадаг.
2. Заахад зориулсан зөвлөмж: “Бурханаас ирэх хувийн холбоогоор заа. Хэрхэн зохистойгоор залбирч, Бурханаас хариултаа хэрхэн авч, мөн ойлгох талаар хүн нэг бүрийг ойлгоход тусал.” (Richard G. Scott, “Four Fundamentals for Those Who Teach and Inspire Youth,” in *CES Old Testament Symposium Speeches, 1987* [1987], 3.)

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Самбарт *Цэвэр ариун шүтлэг* гэж бичээд дараах асуултуудыг тавь:

- *Цэвэр ариун* гэдэг үг ямар утгатай вэ? (Хариултанд, жинхэнэ, бодит, бүрэн, төгс зэрэг нь орж болно.) *Шүтлэг* гэдэг нь ямар утгатай вэ? (Хариултанд, Бурханы үйлчлэл ба бишрэл шүтлэг, итгэл, зан үйлийн тогтолцоо, амьдралын тодорхой арга замаар явах амлалт буюу бүхнээ зориулах явдал зэрэг нь орж болно.)
- Цэвэр ариун шүтлэгийг та хэрхэн тодорхойлох вэ?

Ангийн гишүүдээс Иаков 1:27-г уншихыг хүс. Энэ хичээлд биднийг “цэвэр ариун шүтлэгтэйгээр” амьдарч, “Бурханы өмнө бузар бус” байхад туслахаар Иаковын сургасныг бид хэрхэн хэрэгжүүлж болох тухай ярилцана гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Та Иаковын номон дахь сургаалаас ярилцахдаа тэдгээрийг *Цэвэр ариун шүтлэг* гэсэн гарчгийн дор жагсааж бич. Иаковын заасан ойлголт болгон биднийг хэрхэн цэвэр ариун шүтлэгтэйгээр амьдрахад тусалж чадах талаар ярилц.

Иаковын номыг бичигч нь Есүс Христийн дүү байсан гэж ер нь үздэг гэдгийг тайлбарла. Есүсийг дахин амилсны дараа Иаков Төлөөлөгчөөр үйлчилж, эртний Сүмийн чухал удирдагч байсан (Үйлс 12:17; 15:13–20).

1. Бид зовлон бэрхшээлийг тэвчээртэйгээр туулах ёстой.

Иаков 1:1–4; 5:10–11-ийг уншаад ярилц.

- Итгэлийг маань шалгасан саад бэрхшээлтэй тулгарах талаар Иаков юу заасан бэ? (*Элдвийн сорилт* гэдгийг олон зовлон бэрхшээл гэж өөрчилснийг Иаков 1:2-ын Иосеф Смитийн Орчуулгаас үз.) Зовлон бэрхшээл нь биднийг тэвчээртэй байдлаа хөгжүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ? Зовлон бэрхшээлийг тэвчээртэйгээр давснаар бид хэрхэн адислагддаг вэ? (Иаков 1:4; Ром 5:3–5; Алма 36:3-ыг үз.)

Ахлагч Орсон Ф.Витни бичихдээ: “Бидний зовж мэдэрсэн өвчин шаналал, туулж үзсэн зовлон бэрхшээл огт хий дэмий үрэгдэхгүй. Энэ нь бидний боловсрол болон тэвчээр, итгэл, тэсвэр хатуужил, төлөв түвшин байдал зэрэг чанараа хөгжүүлэхэд удирддаг. Бидний бүхий л зовлон шаналал, давж гарах бүхэн, ялангуяа бид үүнийг тэвчээртэйгээр давж гарвал энэ нь бидний зан чанарыг төлөвшүүлж, зүрх сэтгэлийг цэвэршүүлж, бие сэтгэлийг маань хөгжүүлж, биднийг улам зөөлөн, энэрэнгүй, Бурханы хүүхдүүд хэмээн нэрлэгдэхэд улам зохистой болгодог” гэжээ. (Spencer W. Kimball, *Faith Precedes the Miracle* [1972], 98.)

- Зовлон бэрхшээлийг тэвчээртэйгээр давдаг хүний жишээгээр Иаков хэний тухай дурьдсан бэ? (Иаков 5:10–11-ийг үз.) Хожмын үеийн бошиглогчдыг энэхүү тэвчээрийг үзүүлэхийг та нар хэрхэн харсан бэ? Тэдний жишээ танд хэрхэн тусалсан бэ?

2. Бид итгэлтэйгээр Бурханд залбирах ёстой.

Иаков 1:5–7 ба 4:8-ыг уншаад ярилц.

- “Мэргэн ухаанаар дутдаг” хүмүүст Иаков ямар зөвлөгөө өгсөн бэ? (Иаков 1:5–6-г үз.) Бид итгэлтэйгээр гуйвал Тэнгэрлэг Эцэг юу хийх вэ? Залбирлын хариугаа хүлээн авсан ямар жишээ танд тохиолдсон бэ?
- Иаков 1:5 дээрх зөвлөгөө Бошиглогч Иосеф Смитэд хэрхэн нөлөөлсөн бэ? (Иосеф Смитийн Түүх 1:11–13-ыг үз.) Түүнд тохиолдсон явдлаас бид юу сурч болох вэ? Иаков 1:5 дээрх зөвлөгөөг дагах Иосефийн шийдвэр бидэнд хэрхэн нөлөөлсөн бэ? (Иосеф Смитийн Түүх 1:14–20-ийг үз.)

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл хэлэхдээ: “Арван дөрвөн настай хүү судраас уншаад залбирахаар мод руу явсан учраас . . . дээрээс ирсэн илчлэлтийн дагуу амьдарсан учраас бидэнд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бий. Арван дөрвөн настай хүү залбирахаар ой мод руу явсан учраас биднийг бүх дэлхийн хамгийн аз жаргалтай хүмүүс болгох бүх адислалууд бидэнд бий” гэжээ (Conference Report, Melbourne Australia Area Conference 1976, 23).

Хэрэв та өсвөр насныханд зааж байгаа бол Бурханаас итгэлтэйгээр гуйж, мэргэн ухаан олж авахад нас эсвэл өөр бусад шалтгааны хязгаарлалт гэж үгүй гэдгийг гэрчил. Иаковын үгийг үзэж, Анхны Үзэгдлээ үзэхдээ Иосеф Смит 14 настай байсан. Тэнгэрийн элч Моронайг түүн дээр зочлон ирж, алтан ялтсуудыг хаана хадгалсныг илчлэхэд тэр 17 настай байсан.

- Итгэлгүйгээр залбирдаг хүмүүсийг Иаков хэрхэн дүрсэлсэн бэ? (Иаков 1:6–7-г үз.) Итгэлээ бэхжүүлэхийн тулд бид юу хийж чадах вэ?
- Иаков заахдаа, “Бурханд ойртогтун. Тэгвэл тэр та нарт ойртоно” гэсэн (Иаков 4:8). Чин сэтгэлийн залбирал биднийг Бурханд хэрхэн ойртуулдаг вэ?

3. Бид хэл яриагаа цэгнэж, “уур хилэндээ хойрго” байх ёстой.

Иаков 1:19–20, 26; 3:2–18-ыг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Иаков биднийг “сонсохдоо түргэн, ярихдаа удаан” (Иаков 1:19) байх ёстой гэж заасан. Энэ зөвлөгөөний мэргэнийг таны амьдралд тохиолдсон ямар явдал баталж өгсөн бэ? Бид хэрхэн илүү сайн сонсогч, илүү бодож ярьдаг болж чадах вэ?
- Мөн Иаков, бид “уур хилэндээ хойрго” байх ёстой гэж заасан (Иаков 1:19). Уурандаа хэлж эсвэл үйлдсэн зүйлсийн зарим сөрөг үр дагавар нь юу байдаг вэ? Иаковын зөвлөгөөний мэргэнийг таны амьдралд тохиолдсон ямар явдал баталж өгсөн бэ? Бид уур хилэнгээ хэрхэн барьж, хянаж чадах вэ?
- Иаков биднийг хэл яриагаа хазаарлах ёстой гэж заасан (Иаков 1:26). Морины хазаар ямар үүрэгтэй вэ? (Морийг залахад) Хэл яриагаа “хазаарла” гэсэн Иаковын зөвлөгөөг бид хэрхэн хэрэгжүүлж чадах вэ? (Иаков 4:11-ийг үз. Хариултанд, хов жив ярих, худал хэлэх, хэрэлдэх, хараах, хэрцгий үгс хэлэхээс зайлсхийж, үүний оронд бид хэл яриагаа эелдэг үгс, үнэнийг ярих, залбирах, амар амгаланг тогтооход зориулах ёстой.)
- Иаков 3:3–5-ыг унш. Эдгээр шүлэгт Иаков хэлийг юутай зүйрлүүлсэн бэ? (Морины хазаарны амгай, усан онгоцны залуур. Амгай нь морины ам руу амгайлсан хазаарны төмөр хэсэг юм гэдгийг та тайлбарлаж болно.) Энэ харьцуулалтаас бид юу сурч болох вэ? Үг яриагаа хянаж сурах нь биднийг амьдралынхаа бусад зүйлсийг хянахад хэрхэн тусалж чадах вэ?
- Иаков 3:9–13-ыг унш. Яриагаа хянах талаар эдгээр шүлгүүдэд Иаков юу гэж заасан бэ? (Энэ зөвлөгөөг хэрэгжүүлэх талаар ангийн гишүүдтэй ярилц. Жишээ нь, ангийн зарим нэг гишүүд прист бол тэд долоо хоногийн туршид яриагаа цэвэр ариун байлгах нь чухал юм. Тэгснээр тэд Ням гарагт ариун ёслолыг зохистойгоор адислаж чадна гэдгийг та ярилцаж болно. Үүнтэй адил төстэй зүйлийг сайн мэдээ заадаг хүмүүст хэрэглэж болно.)
- Хэл яриагаа хянах нь амар амгалан руу хөтлөхөд хэрхэн тусалдаг вэ? (Иаков 3:16–18-ыг үз.) Хэл яриагаа хянах нь яагаад цэвэр ариун шүтлэгийн нэг чухал хэсэг болдог вэ?

4. Бид үйлсээрээ итгэлээ харуулж “үгийг хэрэгжүүлэгчид” байх ёстой.

Иаков 1:22–25, 27; 2:14–26; 4:17-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Үгийг “зөвхөн сонсогчид” байх гэдэг нь ямар утгатай вэ? (Иаков 1:22). “Зөвхөн сонсогчид” ямар байдлаар өөрсдийгөө хуурдаг вэ? (Иаков 1:22–25; 4:17-г үз.) “Үгийг хэрэгжүүлэгчид” байснаас ямар адислалууд ирдэг вэ?
- Итгэл, үйлс хоёрын хоорондын харилцаа холбооны талаар Иаков юу заасан бэ? (Иаков 2:14–26-г үз.) Итгэл нь яагаад үйлсгүй бол үхмэл вэ? Сайн үйлс хэрхэн бидний Есүс Христэд итгэх итгэлийг бэхжүүлдэг вэ?

- Иаков яагаад бид цэвэр ариун шүтлэгтэйгээр амьдрах ёстой гэж онцлон тэмдэглэсэн бэ? (Иаков 1:27-г үз эсвэл ангийн гишүүдэд анхаарал татах ажиллагааг сануул.) Тусламж хэрэгтэй хүмүүсийнд зочилж, туслах нь яагаад цэвэр ариун шүтлэгийн нэг хэсэг гэж та нар бодож байна вэ?
- “Дэлхийгээс бохирдолгүй” үлдэхийн тулд бид юу хийж чадах вэ? (Иаков 1:27; С ба Г 59:9-ийг үз.) Долоо хоног бүр Сүмд явж, ариун ёслолоос хүртэх нь дэлхийгээс бохирдолгүй үлдэхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Дүгнэлт

Иаковыг сургаалын үнэнийг гэрчил. Бид зовлон бэрхшээлд тэвчээртэй байж, Бурханд итгэлтэйгээр залбирч, өөрсдийгөө удирдан, сайн үйлсийг хийснээрээ илүү цэвэр ариун шүтлэгтэйгээр амьдарч чадна гэдгийг онцлон тэмдэглэ.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Ангийн гишүүний бэлтгэсэн хөтөлбөр

Энэ хичээлийг заахаас долоо хоногийн өмнө ангийн таван гишүүн бүрийг Иаковын өөр өөр бүлгүүдээс суралцаж ирэхийг хүс. Хичээлийн эхэнд (хэрэв хэрэглэвэл анхаарал татах ажиллагааны дараа) тэдний суралцсан бүлгийн тухай сэтгэгдлийг нь хуваалцуул.

2. Дүрс Бичлэг

Иаков 1:27-г уншаад, дараа нь *New Testament Video Presentations* (53914)-ээс “The Body Is a Temple” гэсэн зургаан минутын бичлэгийг үзүүл. Энэ дүрс бичлэгт өөрсдийгөө дэлхийгээс бохирдохгүй байлгах талаар юу заадаг тухай ярилц.

3. Иаковын номын тухай нэмэлт ярилцлага

- Иаков 1:12-ын Иосеф Смитийн орчуулгад *тэвчих* гэдэг үгийг *эсэргүүцэх* гэж өөрчилсөн байдаг. Уруу таталтыг тэвчих, уруу таталтыг эсэргүүцэх хоёр ямар ялгаатай вэ? Уруу таталтын эсрэг тэмцдэг хүмүүст юу амласан байдаг вэ? (Иаков 1:12; 4:7-г үз.)
- Бусдыг шүүх тухай Иаков юу гэж заасан бэ? (Иаков 2:1–9-ийг үз.) Зарим хүмүүс бусдыг яагаад дэлхийн байр суурь буюу материаллаг эд зүйлсээр нь шүүдэг вэ? Бид хүмүүсийн гадаад төрх байдлаас нь цааш тэдний зүрх сэтгэлийг Бурханы адилаар хэрхэн харж сурах вэ? (1 Самуел 16:7; С ба Г 38:24–27-г үз.)
- Иаков атаархах, шунахайрах байдлын нөлөөний тухай юу гэж заасан бэ? (Иаков 3:16; 4:1–6-г үз.) Бид атаархах, шунахайрах байдлаа хэрхэн даван тууулж чадах вэ? (Иаков 4:7–10-ыг үз.)
- Өвчтөнийг адислах талаар Иаков юу заасан бэ? (Иаков 5:14–15-ыг үз.) Пристийн зэргийн анагаах хүчээр та хэрхэн адислагдаж, бусдыг адислуулж байхыг харсан бэ?
- Иаков “үнэнээс гаждаг” хүмүүст туслахын чухлын талаар онцлон тэмдэглэсэн (Иаков 5:19–20). Бид үүнийг хэрхэн хийж чадах вэ?

1 ба 2 Петр; Иуда

Зорилго Ангийн гишүүдэд ариун журамтай амьдарч, сонгогдсон үе удам байхад туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - 1 Петр 1; 2:1–10. Бид итгэлтэй байж, ариун журамтай амьдрах ёстой гэж Петр заадаг. Тэрээр Гэгээнтнүүд нь сонгогдсон үе удам мөн бөгөөд Аврагчийг магтан дуулахаар дуудагдсан.
 - 1 Петр 2:19–24; 3:13–17; 4:12–19. Бид сорилт, мөрдлөг хавчлагыг тэвчин гарах Аврагчийн жишээг дагах ёстой гэж Петр заадаг.
 - 2 Петр 1. Петр биднийг бурханлаг мөн чанарын хуваалцагч байж, дуудлагаа биелүүлж, сонгогдсоноо бататгахын тулд хичээнгүй байхыг уриалдаг.
 - 2 Петр 2–3; Иуда. Петр, Иуда нар биднийг худал хуурмаг багш нар болон Хоёр дахь Ирэлтийг эсэргүүцдэг хүмүүсээс сэрэмжлүүлдэг.
2. Нэмэлт Уншлага: 1 Иохан 3:2–3; 3 Нифай 12:48; Сургаал ба Гэрээ 122:7–8.
3. Заахад зориулсан зөвлөмж: Гарын авлагаас ойр ойрхон хараад байхааргүйгээр хичээл бүрийг сайн судал. Заах зүйлээ мэдэж байх нь таныг зааж байхдаа нүдээрээ ангийн гишүүдтэй харьцах боломжтой болгодог. Нүдээрээ харьцаж заах нь ангийн гишүүдийн оролцоо, дэг журмыг дээшлүүлж, тэднийг хайрлах хайр, анхаарал халамжийг чинь илэрхийлэхэд тусалдаг.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Бишоп Воон Ж.Фэдэрстөүний ярьсан дараах түүхийг хуваалц.

“Олон жилийн өмнө би Францын XVI Луис Хааны хүүгийн тухай түүхийг сонссон юм. Луис Хааныг хаан ширээнээс нь буулгаж, шоронд хорьсон байжээ. Түүний залуухан хүү хун тайжийг, хааныг ширээнээс нь буулгасан хүмүүс барьж авсан байв. Тэд хааны хүү хаан ширээг үе залгамжлан авах тун түүнийг ёс суртахуунаар доройтуулбал амьдралаас түүнд хүртээсэн агуу, гайхамшигт хувь заяагаа хэзээ ч ухаарч ойлгохгүй байх болно гэж боджээ.

“Тэд хүүг хол орших жижигхэн тосгонд аваачиж, амьдралд байдаг бохир заваан, ой гутам бүхнийг харуулав. . . . Тэрээр энэ байдлын дунд зургаан сар гаруй байсан ч залуу хүүг нэг ч удаа дарамтанд оруулж хүчилж байгаагүй. Тэд ихэд уруу татсаныхаа эцэст түүнээс, Тэрээр яагаад өөрийгөө эдгээр зүйлстэй нийлүүлээгүй вэ, яагаад эдгээр зүйлсээс хүртээгүй вэ? гэж асуув. Эдгээр нь таашаал, дур хүслийг нь хангаж, сэтгэл татахуйц байсан. Тэд бүгд

түүнийх байв. Хүү хэлэхдээ, ‘Би та нарын хүссэнийг хийж чадахгүй, учир нь би хаан байхаар төрсөн’ гэжээ.” (“The King’s Son,” *New Era*, Nov. 1975, 35.)

Бишоп Фэдэрстөүн тайлбарлахдаа:

“Бидний Эцэг бол хаан бөгөөд хааны хүүд энэ амьдралын ой гутам, гаж буруу зүйл бүрийг үзүүлсэн шиг та нарт мөн бидний үе удмын бохир заваан, дорой олон зүйлийг үзүүлэх болно. Гэвч та нар . . . бас хаад, хатад, санваартан, санваартан эмэгтэйчүүд байхаар төрсөн” гэсэн (*New Era*, Nov. 1975, 35).

- Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүдийн хувьд бидний чадавхи юу вэ? Тэнгэрлэг чадавхийнхаа тухай мэдэж байх нь бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?

Тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүдийн хувьд бид түүнтэй адил болж, түүнд байгаа бүхнийг өвлөн авч чадна гэдгийг онцлон тэмдэглэ. Петр, Иуда нарын захидалд Бурханы хүүхдүүдийн хувьд зохистой амьдрахад бидэнд туслах үнэт сургаалыг санал болгосон байдаг.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбиран сонго. Эдгээр судруудыг өдөр тутмынхаа амьдралд хэрхэн хэрэглэж болох талаар ярилц. Судрын зарчмуудтай холбоотой тохиолдсон явдлаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Сонгогдсон үе удмын адилаар итгэлтэй, ариун журамтай амьдар.

1 Петр 1 ба 2:1–10-ыг ярилц. Сонгосон шүлгүүдийг уншихыг ангийн гишүүдээс урь.

- Есүс Христийн номлолын талаар Петр нэгдүгээр бүлэгт юу гэж заасан бэ? (1 Петр 1:3–4, 18–21-ийг үз.) Аврагчийн номлол, золиослолыг мэдэх нь бидний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлөх учиртай вэ? (1 Петр 1:8, 13–16, 22–23; 2:5-ыг үз. Та ангийн гишүүдийн хариултыг самбарт бичиж болно.)
- Петрийн тодорхойлсноор итгэл яагаад “алтнаас . . . хавьгүй илүү үнэтэй” байдаг вэ? (1 Петр 1:7; Еврей 11:6; 1 Нифай 7:12-ыг үз.) Итгэлээ галаар шалгуулах гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? Бидний итгэлийн цорын ганц зорилго юу вэ? (1 Петр 1:5, 9-ийг үз.)
- Есүс Христийг гэрчилдэг бошиглогчид “асууж, хичээнгүйлэн эрэлхийлсэн” гэж Петр заасан. (1 Петр 1:10; мөн шүлэг 11-ийг үз.) Хичээнгүйлэн залбирч, судраас суралцах нь Аврагчийн тухай бидний гэрчлэлийг хэрхэн батжуулдаг вэ?
- Петрийн ярьсан сонгогдсон үе удам нь хэн бэ? (1 Петр 2:9–10 болон дор байгаа ишлэлийг үз.) Сонгогдсон үе удмын хувьд бидний үүрэг хариуцлага юу вэ? (1 Петр 2:9-ийг үз.) Бид энэ үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж чадах вэ? (Матай 5:16-г үз.)

Ахлагч Брус Р.МакКонки сонгогдсон үе удмыг “тодорхой нэг цаг үед амьдарч байсан хүмүүс биш, харин . . . эртний болон Христийн цаг үеийн хоёуланд нь байсан Израилийн гэр ба одоо энэ хожмын үед амьдарч

байгаа хүмүүс гэж тодорхойлсон. . . . [Үүнд] өөрсөд дээрээ Христийн нэрийг авч, түүний гэр бүлд үрчлэгдсэн Сүмийн итгэлтэй гишүүд багтдаг гэсэн.” (*Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [1966–73], 3:294.)

2. Сорилт, мөрдлөг хавчлагыг тэвчин давахдаа Аврагчийн жишээг дага.

1 Петр 2:19–24; 3:13–17; 4:12–19-ийг уншаад ярилц.

- “Христ . . . бидэнд жишээ болж, бидний төлөө зовсон” гэж Петр бичсэн (1 Петр 2:21). Сорилт, мөрдлөг хавчлагыг даван туулж Аврагчийн жишээг дагахын тулд бид юу хийж чадах вэ? (1 Петр 2:19–23-ыг үз.) Сорилтыг тэвчихдээ Христийн адил байдаг ямар жишээг та нар харсан бэ? Сорилтыг давахдаа Аврагчийн жишээг дагаснаараа бид хэрхэн адислагддаг вэ?
- Их Эзэний хүслийн дагуу хийснээрээ та (эсвэл таны мэддэг хэн нэгэн) хэзээ мөрдөгдөж хавчигдаж байсан бэ? Ийм тохиолдолд бид яах ёстой гэж Петр бидэнд зөвлөсөн бэ? (1 Петр 3:13–17; 4:12–19-ийг үз. Та ангийн гишүүдийн хариултыг самбарт бичиж болно.) Сорилт нь ямар замаар биднийг Их Эзэнд ойр болж, түүнийг алдаршуулах боломж олгодог вэ?

3. Бурханлаг мөн чанарыг хуваалцаж, дуудлагаа биелүүлж, сонгогдсоноо бататгахын тулд чармай.

2 Петр 1-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Бурханлаг мөн чанарын нэг хэсэг болгон Петр ямар чанаруудыг тайлбарладаг бэ? (2 Петр 1:4–7-г үз. Чанаруудыг самбарт бич.) Эдгээр чанаруудыг хөгжүүлэх нь яагаад чухал вэ? (2 Петр 1:8-ыг үз.) Бусдад байгаа эдгээр чанаруудыг та хэрхэн харсан бэ?
- Петр Гэгээнтнүүдэд “дуудлагаа биелүүлж, сонгогдсоноо бататгахын тулд чармай” гэж уриалсан (2 Петр 1:10). Дуудлагаа биелүүлж, сонгогдсоноо бататгах гэдэг нь ямар утгатай вэ? (Их Эзэнээс сэлэсчел хаант улсад өргөмжлөгдөх баталгаа, амлалт авах.) Дуудлага, сонгогдсоноо баттай болгосон хүн өөрийгөө илчлэлт, бошиглолын сүнсээр мөнхийн амьдралд холбогдсон гэдгээ мэддэг. (С ба Г 131:51-ийг үз.) Иосеф Смит Сургаал ба Гэрээ 132:49 дээр тэмдэглэсэн шиг Их Эзэнээс энэ амлалтыг авсан.
- Бид дуудлага, сонгогдсон байдлаа баттай болгохын тулд юу хийх ёстой вэ?
Бошиглогч Иосеф Смит заахдаа: “Хүн Христэд итгэж, нүглээ наманчлан, нүглийнхээ өршөөлийн төлөө усаар батлуулж, (гар тавиулан) Ариун Сүнсийг хүлээн авсныхаа дараа . . . уг хүн Бурханы өмнө өөрийгөө даруухан хэвээр байлгаж, зөв шударга байдлын төлөө өлсөж, цанган, Бурханы үг нэг бүрийг дагаж амьдраг тэгвэл Их Эзэн түүнд төдөлгүй, Хүү минь, чи өргөмжлөгдөнө гэж хэлнэ. Их Эзэн түүнийг бүхий л талаар баталж, уг хүнийг Түүнд бүх л аюул саадтай тулгарах үед түүнд үйлчилнэ гэдгийг тодорхойлсны дараа тэр хүн өөрийн дуудлага, сонгогдсон байдлаа бататгана” гэсэн (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 150).

4. Худал хуурмаг багш нар болон Хоёр дахь Ирэлтийг үгүйсгэдэг хүмүүсийн эсрэг зогс.

2 Петр 2–3 ба Иудагаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Иуда бол Иосеф, Мариа хоёрын хүү, Есүсийн дүү нь байсан гэдгийг тайлбарла.

- Петр, Иуда нар хүмүүст худал хуурмаг багш нар Сүмийн гишүүдийн дунд байх болно гэж сэрэмжлүүлсэн. Худал хуурмаг багш нарын шинж байдлын талаар тэд юу гэж хэлсэн бэ? (2 Петр 2:1–3, 10, 12–19; Иуда 1:4, 8, 10–13, 16, 18–19-ийг үз.) Бид өнөөдөр худал хуурмаг багш нарыг хэрхэн таньж болох вэ?
- Худал хуурмаг сургаалаас сэргийлж, Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхдээ итгэлтэй үлдэхэд бидэнд туслах ямар зөвлөгөөг Петр, Иуда нар бидэнд өгсөн бэ? (2 Петр 3:11–14, 17–18; Иуда 1:3, 20–21; мөн Моронай 7:12–17; С ба Г 45:57; 46:7–8-ыг үз.)

Дүгнэлт

Та заасан үнэнийхээ тухай гэрчил. Ангийн гишүүдийг итгэлтэй, ариун журамтай амьдрахаар чармайхдаа Петр, Иуда нарын сургаалыг дагахыг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. 1 Петрийн тухай нэмэлт ярилцлага

- 1 Петр 1 дээр юу нь мөхдөг буюу бузартдаг ба юу нь мөхөшгүй, бузартаагүйг хэрхэн харьцуулсан бэ? (1 Петр 1:4, 7, 18–19, 23–25-ыг үз. Ангийн гишүүдийн хариултыг самбарт *Мөхдөг*, *Бузартдаг* ба *Мөхөшгүй*, *Бузартаагүй* гэсэн хоёр гарчгийн дор жагсааж бич.) Энэ харьцуулалтаас бид юу сурч болох вэ?
- Есүс Аврагч байхаар “ертөнцийн сууринаас урьдаас томилогдсон” байсан гэж Петр заасан. (1 Петр 1:20; мөн Илчлэлт 13:8-ыг үз.) Энэ үнэн яагаад чухал вэ? Хожмын үед Аврагчийн урьдчилсан томилолтын тухай бидний ойлголтонд нэмэрлэх юуг Судрууд илчилдэг вэ? (Мосе 4:1–4; Абрахам 3:27–28-ыг үз.)
- Газар нутгийн хуулийн талаар Петр ямар зөвлөгөө өгсөн бэ? (1 Петр 2:13–15-ыг үз.) Их Эзэн хожмын үед газар нутгийн хуулийн талаар ямар зөвлөгөөг илчилсэн бэ? (С ба Г 58:21–22; 98:4–10; 134:5; Итгэлийн Тунхаг 1:12-ыг үз.)
- Нас барагсдад сайн мэдээг номлох тухай Петр юу гэж заасан бэ? (1 Петр 3:18–20; 4:6-г үз.) Нас барагсдын дунд сайн мэдээг номлох явдлыг зохион байгуулахаар Их Эзэн сүнсний дэлхий рүү хэзээ явсан бэ? (С ба Г 138:27-г үз.) Тэр яагаад үүнийг хийсэн бэ? (С ба Г 138:29–37-г үз.) Сүнсний дэлхийд Аврагчийн үйлчилсэн явдал нь Бурханы ажлын талаар юуг илчилдэг вэ? (Хариултанд, яагаад гэвэл Бурханы төгс төгөлдөр шударга ёс, нигүүлслээс болж дэлхий дээр амьдарсан бүх хүмүүс сайн мэдээг хүлээн зөвшөөрч, үүнээс ирэх бүрэн дүүрэн адислалуудыг баяртайгаар хүртэх болно гэдэг нь орж болно.)
- 1 Петр 5:1–4 дээр Петр Сүмийн удирдагчдад ямар зөвлөгөөг өгсөн бэ? Сүмийн гишүүд “Бурханы сүргийг” хэрхэн тэжээж чадах вэ? (1 Петр 5:2; 2 Петр 1:12–15; С ба Г 42:12–14-ийг үз.) Та энэ зөвлөгөөг дагадаг Сүмийн удирдагчдаар хэрхэн адислагдсан бэ?

2. “Нэг ч . . . судар хувийн орчуулга биш” (2 Петр 1:20)

- 2 Петр 1:20–21-ийг унш. Петр эдгээр шүлгүүдэд судрын эх сурвалжуудын талаар юу гэж заасан бэ? Бид судруудыг зөвөөр орчуулж байгаагаа хэрхэн бататгаж чадах вэ? (Хариултанд, Сүмийн удирдагчдын илчлэлтээр орчуулсан зүйлсийг эрэлхийлэх, Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлснээр гэдэг нь орж болно.) Сүмийн удирдагчдын сургаалууд эсвэл Сүнсний удирдамж тодорхой нэг судрыг ойлгоход танд хэрхэн тусалсан бэ?

Зорилго

Ангийн гишүүд Эцэг, Хүү хоёр хайраа бидэнд хэрхэн үзүүлдэг, мөн бид хайраа тэдэнд хэрхэн харуулах ёстойг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 1 Иохан 2:28–29; 3:1–2; 4:7–19; 5:1, 11–15. Тэнгэрлэг Эцэг бидэнд түүнтэй адил болох зам, мөнхийн амьдралыг өвлөх боломжийг өгч өөрийн хайраа бидэнд харуулдаг гэж Иохан заадаг.
 - б. 1 Иохан 1:7–9; 2:1–2; 3:5–8, 16; 5:11–13. Биднийг Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болох боломжтой болгодог цагаатгалын золиослолоороо Есүс бидэнд хайраа үзүүлсэн гэж Иохан заадаг.
 - в. 1 Иохан 2:3–17; 3:9–24; 4:4–21; 5:1–10; 2 Иохан; 3 Иохан. Бид дуулгавартай байж, бие биенээ хайрласнаар Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт хайраа үзүүлдэг гэж Иохан заадаг.
2. Нэмэлт Уншлага: Моронай 7:48; Сургаал ба Гэрээ 45:3–5.
3. Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэвэл гэр бүлийн зураг эсвэл дараах зургуудаас нэгийг нь авчир: Гэр Бүл Хамтдаа Ажиллаж Байгаа нь (62313); Гэр Бүлийн Зугаа Цэнгэл (62384); буюу Гэр Бүлийнхэн Хамтдаа (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 616).
4. Заахад зориулсан зөвлөмж: “Хайр, халамж, үүрэгтээ чин сэтгэлээсээ хандах, харамгүй байх, судраас суралцах, залбирал зэрэг нь таны зааж байгаа зүйлийн сүнслэг үндэс болдог. Та хичээлд бэлтгэхдээ эдгээр зүйлүүдийг нэгтгэвэл, ангийн гишүүдэд заахаас өмнө таныг бодол санаа, зүрх сэтгэлдээ хичээлээ бий болгон бэлтгэхэд тусална.”

Хичээл Заах

Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Гэр бүлийн зургийг үзүүл.

- Эцэг эхчүүд хүүхдүүддээ ямар замаар хайраа илэрхийлдэг вэ? Хүүхдүүд эцэг эх, ах, эгч нартаа хайраа хэрхэн харуулдаг вэ?
- Бид ямар утгаараа нэгэн гэр бүлийнхэн бэ?

Бид дэлхийн гэр бүлд хамаарахын зэрэгцээгээр бидний хүн нэг бүр биднийг хайрлаж, адислахыг хүсдэг Тэнгэрлэг Эцэгийнхээ сүнсэн охид, хөвгүүд мөн гэдгийг ангийн гишүүдэд сануул. Иохан захидалдаа Эцэг, Хүү хоёр бидэнд хайраа хэрхэн илэрхийлдэг, мөн бид тэдэнд хайраа хэрхэн илэрхийлж болох тухай дахин давтан онцлон тэмдэглэсэн.

Та дараах судрын хэсгүүдийг заахдаа тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Тэнгэрлэг Эцэгийн биднийг хайрлах хайрын илрэл

Дор байгаа шүлгүүдийг ярилц. Та Бурханы хайрын илрэлийн тухай дүгнэн ярилцаж самбарт бичиж болно.

- Хэрэв та Тэнгэрлэг Эцэгийг тодорхойлох нэг л үгийг хэрэглэх байсан бол ямар үгийг хэрэглэх вэ? 1 Иохан 4:8, 16 дээр Иохан Тэнгэрлэг Эцэгийг тодорхойлохдоо ямар үгийг хэрэглэсэн бэ? Энэ нь ямар учраас зохих үг вэ?
- 1 Иохан 3:1–2-ыг унш. Эдгээр шүлгүүд дээр Иохан Бурханы хайрын ямар илрэлүүдийн талаар дурьдсан бэ? (Бурхан биднийг өөрийн охид хөвгүүд хэмээн нэрлэж, биднийг Христийн адил алдаршуулж, өргөмжлөн, түүнд хамаатай үе залгамжлагч хэмээн нэрлэнэ; мөн Ром 8:14–17-г үз.) Бурханы хөвгүүд хэмээн нэрлэгдэхийн тулд бид юу хийх ёстой вэ? (1 Иохан 2:28–29; 4:7; 5:1; Галат 3:26–27; Мозая 5:5–9; Моронай 7:48-ыг үз. Бид нэгэнт бүгдээрээ Бурханы сүнсэн хүүхдүүд тул 1 Иохан 3:1–2 дээр “Бурханы хөвгүүд” гэсэн үгсийг хэрэглэсэн явдал нь усан баталгаагаар өөрсөд дээрээ Христийн нэрийг авч, итгэл, зөв шударга байдлаараа түүний нэрийг хүндэтгэдэг хүмүүсийг хэлж байгаа юм.)
- 1 Иохан 4:9–10-ыг унш. Эдгээр шүлгүүд дээр Иохан Бурханы хайрын ямар илрэлүүдийн талаар дурьдсан бэ? (Мөн Иохан 3:16; 1 Иохан 5:11; 2 Нифай 9:10-ыг үз. 1 Иохан 4:10 дээр гардаг эвлэрүүлэл гэдэг үг нь Есүс Христийн цагаатгалын золиослолын тухай хэлж байгаа юм гэдгийг тайлбарла.) Хүүгээ бидний гэм нүглийг цагаатгахаар илгээсэн нь Тэнгэрлэг Эцэгийн биднийг хайрладаг хайрыг хэрхэн илэрхийлдэг вэ?
- 1 Иохан 4:13-ыг унш. Эдгээр шүлгүүд дээр Иохан Бурханы хайрын ямар илрэлүүдийн талаар дурьдсан бэ? Сүнс таны амьдралд хэрхэн чухал бэлэг болсон бэ?
- Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийн хүслийн дагуу асуувал Тэр бидний залбирлыг хариулна гэж Иохан заасан (1 Иохан 5:14–15). Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдрэхэд танд залбирал хэрхэн тусалсан бэ? Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болоход залбирал яагаад чухал зүйл байдаг вэ?
- “Бурхан биднийг эхлээд хайрласан учир бид түүнийг хайрладаг” гэж Иохан заасан. (1 Иохан 4:19) Бурхан та нарт хайраа харуулсан зарим ямар арга замууд байдаг вэ? Бурханы хайраа харуулсан замыг нь ухаарч ойлгохдоо та нар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ?

Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлэхдээ: “Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөгөөнд хайрын хязгааргүй их илрэл багтсан байдаг. Гэр бүл, найз нөхөд, баяр баясгалан, мэдлэг, гэрчлэл маань гээд бидний харйлаж явдаг бүх зүйлс Эцэг, Түүний Хүү, Их Эзэн, Есүс Христ хоёр байгаагүй бол байхгүй байх байсан. . . . Үүрдийн хайраас өөр агуу бэлэг гэж үгүй, мөн өөр зүйлийг мэдэхгүй гэдгийг ертөнц гэрчилдэг” гэсэн (Conference Report, Apr. 1993, 77; or *Ensign*, May 1993, 62–63).

2. Аврагчийн биднийг хайрлах хайрын илрэл

Дор байгаа шүлгүүдийг ярилц.

- 1 Иохан 3:16-г унш. Эдгээр шүлгүүд дээр Иохан Аврагчийн хайрын ямар илрэлүүдийн талаар дурьдсан бэ? Аврагчийн цагаатгалын золиослолоос бид ямар адислалыг авч болох вэ? (1 Иохан 1:7–9; 5:11–13; 2 Нифай 9:11–13; Алма 11:40–44-ийг үз. Та эдгээр шүлгүүдийг ярилцахдаа ангийн гишүүдийн хариултыг самбарт бичиж болно.)
- 1 Иохан 2:1–2-ыг унш. Эдгээр шүлгүүд дээр Иохан Аврагчийн хайрын ямар илрэлүүдийн талаар дурьдсан бэ? Өмгөөлөгч гэж хэн бэ? (Нөгөө хүнээ учирлан тайлбарлаж хамгаалдаг хүн.) Өмгөөлөгчийн хувьд Есүс бидний төлөө юу хийдэг вэ? (С ба Г 45:3–5-ыг үз.)
- Бурханы Хүү муу ёрын сүнсний ажлуудыг устгахаар ирсэн гэж Иохан заасан (1 Иохан 3:8). Аврагчийн амьдрал, сургаал нь муу ёрын сүнсний ажлуудыг хэрхэн устгадаг вэ?

3. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон бусдад өөрсдийн хайраа үзүүлэх нь

Дор байгаа шүлгүүдийг ярилц. Та ярилцлагыг дүгнэж самбарт Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд хайраа харуулах замуудыг жагсаан бичиж болно.

- 1 Иохан 2:3–6-г унш. Бид Бурханд хайраа хэрхэн үзүүлэх талаар эдгээр шүлгүүдээс юу сурч болох вэ? (Мөн иохан 14:15; 1 Иохан 3:24; 5:3; 2 Иохан 1:6-г үз.) Дуулгавартай байх нь бидний хайрыг Бурханд хэрхэн харуулдаг вэ?
- 2 Иохан 1:4 ба 3 иохан 1:4-ийг унш. Бидний итгэлтэй байдал Тэнгэрлэг Эцэгт маань хэрхэн баяр баясгаланг авчирдаг вэ?
- 1 Иохан 2:15–17-г унш. Бид Бурханд хайраа хэрхэн харуулах тухай эдгээр шүлгүүдээс юу сурч болох вэ? Бид заримдаа Бурханыг хайрлахын оронд ертөнцийг хэрхэн хайрладаг вэ? Ертөнцийг хайрлах нь бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ? Дэлхийн эд номст хайртай байх байдлаа бид хэрхэн таслан зогсоож болох вэ?
- 1 Иохан 4:7–8, 11-ийг унш. Бид Бурханд хайраа хэрхэн харуулах тухай эдгээр шүлгүүдээс бид юу сурч болох вэ? (1 Иохан 3:11, 23; 4:21-ийг мөн үз.) Бурханд хайртай гэдэг боловч “нэг нэгнээ хайрладаггүй” хүмүүсийн талаар Иохан юу гэж тайлбарласан бэ? (1 Иохан 2:9, 11; 3:14–15, 17; 4:20-ийг үз.) Бусдыг хайрлах хайр маань хэрхэн Бурханы хайрын хэмжүүр болдог вэ? Бид бие биедээ хайраа хэрхэн илүү ихээр илэрхийлж чадах вэ? Бусдын хайр таныг хэрхэн адисалсан бэ?

Хэрэв та анхаарал татах ажиллагааг хэрэглэсэн бол гэр бүлийн зургийг үзүүлж, дараах асуултуудыг тавь.

- Нэг нэгнээ, мөн Бурханыг хайрладаг гэр бүлд амьдрахад ямар адислал ирдэг вэ? Бурханы гэр бүлийн нэг хэсгийн хувьд ийм адислалуудыг бусдад хүртээхэд бид хэрхэн тусалж чадах вэ?

Дүгнэлт

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн бидэнд өгдөг агуу хайрын тухай гэрчил. Ангийн гишүүдийг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон бусад хүмүүст хайраа харуулахаар хичээхдээ Иоханы сургаалуудыг санахыг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Гэрэлд алх” (1 Иохан 1:7)

1 Иохан 1:6–7-г унш.

- “Харанхуйд алхах” гэдэг нь ямар утгатай вэ? “Гэрэлд алхах” гэдэг нь ямар утгатай вэ? (Эдгээр асуултуудыг ярилцахдаа та ангийн гишүүдээр “Гэрэлд нь Алхахыг Надад Заагаач” дууг дуулуулж болно. *Сүмийн Дуулал ба Хүүхдийн Дуунууд*, 66-г үз.)

2. Иохан Христийн эсрэг сүнснээс сэрэмжлүүлсэн.

- Иохан захиадалдаа Христийн эсрэг байдаг хүмүүсээс болгоомжлохыг Гэгээнтнүүдэд дахин давтан сэрэмжлүүлсэн. Христийн эсрэг байдаг хүмүүс юу хийхийг оролддог гэж Иохан хэлсэн бэ? (1 Иохан 2:22–23; 4:1–3; 2 Иохан 1:7-г үз.) Аврагчийн тухай бидний гэрчлэлийг дайснууд яагаад утсгахыг оролддог гэж та нар бодож байна вэ? Бид гэрчлэлээ хүчтэй байлгахын тулд юу хийж болох вэ?

Ахлагч М.Рассел Баллард заахдаа: “Сайн мэдээний үнэний, ялангуяа Их Эзэн, Есүс Христийн тэнгэрлэг амьдрал, номлолын тухай хүний хувийн гэрчлэл нь бидний мөнхийн амьдралд нэн чухал байдаг. . . . Тэнгэр дэх Эцэг, Түүний Ариун Хүүгийн тухай мэддэг хувийн мэдлэг маань мөнх амьдралыг баталдаг. Үүнийг зүгээр л мэддэг байх нь хангалттай зүйл биш. Биднийг тогтоон барьж байх хувийн сүнслэг туршлага бидэнд байх ёстой. Эдгээрийг эрж хайдаг хүмүүс, өлссөн хүн хоол хайхтай адил нэгэн зүйлд бодлоо төвлөрүүлдэг тийм хүсэл эрмэлзлээр үүнийг хайх болдог” гэсэн (Conference Report, Apr. 1996, 111; or *Ensign*, May 1996, 80).

3. “Нэг ч хүн Бурханыг хэзээ ч хараагүй” (1 Иохан 4:12)

Хэрэв ангийн гишүүд, 1 Иохан 4:12 нь хүн Бурханыг харж чадахгүй гэсэн эсэх талаар гайхаж байгаа бол тэднийг Иосеф Смитийн Орчуулга дахь итгэдэг хүмүүсээс өөр хэн ч Бурханыг хэзээ ч хараагүй гэсэн шүлэгт хандуул. (1 Иохан 4:12-ыг үз.) Олон бошиглогчид Бурханыг харсан гэдгийг цохон тэмдэглэ. Египетээс гарсан нь 33:9–11; Иохан 6:46; Үйлс 7:55–56; Сургаал ба Гэрээ 67:10–12; Мосе 1:1–2; Абрахам 3:11; Иосеф Смитийн Түүх 1:16–17-г үз.)

4. Өсвөр насныханд зориулсан ярилцлага

Өсвөр насныхан эцэг эхдээ хайраа хэрхэн илүү их үзүүлж болох талаар улам дэлгэрэнгүй ярилцаж анхаарал татах ажиллагааг бататга. Ангийн гишүүдийг гаргасан санаа бодлоо хэрэглэхийг уриалж дараагийн долоо хоногт өөрсдөдөө тохиолдсон явдлаа хуваалцахаар бэлэн байхыг хүс.

5. Хайрын тухай дууллууд

Хайрын тухай нэг дуулал сонго. Ангийн хэдэн гишүүнээр дууллыг дуулуулахаар товлох буюу ангиараа дууллыг дуул эсвэл дууллын үгийг унших буюу энэ дууллын бичлэгийг тавь.

Зорилго

Ангийн гишүүд Есүс Христийн талаарх гэрчлэлээрээ мөнх бус байдлын саад тотгорыг даван туулдаг хүмүүст ирэх зарим адислалуудыг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Илчлэлт 1:1–3, 9–20. Тэнгэрийн элчээр дамжуулан Их Эзэнээс хүлээн авдаг илчлэлтүүдээ бичиж тэмдэглэн үлдээхийг Иоханд зааварладаг. Иохан илчлэлтээр Есүс Христийн Сүмийн хэсгүүдийг төлөөлсөн хэд хэдэн бэлэг тэмдгийг хардаг.
 - б. Илчлэлт 2–3. Иоханаар дамжуулан Их Эзэн мөнх бус байдлын саад тотгор, уруу таталтыг давж туулсан хүмүүсийг агуу адислалууд хүлээж байгаа талаар Ази дахь Сүмийн долоон салбарын тухай заадаг.
 - в. Илчлэлт 12. Иохан Тэнгэр дэх Дайн, мөн энэ нь ертөнц дээр үргэлжлэх тухай үзэгдэл үздэг. Тэрээр Гэгээнтнүүд Сатаныг Аврагчийн Цагаатгал, гэрчлэлээрээ ялж гарна гэдгийг сурч авдаг.
2. Нэмэлт Уншлага: Илчлэлт 21:7;
3. Та анхаарал татах ажиллагааг хэрэглэх бол 191-р хуудсанд байгаа зургийг үзүүлэхээр бэлтгэ. Ангийн бүх гишүүдэд харагдахаар байлгахын тулд та энэ зургийг самбарт эсвэл том цаасан дээр томруулж зурж болно.
4. Заахад зориулсан зөвлөмж: Сайн багш нь сайн сонсогч байдаг. Сонсоход зөвхөн чагнах төдийгүй мөн юу хэлснийг нь ойлгохыг оролдох нь багтдаг. Анхааралтай сонсдог багш нар ангийн гишүүдийг ойлгож, үнэлж харьцдаг.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Их Эзэн дэлхий дээр үйлчлэхдээ сургаалуудаа заахад хэрэглэсэн бэлэг тэмдгүүдийн талаар бодохыг ангийн гишүүдээс хүс. (Хариултанд, давс, буудай ба зэрлэг өвс, талх ба чидун жимсний мод зэрэг орж болно.)

- Сургаалыг дагахад бэлэгдлүүд нь яагаад их хэрэглэгддэг вэ? (Тэдгээр нь танил биш санаа бодол, эсвэл зүйлсийг танил зүйлүүдтэй харьцуулснаар суралцагчийг тэдгээрийг ойлгож, тогтооход нь тусалдаг; тэдгээр нь янз бүрийн түвшинг хамардаг; суралцагч зааж буй зүйлийн талаар илүү гүн гүнзгий бодоход уриалдаг.)

Сударт ялангуяа Илчлэлтийн номонд үргэлж бэлэгдлийг хэрэглэсэн байдгийг тайлбарла. 191-р хуудсанд байгаа зургийг үзүүлж, эдгээр нь Илчлэлтийн нэгдүгээр бүлэгт ярилцдаг бэлэгдлүүдийн талаар үзүүлдэг гэдгийг цохон тэмдэглэ. Эдгээр бэлэгдэл нэг бүрийн талаар энэ хичээлд ярилцана.

Илчлэлтийн номыг бичигч Төлөөлөгч Иохан нь хэл яриа, утга зохиолдоо бэлэгдлийг өргөн хэрэглэдэг байсан соёл иргэншлийн үед амьдарч байсныг та тайлбарлаж болно. Өнөөгийн уншигчид Иоханы бичсэн бэлэгдлийг уншихдаа үргэлж саадтай тулгардаг. Хэрэв бид дүрслэлийг нь байгаагаар нь орчуулбал Илчлэлтийн ном нь сонин хачин мөн толгой эргүүлсэн мэт санагддаг. Хэрэв бид ихэнх дүрслэл нь бэлэгдэл ба хүмүүс, юмс эсвэл бидний аль хэдийний танил ойлголтыг төлөөлдөг гэдгийг санавал энэ номыг ойлгоход хялбар болно.

Судрын Ярилцлага
ба Ашиглалт

Энэ хичээлээс аль судрын хэсгүүд болон асуултууд нь ангийн гишүүдийн хэрэгцээнд нийцэхийг залбирч бодож үз. Хичээлийн үндсэн цагийг эдгээр хэсгүүд ба асуултуудын талаар ярилцахад зарцуул. Илчлэлтийн ном нь өнөөдөр бидэнд хамаатай бөгөөд хэрэгтэй гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд тусал.

1. Иохан Есүс Христийн Сүмийн хэсгүүдийг төлөөлдөг хэд хэдэн бэлэгдлүүдийг хардаг.

Илчлэлт 1:1–3, 9–20-ийг уншаад ярилц.

Ангийнхантайгаа Илчлэлтийн номны тухай ерөнхий мэдээллийг хянаж үз.

Иохан нь Аврагчийн анхны Төлөөлөгчдийн нэг байсан. Есүс Христийн тухай гэрчлэлээ хуваалцсаных нь төлөө Ромын засгийн газраас Иоханыг одоогийн Туркийн баруун захын жижиг арал болон Патм уруу цөлж хөөсөн. Тэнд байхад нь Иохан дээр тэнгэр элч ирж, Ази дахь Сүмийн долоон салбарт явуулсан захидалд бичиж тэмдэглэсэн илчлэлтийг өгсөн (Илчлэлт 1:1, 9–11). Эдгээр захидлууд нь Илчлэлтийн ном болсон).

Илчлэлт ном нь үндсэндээ бэлэгдлийн хэлээр бичигдсэн. Үүний уриа бол “Энэ ертөнц дээр Бурхан муу ёрын сүнснийг ялж, сайн сайхан нүгэлт явдлыг бүрэн ялж, гэгээнтнүүд хавчигсдаа ялж, Бурханы хаант улс нь хүмүүсийн болон Сатаны хаант улсуудыг ялсан ялалт болно. . . . Араатнууд, дайн дажин, тэнгэрийн элчүүд, хүмүүс гэх мэтийг нарийн тодорхой авч үзэх нь энэ уриаг дэлгэрүүлэхэд нэмэр хандив болдог. Нарийвчилсан зүйлүүдийг бүрэн дүүрэн тодорхойлоогүй ч гэсэн уриаг жаахан судлахад л ойлгож авч болдог” (Bible Dictionary, “Revelation of John,” 762).

Номын эхний гурван бүлэгт Илчлэлтийн үнэн бодит байдлын талаарх Иоханы гэрчлэл, Иоханы Их Эзэнээс авсан зааварчилгаа болон Ази дахь Сүмийн долоон салбарт өгсөн Иоханы зөвлөгөөг бичиж тэмдэглэсэн байдаг. 4-р бүлэгт тэнгэрийн тухай Иоханы үзсэн үзэгдэл, 5–20-р бүлэгт Бурханы хаант улсын ялгуулсан хувь заяаны тухай түүний үзсэн үзэгдэл бичигдсэн. Энэ үзэгдэлд Сатаны хаант улсын эсрэг тулалдаан, Сатаны хаант улсын сүйрэл болон дэлхийн түүхийн эцсийн дүр төрхийг үзүүлдэг (Илчлэлт 21:1–5). Илчлэлтийн ном нь тэнгэр элчийн гэрчлэл болон Их Эзэнээс өгсөн нэмэлт зөвлөгөөгөөр төгсдөг.

- Иохан энэ илчлэлд үзсэн анхны дүрслэл буюу бэлэгдэл нь юу байсан бэ? (Илчлэлт 1:12-ыг үз.) Дэнлүүний сууринууд юуг бэлэгдсэн бэ? (Илчлэлт 1:20-ийг үз.) Дэнлүүний суурь нь яагаад Сүмийн салбарын тохиромжтой бэлэгдэл вэ? (3 Нифай 18:24 ба доорх ишлэлийг үз.) Хэсэг, салбарууд өнөөдөр яаж дэнлүүний суурь мэт үйл ажиллагаа явуулдаг вэ?

Ахлагч Брүс Р.МакКонки хэлэхдээ: “Дэнлүүний суурь нь дэнлүүг тогтоодог. Энэ нь дэнлүүг асаадаггүй. Үүний үүрэг нь дэнлүүг асаахад биш, тогтоож байх юм. Тиймээс одоо Иохан долоон сүмийг болон долоон дэнлүүний суурь ашиглан дүрсэлж зөвлөхдөө, Их Эзэн дэлхий дээрх түүний хүмүүс гэрлийг нь дэлхийд авч явах үүрэгтэй гэдгийг харуулж байгааг хэлжээ” гэсэн (*Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [1966–73], 3:442).

- Долоон дэнлүүний суурь, Аврагчтай ямар холбоотой вэ? (Илчлэлт 1:13-ыг үз.) Аврагч өнөөдөр сүмдээ яаж оршдог вэ? Түүнийг хүмүүсийнхээ дунд байна гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ?
- Аврагч долоон дэнлүүний суурины дунд зогсож байхдаа баруун гартаа юу барьж байсан бэ? (Илчлэлт 1:16-г үз.) Долоон од юуг төлөөлдөг вэ? (Илчлэлт 1:20-ийг үз. Мөн Илчлэлт 2:1 ба Илчлэлт 3:1-ийг үз. Илчлэлт 1–3-ын Иосеф Смитийн Орчуулгад *тэнгэр элч* гэсэн үгийг *үйлчлэгчид* гэж сольж, Сүмийн долоон салбарын удирдагчдыг одоор төлөөлүүлснийг тодорхой болгосон.) Сүмийн удирдагчид хэрхэн од мэт байдаг вэ? (Хариултанд, тэд үргэлж байсаар байдаг бөгөөд удирдамж эрэлхийлж байгаа хүмүүсийг удирдан залж байдаг зэрэг орж болно.)
- Энэ үзэгдэлд Аврагчийн амнаас юу гарч ирсэн бэ? (Илчлэлт 1:16-г үз.) Энэ илд юуг төлөөлж байсан бэ? (Их Эзэний үг нь хурдан бөгөөд хүчирхэг, хоёр талдаа иртэй илднээс илүү хурц байдаг; С ба Г 6:2-ыг үз.) Их Эзэний үг ямар замаар илдтэй адил байдаг вэ? (Еврей 4:12; Хиламан 3:29-ийг үз.)
- Энэ илчлэлтэд Их Эзэн өөр ямар бэлэгдлийг хэрэглэсэн бэ? (Илчлэлт 1:18-ыг үз.) Аврагч эдгээр түлхүүрүүдээр яах вэ? (Тэр бүх хүмүүсийг бие махбодын үхлээс босгож, зөв шударгыг нь оюун санааны үхлээс босгоно. 2 Нифай 9:10–13-ыг үз.)

2. Их Эзэн Азийн долоон салбарт ялагч хүмүүст амласан адислалуудын тухай хэлдэг.

Илчлэлт 2–3-ыг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь. 2 ба 3-р бүлгүүд нь Ази дахь Сүмийн долоон салбарт хэлсэн Их Эзэний үгийг агуулдаг гэдгийг тайлбарла. Их Эзэн салбар бүрийн зарим хүчтэй ба сул талыг дүгнэж үзээд, Гэгээнтнүүдэд сул талаа засахыг сэрэмжлүүлсэн.

- Их Эзэн Ази дахь Сүмийн гишүүдийг сайшаан, алдааг нь зассантай адил тэр өнөөдөр биднийг сайшааж, алдааг маань засдаг. Их Эзэн биднийг юуны төлөө сайшааж болох вэ? Их Эзэн юугаа засаж залруулахыг бидэнд хэлсэн бэ?

Ази дахь Сүмийн салбарт өгсөн зааварчилгаандаа Их Эзэн мөнх бус байдлын саад тотгор, уруу таталтыг ялан дийлэх хүмүүст агуу адислалуудыг бас амласан гэдгийг тайлбарла. Самбарт *Ялсан Хүмүүст Өгсөн Амлалтууд* гэж бич. Та амлалт бүрийн талаар ярилцахдаа энэ гарчгийн дор амлалтуудыг жагсааж бич.

Ефес рүү (Илчлэлт 2:1–7)

- Их Эзэн Ефесчүүдийг наманчлах хэрэгтэй гэж хүссэн. Хэдий тийм ч тэр бас “Амийн модноос идэхийг Би ялагч нэгэнд соёрхоно” гэж амласан. Амийн мод юуг төлөөлдөг вэ? (Хүмүүний үрсийн зүрх сэтгэлд өөрийгөө

өгсөн мөн бүх зүйлээс хамгийн их хүсүүштэй Бурханы хайр; 1 Нифай 11:21–22-ыг үз.) Энэ нь яагаад бүх адислалуудаас хамгийн хүсүүштэй нь вэ?

Смирна руу (Илчлэлт 2:8–11)

- Их Эзэн Смирна дахь Гэгээнтнүүдэд гай гамшгийг туулахыг нь сэрэмжлүүлсэн. Хэдий тийм ч тэр бас “Ялагч нь хоёр дахь үхлээр хохирохгүй” гэж амласан. Хоёр дахь үхэл гэж юу вэ? (Алма 12:16, 32; Хиламан 14:18-ыг үз.) Их Эзэний Смирна дахь Гэгээнтнүүдэд өгсөн амлалт гай гамшигтаа зүй ёсоор хандахад бидэнд хэрхэн туслах вэ?

Пергам руу (Илчлэлт 2:12–17)

- Пергам дахь зарим хүмүүсийг дэлхийн нэр хүнд, шагналыг Их Эзэний хүслийг дагахаас илүүтэйгээр хүссэн Хуучин гэрээний бошиглогч Балаамын сургаалыг дагаж байгаад нь шүүмжилсэн. Их Эзэний хүслийг дуулгавартай дагахын тулд бид дэлхийн ямар нэр хүнд, шагналаас татгалзаж болох вэ?
- Пергам дахь Гэгээнтнүүдэд Их Эзэн амлахдаа “Ялагчид Би нууцалсан маннагаас өгнө” гэсэн. (*Нууцалсан* гэдэг үг нь энэ хэсэгт нандин буюу хүн бүрт тодорхой бус гэдэг утгыг илэрхийлдэг.) Нууцалсан манна юу төлөөлдөг вэ? (Иохан 6:35, 49–51-ийг үз.)

Туатейр рүү (Илчлэлт 2:18–29)

- Туатейрын Гэгээнтнүүдэд хэлсэн үгэндээ Их Эзэн ялагчид юуг амласан бэ? (Илчлэлт 2:26–28. Эдгээр амлалтууд нь зөв шударга нэгэн нь тэнгэрлэг хаант улсуудыг захирах үед хүлээн авах өргөмжлөлийн адислалууд, мөнхийн амьдралыг хэлж байгааг тайлбарла.) Зөв шударга нь төмөр бариултайгаар үндэстнүүдийг захирах нь юу вэ? (Бурханы үг; 1 Нифай 11:25; Иосеф Смитийн Орчуулга, Илчлэлт 2:27). Бид өөрсдийн амьдралаа удирдахдаа Бурханы үгийг хэрхэн хэрэглэж болох вэ?
- Илчлэлт 2:28-д дурьдсан үүрийн цолмон нь хэн бэ? (Илчлэлт 22:16-г үз.) Үүрийн цолмонд өгөгдөнө гэдэг нь юу гэсэн утгатай байж болох вэ? (Хариултанд, Есүс Христийг амьдралдаа хүлээж авах, түүний Цагаатгалын адислалуудыг хүлээж авах зэрэг орж болно.)

Сардей рүү (Илчлэлт 3:1–6)

- Сардей дахь Гэгээнтнүүдэд Их Эзэн ямар адислалуудыг амласан бэ? (Илчлэлт 3:5-ыг үз.) Ариун сүмийн ёслолуудад оролцох нь биднийг мөнхөд “цагаан хувцастай” байхад хэрхэн бэлтгэдэг вэ? Амьдралын ном гэж юу вэ? (Тэнгэрт хадгалагдсан бичээс; С ба Г 128:7; мөн Египетээс гарсан нь 32:33; Алма 5:58-ыг үз.) Номонд бичигдсэн хүмүүст болон бусармаг явдлаасаа болоод толбоноосоо салаагүй хүмүүст юу тохиолдох вэ? (Илчлэлт 21:10, 23–27; Алма 5:58; С ба Г 88:2-ыг үз.)

Филадельфи руу (Илчлэлт 3:7–13)

- “[Түүний] үгийг дагаж, . . . [түүний] нэрийг үгүйсгээгүй” учраас Их Эзэн Филадельфи дахь Гэгээнтнүүдийн төлөө юу хийнэ гэж хэлсэн бэ? (Илчлэлт 3:10-ыг үз.) Зөв шударга амьдрах нь уруу таталтыг эсэргүүцэхэд хэрхэн хялбар болгодог вэ?

- Их Эзэн ялагчид “Би түүн дээр Өөрийн Бурханы нэр, Өөрийн Бурханы хотын нэрийг бичнэ” гэж амласан. Өөрсөд дээрээ бичүүлсэн Бурханы нэрийг авах, түүний хотын нэрийг авах гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Бид Бурхантай адил болж, түүний мөнхийн хаант улсын иргэд болдог.)

Лаодик руу (Илчлэлт 3:14–22)

- Их Эзэн “халуун ч биш, хүйтэн ч биш, бүлээвтэр” Лаодикийн Гэгээнтнүүдийг шийтгэсэн (Илчлэлт 3:15–16). Бид заримдаа хэрхэн сүнсээрээ “бүлээвтэр” болдог вэ? Есүс Христийн сайн мэдээг дагахаар өгсөн амлалтаа бид хэрхэн чандлан сахиж чадах вэ?
- Их Эзэн Лаодикчуудад амлахдаа “Би ялж, Эцэгийнхээ хамт Түүний сэнтийд заларсны адил надтай хамт миний сэнтийд залрахыг ялагчид соёрхоно” гэсэн (Илчлэлт 3:21). Их Эзэний сэнтийд залрах амлалтаар ямар адислалуудыг бэлэгддэг вэ? (Ром 8:16–17-г үз.)

Самбарт бичсэн амлалтуудыг хэрэглэн эдгээр бүх амлалтуудыг хамтад нь авч үзвэл тэд зөв шударгын мөнхийн хувь заяаг тайлбарладаг гэдгийг тайлбарла. Ангийн гишүүдээр Сургаал ба Гэрээ 132:20-ийг эдгээр амлалтуудын дүгнэлт болгож уншуул.

3. Иохан Гэгээнтнүүд Сатаныг Аврагчийн Цагаатгал, гэрчлэлээр ялж гарна гэдгийг сурч авдаг.

Илчлэлт 12-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Иохан илчлэлтийнхээ нэг хэсэг болох Тэнгэр дэх Дайн мөн энэ нь дэлхийд үргэлж байгаа тухай үзэгдэл үзсэн.

Илчлэлт 12:1–2, 5-д дүрслэгдсэн эмэгтэй нь Бурханы Сүмийг төлөөлдөг гэдгийг тайлбарла. Түүний авчирсан хүүхэд Бурханы хаант улсыг Есүс Христийн мянган жилийн хаанчлалын үеэр дэлхийд орших засаглалыг төлөөлдөг.

- Илчлэлт 12-т гардаг луу ноуг төлөөлдөг вэ? (Илчлэлт 12:9-ийг үз.) Тэнгэр дэх Дайнд луу болон түүний дагалдагч нарт юу тохиолдсон бэ? (Илчлэлт 12:3–4, 7–9-ийг үз.) Луу гадагш хаягдсаныхаа дараа юу хийсэн бэ? (Илчлэлт 12:17-г үз.) Сатан өнөөдөр хэнтэй тулалдаж байна вэ? (Илчлэлт 12:12-ыг үз.)

Ерөнхийлөгч Вилфорд Вүүдраф хэлэхдээ: “Дэлхийн оршин суугчдын дунд Бурханы хүч ба муу ёрын сүнсний хүч гэсэн хоёр хүч байдаг. . . . Бурханы хүмүүсийг дэлхий дээр байх ямар ч цаг үед хамаагүй Үүрийн Хүү Люсифер болон тэнгэрээс хөөгдөж унасан сая сая сүнснүүд Бурханы эсрэг, Христийн эсрэг, Бурханы ажлын эсрэг, Бурханы хүмүүсийн эсрэг дайтаж байсан. Тэд үүнийг, өнөөдөр бидний үед хийхээс хойш суухгүй. Их Эзэн хэзээд аливаа үйлийг гүйцэтгэхээр гар бие оролцоход тэдгээр хүч чадлууд үүнийг холдуулж хаяхаар ажилладаг” гэжээ. (*Deseret Evening News*, 1896 оны 10 сарын 16, 9; иш татсан Gordon B. Hinckley, Conference Report, 1986 оны 10 сар, 56; or *Ensign*, 1986 оны 10 сар, 43.)

- Сүм болон Бурханы хаант улс эцэст нь Сатаныг хэрхэн ялан дийлэх вэ? (Илчлэлт 12:11-ийг үз.) Христийн Цагаатгал болон үүний тухай бидний гэрчлэл Сатаны эсрэг тэмцэх хувийн тэмцэлд хэрхэн тусалдаг вэ?

Дүгнэлт

Дэлхийн уруу таталт, саад тотгорыг ялан дийлдэг хүмүүс мөнхийн амьдралын адислалыг хүртэнэ гэдгийг гэрчил. Ангийн гишүүдэд хэрэв бид наманчилж, итгэлтэй байвал Аврагчийн Цагаатгал бидэнд үүнийг даван туулах замыг зааж өгдөг гэдгийг сануул.




**Заах Нэмэлт
Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэхүү санааг хичээлдээ хэрэглэж болно.

“Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна” (Илчлэлт 3:20).

Есүс Үүдэн дээр (62170; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 237) зургийг үзүүл.

- Илчлэлт 3:20 бидэнд Их Эзэний талаар юу заадаг вэ? (Мөн Илчлэлт 22:17-г үз.) Бид үүнийг үнэн гэдгийг яаж мэдсэн бэ?



“Тэр Тэдний Дунд Нутаглаж, Тэд Түүний Ард Түмэн болно”

Хичээл
46

Илчлэлт 5–6; 19–22

Зорилго Ангийн гишүүд нүгэл хилэнцийн хүч дарагдаж, Аврагч ялгуусан алдраар хаанчилна гэдгийг мэддэг учраас ирээдүйгээ итгэлтэйгээр угтахад тэднийг уриалах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Илчлэлт 5:1–5; 6. Иохан илчлэлтээр долоон тамга дарж лацадсан хуйлмал ном байхыг үзэж, эхний зургаан тамга дарж лацадсан хэсэг буюу цаг хугацааны үеийн үйл явдлуудын заримыг ажигладаг. Тэрээр Сатан бүхий л цаг хугацааны турш зөв шударгын эсрэг тэмцэхийг хардаг.
 - б. Илчлэлт 19:1–9; 20:1–11. Иохан Сатаныг хүлэгдсэн байх бөгөөд Христ Мянган Жилийн үеэр ялгуусан алдраар хаанчлахыг хардаг.
 - в. Илчлэлт 20:12–22:21. Эцсийн шүүлт болж дуусахад зөв шударга нь Бурхантай хамт амьдарна гэдгийг Иохан сурдаг.
2. Нэмэлт Уншлага: Сургаал ба Гэрээ 77.
3. Заахад зориулсан зөвлөмж: “Энэ бүгдийн дээр хамгийн чухал бэлтгэл бол өөрийгөө бэлтгэх юм. Ариун Сүнсний нөлөөллийг мэдрэхэд бэлтгэ” (Boyd K. Packer, *Teach Ye Diligently* [1975], 219). Хүн нэг бүр Аврагчийн адилаар амьдарч, түүний адилаар заахыг хичээх ёстой. Ариун Сүнсний нөлөөгөөр зааж байгаадаа баттай байхын тулд юу хийж болохоо залбирч шийд.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ:

Саяхны гарсан сонин үзүүлж, гэмт хэрэг, байгалийн гамшгийн талаар мэдээлсэн хоёр гурван сэтгэл эмзэглүүлсэн өгүүллэгийг анхаарч үз.

- Эдгээрийн адил болсон явдлуудын талаар уншаад та нар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ? (Болсон явдлын талаар нэг бүрчлэн ярилцах хэрэггүй.)

Ангийн гишүүнээр 2 Тимот 3:1-ийг уншуул.

Бид “аюултай” хэмээн Төлөөлөгч Паулын дүрсэлсэн эцсийн өдрүүдэд амьдарч байгааг цохон тэмдэглэ. Эцсийн өдрүүдийн үеэр амьдрахын сорилт шалгалтуудын нэг нь айдас, гунигаа ялан дийлж сурах явдал бөгөөд ингэвэл бид саад бэрхшээл, уруу таталтыг давж гарч чадна гэдгийг тайлбарла. Энэ хичээлд бид эцсийн өдрүүдэд болох үйл явдлуудыг ойлгосноор хэрхэн итгэл найдвар, урам зориг олж авч чадах талаар ярилцана.

Дараах судрын хэсгүүд бидэнд эцсийн өдрүүдэд хүнд хэцүүг туулах найдлагатай байхад хэрхэн тусалж чадах талаар ярилц. Ангийн гишүүдэд зөв шударга нэгэн нь Хоёр дахь Ирэлтээс эмээх хэрэггүй гэдгийг ойлгоход тусал.

1. Сатан зөв шударгын эсрэг тэмцдэг.

Илчлэлт 5:1–5; 6-г ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Илчлэлт номын Иоханы цаг үетэй холбоотой эхний гурван бүлгийг тайлбарла. (Хичээл 45- ыг үз.) Номын үлдсэн хэсгүүдэд Иоханаас хойш, ирээдүйд болох, Төлөөлөгчдийг нас барсны дараа болсон Урвалтаас эхлээд Есүс Христийн Хоёр дахь Ирэлт, эцсийн шүүлт хүртэлх үйл явдлуудын талаар гардаг.

Илчлэлтийн 5, 6-р бүлгүүдэд “долоон тамга дарж лацадсан” номын бэлэгдлийг хэрэглэсэн байдаг (Илчлэлт 5:1). Лац бүр дэлхийн түр зуурын оршнолын мянган жилийн хугацааг төлөөлдөг (С ба Г 77:6–7). Бид зургаа дахь лацыг төлөөлсөн цаг хугацааны үед нь амьдарч байна. (Долоон лацны тухай илүү мэдээлэл авахдаа 3 дахь заах нэмэлт санааг үз.) 6-р бүлэгт Хурга (Есүс Христ) цаг хугацааны үе бүртэй холбоотой зарим үйл явдлуудыг үзүүлэн зургаа дахь лацыг нээдэг.

- 6-р бүлгээс бидний сурдаг нэг зүйл бол Сатан ертөнцийн түүхэнд үргэлж зөв шударгын эсрэг тэмцсээр байдаг. Илчлэлт 6:4–11-т заасны дагуу тэр үүнийг ямар ямар замаар хийдэг вэ? (Хариултанд дор дурьдсан зүйлүүд орж болно.)
 - а. Хүчирхийлэл ба дайн (Илчлэлт 6:4, 8)
 - б. Өлсгөлөн ба хоосрол (Илчлэлт 6:5–5, 8). Ромын нэг зоос нь дунджаар нэг өдрийн цалин байсан бөгөөд буудайн хэмжээс нь нэг хүний нэг өдөр идэх хоолны хэмжээтэй тэнцэж байв. 6-р шүлэгт өдрийн цалин хөлс зөвхөн нэг хүний нэг өдрийн хоолыг авах мөнгө байсныг үзүүлдэг.
 - в. Хавчлага (Илчлэлт 6:9–11)

- Зөв шударгыг ялан дийлэхийн тулд Сатан өнөөдөр ямар арга хэрэглэдэг вэ? Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли мэдэгдэхдээ:

“Тэр харгис, ширүүн дайн эхэлж, хэзээ ч зогсоогүй үргэлжилсээр. Энэ бол үнэн, алдаа хоёр, сонголт, шахалт хоёр, Христийн дагагчид, Түүнийг эсэргүүцэгч нарын хоорондын дайн юм. Түүний дайснууд энэ мөргөлдөөнд бүхий л төлөвлөгөөг хэрэглэсэн. Тэд хуурч мэхлэх явдалд баясдаг. Тэд мөнгө, эд баялгийг эзэмшдэг. Тэд хүний оюун санааг төөрөгдүүлсэн. Тэд алан хядаж, сүйтгэж, Христийн ажилд саад хийхээр бүхий л бузар, ариун бус үйлдлийг явуулсан. . . .

“[Сөргөлдөх] нь Сүмийн дотор гадна хоёуланд нь итгэлийг үгүй хийж, дорд оруулж, худал гэрч болж, манай хүмүүсийг Бурханы энэ ажлын сургаал, жишигт үл нийцэх зүйлийг хийхэд уруу татан, толгойг нь эргүүлэх олны үүрдийн чармайлтанд илэрсээр байсан. . . .

“Дайн үргэлжилсээр. Дэлхий даяар сонголт, шахалтын асуудлуудаар дүүрч байна. Энэ дайнд үнэн, алдааны талаар номлогчид тэмцэж байна. Мөн бид амьдралдаа, гэртээ, ажил дээрээ, сургуультай холбоотой зүйлүүд дээрээ өдөр бүр тэмцэж байна. Хайрын тухай асуудал дээр болон хүндэтгэл, шударга, үнэнч байдал, дуулгавартай байдал, зарчимч байдал дээр ч

тэмцсээр. Бид бүгд үүнд оролцож байна” гэжээ (Conference Report, Oct. 1986, 55–58; or *Ensign*, Nov. 1986, 42, 44–45).

- Дээрх ишлэлд дурьдсан бодлоо хэлснийхээ дараа Ерөнхийлөгч Хинкли нэмж, “Бид [Сатаны эсрэг дайнд] ялж байгаа бөгөөд ирээдүй хэзээ ч үүнээс илүү гэгээтэй харагдаж байгаагүй” гэв (Conference Report, Oct. 1986, 58; or *Ensign*, Nov. 1986, 45). Сатаны эсрэг дайтахдаа бид хэрхэн итгэлтэй мөн гаднаа өөдрөг харагдаж чадах вэ? Сатан болон түүний дагалдагчдын хүчний эсрэг биднийг зоригжуулах ямар зүйлүүд бидэнд байгаа вэ? (Хариултанд, судрууд, амьд бошиглогчдын сургаалууд, пристийн зэргийн эрх мэдэл, ариун сүмүүд болон сүмийн бусад гишүүдтэй харьцах харьцаа зэрэг орж болно.)

2. Сатан хүлэгдсэн байх бөгөөд Христ Мянган Жилийн үеэр ялгуусан алдраар хаанчилна.

Илчлэлт 19:1–9 ба 20:1–11-ийг уншаад ярилц.

- Иохан Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнө болох олон янзын өвчин зовлон, дайн, шүүлтийн тухай тодорхойлон хэлсэн (Илчлэлт 8–16). Дараа нь Илчлэлт 19-д тэрээр Их Эзэний ирэлтийг хуримын зоогоор бэлэгдэн тайлбарласан (Илчлэлт 19:7–9). Хурганы эхнэр юуг төлөөлдөг вэ? (Есүс Христийн Сүм) Христ шинэ хүргэн болж, Сүм шинэ бэр болсон хуримын зоогийн бэлэгдэл нь Их Эзэн ба түүний Сүм хоёрын хоорондын харьцааны талаар юуг зөвлөдөг вэ?

- Энэ хуримын зоогонд уригдахын тулд бид юу хийх ёстой вэ?

Ахлагч Брүс Р.МакКонки тайлбарлахдаа: “Израилийн ахлагч нар одоо Их Эзэний хуримын зоогны урилгыг тарааж байна. Сайн мэдээнд итгэж, дуулгавартай дагадаг хүмүүс урилгыг хүлээн авдаг бөгөөд хуримын найранд . . . цагтаа очно” гэжээ (*Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [1966–73], 3:563–64).

- Христ дэлхийд өөрийн биеэр мянган жилийн хугацаанд хаанчлах Мянган Жилийг Есүс Христийн Хоёр дахь Ирэлт эхлүүлнэ. Мянган Жилийн үед Сатанд юу тохиолдох вэ? (Илчлэлт 20:1–3-ыг үз.) Сатаныг хүлээтэй байх үед амьдрал ямар байх вэ? (Сатан хүмүүсийн зүрх сэтгэлийг эзэгнэх хүчгүй болж; хүмүүс өсч үржин, хүчирхэгжиж, тэдний хүүхдүүд аврал уруу нүгэлгүйгээр өсч торних болно; 1 Нифай 22:26; С ба Г 45:55, 58-ыг үз.) Бид яг одоо амьдралдаа Сатаны хүчийг хэрхэн хязгаарлаж чадах вэ?
- Мянган Жилийг өнгөрсний дараа Сатан нэгэн улирлын турш суллагдах бөгөөд сүүлчийн ганц агуу их дайн Бурханы болон Сатаны армиудын дунд болно (Илчлэлт 20:7–8; С ба Г 88:111–13). Үүнийг заримдаа Гог болон Магогийн дайн гэж нэрлэдэг. Мянган Жилийн төгсгөлд энэ агуу дайны үр дүн юу байх вэ? (Илчлэлт 20:9–11; С ба Г 88:114–15-ыг үз.) Дайны үр дүнг аль хэдийн мэдэж байгаа тул бид энэ ялалтын төлөө ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлэхдээ: “Өдөр бүр нүгэл хилэнцийн хүч чадал, сайн үйлсийн хүч чадал нь шинэ хүчээ сэлбэж байдаг. Өдөр бүр бид хувьдаа олон шийдвэр гаргаж үүнийг дэмжиж буй шалтгаанаа харуулдаг. Эцсийн үр дүн нь тодорхой бөгөөд зөв шударгын хүч ялах болно. Гэхдээ юу нь ил харагдаж үлддэг вэ гэвэл, одоо болон ирээдүйд хүн нэг бүр энэ

даинд хаана нь зогсох вэ, бид хэр өндөрт зогсох бол гэсэн явдал юм. Бид эцсийн өдөрт үнэнч байж, өмнө нь томилогдсон байсан үүргүүдээ гүйцэтгэх болов уу?” гэжээ (“In His Steps,” *Ensign*, Sept. 1988, 2).

3. Эцсийн шүүлтийн дараа зөв шударга нь Бурхантай хамт амьдарна.

Илчлэлт 20:12–22:21-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Сүүлчийн агуу дайны дараа эцсийн шүүлт болно. Бид Илчлэлт 20:12-оос хэрхэн шүүгдэх талаар юу сурч болох вэ? Зөв шударга байснаа шүүлгэсэн хүмүүст ямар адислалууд ирэх вэ? (Илчлэлт 21:3–7-г үз. Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич. Хариултанд дараагийн хуудсанд байгаа зүйлс орж болно.)

Зөв шударга нь:

- а. Бурханы дэргэд оршино. (Илчлэлт 21:3)
- б. Дахин хэзээ ч үхэл, гуниг зовлон, уй гашуу, өвчин үзэхгүй. (Илчлэлт 21:4)
- в. Бурханы охид, хөвгүүдийн хувиас бүх зүйлийг өвлөнө. (Илчлэлт 21:7)

- Эдгээр агуу адислалуудын тухай мэдэх нь мөнх бус байдалд хүнд хэцүү зүйлтэй тулгарахад бидэнд хэрхэн туслах вэ?
- Илчлэлт 21:10–22:5-д дэлхийн сэлэсчел алдар хүнд, сэлэсчел алдар хүндийг хүртсэн хүмүүсийн орших хотын талаар тайлбарласан байдаг. Сэлэсчел хотод яагаад ариун сүм байхгүй байсан бэ? (Илчлэлт 21:22-ыг үз. Ариун сүмийн зорилго нь биднийг Бурханд улам ойр болгож, түүний төлөвлөгөөг бидэнд заах явдал юм. Бид түүнтэй дахин амьдрахад ариун сүм хэрэггүй болно.) Илчлэлт 22:14-т мөнхийн хотын хаалгаар орох боломжтой байхын тулд бид юу хийх ёстой гэж хэлдэг вэ?

Ерөнхийлөгч Давид О.МакКэй, олон хүмүүс болон Аврагч цагаан хувцас өмсөөд үзэсгэлэнт хотод байхыг үзсэн үзэгдлийнхээ тухай ярьсан.

“Тэр хотыг би [Аврагчийнх] гэдгийг нь ойлгосон юм. Энэ бол мөнхийн хот байсан. Түүнийг дагах хүмүүс нь тэнд амар амгалан, мөнхийн аз жаргалыг тогтоохоор байж байсан.

“Гэвч тэнд хэн байсан бэ?

“Аврагч миний бодлыг уншсан юм шиг тэрээр, тэдний дээр байгаа хагас дугуй хэлбэртэй зүйл дээр алтан үсгээр [Тэд Дэлхийг Даван Туулж— Үнэхээр Дахин Төрсөн Хүмүүс] гэж бичсэн зүйлийг заалаа” гэв (*Cherished Experiences from the Writings of President David O. McKay*, comp. Clare Middlemiss [1976], 60).

Дүгнэлт

Шинэ Гэрээ агуу итгэл найдлагын захиасыг агуулж төгсдөг гэдгийг тайлбарла. Илчлэгч Иохан шиг бошиглогчид болох зүйлүүдийг харж, хэрэв бид зөв шударга байж, эцсээ хүртэл тэвчвэл хүлээн авах адислалуудын тухай бидэнд хэлсэн. Зөв шударга нь дэлхийн төгсгөлд ялах болно гэдгийг гэрчил. Ангийн гишүүдийг бусармаг явдлын эсрэг зогсож, энэ амьдралын саад тотгорыг давахад эндээс мэдсэн зүйлээсээ зориг, итгэл найдвар олж авахыг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Дэлхийн эд зүйлст зүрх сэтгэлээ өгөхийн аюул

- Илчлэлт 18:11–18-д муу санаатнууд эд хөрөнгөө алдсандаа уйлж, дэлхийн зүйлсийн агуу хаант улс богинохон хугацаанд сүйрч болдгийг хараад гайхна. Богинохон хугацааны дотор дэлхийн эд зүйлс устаж үгүй болохыг эсвэл алдагдахыг та хэзээ харсан бэ?
- Дэлхийн зүйлүүдэд зүрх сэтгэлээ өгөхийн аюул нь юу вэ? Дэлхийн зүйлс ямар замаар биднийг сүнслэг зүйлүүдээс сатааруулдаг вэ?

2. Анхны Дахин Амилалт

Ангийн гишүүнээр Илчлэлт 20:4–6-г уншуул. Эдгээр шүлгүүдийг ойлгоход ангийн гишүүдэд туслахын тулд дараах мэдээллийг (дараагийн хуудсан дахь) хуваалц.

Анхны Дахин Амилалт буюу шударга ёсны дахин амилалт нь Аврагчийн Хоёр дахь Ирэлт дээр эхэлнэ. Сэлэсчел эсвэл тэррэстрил шагналыг авах хүмүүс энэ дахин амилалтыг авна (С ба Г 88:98–99). Хоёр дахь Дахин Амилалт буюу шударга бусын дахин амилалт нь Мянган Жилийн төгсгөл хүртэл эхлэхгүй. Тэлэсчел шагналыг авах хүмүүс болон мөхлийн хөвгүүд энэ дахин амилалтыг авна (С ба Г 88:100–102) .

3. Илчлэлтийн номон дахь долоон лац

Дараах бүдүүвч зураг долоон лац бүрийн тухай нэмэлт мэдээлэл өгнө. Түүнчлэн бүдүүвч зураг нь Илчлэлт номын бүтцийг ойлгоход хэрэглэгдэж болно.

Лац	Гол Үйл Явдлууд
Нэгдүгээр лац	Бүтээлт, Адамын Уналт, Ева; Енохын үйлчлэл ба түүний хотыг тэнгэр лүү шилжүүлсэн. (Илчлэлт 6:1–2)
Хоёрдугаар лац	Ноа ба Үер (Илчлэлт 6:3–4).
Гуравдугаар лац	Абрахам, Исаак, Иаков, Иосефийн үйлчлэлүүд. (Илчлэлт 6:5–6)
Дөрөвдүгээр лац	Мосегийн үйлчлэл; Египетээс гарсан нь; шүүгчдийн засаглалын үеүд; хаадын засаглалын үеүд; хаант улсуудад хуваасан нь; хаант улсыг эзэлсэн нь. (Илчлэлт 6:7–8)
Тавдугаар лац	Есүс Христийн төрөлт, үйлчлэл, цовдлол, дахин амилалт; Түүний Сүмийн босголт ба Төлөөлөгчдийн үйлчлэл; Төлөөлөгчдийг алсан нь; Урвалт (Илчлэлт 6:9–11).
Зургаадугаар лац	Урвалт үргэлжилсэн нь; Бошиглогч Иосеф Смитээр дамжин сайн мэдээ дахин сэргэсэн нь; цаг хугацааны тэмдгүүд өгөгдсөн нь (Илчлэлт 6:12–17; 7:1–8).
Долоодугаар лац	Дайн, гай гамшиг, сүйрэл; Их Эзэний Хоёр дахь Ирэлт (Илчлэлт 8:1–19:21). Амар амгалангийн Мянган Жил (Илчлэлт 20:1–6). Сатан нэгэн улирлын турш суллагдсан, сүүлчийн тулаан ба эцсийн шүүлт (Илчлэлт 20:7–15).
Долоодугаар лацны дараа	Дэлхий сэлэсчөл байдалд орно (Илчлэлт 21:1–22:6).

- Эхний таван лац нь 11 шүлэгт, зургаадугаар лац нь 14 шүлэгт, долоодугаар лац нь 226 шүлэгт багтдаг гэдгийг цохон тэмдэглэ. Энэ нь бидэнд юуг зааж байна вэ?

Иохан ихэнх анхаарлаа бидний цаг үед болон ирэх цаг үед зориулсныг цохон тэмдэглэ. Илчлэлтийн номыг бидний үед зориулж бичсэн бөгөөд бид Аврагчийн Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэж үүнийг суралцвал амьдрал маань адислагдах болно.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



4 02356 81363 9

35681 363